

Удирдлагадаа хандах хандлагаараа  
ирээдүйгээ шийднэ



ШИНЭЧИЛЖ  
САЙЖРУУЛСАН

# БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР



## ЖОН БИВЭР

“Криптонитыг Устга” бестселлер номын зохиолч

Хүндэт найз минь

Эрх мэдэлд хандсан Бурханы дизайн, зорилгыг мэдэхгүйгээсээ болоод олон хүн зовдог. Бурхан сайн ч, муу ч удирдагч нараар дамжуулан биднийг тогтоод, үйлчлэх чадвартай байлгахаар зан чанарыг маань хэлбэршүүлэн, тордож, дотоод чанарыг маань тултал хөгжүүлдгийг бид мэддэггүй. Эрх мэдэлтнүүдтэй харилцан холбогдох Бурханы хүслийг ойлгосон хүн удирдагч нар нь сайн, мууг үйлдэхээс үл хамааран энх тайван, хамгаалалт, хангамжаа хадгална.

Таны өмнө Бурхан доторх хувь тавилан чинь байна. Та дээрх эрх мэдэлтнүүддээ захирагдах сонголт хийхдээ, Бурханаас тогтоож өгсөн, Бурхан доторх хувь тавилангаа ойлгож, биелүүлнэ.

Энэ ном бол дэлхий даяарх итгэл нэгт удирдагч та нарыгаа гэх сэтгэл зүрхний минь тасархай юм шүү. Заавал уншиж судлаарай. Өөрөө мэдээд зогсохгүй, энэ болоод бусад бүх ном, сургалтын материалыг маань таньж мэддэг хүн бүртээ заавал хүргээрэй. CloudLibrary.org хаягаар зочлоорой.

Мөн та, бид хоёр гайхамшигт Эзэндээ алдрыг авчрах захирамжийг биелүүлэх хүмүүс байхын төлөө залбираарай.

Христ доторх анд



MessengerX.com

Жон Биверээс чинь.

JohnBevere@ymail.com



**MESSENGER**  
INTERNATIONAL

# **БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР**



**Удирдлагадаа хандах хандлагаараа  
ирээдүйгээ шийднэ**

**ЖОН БИВЭР**

*UNDER COVER:*

*Why Your Response to Leadership Determines Your Future* Mongolian by John P. Bevere

© 2020 Messenger International

MessengerInternational.org

Originally published in English as *UNDER COVER: Why Your Response to Leadership Determines Your Future*

This updated version offers new and revised content from the author.

© 2001, 2018 Messenger International

Additional resources in (Mongolian) are available for free download and video streaming at

**MessengerX.com** and on the **MessengerX app**

To contact the author: JohnBevere@ymail.com

This book is a gift from Messenger International and is NOT FOR SALE

*БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР:*

*Удирдлагадаа хандах хандлагаараа ирээдүйгээ шийднэ* Жон П. Бивэр

© 2020 Messenger International

MessengerInternational.org

Англи нэр: *UNDER COVER: Why Your Response to Leadership Determines Your Future*

Энэхүү хэвлэл нь агуулга нэмж, шинэчлэн найруулсан хувилбар болно.

© 2001, 2018 Messenger International

Монгол хэл дээрх бусад хэрэгтэй материалаа

**MessengerX.com** болон **MessengerX app** -аас

шууд үзэх эсвэл утсандаа татаж авах боломжтой.

Зохиолчтой холбогдох имэйл: JohnBevere@ymail.com

Монгол хэл дээрх энэхүү номыг Мессенжер Интернэйшнэл байгууллагаас

Монголчуудад бэлэглэж байгаа бөгөөд ХУДАЛДАХЫГ ХАТУУ ХОРИГЛОНО.



App Store is a trademark of Apple Inc., registered in the U.S. and other countries.

Google Play and the Google Play logo are trademarks of Google LLC.

Номоо ууган хүү Аддисондоо зориулав.

*“Мэргэн хүү эцгийн баяр баясгалан.”*  
— Сургаалт үгс 10:1

Чиний нэр “Итгэл даахуй, хайрлуулсан нэгэн” гэсэн утгатай бөгөөд  
чи нэр алдраа даасан шиг дааж, яг л энэ номын сургаалаар  
алхаж амьдарч яваа журамт эр хүн.

Миний хүү, Бурханы дээдийн дээд ерөөл, амлалтыг өвлөх болтугай.  
Бурханы царай миний хүү дээр гийсээр байх болтугай.  
Үрт наслаж, удаан жаргах болтугай.

Бурханаас заяасан энэ насны минь бөгөөд өнө мөнхийн минь  
хамгийн өндөр ерөөл болсон чамдаа аав, ээж нь хайртай!



# АГУУЛГА

## ХЭСЭГ 1: БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

- |                                      |    |
|--------------------------------------|----|
| 1. Бурханы хамгаалалт                | 11 |
| 2. Хадаасны үзүүр өөд өшигчих хэцүү! | 18 |

## ХЭСЭГ 2: БУРХАНЫ ШУУД ХАМГААЛАЛТ

- |                                       |    |
|---------------------------------------|----|
| 3. Нүглийг тодорхойлбол               | 35 |
| 4. Хуульгүй байдлын нууц хүч          | 46 |
| 5. Дуулгаваргүй байдлын үр дагавар I  | 61 |
| 6. Дуулгаваргүй байдлын үр дагавар II | 71 |
| 7. Илбэдүүлсэн                        | 86 |

## ХЭСЭГ 3: БУРХАНЫ ТОГТООСОН БҮРХҮҮЛ

- |  |     |
|--|-----|
| 8. Хэн хариуцаж байгааг Бурхан мэдэх үү? | 101 |
| 9. Хааныг хүндэтгэх                      | 115 |
| 10. Давхар хүндэтгэл                     | 129 |
| 11. Дуулгавартай байж, захирагдах        | 148 |
| 12. Эрх мэдэлтнүүд надаар...?            | 161 |
| 13. Шударга бус хандлага                 | 179 |
| 14. Өөр дээрээ буулгасан шүүх            | 197 |
| 15. Нэг                                  | 213 |
| 16. Магадлал ба төгсгөл                  | 227 |
| 17. Аугаа итгэл                          | 243 |
| 18. Дүгнэлт                              | 258 |
| Ярилцах асуулт                           | 261 |





ХЭСЭГ 1



# БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР



## БҮЛЭГ 1

# БУРХАНЫ ХАМГААЛАЛТ

*Бурам шиг зөөлөн үг бус,  
бул чулуун үг л хамгийн том эрх чөлөө,  
хамгаалалтыг авчрах нь бий.*

**Б**атлан хамгаалалт дор гэдэг үг нь олон төрлийн нөхцөл байдалд хэрэгжих байх. Хамгийн энгийн дээ - дулаан хөнжилдөө шурган шигдэх юмуу эсвэл аюултай эгшинд аав, ээжийнхээ ар өвөрт хорогдож, өмгөөлөн хамгаалагдах жаахан хүүхэд дүрслэгдэх. Нийгэм дээр авч үзбэл, цагдан сэргийлэх, цэргийн хамгаалалтанд оршин тогтнох хотыг хэлж болох байх. Эсвэл мод бут, хад агуй, газар доогуурх хорогдох газар нуугдах ан амьтныг дүрсэлж болох. Бас гадаа хар шуурга дэгдэн тэнгэр, газар нийлж байхад дулаан гэртээ айх аюулгүй, аяга цайгаа оочин суух айл гэрийг дүрсэлж болох.

Намайг хүүхэд байхад манай нутагт байнга хар шуурга дэгддэг байлаа. Цонхоор бүлгийгэл, тэртээ тэнгэрийн хаяанд хар үүлс угалзран бөөгнөж, аянга цахилгаан цавчилдан нижигнэж байснаа, хэдхэн минутын дотор гадаа ирчихсэн, таарсан бүхнээ самарч, баригдсан бүхнээ чулуудан, агсамнаж өгдөг сөн. Аянга цахилгаан тас няс үсэрч, араас нь тэнгэрийн дуу дэлбэ авна. Бороон дуслууд түмэн алхаар хадах шиг л дээвэр бөмбөрдөнө. Тийм боловч тэр хар шуурга манай байшинг бүр л аюулгүй, амар тайван цайз хэрэм шиг

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

санагдуулдаг байж билээ. Цонхны гаднах орчин хүйтэн бороонд шалба цохиулж, аянганд ниргүүлэх аюулд байвч, манай гэр бүл бат дээвэр дороо хар салхинаас аюуж чичрэлгүй, амар жимэр сууцгаана. Учир нь батлан хамгаалалт дор байв.

Бүгдээрээ энэ санааг цааш нь задлан дэлгэрүүлэх үүднээс *батлан хамгаалалт* гэсэн энэ хоёр үгийг нийлүүлээд, *нууц* гэдэг тэс өөр нэгэн нэр томъёог гаргаж ирье. Энэ нь “нууц дүрийн” дотор орших хамгаалалтыг илтгэнэ. Тухайлбал нууц тагнуулын ажилтан дайснаасаа айх явдалгүйгээр ажил үүргээ чөлөөтэй гүйцэтгэдэг. Засгийн газар нь түүний жинхэнэ нэр, ажлыг чандлан нууцалж, хуурамч тодорхойлолт дор ажиллуулдаг учраас тэрбээр дайсны ар талд чөлөөтэй ажиллана. Товчхондоо, бид энэ үгийг юмуу нэр томъёог яаж ч хэрэглэсэн бай, дотор нь *хамгаалалт*, *эрх чөлөө* гэсэн утга оршсоор байна.

Тэгвэл *батлан хамгаалалт дор* гэсэн энэ нэр томъёо нь Христэд итгэдэг хүмүүст хэрхэн хэрэгжих вэ? Давид “Хамгийн Дээд Нэгэний халхавчинд оршигч нэгэн Төгс Хүчит Нэгэний сүүдэр *дор* амьдарна. Би ЭЗЭНд “Миний хоргодох газар, бат цайз минь, Миний итгэдэг Бурхан минь” гэнэ” (Дуулал 91:1-2) хэмээн бичсэн. Эндээс ч бид Бурханы батлан хамгаалалт дор оршдог хүмүүст байх хамгаалалтыг харж байна. Гэхдээ “...оршигч нэгэн” гэдэг эхний үгээс бид “Хэн Бурханы хамгаалалт дор орших вэ?” гэсэн маш чухал асуултыг олборлон гаргаж байна. Тэгвэл таны гар дээр байгаа энэ ном нь энэхүү амин чухал хариултын эрэл хайгуул болой. Товчхондоо, батлан хамгаалалт дор байгч нь Бурханы эрх мэдэл дор байгч нэгэн ажээ.

Адам, Ева хоёр цэцэрлэгт Бурханы батлан хамгаалалт дор эрх чөлөө, аюулгүй байдлыг эдэлж байв. Гэтэл дуулгаваргүй загнасан даруйдаа тэд сайн дураараа тавиад туучихсан яг тэр зүйлээ үгүйлэн хайж эхэлсэн бөгөөд тэр нь “өөрийгөө хучих” хэрэгцээ байв (Эхлэл 3:7). Бурханы эрх мэдэлд дуулгаваргүй хандсан явдал нь хүн төрөлхтний нэгэнтээ эрх дураараа эдэлж байсан амтат эрх чөлөө, аюулгүй байдлыг нь дээрэмджээ.

Тэгэхээр үнэнийг хүлээн зөвшөөрцгөөе. *Эрх мэдэл* гэдэг үгд бид тийм дуртай биш. Гэтэл бид эрх мэдлийг үгүйсгэх юмуу эрх мэдлээс айснаараа эрх мэдлээс ирдэг бат хамгаалалт, ашиг тусыг алддаг. Бид эрх мэдлийг Бурханы үзэл бодлоор хардаггүй учраас, дургүйцдэг. Эрх мэдэлд хандах хандлага маань миний гурав дахь хүү Алект тохиолдсон нэгэн түүхийг санагдуулдаг юм.

Алек нэгдүгээр ангид ороходоо, ангийнхаа багштай хэл амаа олсонгүй. Багш эмэгтэй нь биеэ ч хянан захирах чадваргүй, байнгын уур бухимдалтай, сурагчид руугаа орилж хашгичиж, ер нь юу юугүй тэсрэхэд бэлэн байдаг байжээ. Гэтэл миний хүү номхон суухаасаа илүүтэй яриа хөөрөө дэлгэх дуртай, оргилуун эрч хүчтэй, ширгэшгүй бүтээлч залуу учраас, багшийнхаа уур хилэнгийн бай болох нь олонтаа. Алекийн хувьд сургууль гэдэг олон нийтийн гайхамшигтай цугларалт байсан юм. Гэтэл түүний энэ жаргалтай, өөдрөг хандлага нь багшийнхаа сөрөг зан чанар, тэвчээргүй байдалтай байнга мөргөлддөг байсныг та хэлүүлэлтгүй ойлгосон байх.

Мөн ч олон удаа тэр багш гэргий, бид хоёрт “зөвлөгөө өгөхөөр” хичээлийн дараа өрөөндөө дуудаж уулзсан сан. Бид хоёр ч багштай гар нийлэн ажиллаж, Алект багшийнхаа тавьсан дүрэм журамд захирагдаж, үгэнд нь орохыг зааж урамшуулдаг байсан боловч, энэ бүх төвөгтэй үйл явц нь хүүгийн маань хайраар жигүүрлэсэн сэтгэлийг зохион байгуулалттай эрдмийн сургалтаар дэгээдэж байв.

Тэгтэл манайх нүүж, Алек хоёрдугаар ангид элсэн орлоо. Энэ удаа хүү маань тэс өөр багштай учрав. Тэр багш эмэгтэй сурагчдынхаа баяр хөөртэй зүрх сэтгэл, хандлагад туйлаас анхаардаг, арай л дэндүү гэмээр сайн хүн байлаа. Тэрбээр Алекийг маань хайр булаам жаал хэмээн үзэж, багшийнхаа хайрыг булаасан хүү маань ч ялгаагүй багшдаа “дурлаж”, үүнийхээ ачаар бараг л бүх асуудлаас мултардаг болсон боловч, хичээл дээрээ олигтой ахиц гаргахгүй байв. Тийнхүү Алек маань сурлага дээрээ ахицгүй байсан болохоор, бид хүүгээ эрдмийн тал дээр онцлон анхаардаг, нэр хүндтэй чартер сургуульд оруулав.

Гэтэл Алек маань тэнд ороод барьц алдаж, навс унав. Учир нь хүү маань эхний хоёр жилээ онцсайн дүүргэсэн хүүхдүүдийн дунд ороод явчихав. Одоо Алек мяндас зөөлөн сэтгэлтэй боловч сургах тал дээрээ хатуу бөгөөд чадуу багшийн найдвартай гарт оржээ. Алек эрдмийн тал дээрээ бусад сурагчдаас хоцорч яваа нь төдөлгүй ил болов. Лиза, бид хоёр дахиад л хүүгийнхээ ангийн багштай тогтмол боловч, энэ удаа ашиг ахицтай уулзалт хийдэг боллоо. Лиза, бид хоёр хүүгийнхээ хичээл сургуулийн үйл хэрэгт бодитоор оролцдог болов.

Өдөржин сургууль дээрээ нүдүүлж, оройжин хүзүүн дээрээ аав, ээжийнхээ хүнд амьсгалыг мэдэрнэ гэдэг амаргүй. Алек маань олон ч удаа дуугаа хураан суудаг байж билээ. Хүү маань ахиц гаргаад байгаа атлаа өөрийгөө сүйрч байна гэж бодоод, уйлаад л суудаг байв.

Тэгж тэгж нэг өдөр хүүгийн маань тэвчээр барагдаж, сэтгэл мэдрэмж нь сад тавив. Ах нар нь сургууль дээрээ скэйтээр гулгах өдөрлөгт оролцохоор явж байхад, манай залуу хийгээгүй гэдгээ нуучихсан байсан даалгавраа дуусгахаар гэртээ үлдэв. Тэрбээр багшийнхаа өгсөн даалгавраас болж, найзуудтайгаа зугаацаж чадахгүй нь гэхээс голоо тасартал гомдож, асгартал уйллаа. Тэгээд бид хоёр ээлжит аав - хүүгийн яриагаа өрнүүлэхээс өөр аргагүй болов. Би хүүтэйгээ ганц хоёр үг солиод л учрыг ойлгов. Бяцхан хүүгийн маань найдвар тасарчээ. Гомдлын нулимс нь тасралтгүй урссаар... хүү маань аавынхаа үгийг ч сонсох тэнхэлгүй болов. Тэгээд бид хоёр хоёулаа хэлэх үггүй болоод, нэг хэсэг нам суулаа. Хүү минь доошоо хараад л, уйлаад л байв.

Тэгтэл дараа нь юу болсныг би хэзээ ч мартдаггүй юм. Яасныг бүү мэд - хүү маань гэнэт уйлахаа больсноо, нуруугаа эгцлэн сууж, нүүрээ хуурайлан арчаад, аав руугаа нөгөө л хөөрхөн бурман бор нүдээрээ ширтэв. Гэхдээ энэ удаа түүний харцанд итгэл бадарч байв. Хүүд маань нулимсыг нь шударч, асуудлыг нь шийдэх, итгэл найдвар авчирсан, шинэ санаа төрсөн нь илт байлаа. Алек цэх суугаад, хоёр гараа элгэндээ эвхсэнээ эр бор дуугаар: “Аав аа, би танд нэг юм хэлмээр байна. Манай ангийн Жессика байш дээ, тээ... эмчид итгэдэггүйг та мэдэх үү?” гэлээ. Тэгээд жаахан тэвдсэн янзтай хэсэг сууснаа: “Тэгвэл байш дээ... Аав аа, би багшид итгэдэггүй” гэж хэлэх нь тэр.

Би уурлах инээхээ мэдэхгүй мэлрэв. Хүү маань намайг ёстой нам болгов. Тэгснээ: “Манай ангийн Жессика эмчид итгэхгүй байж чадаж байгаа юм бол, би ч бас багшид итгэхгүй байж болно” гэлээ. Би ч пис хийгээд л явчихав. Хүү маань тэр үгээ уйлангаа гонгинож хэлсэн бол, тийм инээдтэй сонсогдохгүй байх байв. Гэтэл тэр дууных нь өнгийг ээ! Хүү маань аавынхаа нүдийг нээж, өөрийнхөө бүх асуудлыг шийдэх цоо шинэ илчлэлийг танилцуулж байгаа гэдэгтээ тун ч итгэлтэй байв. Яг л шүүх танхимд мэдүүлэг өгч байгаа хүн шиг чухал дуугаар ярив.

Мэдээж би энэ боломжийг ашиглан, багш нар байгаагүй бол, хүү маань ямар байх байсныг тайлбарлаж өглөө. Тэгээд өмнөх жил нь Африкийн Анголд очиж, өлсгөлөнд нэрвэгдсэн жаахан хүүхдүүдийг хооллох цэгүүд дээр үйлчилж байхад тэдний амьдрал ямар байсныг ярьж өгөөд, тэр хүүхдүүд Александрын оронд байхын төлөө юу ч хийхэд бэлэн байгааг хэллээ. Тэр хүүхдүүд хожмын нэгэн өдөр гэр бүлээ тэжээх учраас, эрдэм мэдлэгтэй байх нь хичнээн чухал болохыг ойлгосон болохоор, суралцах боломж олдох л юм бол, шууд шүүрээд

л авна. Миний энэ урт удаан ярианы дараа Алек дөнгөж сая шинээр нээсэн гүн ухаанаа дурамжхан орхиод, өөрийг нь хүлээж байгаа овоолгоотой даалгавраа дуусгахаар гал тогоо руу алхлав.

Хүү, бид хоёрын дунд өрнөсөн энэ яриа миний толгойноос хэдэн долоо хоног гараагүй бөгөөд би өөрийн эрхгүй энэ явдал, хүмүүсийн эрх мэдлийг харах үзлийн хооронд параллель шугам татсаар байлаа. Түүх эрх мэдлийн таагүй жишээгээр дүүрэн: зарим хүмүүс үнэхээр харгис дарангуй удирдагч нарын дор зовсон бол, манай хүү шиг зарим хүмүүс сайн сайхан удирдагч, эрх мэдэлтний дор байх атлаа гомдол гутралаасаа юмуу эсвэл дураараа амьдрах гэснээсээ болоод өөрийнхөө дээр байгаа эрх мэдэлтнүүдийг амьдралын садаа хэмээн үзэж, ялладаг. Гэхдээ дээрх буруу хандлага нь *“Би эрх мэдэлд итгэдэггүй”* гэх юмуу эсвэл томчуудын хэлдгээр *“Би санал нийлэхээс нааш эрх мэдэлд захирагдахгүй”* гэсэн утгагүй туршлагаас л үүдэн бий болдог юм.

Тэгвэл Бурхан үүнийг юу гэж үздэг вэ? Эрх мэдэлтнүүд шударга бус байсан ч, бид захирагдах ёстой юу? Тэд завхарсан амьтад байвал, яах уу? Тэд биднээр буруу зүйл хийлгэх гэвэл, яах уу? Биднээр нүгэл үйлдүүлэх гэвэл, яах уу? Хил хязгаарын дээсийг хаагуур татах вэ? Ер нь бид яахаараа тэдэнд захирагдах ёстой юм? Захирагдлаа гээд ашиг тус байна уу? Зүгээр л Бурханыхаа Сүнснийг л дагаад явж байхад болох биш үү?

Энэ бүх асуултад Бурханы Үг тухай бүр тодорхой хариулдаг. Би энэ номыг Эзэний надад даалган бичүүлсэн хамгийн чухал номуудын нэгт тооцно. Учир нь энэ ном эдүгээ хүмүүсийн амьдралд тулгардаг олон бэрхшээлийг уг үндсээр нь шийдвэрлэдэг юм. Люсиферыг юу унагалаа? Тэрслэл. Адамыг юу унагалаа? Тэрслэл. Гэхдээ хамгийн зог тусмаар нь ихэнх тэрслэл нь бүдүүн баараг биш, харин маш нарийн зальтай байдаг.

Би энэ номоороо танд өөрийнхөө алдааг дэлгэнэ. Би сүргээ, ажилчдаа, гэр бүлээ атгахыг санаахдаг, эрх мэдэлд улайрсан удирдагч биш ээ. Би гайхамшигтай сайхан хамт олон, гэр бүлтэй хүн. Би нутгийн чуулганы пастор биш. Тиймээс би маш олон алдаа - за ний нуугүй хэлэхэд нүгэл хийсэн хүнийхээ зүгээс бичнэ. 1980-аад онд би хоёр ч олон улсын үйлчлэлд үйлчилж явсан учраас, дийлэнх жишээгээ тэр үеийнхээ л үйл явдлаас эш татах болно. Хамгийн аюултай нь би алдаа гаргах тоолондоо өөрийгөө яриангүй зөв гэдэгт үнэн голоосоо итгэж байсан боловч, хэрэг дээрээ тас буруу байсан юм. Тиймээс сэдлийг минь Үгээрээ илчилж өгсөн Эзэндээ талархаад баршгүй.

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Та миний алдаанаас сургамж авч, сэргийлээсэй гэсэндээ л би үүнийг бичиж байгаа юм. Та миний мунхаглалаас бурханлаг ухаарал олж, заавар авч, ач тус хүртэх нь миний чин зүрхний залбирал болой. Учир нь тэр олон алдааныхаа эцэст би гайхамшигтай сайхан, ач тустай үр дүнд хүрсэн билээ. Гэмшлээр дамжин надад аюулгүй байдал, хангамжийн аль аль нь ирсэн.

Тэгвэл таны хувьд ч ийм зүйл боломжтой. Энэ номон дээрх Библийн бөгөөд миний амьдралын жишээг унших явцад зүрх чинь гийх болтугай. Зарим санаа нь таны мэддэг зүйлийг улам бататгах бол, зарим нь таныг чөлөөлнө. Аль ч тохиолдолд миний бие танд Бурханы Үгийг номхон даруугаар түгээж байгаа шиг, та ч бас Бурханы Үгийг номхон даруугаар хүлээж авахын төлөө залбирч байна.

Хүн үнэнтэй нүүрэлдэхдээ, хоёр янзаар хариу үйлддэг. Нэг бол Адамын хүү Каин шиг биеэ өмөөрөн уурлаж, өөрт хэрэгтэй илчлэлийг хөсөр хаяж болно (Эхлэл 4) эсвэл Натаны өмнө улаан нүүрээ улалзуулсан гэмшсэн Давид шиг эмтрэн даруусч, зовлон гэмшлээр дамжин бурханлаг зан чанараар илүү өндөр төвшин рүү ахин, өсч болно (2Самуел 12). Ийм асуудал дээр биднийг Бурханы хангамж, хамгаалалтын төлөвлөгөөнөөс хорих гэж хүчин зүтгэдэг бардам занг таягдан хаяад, Давид шиг зөөлөн зүрхтэй байя.

Замд гарахаасаа өмнө, бурам шиг зөөлөн үг бус, бул чулуун үг л хамгийн том эрх чөлөө, хамгаалалтыг авчирдгийг мэдээрэй. Намайг хоёрдугаар ангид байхдаа вакцин хийлгэхээс өмнө нэг найз маань аймаар өвдөнө шүү гэж анхааруулж билээ. Тэр үгийг сонсоод би тариулахгүй гэж байдгаараа тэмцэв. Тэгээд хоёр сувилагч эгчтэй тэнхээ мэдэн үзэлсэнд, эцэстээ нөгөө хоёр чинь тамирдаад, бууж өгөв. Тэгтэл аав, ээж хоёр маань намайг суулгаж байгаад, тэр сүрьеэгийн вакциныг хийлгэхгүй бол, надад юу тохиохыг тайлбарлаж өгсөн юм. Эгч маань хорт хавдраар нас барахыг би харсан учраас аав, ээж хоёр намайг хамгаалах гэсэндээ л хэлж байгааг ойлгож байлаа. Тариулахад мэдээж өвдөнө. Гэхдээ тариа намайг халдвартай тэгээд магадгүй аминд халтай өвчнөөс хамгаална гэдгийг би ойлгов. Үүнийг ухаармагцаа би сайн дураараа буцаж очоод, тариулсан юм.

Бурханы Үгийн таагүй эсвэл бүр магадгүй зовиуртай болов ч, дархлаа тогтоох үнэнтэй нүүрэлдэх бүрийдээ энэ жишээг санаарай. Тэнгэрийн Аавын тань арга зам төгс байдаг бөгөөд хэдийгээр заримдаа алах нь уу гэмээр зовиуртай санагдав ч, хэрэг дээрээ таныг



## БУРХАНЫ ХАМГААЛАЛТ

аюулгүй байдал, ерөөл, аврал дотор байршуулж байж болох. Биднийг гэх Бурханы хайр бүрэн дүүрэн, цэвэр бөгөөд мөнхийн байдгийг бүү мартаарай!

За, ингээд замд гарахаасаа өмнө залбирцгаах уу:

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, би гаднаа тав тух, таашаал эдлэхээсээ илүүтэй дотроо Таны үнэнийг л хүснэ. Таны арга зам төгс. Тиймээс зүрх сэтгэлээ Таны мутарт даатгая. Та намайг хайрласандаа Өөрийнхөө санаж сарвайх ганц Хүү - Есүс Христийг өгсөн. Та намайг мөнхөд амьдруулах гэсэндээ миний өмнөөс Хүүгээ үхүүлсэн. Та намайг ингэтэл хайрласан болохоороо амьдралд маань эхлүүлсэн ажлаа бүрэн гүйцэт хийхийг хүсч байгаа тань тодорхой. Энэ номоор дамжуулан надтай Сүнсээрээ ярьж, миний амьдралд хандсан хүсэл, замаа ойлгуулаарай. Таны Үгийг харах нүд, сонсох чихийг минь нээгээрэй. Надад Есүсийг урьд урьдынхаас тод харуулаарай. Энэ номон дээрх Үгээрээ дамжуулан амьдралд маань хийх Таны бүх үйлст баярлалаа. Есүсийн нэрээр. Амень.*

## БҮЛЭГ 2

# ХАДААСНЫ ҮЗҮҮР ӨӨД ӨШИГЧИХ ХЭЦҮҮ!

*Хаанчлалын зарчмыг  
ардчилсан үзлээр ойлгохгүй.*

**Я**г одоо миний өмнө Бурханы нигүүлсэлгүйгээр хийх ямар ч боломжгүй нэг даалгавар байна. Би хуульгүй байдал өдөр өдрөөр газар авч байгаа дэлхийд эрх мэдлийн тухай заах гэж байна. Тиймээс энэ номын олон сэдэв манай нийгмийн түрүү барьдаг шалтаг, шалтгаануудтай шууд мөргөлдөнө. Бид одоо халз тулах гэж байгаа суурь үнэнээс тэс өөрөөр бодож сэтгэж байхаар горимлогджээ. Энэ нь бидний сэтгэлийн дайсан Сатаны үндсэн арга барил бөгөөд тэрбээр ёрын муу зүйлийг дур булаамаар харагдуулж, эрх чөлөө авчирдаг зүйлийг хүлээс дарамт мэтээр дүрслэн, манийгаа урхидах болжээ.

Анх яг л ингэж эхэлсэн. Сатаны энэ арга цэцэрлэгт жигтэйхэн амжилттай ажилласан бөгөөд тэр цагаас хойш өнөөг хүртэл тэр эрчээрээ ажилласаар л байна. Тиймээс л бидэнд: “Хайрт ах дүү нар минь, бүү мэхлэгдэгтүн” (Иаков 1:16), “Энэ үеийн явдалд нийцэлгүй, харин оюун санааныхаа шинэтгэлээр өөрчлөгдөж байгтун! Тэгвэл Бурханы сайн, тааламжит, төгс төгөлдөр таалал юу болохыг таних болно” (Ром 12:2) хэмээн анхааруулжээ.

## ХАДААСНЫ ҮЗҮҮР ӨӨД ӨШИГЧИХ ХЭЦҮҮ

Миний харснаар Бурханы Үгийг сонсохдоо хамгийн хойрго хүмүүс бол Барууныхан. Үүний хамаг учир сууриндаа л байгаа юм. Хаанчлалын зарчмыг ардчилсан үзлээр ойлгохгүй. Ардчилал чинь дэлхий дээр л хэрэгтэй тогтолцоо. Гэтэл Бурханы хаанчлал чинь хаанчлал гэдгийг мартаж болохгүй. Хаанчлал гэдэг чинь Хаанд захирагддаг, хэргэм зэрэг, эрэмбэ дараа, эрх мэдлээс тогтдог тогтолцоо. Хүмүүсийн алдартай санаа бодол, сонгууль, судалгаа нь Бурханы хаанчлалын хуулийг хөндөж, нөлөөлөхгүй. Тэр хуулийг хүний өөртөө бодож олсон итгэл үнэмшил хөндөхгүй. Тэр итгэл үнэмшил чинь Еваг хурууныхаа үзүүрээр дөнгөчихсөн шүү дээ. Тиймээс Хаанчлалын арга замыг ухуулан заахаа больсон энэ нийгэмд бид Самуел “ард олонд хаанчлалын эрхийг хэлж, тэдгээрийг номд бичсэн” (1Самуел 10:25) шиг хаанчлалын зарчимд суралцах ёстой билээ.

Бид соёлын нөлөөт сэтгэлгээгээр дээд эрх мэдэлдээ хандаад, итгэгч хүн шиг амьдрах гэж оролдож, наанадаж үр нөлөөгүй байна, цаанадаж аюулд өртөх магадлалтай. Амьдралынхаа жинхэнэ Эх үүсвэрээс салах учраас бидний аюулгүй байдлын хангамж гацах юмуу эсвэл бүр тасарч болзошгүй. Яг л Бурхан хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн зохиож байхад, бэйсбол тоглоод байхтай л адил юм. Бас тогонд залгаагүй байж, цахилгаан хэрэгслээ ажиллуулах гэж оролдохтой адил.

Өнөөдөр бид дээд эрх мэдэлтэйгээ санал нийлэхгүй бол, шууд л гомдоллож, эсэргүүцлээ илэрхийлдэг болсон. “Ер нь тэгээд засаглал чинь “ард түмнийх, ард түмнээр, ард түмнийхээ төлөө” байх ёстой биз дээ, тийм биш үү?” Ийм маягийн ардчилсан сэтгэлгээ нь манай Христэд итгэх итгэлд нэвчиж, олон хүнийг “Би мэдэж байна” гэдэг худлын замаараа уруудуулж байна. Эрх мэдэлтэй сөргөлддөг байсан хүмүүс энэ замаар уруудахдаа эцэстээ бүр даварч, эрх мэдлийг улайм цайм жадлан эсэргүүцдэг болно. Тэгтэл бас эрх мэдлийг эрээ цээргүй жигшдэг хүмүүс ч байх бөгөөд тэд энэ байдлаа эрх мэдлийг үл тоосноороо харуулдаг. Ийнхүү тэд Бурханаас айж эмээх сэтгэлээсээ бүрэн урвана.

Тийм боловч эдгээр хандлагын нэг нь ч бидэнд хүсээд байгаа эрх чөлөөг маань авчрахгүй. Бичээс:

Хэрэв тэд сонсоод (Түүнд) үйлчилбэл тэд өдөр хоногуудаа амжилт цэцэглэлд, он жилүүдээ дэвшил дунд өнгөрөөх болно. Харин сонсохгүй аваас тэд илдэнд мөхөж, мэдлэггүйгээр үхэх болно (Иов

36:11-12) гэдэг.

“Түүнд гэдэг нь Бурханаас өөр хэн байх билээ. Бурханы эрх мэдэлд захирагдахад хангамж, хамгаалалт амлагдсан байхыг харж байна уу? Түүнчлэн Бурханы засаглалыг үл тоосон нөхцөлд ирэх аюулыг бас хэлсэн байхыг харж байна уу? Бид эрх мэдлийг эсэргүүцэхдээ, эрх мэдэлд захирагдсан нөхцөлд л ирдэг эрх чөлөөгөө алддаг. Гэргий маань “Захирагдахад - эрх чөлөө, тэрслэхэд - хүлээс” гэдэг сэн. Үндсэндээ Иовын үгийг базаж хэлсэн нь л тэр.

Зарим чинь: “Би хүнд биш, Бурханд захирагддаг хүн. Хүнд захирагдах ёстой болбол - санал нийлсэн тохиолдолд л захирагдана” гэх байх. Яг үүн дээр л бид, хүн болж өсөхдөө бас чуулганд бойжихдоо өөриймшүүлсэн буруу сэтгэлгээндээ дэгээдүүлдэг юм. Бурханы эрх мэдэлд захирагдах явдал, Бурханыг төлөөлөн захирдаг хүмүүст захирагдах явдал - энэ хоёрыг салгах аргагүй юм. Учир нь бүх эрх мэдэл Бурханаас эхтэй! Бичээс юу гэж анхааруулсныг үзнэ үү:

*Бурханаас гадуурх эрх мэдлүүд гэж үгүй* бөгөөд Бурханы тогтоосноор л байгаа тул дээд эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд. Тиймд эрх мэдлийг эсэргүүцэгч нь Бурханы тогтоолыг эсэргүүцсэн хэрэг. Эсэргүүцсэн хүмүүс нь өөрсдөдөө шийтгэл хүртэх болно (Ром 13:1-2).

Энэ хэсэг дээр бодууштай зүйл олон байгаа бөгөөд эдгээрийг бүгдээрээ хожим нэг бүрчлэн авч хэлэлцэнэ. Харин одоогоор ганц, хоёр чухал зүйл л хэлье. Нэгдүгээрт - дэлхий дээрх бүх захирагчийг Бурхан Өөрөө томилдог. Үнэндээ Бурханы зөвшөөрөлгүйгээр хэн ч хууль ёсны эрх мэдэлд гарч чадахгүй. Үүнийг тогтоогоод аваарай. Олон хүн шударга бус, харгис хатуу эрх мэдэлтнүүдэд дарлагдсандаа, энэ үнэнийг хүлээн зөвшөөрч чаддаггүй юм. Тийм боловч бид дээрх үгийг анхааралтай унших хэрэгтэй. Тэнд: *бүх эрх мэдэл Бурханых* гэж хэлсэн байгаагаас биш, *бүх эрх мэдэл бурханлаг* гэж хэлээгүй байна. Энэ хоёр нь тэнгэр, газар шиг ялгаатай ойлголт бөгөөд бид эдгээрийг тус бүр нарийн авч үзнэ.

Хоёрдугаарт - тэдгээр эрх мэдэлтэй тэрсэлдэх нь Эзэний буюу Бурханы Өөрийнх нь томилгоотой тэрсэлдсэн явдал болох бөгөөд ингэсэн хүмүүс өөр дээрээ шийтгэл буулгана. “Бичвэр бүр Бурханы амьсгалснаар” (2Тимот 3:16) гэсэн байдаг тул дээрх үгийг эрх

мэдэлд улайрсан нэгэн бус, харин бидний Бурхан Аав Өөрөө зохиож бичүүлсэн болохыг санаарай. Хүн холион бантан хутгасан байлаа гээд дээрх үг нь Бурханы Үг байхаа больчихгүй.

Олон хүн наанаа хүлээн зөвшөөрдөггүй боловч, цаанаа “Би хүнд бус, гагцхүү Бурханд захирагдана” л гэж боддог. Ийм хүмүүс “Эзэн” хэмээн дууддаг Нэгэнтэйгээ хэзээ нэгэн өдөр нүүр тулан уулзана. Есүс Саулд (хожмын элч Паулд) юу гэж хэлснийг санахгүй байна уу? “Жадат шилбүүрийн өөдөөс өшиглөх хэцүү” (Үйлс 9:5). Библийн үеийн тариачид жад маягийн урт мод хэрэглэдэг байжээ. Энэ нь холтсоос нь нүцгэлсэн царс зэрэг хатуу модны, хоёр метр урттай мөчир. Тэгээд үзүүрт нь хурц иртэй жад суулгаад, үүгээрээ газар хагалж байгаа шарыг туудаг байжээ. Шар ч өөрийг нь сүрхий өвтгөж, гэмтээх чадалтай хурц мэсний өөдөөс эсэргүүцэхгүй. Паулын үед энэ зүйр үгээр дээд эрх мэдэл, хүчтэй сөргөлдөөд нэмэргүйг дүрсэлдэг байжээ.

Тэгвэл энэ үг өнөөдөр ямар утга илэрхийлэх вэ? Бүгдээрээ “жадыг” хадаас гэж үзье. Хадаасны үзүүр өөд өшигчих нь мунхаг бөгөөд зовиуртай үйлдэл. Паул шиг шууд Бурхантай Өөртэй нь сөргөлддөг юмуу эсвэл Бурханы төлөөний эрх мэдэлтэй сөргөлддөг хүмүүс нь хадаасны үзүүр өөд өшиглөнө. Тэгээд үүнийхээ гороор олонх нь над шиг яс махаараа зовж байж л хатуу сургамж авдаг юм.

## Нүд нээсэн үйл явдал

Зовиур гэснээс, би Бурханы төлөөний эрх мэдлийг эсэргүүцэх нь Бурханы Өөрийнх нь эрх мэдлийг эсэргүүцсэн явдал гэдэг үнэнийг махандаа хэлүүлж байж ухаарсан юм шүү. Тиймээс “хадаасны үзүүр өөд өшигчиж болдоггүй юм” гэдэг сургамжийн тамгатай хүн билээ, би.

1980 - аад оны дундуур надад олон улсад үйл ажиллагаа явуулдаг, маш том чуулганаас залуусын пастораар үйлчлэх санал ирэв. Тэгээд залбирч, гайхамшигтай баталгаа хүлээн авсныхаа дараа би тэр ажлыг Бурханы хүсэл мөн гэдэг бат итгэлтэйгээр хүлээн авсан юм.

Өмнө залуусын чуулганд үйлчилж яваагүй болохоороо туршлагагүйгээсээ болоод нилээд сандарч байсан ч, ямартаа ч Америкийн хамгийн хурдан өсч яваа, хамгийн нэр нөлөө бүхий чуулганы ажилчдын эгнээнд элсэв ээ. Тэгээд би залуусын үйлчлэлийн талаарх ном, гарын авлагаас салахаа болив. Тэр дунд Луизианад маш амжилттай залуусын чуулган байгуулсан, нэгэн манлайлагч

пасторын бичсэн ном байж таарав. Би нарийн бичигтээ тийшээ нисч очоод, хоёр өдөр тэдний бүлэг дунд байж, туршлага судалж болох эсэхийг тэр чуулганаас лавлаж өгөхийг хүстэл, удирдагч нар нь надад тун уриалгахан хандаж, бид ч цаг хугацаагаа тохирлоо.

Би очсон өдөртөө л Гурав дахь өдрийн оройн залуусын цуглаанд нь оролцов. Тэгээд ёстой л ангайсан даа. Тэд зөвхөн залуусын цуглаанд зориулсан 1,500 гаруй хүний суудалтай танхимтай бөгөөд танхим нь пиг дүүрчээ! Тэд тоглоом тоглолгүй, хөнгөн хөгжилтэй номлол номлолгүй, харин цэвэр байдал, хүч чадлын үгийг номлов. Гэтэл тэнд байгаа залуусын баяр хөөр намайг үнэхээрийн гайхшруулсан юм. Би ч учиргүй догдолж, зөв хүмүүсээс суралцаж байгаадаа бат итгэв.

Маргааш нь би тэр чуулганы удирдагч нартай уулзалдлаа. Тэгээд харсан зүйлдээ бас л итгэж ядав. Тэд өөрийн гэсэн залуусын цуглааны байртай, залуусын чуулганы үйл ажиллагааг хариуцан бүтэн цагаар ажилладаг хоёр зохион байгуулагчтай, залуусын чуулганд бүтэн цагаар ажилладаг дөрвөн пастортой ажээ. Дараагийн хоёр өдөр нь би тэр дөрвөн пасторыг дагаж, гадаад болоод дотоод үйл ажиллагаанд нь оролцов. Статистикийн тоо баримт нь ямар гээч?! Тухайн үед тэд ахлах сургуулийн үйлчлэлд гар бие оролцдог 1,250 дунд сургуулийн сурагчтай байсан бөгөөд энэ тоо нь гэрлийн хурдаар тасралтгүй өсч байгаа гэнэ.

Тэр дөрвөн пастор дөрвүүлээ нэг л үг хэлж байлаа. Үйлчлэлийнх нь амжилтын үндэс нь Тав дахь өдрийн орой болгон хот даяар зуу гаруй байршилд зохион байгуулдаг “үдэшлэг” гэнэ. Тэр үдэшлэг нь үнэндээ залуу хүмүүсийг аврах зорилготой гэрийн бүлгүүд ажээ.

Маш энгийн атлаа гүн ойлголт. Аврагдаагүй өсвөр насны хүүхдүүдийг чуулганд авчрах хэцүү боловч, үдэшлэгт авчрах амархан. Долоо хоногийн дундуур залуусын бүлгийн гишүүн бүр сургуулийнхаа нэг хүнийг онилж, Тав дахь өдрийн оройн үдэшлэгтээ авчрах даалгавартай. Үдэшлэг дээрээ хоол иднэ, нөхөрлөнө, орчин цагийн Христэч дуу хөгжим сонсоно; дараа нь бүлгийн удирдагч нь (ахлах сургуулийн юмуу коллежийн оюутан) Библи суурьтай ярилцлага өрнүүлж, тэр нь эцэстээ авралын сэдэвт хүргэнэ. Дараа нь удирдагч нь шинээр ирсэн залуусыг амьдралаа Есүст өргөхийг урьж, шийдвэрт дуудна. Үүнийх нь ачаар шинээр ирсэн маш олон залуус аврагддаг байжээ. Дараа нь тэдэнтэй хувьчлан уулзаж, чуулганд явж, итгэгч хүмүүстэй нөхөрлөх нь амин чухал болохыг зааварлаж, нэр ус, холбоо барих мэдээллээ солилцож, Гурав дахь өдрийн залуусын цуглаандаа

урина.

Би нэг үдэшлэгт нь оролцохдоо, аврагдаагүй хэд хэдэн сурагч Есүст амьдралаа өгөхийг нь үзээд байдгаараа огшив. Дараа нь чуулгандаа буцаж ирээд, сурч мэдсэн зүйлээ туслахтайгаа хуваалцлаа. Залбирлын дараа бид хоёр өөрийнхөө залуусын дунд яг тэгж ажиллах ёстой мэт санагдав. Би энэ алсын хараагаа нэгэн Бүтэн сайны цуглааны дараа машины зогсоол дээр тэргүүн пастортаа ярьтал, пастор намайг: “Сайн байна. Үзээд алд!” хэмээн урамшууллаа.

## Төлөвлөж, хөдөлмөрлөсөн найман сар

Намайг залбирах үеэр Бурхан надад төлөвлөгөө зааж өгөв. Тэгээд би удирдагч нараа бэлтгэхээр шууд удирдлагын сургууль эхлүүлсэн юм. Энэ тухайгаа Хоёр дахь өдрийн орой залуусын бүлэг дээр зарлалат, ирэх Бүтэн сайны өглөө болох удирдлагын сургалтад бүртгүүлэхээр далан хүн ирсэнд магнай хагарлаа. Би тэдэнд зургаан сарын турш долоо хоног тутам итгэмжтэй байдал, шударга зан чанар, бүрэн зориулалт, үйлчлэл, алсын хараа зэрэг удирдлагын зарчмыг заах төлөвлөгөөтэй байв.

Таван сарын дараа намайг залбирч байтал, Эзэн зүрхэнд маань дахин айлдаж: *“Удирдлагынхаа ангиас хорин дөрвөн хүнийг сонгоод, тэдэнд зориулж дагалдагчийн анги эхлүүл. Тэдний дундаас чи үдэшлэгийнхээ анхны удирдагч нарыг сонгох болно”* хэмээн айлдав. Би ч тэр даруй тэднийг анхны гэрийн бүлгийн удирдагч нар болгохоор сургаж гарлаа.

Тийнхүү хүмүүсээ хоёр сарын турш гэрийн бүлгийн үдэшлэгт бэлтгэн, Хоёр дахь өдрийн оройн залуусын том бүлэгтээ үдэшлэгийнхээ алсын харааг зааж байлаа. Манай туслах пастор, бид хоёр удирдагч нарын сургалтын хөтөлбөр дээр ажиллаж, үдэшлэг хаана, хаана болохыг тодорхойлж, хотоо сургуулийн дүүрэг, зип кодоор нь хуваах, бүлгүүд хэрхэн өргөжих, дагалдууллыг хэрхэн хийх зэрэг нарийн ширийн зүйл дээр ч ажиллав. Төөрсөн хүмүүсийг аврах зорилгоор даллан дуудах алсын харааныхаа төлөө бид эрвийх дэрвийхээрээ зүтгэж байлаа.

Хүмүүс ч янзын догдлоостой. Алсын хараа удирдагч нарын хүрээнээс халин, залуусын цуглааны жирийн гишүүдийн сонорт ч хүрчээ. Залуус маань анхны үдэшлэгтээ хэн, хэнийг урихаа ч товлож эхлэв. Тэгээд “Бурхан итгэдэггүй хүмүүсийн зүрхийг хөндөхөд,

тэд Есүсийг харж, аврагдахын” төлөө залбирч гарчээ. Туслах, бид хоёр Хоёр дахь өдрийн орой бүр 2,500 хүн чихцэлдсэн цуглааны танхимыг төсөөлөх болов. Даруухнаар хэлэхэд, бид алсын хараа, хүсэл тэмүүллээр шатаж байлаа.

## Хэзээ ч мартагдашгүй хурал

Үдэшлэг эхлэхээс хэдхэн долоо хоногийн өмнө би ээлжит долоо хоног тутмын пасторуудын хуралдаа орж ирэхдээ, юу сонсох гэж байгаагаа зүүдлээ ч үгүй юм. Хуралдээр тэргүүн пастор бидний арван нэгэн туслах пасторт: “Эрхмүүд ээ, Ариун Сүнс надад энэ чуулган гэрийн бүлэгтэй байх ёсгүй гэсэн чиглэл өглөө. Тиймээс та бүхэн гишүүдийнхээ гэрт хийж байгаа бүх жижиг бүлгээ цуцлаарай” хэмээн пал хийтэл хэлэв.

Би чихэндээ ч итгэсэнгүй. Ямар нэгэн үл ойлголцол юмуу алдаа гарсан болтой. Туслах, бид хоёрын цочирдсон харц мөргөлдөж, хэн хэн маань ангайв. Тэгээд би “*Пастор залуусын талаар яриагүй байх аа. Зүгээр бусад пасторуудын талаар л ярьсан байх*” гэсэн бодлоор өөрийгөө тайвшруулах гэж оролдов. Ганц бие хүмүүсийн пастор, ахмадуудын пастор, гэр бүлтэй хүмүүсийн пастор зэрэг бусад пасторууд гэрийн бүлэг хийдэг байсан ч, үүндээ нэг их анхаардаг ч үгүй, нэг их амжилт олдог ч үгүй байлаа. Тэдний гэрийн бүлэг ерөнхийдөө “халамжийн бүлэг” шиг л ажилладаг байсан бол, харин манайх чинь Сайн мэдээ тараахаар загварчлагдсан бүлгүүд. Тэгээд ч хэдэн сарын өмнө машины зогсоол дээр намайг санаагаа хэлэхэд, тэргүүн пастор маань: “Үзээд алд!” гэж хэлсэн шүү дээ. Тиймээс би түүний үгд залуусын хэлтэс багтаагүй гэсэн дүгнэлтэд хүрэв.

Тэгснээ тэсэхээ байгаад: “Уучлаарай, пастор аа. Та залуусын үйлчлэлээс бусдынх нь талаар ярьж байгаа биз дээ?” гээд асуугаатлаа.

Пастор над руу харснаа: “Жон, Ариун Сүнс надад энэ чуулган гэрийн бүлэггүй байна гэдэг чиглэл харуулсан” гэж хэлэв.

Тэгэхээр нь би: “Пастор аа, би хэдэн сарын өмнө Луизианагийн залуусын бүлэгт очсоныг та санаж байгаа биз дээ? Тэндхийн залуусын бүлэгт ахлах сургуулийн 1,250 сурагч байдаг. Энэ бүхэн гэрийн бүлгийн л ач тус гэдгийг тэдний дөрвөн пастор дөрвүүлээ хэлсэн” гэлээ.

Тэргүүн пастор нар руу харснаа: “Жон, Ариун Сүнс надад энэ чуулган гэрийн бүлэггүй байна гэдэг чиглэл харуулсан” гэж хэлэв.



Би дотроо “*Пастор ойлгохгүй байна*” хэмээн бачимдан бодоод, арай өндөр дуугаар: “Пастор аа, аврагдаагүй залуу хүмүүсийг чуулганд авчрах хэцүү. Харин үдэшлэгт бол ямар ч сургуулийн сурагчийг ядах юмгүй авчирна. Би аврагдаагүй хүүхдүүдийг аврахын тулд гэрийн бүлэг дээр суурилсан үйлчлэл явуулах гэж байгаагаа хэдэн сарын өмнө танд тайлбарласан” гэж учирлав.

Тэгсэн пастор: “Жон, Ариун Сүнс надад энэ чуулган гэрийн бүлэггүй байна гэдэг чиглэл харуулсан” хэмээн давтлаа.

Миний тэвчээр алдраад: “Пастор аа, бид танхимаа 2,500 хүнээр дүүргэж чадна. Бид Флоридагийн Орландогийн бүх залуус аврагдахыг харж байна!” хэмээн маргалаа.

Гэтэл Пастор нөгөө л үгээ хэлэв.

Би пастортайгаа арван тав орчим минут маргасан байх. Байдал хурцдаж байгаа нь өрөөн дэхь хүмүүст мэдрэгдэж байлаа. Золоор пастор надад гагцхүү Бурхан өөрөөр нь хэлүүлэхийг хүссэн гэдэгт итгэсэн, ганц үгээ л давтаж байсан юм.

Эцэстээ би дуугаа хураасан боловч, дотроо дүрэлзэж байлаа. Тэгээд хурал таран тартал би нэг ч үг сонсолгүй, толгойд минь гагцхүү “*Бид үүн дээр бүтэн найман сар ажилласан. Пастор бидний юу хийж байгааг мэдэж байсан. Би хэдэн сарын өмнө өөрт нь хэлсэн. Хаанчлалд зуу зуун, мянга мянган хүнийг авчирч чадах тэргийг энэ хүн яаж унтрааж чадаж байна аа? Бурханы ажлыг зогсоож байна! Одоо би залуустаа юугаа хэлнэ ээ? Удирдагч нар маань яана аа? Би Луизиана руу ниссэн. Хайран цаг, хайран мөнгө! Арай ч дээ, арай ч дээ!*” гэсэн маш утга төгөлдөр бодлууд исгэрэн эргэлдэж байлаа. Би өөрийнхөө зөв бөгөөд Бурхан миний талд байгаа, харин пастор буруу гэдэгт итгэл төгс байв!

Хурал дуусахад, би конференцын өрөөнөөс шуурсаар гарлаа. Надаас ахмад нэгэн туслах пастор намайг зогсоогоод, цэц ухаан, тэвчээр, тайтгарлын үг хэлэх гэсэн боловч, би түүн рүү хараад: “Фред, би ярьмааргүй байна!” гэж хэлсэн тул тэрбээр нэмэргүй болохыг ойлгоод, гэдрэг ухрав.

Би гэр рүүгээ давхиж явахдаа, тэргүүн пасторыгаа аймшигтай том алдаа гаргаж байгааг батлах түмэн шалтгааныг толгойдоо давтаж явав. Түүний тэр шийдвэрийг бодох тусам, уур улам савсаж байлаа. “*Тэр үдэшлэг хичнээн үр дүнтэй болохыг пастор зүгээр л үл хэрэгсэж байна. Тэр миний хийсэн ажлыг судлаа ч үгүй - ерөөсөө ч мэдэхгүй. Хангалттай судалгаа шинжилгээ хийгээгүй байж, зүгээр л орж*

*ирээд, хүний хийсэн өч төчнөөн хөдөлмөрийг хүчингүй болгодог гэнэ ээ. Тэр чуулганыг - залуусын бүлгийг өсгөдөг хүчин зүйлийг зүгээр л алж байна. Тэр хүмүүсийг авралд хүргэхээс хорьж байна!”* Гэртээ харих урт замд толгойд минь жирэлзсэн үй түмэн бодлын хэсэгхэн нь л энэ. Би эрүүл учир зүйгээр саруул гаргалгаа гаргасан болохоороо хурал дээр гаргасан авиртаа огт харууссангүй.

Гэрийнхээ гадаа ирээд, хаалгаа онгойлготол гэргий минь надтай мэндлэхээр угтсан боловч, би түүнтэй мэндлэлгүй, ууртай дуугаар: “Цаадах чинь юу хийснийг чи төсөөлөх ч үгүй!” гэж хэллээ.

Гэргий маань миний дууны өнгийг сонсоод ихэд зовнисон янзтай: “Хэн, юу хийсэн гэж?” гэж асуулаа.

-“Пастор л байхгүй юу! Тэр гэрийн бүлгийн үдэшлэгийг цуцалчихлаа! Бидний найман сар ажилласан - залуусын бүлгийн зорилгыг маань цуцалчихлаа! Хэлэх ч үг алга!”

Тэгтэл гэргий маань над руу хараад: “Хмм, Бурхан чамд ямар нэг зүйл зааж өгөх гэж байгаа болтой” гэж хэлснээ үүдний өрөөнөөс унтлагын өрөө рүүгээ яваад өгөх нь тэр.

Тэгсэн гэргийдээ шал дургүй хүрээд явчихлаа. “*Ёстой нээрээ ямар ч цэц ухаангүй, сүнслэг мэдрэмжгүй хүн! Яг л манай удирдах пастор шиг юугаа ч мэддэггүй.*” Би унтлагын өрөөний өөдөөс харсан гал тогооны өрөөндөө хуй татуулан ороод, сандал дээрээ хөлөө ачин, цонхоороо харж суугаад, пасторыгаа хичнээн буруу болохыг үргэлжлүүлэн эргэцүүлж гарлаа. Гэхдээ энэ удаа өмнөх бодол дээрээ гэргий маань ямар мэдрэмжгүй, ялгах хараагүй хүн болох талаар нэмж бодов.

## Эзэнтэй уулзсан нь

Тэгээд цонхоор гөлрөн, бодолдоо умбаж байтал, Ариун Сүнс зүрхэнд маань ярив: “*Жон, чи хэний үйлчлэлийг байгуулаад байна? Өөрийнхөө юу, Минийхийг үү?*”

Би Түүнд: “*Таныхыг, Эзэн минь!*” гэж бувтналаа.

Тэгтэл Ариун Сүнс өөдөөс шууд л: “*Үгүй ээ, тийм биш. Чи өөрийнхөө үйлчлэлийг байгуулж байна!*” хэмээв.

Тэгэхээр нь би: “Эзэн минь, бид аврагдаагүй сурагчдыг чуулганд авчирч чаддаггүй... Гэхдээ үдэшлэг дээр бол авчирч чадна” гэж ирээд л, яг л юу ч мэддэггүй хүнтэй ярьж байгаа юм шиг Эзэнд мөнөөх стратеги, учир шалтгааны үйл явцсаа тоочиж гарав. Хүн дэндүү

амархан мэхлэгдэх юм даа!

Эзэн миний үгийг бүгдийг нь сонсож дуусаад: *“Жон, Би чамайг энэ чуулганд авчрахдаа, тэр хүнд даалгасан үйлчлэлийг тэлүүлэхээр, тэр хүнд үйлчлүүлэхээр авчирсан. Би чамайг түүний гар, хөл болгохоор дуудсан. Би үйлчлэлээ нэг л хүнд хариуцуулдаг”* хэмээн айлдав.

Тэгээд Эзэн надад Мосег санууллаа. Библи “Учир нь хожим яригдах ёстой гэрчлэлийн төлөө Мосе үйлчлэгчийн хувьд Түүний бүх гэрт итгэмжит байсан” (Еврей 3:5) гэдэг. Мосе бол чуулганы дээр Бурханы тохоон томилсон удирдагч байв.

Тэгснээ Бурхан надад Шинэ гэрээний Иаковыг сануулав. Иаков Иерусалимын чуулганы удирдагч байв. Бас итгэгчдийн дунд дэгдсэн хөвч хөндөх асуудлыг сануулав (Үйлс 15). Паул, Барнаб, Петр, Иохан тэргүүтэй элч нар, Иерусалимын чуулганы ахлахууд энэ талаар хуралдахаар цугладаг.

Зарим нэг итгэдэг Фарисай удирдагч нар эхлээд үг хэлсэн. Дараа нь Петр ярьсан. Үүний дараа л Паул, Барнаб хоёр Бурхан Харь хүмүүсийн дунд юу хийж байгаа тухай ярьдаг. Тэднийг ярьж дуусахад, Иаков босоод, ярьсан бүх зүйлийг нь базаад: “За, би шийдвэрээ айлтгая...” хэмээн тэргүүнийхээ хувьд айлдвараа хэлэх үед Иаковын шийдвэрт тэнд байсан Петр, Паул, Иохан тэргүүтэй бүх хүн захирагдсан байдаг.

Би бас тэнгэрэлч Петрийг шоронгоос сулласан Бичээсийн үйл явдал дээр энэ динамик гарч байхыг харав. Петр Мариагийн гэрт байсан итгэгч хүмүүст: “Энэ тухай Иаковт болон ах дүү нарт мэдэгд” (Үйлс 12:17) гэсэн. Лук, Паул хоёрын хувьд ч ялгаагүй. Тэднийг Иерусалимд ирэхэд “... ах дүү нар биднийг баяртайгаар хүлээн авлаа. Дараа өдөр нь Паул бидний хамт Иаковын очиход бүх ахлагчид ирсэн байв” (Үйлс 21:17-18) гэж Лук бичсэн байдаг. Энэ хоёр тохиолдол дээр Петр, Паул хоёр яагаад Иаковын тухай ярив? Түүний нэрийг тусад нь дурьдсан нь тэрбээр удирдагч нь байсныг тодорхой илтгэж байна.

Ариун Сүнс энэ санааг ойлгуулсныхаа дараа: *“Жон, чи Надаар томилогдсон энэ чуулганд үйлчилсэн цаг хугацааныхаа төлөө Миний өмнө шүүгдэхдээ, Флоридагийн Орландогийн хичнээн залуусыг авралд авчирснаа тайлагнахгүй. Чи нэн түрүүнд чиний дээр Миний тавьсан пасторт хэр зэрэг итгэмжтэй үйлчилснээрээ шүүгдэнэ”* хэмээн айлдсанаа, намайг мэл гайхуулж, цэл хөхрөөсөн нэг үг хэлэв: *“Үнэндээ чи Орландогийн бүх залуусыг авралд авчирсан байлаа ч, Миний өмнө зогсохдоо, чиний дээр Миний тавьсан пасторт*

*итгэмжтэй хандаагүйнхээ төлөө, захирагдаагүйнхээ төлөө шүүгдэх болно.” Энэ үгээс болж би Эзэнээс цоо шинээр эмээв! Ийнхүү би шалдаа буугаад, Эзэнийхээ өмнө шолхойн унав.*

Эзэн надад: *“Жон, чи энэ янзаараа зүтгээд байвал, залуус чинь нэг зүг рүү, чуулган чинь нөгөө зүг рүү явна. Чи энэ чуулганд хагарал авчирна”* гэлээ. Хагарал, хуваагдал буюу англиар *дивишин* гэдэг үгийн “*ди*” угтвар нь “*хоёр*” гэсэн утга илэрхийлдэг. Угсраад үзбэл, *дивишин* гэдэг үг нь “*хоёр хараа*” гэсэн үг болно! Өнөөдөр яагаад ийм олон чуулган, гэр бүл хагаралдан хуваагдана вэ? Тэнд нэгээс олон хараа оршиж байгаа бөгөөд аль нэг нь Бурханы төлөөний эрх мэдэлд захирагдаагүй хараа ажээ гэсэн үг. Хоёр толгойтой байгууллага хагаралдан бутрах жамтай байдаг учраас л Бурхан тодорхой эрчүүд, удирдагч нарыг гаргаж томилдог!

## **Миний хариу үйлдэл ба хожмын гэмшил**

Би тэрслүү хандлагаа тэр даруй гэмшив. Залбирсныхаа дараа би юу хийх ёстойгоо мэдэж байлаа. Би утсаа аваад, тэргүүн пастор руугаа залгаад: “Пастор аа, би Жон Бивэр байна. Би танаас уучлал гуйх гэсэн юм. Би таны эрх мэдлийн өөдөөс тэрсэлж, том гэм хийснийг Бурхан надад харууллаа. Намайг уучлаарай. Би гэрийн бүлгүүдээ даруй болиулна аа” гэж хэлэв.

Пастор намайг нигүүлсэнгүйгээр уучлав. Тэгээд намайг утсаа тавьмагц, Ариун Сүнс: *“Тэгэхээр, чи энэ тухайгаа долоо хоногийн сүүлээр хорин дөрвөн удирдагчдаа яаж хэлэх үү?”* гэж асуух нь тэр.

Би удирдагч нарынхаа хүлээн суугаа өрөөнд зэвхий царайлж ороод, зэхэр дуугаар: “Найзууд аа, та нарт муу мэдээ дуулгах боллоо” гэж хэлж байгаагаар төсөөллөө.

Тэд ч над руу гурвалжилсан нүдээр хараад: “Яв ийв?” гэцгээнэ.

Тэгэнгүүт нь би нөгөө л бүрхэг дуугаараа: “Бид энэ ажил дээр олон сар ажилласан... даанч пастор бүх гэрийн бүлгийг хаачихлаа! Одоо бид Тав дахь өдрийн оройн үдэшлэгээ хийх боломжгүй болсон” гэж хэлнэ.

Тэгмэгц манайхан бүгдээрээ уулга алдан халаглаж, пасторын шийдвэрийг жигшицгээнэ. Аргагүй шүү дээ, хэн ч тэгнэ. Бид бүгдээрээ тэр хүний золиос болж, харин пасторынхаа өртгөөр би баатар болно.

Нэг иймэрхүү үзэгдэл толгойдоо тоглуулсан шигээ зогсож байтал, Ариун Сүнс над: “*Чи үнэхээр ингэнэ гэж үү?*” гэж хэлэхийг сонсов.

Би Түүнд: “Үгүй ээ, Эрхэм ээ!” гэлээ.

Уулзалтын өдөр би удирдагч нараар дүүрсэн өрөөндөө итгэл дүүрэн, мишээсээр явж ороод, цовоо дуугаар: “Найзууд аа, сайхан мэдээтэй!” гэж зарлав.

Манай хэд ч: “Юу, юу?” гээд л нүд нь гялалзаж, чих нь сойтоогоод ирцгээлээ.

“Бурхан биднийг хүслээс нь гажсан зүйл хийхээс хамгааллаа. Энэ долоо хоногийн ажилчдын хурал дээр тэргүүн пастор маань Ариун Сүнс энэ чуулганд гэрийн бүлэггүй байх чиглэл өгсөн талаар хэллээ. Тиймээс үдэшлэг маань цуцлагдсан!”

Тэд миний баяр хөөрийг хэсэг зуур тунгааснаа: “За мэдлээ!” хэмээн нэгэн дуугаар хашхирцгаасан юм. Ер нь энэ тал дээр бидний дунд ямар ч асуудал үүссэнгүй! Энэ явдлаар дамжуулан би ганцаараа өсөөгүй, бид бүгдээрээ өссөн юм. Яг юу болсныг би тэдэнд хожим ярьж билээ.

Өнөөдөр тэр хорин дөрвөн хүнээс олонх нь бүтэн цагаар маш сайн үйлчилж яваа.

## Эмтэрч, гэмшсэн зүрх

Эргээд бодоход, тэр явдал миний амьдрал үйлчлэлийн шийдвэрлэх цэг байжээ гэдэгт би итгэдэг. Би эмтрэлгүй, харин өөрийнхөө учир шалтгааныг бариад л гөжүүдэлж дайраад байсан бол, өнөөдөр их л өөр газар явж байх байсан байх. Үдэшлэгийн тал дээр - надад сонголт байхгүй учраас, мэдээж цуцлах байсан. Тийм боловч зүрх маань гэдгэр, бардам, хатуу чигээрээ үлдэх байв. Бурхан зөвхөн гадаад дуулгавартай үйлдлийг бус, харин Бурханы хүслээр өлсөж, цангаж, эмтэрч гэмшсэн зүрхийг хүсдэг. Тиймээс л Давид:

Учир нь Та тахилд баярлахгүй.

Тийм бишсэн бол би түүнийг өргөхсөн.

Та шатаалт тахилыг таалахгүй.

Бурханы авах тахил нь эмтэрсэн сүнс юм.

Эмтэрсэн, гэмшсэн зүрхийг Бурхан Та жигшихгүй

(Дуулал 51:16-17) гэжээ.

Та амьдралдаа лут золиос гаргаж, цаг наргүй үйлчилж, хөлс мөнгөгүй хөдөлмөрлөж, нойр хоолгүй гүрэлзэж, олон хүнд хүрэхийн төлөө ажиллах зэрэг хэзээ ч дуусдаггүй зүсэн зүйлийн үйлчлэл хийж болох. Ийм их золиос гаргасан хүн чинь Бурхан өөрийг нь болоод хүчин зүтгэлийг нь таална гэж төсөөлөх нь тодорхой. Тийм боловч энэ бүхний цаад сэдэл маань “хүний амин хүсэл” гэдэг зүйлд залилуулчихсан байж мэдэх.

Сонсогтун: Бурхан биднийг жинхэнэ дуулгавартай сэтгэлээр захирагдаасай гэж хүсдэг. Энэ ном маань ч танд Бурханы эрх мэдэлд захирагдах нь хичнээн чухал болохыг илчлээд зогсохгүй мөн таны дотор дуулгавартайаа захирагддаг хайр, халуун сэтгэлийг бүтээх гэсэн ганц л зорилготой.

Мэдээж дээрх гэрчлэлийн тал дээр танд хариу нэхсэн олон асуулт төрөө байх. Та магадгүй: “Бурхан Өөрөө таныг залбирч байхад, тэр гэрийн бүлгийг хийгээрэй гэсэн гээ биз дээ?” эсвэл “Пастор чинь чуулганыхаа чиглэлийн талаар буруу сонсчихсон байвал, яах уу? Чуулган чинь гэрийн бүлэгтэй илүү дээр байх байсан бол, яах уу? Түүний буруу, таны зөв байсан бол, яах уу? Пастор чинь буруу нөлөөнд орчихсон байсан бол, яах уу?” гэж асуумаар байгаа байх. Бүгдээрээ энэ тэргүүтэй олон асуултад явцдаа хариулна.

Гэхдээ Бурханы төлөөний эрх мэдлийн талаар үргэлжлүүлэн ярихаасаа өмнө эхлээд Бурханы Өөрийнх нь эрх мэдэлд захирагдах ёстойг ойлгож ав. Уочман Нии ингэж бичжээ:

Хүн Бурханы төлөөний эрх мэдэлд захирагдахаасаа өмнө эхлээд Бурханы Өөрийнх нь эрх мэдэлд сөгдөх ёстой. Энэ эрх мэдлийг хүлээж авсан эсэхээс Бурхантай тогтоох хамаг харилцаа шалтгаална. Энэ эрх мэдлийг хүлээж авсан хүн бүх газрын бүх эрх мэдлийг хүлээж авах бөгөөд үүнчлэн Бурханы хил хязгаар дотор байгаа хүн Бурханд зарагдаж эхэлнэ.

Эхлээд Бурханд Өөрт нь захирагдахуйн бат бэх сүнслэг суурийг тавих ёстой. Үүний дараа л Бурханы төлөөний эрх мэдэлд захирагдах талаар яригдана. Энэ нь биднийг сүндэрлүүлэгч бүхний булангийн чулуу болой.







ХЭСЭГ 2



**БУРХАНЫ  
ШУУД ХАМГААЛАЛТ**



## НҮГЛИЙГ ТОДОРХОЙЛБОЛ

*Чуулган нүглийн үндсэн тодорхойлолтоос зайлсхийдэг.  
Бид үүний жинхэнэ утгатай холбогддоггүй.*

**Б**үгдээрээ нэг тоглоом тоглоё. Тоглоом маань нэр усгүй учраас, агуулгаар нь “сэтгэл зүйч, өвчтөн хоёр” гэж нэрлэе. Та бол буйдан дээр налайж суугаа өвчтөн, харин би таны дэргэд сандал дээр шомбойж суугаа сэтгэл зүйч. Намайг үг хэлэхээр, та хамгийн түрүүнд санаанд чинь буусан зүйлийг над хэлнэ. Бэлэн үү? Тэгэхээр: “нүгэл”. Толгойд чинь хамгийн түрүүнд юу бууж байна?

Даян дэлхийн үй олон итгэгч, удирдагч нартай ярилцаж явсан хүнийхээ хувьд, би таны толгойд юу буусныг бараг л мэдэж байна. Та завхай, садар, гаж дон зэрэг аль нэг төрлийн бэлгийн зүй бус явдлын талаар бодсон байх. “Тэр нүгэл үйлджээ” гэдэг эмгэнэлтэй мэдээг би зөндөө сонсдог. Энэ нь голдуу удирдагч хүн сексийн асуудалтай орооцолдсоныг илэрхийлсэн үг. Энэ мэдээг дуулгасан хүн тухайн хүний юу хийснийг тайлбарлах шаардлагагүй. Юун тухай ярьсныг нь би шууд ойлгоно. *Нүгэл* гэхээр чуулганы хүрээнд чухам энэ ойлголт л хамгийн түрүүнд санаанд буудаг.

Эсвэл толгойд чинь архидагч согтуурах юмуу мансуурах явдал гялс хийсэн байх. Итгэгч нар үүнийг яриангүй нүсэр нүгэлд тооцдог. Үгүй бол магадгүй бооцоотой тоглох, аллага, хулгай юмуу илбэ жатга орж ирсэн байх. Байж болох л юм. Гэхдээ та нүглийнхээ ангилалд үзэн ядах,

зөрчилдөх, атаархах юмуу үл уучлах явдлыг оруулсан гэдэг нь юу л бол. Миний бодлоор нилээд өргөн цар хүрээтэй жагсаалт гарч ирэх байх.

## **Үндсэн тодорхойлолттой нь холбогдохгүй байх**

Энэ бүхнийг нарийн тунгаасны дүнд би “Адам Цэцэрлэгт байхдаа танихгүй эмэгтэйг өвөртөө оруулаагүй бас өвс татаагүй шүү дээ!” гэж хэлмээр байна. Тийм атал түүний үйлдсэн нүгэл бүх бүтээлийг хамж хүлээс дор оруулах хэмжээний аюултай байсан. Бид нүглийг тодорхойлохдоо, Адамын нөхцлийг бодолцох хэрэгтэй. Учир нь түүний зөрчлийн мөн чанар хүн төрөлхтний судсаар тархсан шүү дээ. Адам яг юу хийсэн болоод, хүн төрөлхтөнд тийм их гай авчрав? Товчхондоо, Адам Бурханы үгэнд ороогүй.

Энэ талаар бодоод үз. Би дээр дурьдсан зүйлүүдийг нүгэл биш гэж хэлэх гээгүй, харин чуулган нүглийн үндсэн тодорхойлолтоос зайлсхийх болсныг л цохон тэмдэглэж байна. Бид нүглийн жинхэнэ утгатай холбогдохгүй байна. Энэ чухал холбоосыг мэдэхгүй бол, бид хялбархаан урхидуулж болох бөгөөд одоо бид энэ тухай үзэх гэж байна.

Өөр нэг жишээ хэлье. Та хүний биеийн халуун 37 хэмээс давж, ханиалгах, найтайлгах, бөөлжих зэрэг таагүй шинж тэмдэг илэрбэл, тухайн хүн өвчин тусчээ гэдгийг мэдэж болно гэсэн ерөнхий ойлголттой гэж бодъё. 14 настай хайртай эгч маань хорт хавдартай хэмээн оношлуулах үед 7 настай жаалхүү би өвчний талаар иймхэн л ойлголттой байлаа. Эгч маань байн байн эмнэлэг явж, эмнэлэгт удаан хугацаагаар хэвтдэг болов. Ээж маань: “Жонни, эгч нь маш их өвдсөн” гэж л тайлбарласан сан. Гэтэл эгч маань ерөөсөө халуурахгүй, ханиахгүй бас найтаахгүй. Тиймээс би аав, ээж, эгч маань яагаад тэгтэл зовниод байгааг ойлгохгүй байв. Би эгчийгээ зүгээр л маш их ядарчээ л гэж бодсон юм. Би эгчийнхээ өвчнийг өөрийнхөө мэдлэг, туршлагаар л боловсруулж бодсон учраас, өвчин нь хичнээн ноцтой болохыг ойлгож чадаагүй билээ.

Тэгээд нэг өдөр нэгдүгээр ангид байхдаа ангиасаа дуудуулаад, гэртээ хүргүүлж ирээд, том өрөөнд аав, ээжийн маань дэргэд тахилч сууж байхыг харах хүртлээ үүнийг ерөөсөө ойлгож чадаагүй юм. Тэд надад эгчийг маань нас барсан гэж хэлэв. Тэр эгшинд л би эгчийгээ ямар хүнд өвчтэй байсныг ухаарч билээ. Би өвчнийг халуурал, ханиадаар л төсөөлж байсан учраас, эгчийгээ өвчтэй байсан тэр бүх хугацаанд өрнөж байгаа үйл явдалтай нэг ч холбогдож чадаагүй юм. Дараа нь би асуулт тавьж, илүү ухаж түнхэж эхлэв. Тэгээд өвчтэй

## НҮГЛИЙГ ТОДОРХОЙЛБОЛ

хүн гэдэг нь эрүүл мэндээр доройтсон эсвэл өвчин туссан хүнийг хэлдгийг мэддэг болов. Би цаашид өвчнийг халуурал, ханиадаар хэмжихээ больж, өвчний жинхэнэ тодорхойлолтод юу, юу багтдаг болохыг ойлгодог болсон юм.

### Нүглийн жинхэнэ тодорхойлолт

Тэгвэл өнөөдөр чуулганы олон хүн яг ийм байдалтай явж байна. Тэд нүглийн үндсэн ойлголтыг мэддэггүй. Бүгдээрээ цаашаа явахын тулд Бичээс нүглийг юу гэж тодорхойлсон байдгийг харах ёстой. Библи “Нүгэл бол ёс бус юм (Нүгэл бол хуульгүй байдал юм)” (1Иохан 3:4) гэжээ. “Хуульгүй байдлыг” Грекээр *аномиа* гэнэ. Энэ үгийг Тайерийн Грек толь бичигт “Хуулийг үл тоох юмуу эсвэл хуулийг зөрчсөнөөрөө хуульгүй [байх] нөхцөл” хэмээн тодорхойлжээ. Товчхондоо, хуульгүй байдал нь Бурханы хуульд юмуу эрх мэдэлд захирагдахгүй байх явдал ажээ. Вайны толь бичигт “Тухайн ишлэл нь “[Нүгэл] гэдэг үгийн жинхэнэ утгыг гаргаж хэлжээ” гэж мэдэгдсэн байдаг. Тэгээд цааш нь “Нүглийн энэхүү тодорхойлолт нь нүглийн үндсэн мөн чанар нь Бурханы хууль, хүслийг эсэргүүцэж, хүний хүслээр орлуулах явдал болохыг гаргаж хэлжээ” гэсэн байна.

Энэ тодорхойлолтыг бататгахын тулд Есүсийн сургаалт үлгэрийг харцгаая. Тэрбээр хүмүүстэй хоол идэж байтал, нэг хүн “Бурханы хаанчлалд талх идэх хүн бүр ерөөлтэй еэ!” (Лук 14:15) гэж хэлдэг.

Эзэн тэр хүнийг үгийг өлгөж аваад, Хурганы хуримын зоог дээр найрын ширээнд хэн сууж зоог барих талаар айлддаг. Тэгээд “Нэгэн хүн их зоог бэлдэж, олон хүн урьжээ. Тэгээд зоог барих цаг болоход уригдсан хүмүүст боолоо илгээн «Зоог бэлэн болов. Морилон ирцгээнэ үү» гэж хэлүүлжээ” (Лук 14:16-17) гэсэн үгээр яриагаа эхлүүлсэн байна.

Зоог барьж байгаа хүн нь Аавыг төлөөлөх бол, зарц нь Есүс Христ Өөрөө болой. “Зарц” гэсэн ганц тооны үг нь энэ тайлбарт хүргэж байна. Бичээс “Эрт үед эш үзүүлэгчдээр дамжуулан эцэг өвгөдөд олонтаа бас янз бүрийн замаар айлдсан Бурхан эдгээр эцсийн өдрүүдэд бүхний өвлөгчөөр томилсон, ертөнцийг бүтээсэн Хүүгийнхээ дотор бидэнд хандаж хэлэв” (Еврей 1:1-2) хэмээн онцгойлон мэдэгддэг. Есүс бол бидний хэвлэлийн Төлөөлөгч болой. Эдүгээ энэ Шинэ гэрээний цагт номлодог, заадаг, бичдэг хүмүүс нь Эзэний ам мэт ярих тушаалтай

буюу. Тэрбээр бидэнд юу айлдаж байгааг бид анхааралтай сонсож, ягштал дагах ёстой юм.

Дээрх Сургаалт үлгэр дээр Аав хүслээ дууджээ: “Бүх зүйл бэлэн болов. Ирцгээгтүн!” Энэ зарлал нь Сайн мэдээг хэзээ ч сонсоогүй, итгэдэггүй хүмүүст хандсан үг бус, харин хэдийнээ уригдсан хүмүүст буюу чуулганд байгаа хүмүүст зориулагдсан үг юм.

Гэтэл мөнөөх хүмүүс нь “Ир” гэсэн дуудлагыг үл хэрэгсэхийн тулд шалтаг тоочиж эхлэжээ: Нэг нь “Надад тал шил юм, жаахан өвс байна... тэгээд нэг шоу руу явж байна. Тэнд заавал очих хэрэгтэй учраас, ахыгаа ёстой уучлаарай!” гэв.

Хоёр дахь нь: “Би Лас-Вегас руу аялах дээд зэрэглэлийн аяллын эрх хожсон. Дээрээс нь хүүхэндэж, казинод тоглоход таван мянган доллар зарцуулна. Тиймээс ахыгаа ёстой уучлаарай!” гэв.

Гурав дахь нь: “Би туслахдаа дурласан. Тиймээс бид хоёр энэ долоо хоногийн сүүлээр Хавай арлын нэгэн тансаг амралтанд очиж жаргалаа эдэлнэ. Манай хүнд үг алдуузай. Цаадах чинь намайг томилолтоор яваа л гэж бодож байгаа шүү. Тиймээс ахыгаа ёстой уучлаарай!” гэв.

Тэр хүмүүс яг ингэж хэлсэн үү? Библиэ харах юм бол, нилээд өөр үг хэлсэн байгаа. Бүгдээрээ задалж үзье.

Эхнийх нь [зарц] «Би газар худалдаж авсан тул...» гэжээ. Тэгэхээр цаашаа явахаасаа өмнө: “Газар худалдаж авах нь нүгэл үү?” гэж асуумаар байна. Тийм бол, ихэнх маань өнгөрчээ. Газар худалдаж авах нь нүгэл биш юм. Бид үүнийг мэднэ. Түүний юу хэлснийг дахиад харъя: “Би газар худалдаж авсан тул явж, түүнийг үзэх хэрэгтэй байна” (и18). Газар худалдаж авах нь нүгэл биш гэдгийг сая хэлсэн. Гэхдээ эд хөрөнгийн сонирхлоо Бурханы Үгд даруй захирагдах явдлаас дээгүүр тавьбал, нүгэл болоод явчихна. Энэ нь Бурханы эрх мэдэлд захирагдаагүй, хуульгүй явдал болно.

Дараагийн нөхөр нь мэдээж казинод тоглож, хүүхэндэхээр явна гэж хэлээгүй. Тэрбээр: “Би арван үхэр худалдаж авсан юм. Тэднийг үзэхээр явлаа. Уучлахыг гуйя” (и19) гэжээ. Үхэр юмуу аж амьдралаа залгуулахад хэрэгтэй багаж хэрэгсэл худалдаж авах нь нүгэл болж байна уу? Яалаа гэж. Гэхдээ бизнес, аж үйлдвэрлэл нь Бурханы Үгд даруй захирагдах явдлаас чухал болж хувирбал, нүгэл болно! Адам Едений Цэцэрлэгт эр янхан хөлслөөгүй гэдгийг санаарай. Тэр зүгээр л Бурханы Үгэнд ороогүй юм шүү.

## НҮГЛИЙГ ТОДОРХОЙЛБОЛ

Сүүлийн нөхөр нь: “Би эхнэр авсан. Тиймээс очиж амжихгүй” (и20) гэсэн. Эхнэр авах нь нүгэл юм уу? Мэдээж үгүй. Мөн байсан бол, бид ч өнгөрчээ. Гэхдээ хань ижилдээ таалагдах хүсэл нь Бурханы хүсэлд захирагдах явдлаас чухал болбол, нүгэл болж хувирна. Дахиад Еден цэцэрлэгийг санацгаая. Ева мэхлэгдсэн бол (2Коринт 11:3), харин Адамын хувьд байдал өөр байв: “Адам мэхлэгдээгүй” (1Тимот 2:14). Бичээс Адамын нүглийн мөн чанарын тухайд “Учир нь ганц хүний *дуулгаваргүйгээс* болж олон нь нүгэлтэн болсон” (Ром 5:19) гэдэг. Гэргий нь өөрөө идчихээд, дараа нь нөхрөөсөө идэхийг хүсэхэд, Адам түүний хүслийг биелүүлэхдээ, Бурханд дуулгаваргүй авирласан юм. Адам Бурханы эрх мэдлийг дагахаасаа илүүтэй эхнэртээ таалагдахыг хүсчээ. Энэ бол нүгэл. Адамын дуулгаваргүй байдлын гороор “олон нь нүгэлтэн болсон” буюу “олон хүн хуульгүй болж, Бурханы эрх мэдэлд дуулгаваргүй болсон” гэж хэлж болно. Үүнийг л жинхэнэ нүгэл гээд байгаа юм. Хүн хэрхэн Бурханы Үгийг уландаа гишгэлээд, эхнэрээ сонгодгийг Есүс дээрх сургаалт үлгэрийн жишээгээр харуулжээ.

Тэгвэл дээрх боловсон шалтгуудаар бамбайлан, Бурханы эрх мэдэл, Үгд захирагдахаас зайлсхийсэн эрчүүдийн талаар Есүс юу хэлснийг сонсоно уу: “Би та нарт хэлье, уригдсан байсан нөгөө хүмүүсээс нэг нь ч миний зоогноос амсахгүй!” (Лук 14:24) Аймшигтай! Хүндэтгэлтэйгээр уригдаж байсан хүмүүс чинь хуримын зоогтоо орж чадахгүй ажээ. Тэд хормойн явдал, хар тамхи, архидалтаас болж биш, зүгээр л Бурханы Үгийг дагаагүйнхээ төлөө Хурганы хуримын зоогоос хасагдах нь байна. Яагаад бид үүнд гайхах ёстой вэ? Бодоод үзэх юм бол, Адамын дуулгаваргүй зан хүн төрөлхтөн дээр хамгийн аймшигтай хор хөнөөлтэй шийтгэлийг авчраагүй гэж үү?

Дээрх сургаалт үлгэрт хар тамхинд донтох, янхандах, адгийн авирлах, архидах, алах, хулгайлах талаар юу ч дурьдаагүйд гайхахгүй байна уу?

Тийм биш ээ, дурьдсан!

Цааш нь унших юм бол, зарц нь эзэндээ мөнөөх хүмүүсийн бүх шалтаг үгийг дамжуулан айлтгасан. Тэгтэл гэрийн эзэн зарцдаа “Зам, хашаа хавиар явж, гэрийг минь дүүрэн байлгахын тулд хүмүүсийг албадан авчрах” (Лук 14:23) заавар өгчээ. Зам, хашаа хавиарх хүмүүс нь янхан, адгийн амьтад, хулгайч, дээрмийн бүлэглэл, алуурчид, архичид аж! Пөөх, тэгэхээр эд чинь дээрх сургаалт үлгэрт гардаг

байх нь ээ - бүр сайнаар шүү!

Эцсийн өдрүүдэд эдгээр хүмүүсийн олонх нь өөрсдийгөө гай зовлонгоос өөр юу ч үгүй, хов хоосон - ёстой л хадаас руу өшигчихөөс цаашгүй амьдралтай байгаагаа ухаарыхыг Эзэн мэднэ. Тиймээс тэд Эзэний дуудлагыг сонсоод, шууд дагана. Мөнөөх урилга заллага явуулсан ч, ирээгүй чуулганы хүмүүс чинь өөрсдийгөө их л тэнгэрлэг учраас, Бурханы нигүүлсэлд бат багтана гэж бодно. Гэвч гагцхүү дуртай үедээ юмуу цагийн хуваарь, санаархал, ерөөл, таашаалд нь саад болоогүй тохиолдолд л Бурханы Үгийг дагадаг тэдгээр нөхөд Адамтай хамт Бурханы сүр жавхлант нигүүлслээс хашигдана.

### **“За, аав аа!”**

Тэгэхээр Бурханы эрх мэдэлд дуулгаваргүй хандах явдал нь нүглийн жинхэнэ мөн чанар болохыг бид дээрх хуримын зоогийн сургаалт үлгэрээс мэдлээ. Есүс үүнийг өөр нэгэн сургаалт үлгэрээр маш тодорхой гаргаж хэлсэн бөгөөд тэр сургаалаа “Та нар юу гэж бодож байна?” гэсэн асуултаар эхлүүлсэн байдаг. Энэ үгээрээ Есүс гаднаа жигтэйхэн зөвт байдалтай сонсогч нарыг өгөх хариулт руугаа гүн өнгийгөөд, үнэнийг олж хараасай л гэж хүсчээ.

Есүс хоёр хүүтэй хүний талаар өгүүллүүн. Аав нь эхний хүү дээрээ очоод: “Миний хүү, өнөөдөр усан үзмийн талбай дээрээ ажиллаарай” гэж хэлжээ.

Хүү нь: “Чадахгүй” гэж хариулсан боловч, хожим нь санаагаа өөрчлөн, хийж байсан юмаа орхиод, усан үзмийн талбай дээрээ ажилласан.

Тэгтэл аав нь хоёр дахь хүү дээрээ очоод, яг адилхан зүйл хүссэнд, хүү нь: “За, аав аа!” гэж хариулжээ. Аавыгаа хүндэтгэдэг их л сайн хүү шиг. Гэтэл Есүс түүнийг “хэрэг дээрээ очиж ажиллаагүй” гэжээ.

Дараа нь Есүс амин чухал атлаа амархан хариулчихмаар асуулт тавьжээ: “Тэр хоёрын хэн нь Аавынхаа хүслийг биелүүлсэн бэ?”

Түүнийг сонсож байсан хүмүүс бүгд л: “Эхнийх нь!” хэмээн зөв хариулсан.

Тэгтэл Есүс асуудлын голыг нь заагаад: “Үнэнээр Би та нарт хэлье. Татвар хураагчид ба янхнууд та нараас урьтаж Бурханы хаанчлалд орно” (Матай 21:28-31) гэжээ. Тэгэхээр, мэдээж ямар ч аав хүүгээ “За, аав аа!” гэж хэлэхэд дуртай байна. Тэрбээр хүүгийнхээ тушаалд



## НҮГЛИЙГ ТОДОРХОЙЛОЛ

дуулгавартай занд төдийгүй, хүсэлтэй сэтгэлд нь баясна. Тийм боловч нүглийн үндсэн мөн чанар нь Бурханы эрх мэдэлд дуулгаваргүй байх явдал болохыг энэ сургаалт үлгэр тэр удирдагч нарт харуулжээ. Нүгэл нь завхайрал, аллага, хулгай төдийхнөөр хязгаарлагддаггүй юм.

Тэр удирдагч нар өөрсдийнх нь хэлдгээр “адгийн нүгэлтэй” орооцолдоогүйдээ цээж бардам, итгэл дүүрэн байж. Гэвч тэд нүглийн талаарх хязгаарлагдмал ойлголтдоо мэхлэгдэн, мөнөөх хичээнгүйлэн дөлж явдаг нүгэлдээ буюу тэнгэрийн эрх мэдэлд дуулгаваргүй авирлах явдалдаа унасан байв.

### **“Том нүглийн” хувьд яах вэ?**

Библи эхнээсээ дуустал нэг л санааг ахин дахин давтсан байдаг. Та *“Тэгвэл худлаа хэлэх, архи дан согтуурах, завхайрах, хулгайлах, аллага үйлдэх чинь нүгэл биш болж таарч байна уу?”* гэж бодож байгаа байх. Мэдээж мөн! Эдгээр нь Бурханы эрх мэдэлтэй зөрчилдсөн зүйлс мөнөөс мөн. Бурхан Өөрөө бидэнд “Тиймд худал хуурмагийг хойш тавьж, хүн бүр хөршдөө үнэнийг ярь” (Ефес 4:24-25) хэмээн айлдсан шүү дээ. Бас архи дан согтуурах тухайд “Дарсанд бүү согтуур” (Ефес 5:18) гэсэн бол, завхайрах тухайд “Садар самуунаас зугт” (1Коринт 6:18) хэмээн анхааруулсан. Тэгвэл хулгайн тухайд? “Хулгайлсан нь цаашид бүү хулгайл” (Ефес 4:28) гэсэн. Аллагын тухайд “Ах дүүгээ үзэн яддаг бүхэн алуурчин мөн. Ямар ч алуурчны дотор мөнх амь байдаггүйг та нар мэднэ” (1Иохан 3:15) гэж анхааруулдаг. Эдгээрийг үйлдэгч нь Бурханы хаанчлалд орохгүй гэдгийг Шинэ гэрээ цохон тэмдэглэдэг (1Коринт 6:9-11, Галат 5:19-21, Илчлэл 21:8). Тийм боловч зөвхөн “том нүгэл” бус, том, жижиг ялгаагүй - бүх нүгэл сүйрэлд хүргэдгийг бүү мартаарай.

Одоо бүгдээрээ сэтгэл зүйч, өвчтөн хоёрынхоо тоглоом руу эргэж орьё. Нүглийн талаар тодорхой ойлголттой болсон өвчтөн буйдан дээрээ налайсан чигээрээ нүгэл гэдэг нь “Тэнгэрийн эрх мэдэлд захирагдахгүй байх явдал” хэмээн хариулахад бэлэн сууна. Тэрбээр одоо нүгэл, хуульгүй байдал хоёрын холбоог ойлгодог болжээ.

### **Хуульгүй байдлын өдрүүд**

Есүсийн дагалдагч нар Эзэнээсээ эрин цагийн төгсгөлийн талаар асуужээ. Хариуд нь Есүс Өөрийнх нь хоёр дахь ирэлтийн өмнө газар авах нөхцөл байдал, үйл явдлыг тайлбарласан. Тэдгээр нөхцлийн нэг нь “Ес бус явдал өссөнөөс болж олонхын хайр хөрнө. Харин эцсийг хүртэл тэвчсэн нь аврагдах болно” (Матай 24:12-13).

Энэ үг манай өнөөгийн нийгэмд хамаатай эсэх талаар асуухдаа, би баахан өргөөтэй гарууд, дохиотой толгойнуудыг хардаг бөгөөд ихэнх хүмүүс өнөөгийн энэ нийгмийг нүгэлтэй гэж үздэг. Тун цөөхөн хүн л ингэж үзэх нь зөв эсэхэд эргэлздэг. Гэтэл байна шүү - Есүс үнэндээ тэр үгээрээ нийгмийн аж байдлыг дүрслээгүй, харин чуулганыг дүрсэлсэн! Та намайг яаж ийм дүгнэлтэд хүрчихэв хэмээн гайхаж байж магадгүй. Тэгэхээр Есүс нийгмийн өнгө төрхийн талаар бус, чухамхүү чуулганы талаар ярьсныг дээрх ишлэл дэхь хоёр онцгой хэллэг илтгэдэг.

Эхнийх нь “олонхын хайр хөрнө” гэдэг үг. Хайрын Грек нэр нь *агапэ* юм. Грек хэлний мэргэжилтэн Даблю. Ий. Вайн бичихдээ агапэ гэдэг үгийг “Өмнө нууц байсан санааг илэрхийлэхийн төлөө... илчлэлийн Сүнс” хэрэглэсэн гэдэг. Есүс “Бие биеэ хайрлагтун, Би та нарыг яаж хайрласны адил та нар мөн бие биенээ хайрлагтун [*агапао* - энэ нь *агапэ* гэдэг нэр үгийн үйлдэх нэрийн хэлбэр болно] гэсэн шинэ тушаалыг Би та нарт өгч байна” (Иохан 13:34) гэж хэлснийг санаж байна уу? Энэ хайр урьд өмнө хүн төрөлхтнөөс нууцлаг байсан бөгөөд үүнийг Есүс Өөрөө хүн төрөлхтөнд танилцуулжээ. Тэрбээр үүнийг “Би та нарыг хайрласан шиг” гэдэг үгээрээ тодорхойлж байна. Вайн цааш нь: “Энэ хайр нь ямар ч гавъяагүй юманд хандах Төгс Нэгэний тууштай, гүн гүнзгий “хайр”, “сонирхлыг” илэрхийлдэг” гэжээ. Үндсэндээ энэ нь Бурханы болзол тавьдаггүй хайрыг буюу бидний зүрхэнд Ариун Сүнсний (Түүнгүйгээр “дэлхий хүлээн авч чадахгүй” гэж Есүсийн хэлсэн (Ром 5:5; Иохан 14:17)) цутгасан хайрын тухай ярьж байгаа юм. Үндсэндээ энэ хайр нь Есүс Христийг Аврагчаа болгосон хүмүүсийн дотор л оршдог.

Шинэ гэрээнд “хайр” гэж хөрвүүлсэн өөр Грек үгс бас бий. Гэхдээ тэдгээрийг итгэгч хүмүүст ч, итгэгч бус хүмүүст ч хэрэгжүүлж болдог. Тэдний нэг нь *филео* гэдэг үг юм. Даблю. Ий. Вайны хэлснээр: *филео* нь “уярал дотносол” гэсэн утгатай илүү ойр бөгөөд үүгээрээ *агапаогаас* ялгарах ... Хүнд өгсөн Бурханыг хайрла гэдэг тушаалд *филео* гэдэг үгийг хэзээ ч хэрэглээгүй.” Тэгэхээр, энэ үгийг *агапэ* шиг итгэгч хүмүүс дээр байнга хэрэглэдэггүй ажээ.

## НҮГЛИЙГ ТОДОРХОЙЛБОЛ

Есүсийн “Ёс бус явдал өссөнөөс болж олонхын хайр хөрнө” гэсэн мэдэгдэл дээрх хайр гэдэг үг нь Грек дээрээ филое гэдэг үг бус, харин агапэ гэдэг үг байна! Тэгэхээр Есүс үгээ нийгэмд бус, чухам чуулганд хандаж хэлжээ. Тэрбээр эцсийн өдрүүдэд чуулган дотор хуульгүй байдал газар авна гэсэн.

Бид Түүний мэдэгдлийг ойшоохгүй байх эрхгүй. Матайн Сайн мэдээнд: “Намайг “Эзэн минь, Эзэн минь” гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Эцэгийн минь хүслийг үйлдэгч нь л орно” (Матай 7:21) гэсэн мэдэгдэл бий.

Энэ мэдэгдэл нь “хэн аврагдах талаарх” бидний ерөнхий ойлголт, тодорхойлолтыг хүчингүй болгож байна. Бид “нүгэлтний залбирлыг” хэлэхэд л аврагдаж, тэнгэрт эзлэх байр суурь маань баталгаажина гэж заалгасан бөгөөд ингэж ч итгэдэг байсан. Бид Бурханы тушаалыг сахиж, Түүний тушаалд бүрэн зориулагдахыг ойшоодог ч үгүй, цохон тэмдэглэдэг ч үгүй. Гэтэл Бурханы хүслийг *мэдэгдэж, үйлддэг* буюу Бурханы тушаалыг сахидаг хүмүүс л тэнгэрт орохыг Есүс айлджээ.

Жинхэнэ нигүүлсэл биднийг Бурханы шаардлагыг биелүүлэх чадалтай болгодог. Еврей номын бичээч: “Тиймээс бид үл ганхах хаанчлалыг хүлээн авсан тул талархлаа илэрхийлцгээе. Үүгээр хүндлэл, айдас бүхий тааламжит үйлчлэлийг Бурханд өргөх юм” (Еврей 12:28) хэмээн яг онож хэлжээ. Нигүүлсэл биднийг Бурханд таалагдах замаар буюу Түүний хүсэлд нийцсэн замаар үйлчлэх хүчтэй болгодог.

Есүс цааш нь: ““Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшигийг үйлдэж байсан бус уу?” гэх болно” (Матай 7:22) гэжээ.

Энэ Бичээс дээр цөөн биш, харин *олон* гэсэн байна. Түүний өмнөх мэдэгдэл дээрх *олон* гэдэг үгийг санаж байна уу? “Ёс бус явдал өссөнөөс болж олонхын хайр хөрнө.” Үй олон хүн Есүст “Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, чөтгөрийг хөөж, гайхамшиг үйлдсэн биз дээ?” гэнэ. Үл итгэгч хүн Есүсийн нэрээр чөтгөрийг хөөж чадахгүй (Үйлс 19:13-17). Тиймээс Есүс дахиад л чуулганы хүмүүсийн талаар ярьжээ.

Дараа нь Есүс “Христэд итгэдэг” нэртэй хүмүүст: “Би та нарыг танихгүй. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” (Матай 7:23) гэж хэлнэ гэсэн. Тэд *хуульгүй байдлыг* хэрэгжүүлдэг хүмүүс гэдгийг тэмдэглээрэй. Өөрөөр хэлбэл тэд хуримын сургаалт үлгэрт гардаг хүмүүстэй адил амьдралтай ажээ. Тэд санаархал, таашаал,

төлөвлөгөөгөө Эзэнтэнийхээ тушаалаас дээгүүр тавих үлгэр загварыг хөгжүүлжээ. Энэ байдал өнөөдөр хэвийн бөгөөд төрөлх зан үйлдэл шиг харагдах болсон. Энгийнээр хэлбэл, тэд амаараа ярьдаг шигээ амьдрал дээрээ Эзэндээ захирагддаггүй ажээ. Тэд төлөвлөгөөнд нь нийцсэн зүйлсээ л дагадаг. Тэд хуульгүй амьдарч байгаагаа ч мэдэхгүй. Тэгвэл өнөөдөр Христэд итгэдэг нэртэй үй олон хүн яг ийм байдалтай байгаа нь даанч харамсмаар!

Есүс үгээ чуулганд хандаж хэлснийг илтгэх хоёр дахь шалтгаан нь “Эцсээ хүртэл тэссэн нь аврагдана” гэсэн дараагийн үгд оршино. Уралдаанаа дуусгахын тулд эхлүүлэх ёстой. Тэгвэл үл итгэгч хүмүүс Христэд итгэх итгэлийн уралдааныг эхлүүлээгүй юм.

## Мэхлэгдсэн хүний цочрол ба гаслан

Есүс болоод элч нар эцсийн үеийн хүмүүст хандан *мэхлэгдүүзэй* хэмээн ахин дахин анхааруулсан байгааг харж байгаа биз. Хүмүүс гэм нүглийн үндсэн утгыг мэдэхгүйгээсээ болоод бөөн бөөнөөрөө мэхлэгдэнэ. Энэ нь эгч, бид хоёрын түүхтэй л адил юм. Би эгчийгээ хүнд өвдсөн гэдгийг нь огт ойлгоогүй учраас, гэртээ ирээд, эгчийгээ нас барсныг мэдээд, гүн цочирдож билээ. Энэ маань 1980-аад оны сүүлээр надад тохиолдсон нэгэн явдалтай таардаг.

Би залбирч байхдаа, миний амьдрал, үйлчлэлийн замыг өөрчилсөн нэг аймшигтай сүнслэг үзэгдэл үзсэн юм. Би амьдралдаа хэзээ ч харж байгаагүй үй олон хүн далайн ус шиг цалгилж байхыг үзэв. Тэд Эзэнээсээ “Эцэгээр минь ерөөгдөгсөд өө, нааш ир. Ертөнцийн сууриас та нарт бэлтгэсэн хаанчлалыг өвлөн авсугай” (Матай 25:34) гэдэг үгийг сонсохоор тэнгэрийн хаалганы өмнө язганан оволзоно. Гэтэл Эзэнтэн нь тэдэнд: “Хуульгүй явдлыг үйлдэгсэд та нар, Надаас зайл” гэдэг үг айлдав. Тэр хүмүүсийн царайн дээр ямар аймшигтай цочрол, зовлон, айдас тодорсон гэж санана. Тэд Есүсийг “Эзэн” хэмээн дуудаж, өөрсдийгөө “Христэд итгэдэг” гэдэг байсан болохоороо, тэнгэрт орно гэдэгтээ итгэл төгс байжээ. Тийм боловч тэд нүглийн жинхэнэ, үндсэн мөн чанарыг огт мэдээгүй явжээ. Тэд хэдийгээр тэнгэрт орох хувьтай байсан боловч, тэдэнд Аавынхаа хүслийг дуулгавартай дагах хүсэл тэмүүлэл дутжээ.

Бурхан хүүхдүүдээ чин зүрхнээсээ дуулгавартай амьдраасай гэж хүсдэг. Бид амьдралынхаа тал бүр дээр Бурханы хүслийг

дуртайяа биелүүлэх ёстой. Соломон дуулгавартай байхдаа амжилт, дуулгаваргүй байхдаа зовлон хурааж амьдраад, адаг дээрээ “Энэ бүхнийг дүгнээд, сонордуулахад Бурханаас эмээж, Түүний тушаалыг дагагтун. Энэ нь хүн бүхэнд хамаарна” (Номлогчийн үгс 12:13) хэмээн шүүрс алдсан байдаг.

Матай 7:23-аар ишлэл тэр чигээрээ “Тэгэхэд нь Би тэдэнд “Би та нарыг танихгүй. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ” гэжээ. Зарим чинь энд ““Би та нарыг танихгүй” гэж хэлсэн учраас, энэ яавч итгэгч хүмүүст хандсан үг бишдэг ээ” гэх байх. Гэхдээ үл итгэгч хүмүүс Есүсийн нэрээр чөтгөрийг хөөж чадахгүйг мартаагүй биз? Энд нэг зүйлийг мэдэх нь маш чухал шүү. Есүсийн “Би та нарыг танихгүй” гэдэг үгийн “таних” гэдэг үг нь *гноско* хэмээх Грек үг болно. Шинэ гэрээнд энэ үгээр эр, эм хоёрын хоорондын бэлгийн харилцааг дүрсэлдэг (Матай 1:25). Өөрөөр хэлбэл, энэ үг нь маш дотно харилцааг илтгэсэн үг юм. Тэгэхээр, Есүс хэрэг дээрээ “Би та нартай хэзээ ч ойр дотно байгаагүй” гэж л хэлжээ. 1Коринт 8:3 дээр “Хэн Бурханд хайртай байна, тэр Түүгээр танигдсан” гэдэг. *Танигдсан* гэдэг нь мөнөөх л *гноско* гэдэг Грек үг болно. Өөрт нь хайртай хүмүүсийг Бурхан дотно мэднэ. Бурханы эрх мэдэлд захирагдаж, Түүний Үгийг дагадаг хүмүүс л Бурханд жинхэнээсээ хайртай хүмүүс билээ. Есүс “Намайг эс хайрлагч нь үгийг минь сахидаггүй. Та нарын сонсож байгаа үг Минийх биш, харин Намайг илгээсэн Эцэгийнх билээ” (Иохан 14:24) гэсэн болой.

## БҮЛЭГ 4

# ХУУЛЬГҮЙ БАЙДЛЫН НУУЦ ХҮЧ

*Заль мэхийг сөрдөг хамгийн том хамгаалалт нь  
эчнээ мэдлэг бус, илчлэгдсэн мэдлэг болой.*

**Б**ичээст “Эцсийн өдрүүд” гэдэг үг их гардаг. Эдгээр нь хүн төрөлхтний түүхэн дэхь хамгийн хөөрмөөр бас хамгийн аймаар цаг хугацаа байх байх. Бид Бурханы алдрыг өмнөх үеийнхэнийхээ үзэж байгаагүй хэмжээнд үзэж, төсөөлж яваагүй их сүнсний авралын ургац хураана гэдэг утгаараа хөөрмөөр. Энэ нь алдар, баяр хөөр, шүүх, айдсыг зэрэг зэрэг авчирсан цаг байх болно.

Гэтэл нөгөө талаасаа Паул “Эцсийн өдрүүдэд хэцүү цаг ирнэ” (2Тимот 3:1) гэсэн учраас, аймшигтай. Тэрбээр энэ үгээ “*мэдэж ав*” гэдэг үгээр өндөрлөсөн. Өөрөөр хэлбэл, миний одоо хэлэх гэж байгаа үгийг доогуур нь зурж тодруулаад, тогтоож аваарай гэв! Дараа нь Паул энэ зовлонгийн талаар гуравдугаар бүлэг дээрээ нухацтай ярьжээ. Тэр цагийн хамаг аймшиг нь засгийн газар, атеистүүдээс болохгүй ажээ. Тэр цагийн хамаг аймшиг нь чуулган дотор дэлгэрэх *хууран мэхлэлээс* үүдэх аж. Шинэ гэрээ үүнийг ахин дахин анхааруулсан байдаг.

Мэхлэл гэдэг аймшигтай зүйл. Яагаад? Мэхэлдэг учраас тэр! Мэхлэгдсэн хүн өөрийгөө зөв гэдэгт үнэн голоосоо итгэдэг боловч, хэрэг дээрээ шал буруу байдаг. Сайн мэдээний номууд дээр Есүс мэхлэгдэх бий хэмээн байнга анхааруулдаг. Матай 24 дээр л гэхэд, мэхлэгдэх талаар дөрвөнтөө анхааруулсан. Дагалдагч нар нь Түүнийг эргэж ирэх талаар

лавлах үед Есүс хамгийн түрүүнд: “Хэн нэг нь та нарыг төөрөлдүүлэх вий, болгоомжил” (Матай 24:4) гэсэн байдаг. Есүс хэр ноцтой өнгө аясаар хэлсэн нь шууд л мэдрэгдэж байна. Есүс энэ үгээ дагалдагч нарынхаа сэтгэлд үеийн үед хадахыг хүсчээ. Есүсийн үг мянга мянган жил тогтсоор ирсэн тул Түүний зөвлөгөөг сонсох нь бидэнд л өлзийтэй.

### Хоёр чухал асуулт

Бид хоёр чухал зүйлийг асуух ёстой. Нэгдүгээрт - мэхлэл юунаас үүддэг вэ? Хоёрдугаарт - мэхлэл яаж сэм явсаар, санаандаа хүрдэг вэ? Эхний асуултад хариулахад, мэхлэлийн үндсэн үүдэл нь өмнөх бүлэгт үзсэн тэнгэрлэг эрх мэдэлд дуулгаваргүй байх явдал буюу хуульгүй байдал юм. Бидэнд:

Өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид байг (Иаков 1:22) хэмээн анхааруулжээ.

Аймаар! Хүн Бурханы Үгийг *сонсоод, үл дагах юм бол*, зүрх тархинд нь мэхлэл нэвтэрдэг байх нь. Тийнхүү эдүгээ тэр хүн өөрийгөө зөв явж байна хэмээн бодох боловч, хэрэг дээрээ буруу явж байдаг. Тэрбээр үнэнийг худлаар сольжээ. Бурханы эрх мэдэл, Үгд жинхэнээсээ захирагдахгүй байвал, айхтар аюултай атлаа уран нарийн заль мэх нэвтрэн орж ирнэ.

Тэгвэл эцсийн өдрүүдэд яагаад мэхлэл газар авах вэ? “Аврагдах үнэний хайраас татгалзсан” (2Тесалоник 2:10) тул олон хүн мэхлэгдэнэ гэдгийг Паул хэлжээ. “Үнэнийг хүлээн аваагүйгээс” бус, харин “Үнэнийг хайрлаагүйгээс” болж мэхлэл гаарна гэж хэлсэн байгаа нь сонирхолтой. Үнэнийг хайрлана гэдэг нь үнэнийг сонсоод баясахаасаа илүү үнэнийг дуулгавартай дагах явдал юм. Бурхан эш зүүлэгчдээ:

“Хүний хүү чиний хувьд, хэрмийн дэргэд, гэрүүдийн үүдэнд чиний тухай ярилцаж, өөр зуураа ах дүүтэйгээ хэлэлцдэг танай нутгийнхан “Одоо ирэгтүн, ЭЗЭНээс ямар үг гарахыг сонс” гэж хэлж байна. Ард түмэн ирж байгаа мэт тэд чам уруу ирж, Миний ард түмэн адил чиний өмнө сууж, үгийг чинь сонсох боловч тэд түүнийг үйлдэхгүй. Учир нь амаараа тэд таалалт юмсыг үйлдэвч зүрх нь олз ашгийнхаа араас явдаг” (Езекиел 33:30-31) хэмээн айлдсан.

Чуулганд явдаг олон хүн сайн номлол, сургаалд дуртай ч, амьдрал дээрээ Бурханы Үгийг дагахаасаа илүү өөрийнхөө арга замаар явах дуртай байдаг (2Тимот 3:1-4). Бид үнэнийг хэнээс ч, юунаас ч илүү хайрлах ёстой. Бид Бурханы хүслийг өөрийнхөө тав тух, амьдралаас дээгүүр тавих ёстой. Тэр цагт л бид Түүний хүслийн төлөө хувийнхаа хүслийг дуртайяа хойш тавьдаг болно. Бид Бурханы хүслийг биелүүлэхийн төлөө хувийнхаа эрх, завшааныг няцааж, загалмайгаа авдаг болно. Яагаад? Яагаад гэвэл Тэр бидний Бурхан, Бүтээгч, Авран сэргээгч бөгөөд биднийг төгс хайраар хайрладаг юм. Энэ үнэн л биднийг мэхлэлээс хангалттай сэргийлнэ.

## Хуульгүй байдлын нууц хүч

Өнөөдөр яагаад хуульгүй байдал газар авахыг ойлгохын тулд харгалзаж үзэх ёстой өөр нэгэн хүчин зүйл байна аа. 2Тесалоник 2:7 дээр бидэнд: “Учир нь ёс бусын нууц нь хэдийнээ ажиллаж байна” хэмээн анхааруулжээ. “Хуульгүй байдал” гэж орчуулсан үг нь өмнөх бүлэгт гарсан мөнөөх *аномиа* гэдэг Грек үг юм. Үүнийг Нью Кинг Жэймс Вержн дээр “хуульгүй байдлын нууц” гэдэг. Тэр нууц нь үүний нууц хүчинд нуугдаатай байдаг. Хуульгүй байдал нь итгэгч нарын хувьд улайм цайм биш, харин маш уран нарийн зальтай байж байж л үр нөлөөтэй ажиллана. Энэ бол нууц юм. Бурхан биднийг энэ нууцлал, нууц хүчийг мэдээсэй гэж хүссэндээ л, энэ талаар анхааруулдаг билээ (2Коринт 2:11).

Сатан бол заль мэхийн мастер. Сатан тэнгэрэлч нарын гуравны нэгийг Бурханы өөдөөс босгож чадсан (Илчлэл 12:3-4) гэдгийг л сана. Энэ бүхэн алдарт Эзэний оршихуйд буюу төгс орчинд болсон шүү дээ! Сатан бол мэхлэгч төдийгүй, мэхлэгчдийн эцэг гэдгийг Есүс анхааруулсан (Иохан 8:44). Түүнчлэн Сатаны төөрөгдүүлэл, мэхлэл нь эцсийн өдрүүдэд гаарахын дээдээр гаарч, сонгогдсон хүмүүс ч хүртэл тэр урхинд нь унаж тусна гэдгийг анхааруулсан (Матай 24:24).

Бид яагаад гайхах ёстой гэж? Тэр чинь тэнгэрийн сая, сая тэнгэрэлч нарыг төөрөгдүүлж чадсан бол, газар дээрх үй олныг төөрөлдүүлэх тийм хэцүү гэж үү? Түүнийг чинь “агаарын хүчний ноёрхогч” (Ефес 2:2) гэдэггүй билүү? Бид чинь Есүсийн өгүүлсэн тэр эцсийн өдрүүдэд нь аж төрж байгаа учраас, Коринтын чуулганд хандсан Паулын үнэн сэтгэлийн гуйлгыг анхааралтай шалгана уу:



## ХУУЛЬГҮЙ БАЙДЛЫН НУУЦ ХҮЧ

Могой залиараа Еваг мэхэлсэн шигээ Христ дор [цэвэр] эгэл байдлаас чинь та нарын санаа бодлыг төөрүүлчих вий гэхээс би харин айж байна (2Коринт 11:3).

Итгэгч хүмүүсийн эмзэг, гэнэн байдлыг Паул Евагийн төөрөгдлөөр жишжээ. Еваг дөнгөж чадсан явдал нь Диаволын баатарлаг гавьяа мөнөөс мөн. Ева төгс ахуй орчинд чөтгөрийн захиргаа, нөлөөнөөс ангид аж төрж байсан. Тэрбээр Бурханы Өөрийнх нь дэргэд, махан биеийн тэмцэлгүй алхалж байсан. Ева хүчирхийлэл гэдгийг нэгээхэн ч мэдэхгүй: хүчин, хулгайд юмаа алдах, хов живд өртөх, хатуу чангыг үзэх гэх мэт дэлхий дээр байдаг л юмс түүнд хэзээ ч тохиолдоогүй. Түүнийг тэрслэхэд хүргэсэн арга нь Сатаны хамгийн уран нарийн схем байсан байх. Сатан Евагийн цэвэр ариун оюуныг завхруулахын тулд хамгийн л уран нарийн, башир аргаа хэрэглэсэн байх. Бид Ева дээр хэрэглэсэн Сатаны арга барилыг ойлгох аваас, түүний шилдэг зэвсгийг илрүүлж, биднийг мэхэлдэг арга ухааныг нь ойлгож, яагаад өнөөдөр үй олон хүн түүний дуулгаваргүй байдалд унаад байгааг нь ухаарна.

Ева мэхлэгдсэнийхээ улмаас дуулгаваргүй авирласан бол, Адам юу хийж байгаагаа мэдэхийн дээдээр мэдэж байсныг саная. Чуулганы хүмүүс юу хийж байгаагаа мэдэхийн дээдээр мэдэж, хараатай чигээрээ Бурханы тушаалыг зөрчихийг би харсан. Тэд мэхлэгдээгүй. Тэд аминд халтай нутаг дэвсгэрээр тэнэж, сүнсний мөхөл рүүгээ зорчдог (Ром 8:13). Тэдний хатуурсан зүрхийг хөндөх хэцүү. Гэтэл бас өөр маягийн хүмүүс байх. Тэд бол чуулган доторх дуулгавартай явдлын дийлэнх хувийг төлөөлдөг *мэхлэгдсэн хүмүүс* юм. Евагийн адил хайхрамжгүй явдал нь тэднийг мэхлэлд буюу хуульгүй байдлын нууц хүчинд нээж өгчээ.

Хайхрамжгүй явдал нь мэхлэлийг үржүүлэгч хөрс болдог. Бурхан: “Ард түмэнд минь мэдлэг дутсанаас болж тэд цөлөгдөн хүндэт хүмүүс нь өлсөж, олон түмэн нь цангаж зовно” (Исаиа 5:13) хэмээн айлдсан буюу. Бурханы арга зам, сүнсний хуулийн илчлэгдсэн мэдлэг нь биднийг дайсны мэхлэлээс хамгаалдаг. Бурханы үнэний гэрэл ямарваа худлыг ил болгож, биднийг хамгаалдаг.

## Илчлэл ба эчнээ мэдлэг

Бурхан хүнийг Цэцэрлэгт тавиад: “Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг идэж болно. Харин сайн мууг мэдүүлэгч модны жимснээс

идэж болохгүй. Түүнээс идсэн тэр өдөртөө л чи зайлшгүй үхнэ!” (Эхлэл 2:16-17) хэмээн айлджээ.

Үүний дараа Эзэн эмэгтэйг эрэгтэйгээс гаргаж авсан. Энэ хоёр үйл явдлын хооронд нилээд хугацаа өнгөрсөн байх. Учир нь эмэгтэй хүн эр хүнээс бий болохоос өмнө эр хүн газрын ан амьтад, тэнгэрийн шувуудыг бүгдийг нь нэрлэсэн байдаг.

Адамаас ялгаатай нь Ева тэр тушаалыг шууд Бурханы амаас сонсоогүй. Адам эхнэртэйгээ Бурханы цэцэрлэгт жаргалаа эдлэж байхдаа, магадгүй тэр талаар ярьсан л байх. Үүнийг нь бид могойд хэлсэн эмэгтэйн хариултаас ажигладаг. Дараах ишлэлийг анхааралтай уншина уу:

ЭЗЭН Бурханы буй болгосон хээрийн хамаг амьтдаас хамгийн ов мэхтэй нь болох могой, эмэгтэйд —Энэ цэцэрлэгт байгаа аль ч модноос идэж болохгүй гэж та нарт Бурхан үнэхээр хэлсэн үү? гэжээ. Тэр эмэгтэй, могойд —Бид энэ цэцэрлэг дэх моддын жимсийг идэж болно оо. Харин цэцэрлэгийн голд байгаа модны жимсний тухайд Бурхан “Та нар түүнээс бүү ид бас түүнд бүү хүр, эс бөгөөс та нар үхнэ” гэж айлдсан гэхэд... (Эхлэл 3:1-3).

Нэгдүгээрт - могой Бурханы тушаалыг лавлах үед эмэгтэй: “Бурхан... гэж хэлсэн” гэхийн оронд “... идэж болно оо” гэж хариулсныг тэмдэглээрэй. Энэ бол аливаа тушаал, дүрмийг дам сонссон хүний сонгодог хариулт. Энэ бол тушаалыг өгсөн Нэгэний зүрхний цохилт, сэдлийг тээсэн хүний хариулт яав ч биш.

Хоёрдугаарт - Евагийн хариулт Бурханы анхдагч тушаалаас өөр байгааг анхаараарай. Ева: “Бурхан “Та нар түүнээс бүү ид бас түүнд бүү хүр, эс бөгөөс та нар үхнэ” гэж айлдсан” гэдэг үгийг нэмж хэлжээ. Бурхан хүрч хөндөх талаар хэзээ ч, юу ч айлдаагүй. Бодоод үз: Адам, Ева хоёр түмэн мододтой, уудам цэцэрлэгээр зугаалсаар, нэгэн модны дэргэд иртэл Адам: “Хонгор минь, бид энэ модонд хүрч болохгүй” гэж хэлсэн байх. Бурхан энэ талаар ямар санаатай байгааг Адам мэдэж байсан бол, Ева мэдээгүй. Тиймээс магадгүй Адамын зүйрлэж ярьсныг нь Ева шууд утгаар нь хүлээгээд авчихсан байх. Эзэнээс Өөрөөс нь шууд хүлээж авалгүй, хүнээс дамаа сонсох үед юу болдгийн сонгодог жишээ энэ байна.

Бурханы Сүнс, Үгээс илчлэл болгон хүлээж авсан зүйл нь бидний нэгээхэн хэсэг болдог. Ном унших, сургаал сонсох, бие дааж Библи унших юмуу эсвэл Бурханы Сүнстэй харилцаж байх үед илчлэл ирдэг. Адамын хувьд Бурханы тушаал нь түүний эргэн тойрон дахь бүх зүйл

шиг бодитой байж, өөрийнх нь нэгээхэн хэсэг болжээ. Тонгоруулж хэлбэл, бид Бурханы тушаалыг сонсов ч, энэ нь Түүний Сүнсээр илчлэгдээгүй л бол, бидний нэгээхэн хэсэг болж чадахгүй. Энэ нь бидний хувьд зүгээр л хууль болох бөгөөд харин “хууль нь нүглийн хүч юм” (1Коринт 15:56).

Тэр ямар учиртай мод болох талаар Ева Бурханаас Өөрөөс нь лавлаагүй гэвэл онох байх. Ева Адамаас ирсэн мэдээллийг л “тэр чигээр” нь хүлээгээд авчихжээ. Гэтэл энэ нь Евагийн хувьд илчлэгдсэн мэдлэг бус, эчнээ мэдлэг байв. Хүнээс дам сонссон үг нь Еваг мэхлэлд өртөмхий болгожээ. Энэ шалтгаанаар л могой Адамыг бус, Еваг онилсон байж.

Заль мэхийг сөрдөг хамгийн том хамгаалалт нь эчнээ мэдлэг бус, илчлэгдсэн мэдлэг болой. Олон хүн Бичээсийн мэдлэг, заавар юмуу хязгаарлалтыг сонсоод, хуульчлалын хүлээсэнд ордог. Тэд аав ээж, Библийн багш нар, подкаст, олон нийтийн сүлжээ юмуу номноос хүлээж авсан юмсынхаа талаар Бурханы Өөрийнх нь зүрх сэтгэлийг мэдэхээр эрэлхийлдэггүй. Гэтэл угтаа энэ нь л тэдэнд мэхлэлээс хамгаалагдах ойлголтыг хайрлах буюу. Тэд ямар ч зүрхний цохилтгүй үсгийг л тээнэ. Тэд бүлэг, ишлэлийг “аа, бээгүй” давтан эшлэв ч, Бичээсийн цөмд орших тэр л амин амьсгалыг нь л гээчихдэг.

Тэр бүү хэл тэд дөнгөж сая семинар, конференц дээр сонссон шинэ сургаалаа гал цогтой хуваалцаж ч болох. Тийм атал бусадтай тэгтэл хөөрөн хуваалцсан зүйлээ амьдруулж үл чадна. Энэ нь тэдний нэгээхэн хэсэг болдоггүй. Тэд үгийг тээв ч, Бурханы амийг бүтээх чадваргүй бөгөөд үржилгүй байдаг. Ийм нөхцөлд Бурханы айлдсан дээр нэмэх юмуу хасах өдөөлт их бий. Тэд Бурханы арга замын талаар ойлголт дутмаг учраас хялбархан мэхлүүлдэг.

Жишээлбэл “Ах дүүс минь, мөнгө чинь хамаг л ёрын муугийн үндэс!” гэж ярихыг би олонтаа сонсдог. Гэтэл Бурхан ингэж хэлээгүй. Бурхан “Мөнгөнд *дурлах* нь хамаг муугийн үндэс мөн” (1Тимот 6:10) гэж л хэлсэн.

Мөнгө хамаг л ёрын муугийн үндэс юм бол, няравтай бас мөнгөний ууттай байсан Есүс тушаал зөрчсөн болж таарна! Нэгэн эмэгтэй хүний бүтэн жилийн цалинтай дүйцэх үнэтэй, шил дүүрэн тосыг хагалаад, Есүс дээр цутгадаг. Гэтэл мөнгөнд дуртай Иудас эмэгтэйн үйлдэлд эгдүүцэхэд, Эзэн Иудасыг зэмлээд, эмэгтэйг сайшаасан (Иохан 12:3-7).

Үгүй юм. Мөнгө биш, харин мөнгийг хайрлах хайр л хамаг муугийн үндэс юм. Энэ нь мөнгөнд найдах эрүүл бус хүсэл ажээ. Энэ

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

хуульчилсан үзэл бодол нь хүмүүсийг мөнгөнд эрүүл бус ухаанаар хандахад хүргэдэг бөгөөд Бурхан ийм зүйлийг ердөө ч хүсдэггүй. Тиймээс тэр хүмүүс санхүүгийн талбар дээр хэзээ ч бурханлаг зан байдлаар ажиллаж чаддаггүй. Энэ хайхрамжгүй байдал нь тэдний зүрхэнд Бурханы Үг ичлэгдээгүй болохыг л батална. Тэдэнд Бурханы Үгийн эчнээ мэдлэг л байх бөгөөд тэд мэхлэлд ороогдох хамгийн боломжтой нэр дэвшигчид ажээ.

Тэгэхээр бид илчлэгдсэн мэдлэгийг хэрхэн хүлээж авах вэ? Бурханы өмнө Бурханы хайр, Бурханаас эмээх эмээхүйгээр бадарсан зүрхтэй явснаараа.

Энэ бүх юмсыг Миний мутар бүтээсэн бөгөөд  
Энэ бүхэн байдаг болжээ” гэж ЭЗЭН тунхаглав.  
“Харин даруу, гэмшсэн сэтгэлтэй,  
Үгэнд минь чичирдэг нэгнийг л Би анхаарна (Исаиа 66:2).

Бурханы Үгд чичирдэг хүн ашигтай байна уу, ашиггүй байна уу хамаагүй - Бурханыг үг дуугүй дагана. Тэрбээр Бурханаас жинхэнээсээ эмээнэ. Тийнхүү Бичээс “ЭЗЭНий андлал Өөрөөс нь эмээгчидтэй хамт байдаг. Тэр тэдэнд гэрээгээ мэдүүлнэ” (Дуулал 25:14) гэдэг.

Тэгэхээр бид амьдралынхаа адаг дээр: “Энэ бүхнийг дүгнээд, сонордуулахад Бурханаас эмээж, Түүний тушаалыг дагагтун. Энэ нь хүн бүхэнд хамаарна” (Номлогчийн үгс 12:13) гэсэн Соломоны үгийг илүү ойлгодог боллоо. Бурхан Өөрөөс нь эмээдэг хүмүүст нууцуудаа, арга замуудаа илчилдэг бөгөөд Иохан дараах бүлэг хүмүүст:

Та нарыг мэхлэх хүмүүсийн талаар үүнийг би та нарт бичсэн. Та нарын Түүнээс авсан тосолгоо нь та нарын дотор байдаг бөгөөд өөрсдөд чинь заах хэн нэгэн та нарт хэрэггүй. Харин Түүний тосолгоо нь та нарт бүхнийг заадаг бөгөөд тэрхүү тосолгоо нь худал биш, үнэн. Та нарт заасан ёсоор та нар Түүний дотор байгтун (1Иохан 2:26-27) гэж хэлжээ.

Энэ нь Бурханы илчлэгдсэн Үг биднийг заль мэхээс хамгаалдгийг л хэлж байна. Бурханы илчлэгдсэн мэдлэгээр гачигдсан Ева мэхлэгдэж, дуулгаваргүй загнахад хүрсэн. Тиймээс тэрбээр могойн үгийн цаад завхрал, зангыг гадарлаагүй.

## Могой хэрхэн дөнгөв?

Бүгдээрээ дараагийнхаа асуултын хариуд орцгооё: Могой эмэгтэйг хэрхэн дөнгөв? Тэр ямар далд схемээр довтлов? Үүний хариултыг олж мэдэх нь чухал. Бодоод үз: Могой яаж эмэгтэйг залилж дөнгөв? Ева туйлаас төгс төгөлдөр орчинд аж төрж байсан. Тэрбээр аавдаа, даргадаа, үйлчлүүлэгчид дарамтлуулж үзээгүй. Тэр чөтгөрийн дарлалгүй, хөгжин цэцэглэсэн цэцэрлэгт амьдарч байв. Тэрбээр Бурханы сайн сайхан, хангамжийг л мэднэ. Тэрбээр Бурханы оршихуйд алхалж амьдарч байв. Тэгвэл могой түүнийг яаж дөнгөв?

Бурхан: “Чи энэ цэцэрлэгийн аль ч модны жимсийг идэж болно. Харин сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идэж болохгүй. Түүнээс идсэн тэр өдөртөө л чи зайлшгүй үхнэ!” (Эхлэл 2:16-17) хэмээн тушаасныг санаж байна уу?

Бурхан: “...идэж болно” хэмээн сайн сайхнаа чөлөөтэй зөвшөөрсөн боловч, бүрэн эрхийнхээ дагуу: “Харин сайн мууг мэдүүлэгч модны жимснээс идэж болохгүй” хэмээн хориг тавьжээ. Бурхан тэдэнд нэгээс бусад бүх модноос чөлөөтэй идэхийг зөвшөөрсөн байна.

Хайрлаж, өгөх нь Бурханы амин мөн чанар болой. Бурхан Цэцэрлэгт Өөртэй нь харилцаа тогтоож, харилцаандаа үнэнч байх анд нөхөртэй байхыг л хүссэн. Бурхан ямар ч эрх чөлөөгүй роботуудыг хүсээгүй. Бурхан Өөрийнх нь дүр төрхөөр бүтээгдсэн, чөлөөт хүсэлтэй хүүхдүүдийг хүссэн. Бурхан хүмүүст модонд хүрэхийг хориглохдоо, өөрсдийг нь үхлээс хамгаалагч Түүнтэй тогтоосон харилцаандаа үнэнч байх уу, үгүй юу гэдэг сонголтыг нь хүмүүст олгосон юм. Хүмүүсийн хүсэл энэ сонголтонд нь чухал үүрэг гүйцэтгэж байв. Тэд найдаж, дагах болов уу? Тушаал үгүй бол, сонголт үгүй байх байв.

Могойн үгийг анхааралтай шинжинэ үү: “ЭЗЭН Бурханы буй болгосон хээрийн хамаг амьтдаас хамгийн ов мэхтэй нь болох могой, эмэгтэйд — Энэ цэцэрлэгт байгаа аль ч модноос идэж болохгүй гэж та нарт Бурхан үнэхээр хэлсэн үү? гэжээ (Эхлэл 3:1). Одоогийнхоор бол могой: “Бурхан та нарыг бүх модноос идэж болохгүй гэсэн гэв үү? Тэр үнэн үү?” гэжээ.

Могой Бурханы тушаалын голыг самардах маягаар стратегиэ эхлүүлжээ. Тэрбээр тушаалын утгыг мушгин гуйвуулснаараа Бурханы сэдэлд эргэлзүүлжээ. Могой Еваг сугадаад, эцсийн дүнд Бурханы сайн сайхан, шударга чанарт эргэлзэхэд хүргэх учир шалтгааны

гаргалгааны замаар дагуулан уруудуулжээ.

Чадсан тохиолдолд Еваг Бурханы эрх мэдлээс эргүүлэх амархан болох байв. Могой Бурханы өгөөмөр чанарыг үл хэрэгсэн, Түүнийг хоригийг чичлээд, Бурхан тэднээс ямар нэгэн сайн зүйлийг нуужээ гэсэн санааг дэвшүүлжээ.

Могой ганцхан асуултаараа л хүмүүсийг хамгаалахын төлөө өгөгдсөн тушаалыг сайныг нуун дарагдуулсан, шударга бус явдал болгон завхруулжээ. “Тэгэхээр, Бурхан та нарыг бүх модноос идэж болохгүй гэсэн гэв үү?” гэдэг асуултынх нь цаад ёжлолыг сонсож байна уу? Тэд цэцэрлэгийн хаа хүссэн газраасаа идэж болох байтал, могой Евагийн анхаарлыг хориотой ганц модонд л хандуулжээ. Могой Бурханыг “өгөгч” биш, “авагч” болгон харагдуулжээ.

Могой Эзэнийг шударга бус нэгэн болгож харагдуулахдаа, Бурханы эзэмшил рүү дайрах гарцтай болж авав. Сатан тэнэг биш. Сатан Эзэний эрх мэдлийн яг суурийг нь оносон: “Зөвт байдал ба шударга ёс Түүний сэнтийн суурь болой” (Дуулал 97:2). Бурханы сэнтий Бурханы эрх мэдлийг төлөөлдөг. Сатан заль мэхээрээ Бурханы зөвт чанарыг завхруулан бусниулахад, бүтээл нь Бүтээгчийнхээ эрх мэдлийн суурийг эргэлзээтэй нүдээр харж эхлэх байв.

Эмэгтэй могойд хариулахдаа, үгийг нь залруулжээ: “Бид энэ цэцэрлэг дэх моддын жимсийг идэж болно оо. Харин цэцэрлэгийн голд байгаа модны жимсний тухайд Бурхан “Та нар түүнээс бүү ид бас түүнд бүү хүр, эс бөгөөс та нар үхнэ” гэж айлдсан. (Эхлэл 3:2-3)

Эмэгтэй могойд хариулж байхдаа, тушаалын цаад шалтгааны талаар гайхширсан байж мэдэх. Тэрбээр одоо тэр модон дээр л төвлөрч, Бурханы сайн сайханд эргэлзжээ. Түүнд юу гэж бодогдсоныг төсөөлж байна уу? “Энэ мод сайхан харагдаж байна шүү. Бид яагаад үүнээс идэж болдоггүй юм бол? Ямар хор хохирол учрах юм бол? Бидэнд ямар хортой юм бол?” Ийнхүү Бурханы санаа сэдэлд эргэлзэж эхэлсэн эмэгтэй Бурханы эрх мэдэлд ч эргэлзэж эхлэв.

Могой Бурханы эрх мэдэл, үнэнч чанар, шударга чанарыг дорд үзэх боломжийг өлгөж аваад: “Та нар ерөөсөө үхэхгүй. Та нар түүнээс идсэн тэр өдөртөө л нүд чинь нээгдэн, Бурхан шиг болж, сайн мууг мэдэх болно гэдгийг Бурхан мэдэж байгаа” гэжээ. (Эхлэл 3:4-5)

Заль мэхийн мастер Сатан Бурханы үгийг улайм цайм сөрөн, Еваг үхэхгүй хэмээн батлан гөрдөхдөө, эмэгтэйн үнэнч зангийн амин суурийг л нураахыг санаархжээ. Тиймээс араас нь тэр даруй: “Үхэх нь байтугай,

та нар Бурхантай улам адилхан болно. Та нар ухаажих учраас өөрсдөө сайн, мууг сонгож мэддэг болно. Та нар бусдаас дам үг сонсох юмуу аль нэг шударга бус тушаалд захирагдах шаардлагагүй болно” гэжээ.

### Нүгэл үйлдэгдмэгц - боолчлол дагалдана

Ева цочирдож, эргэлзээд: *“Бурхан яахаараа энэ үр жимсийг надаас нуудаг билээ?”* хэмээн гайхширчээ. Тэгээд мөнөөх модыг тэс өөр нүдээр дахин нэг харж, үр жимсийг нь дахин нэг шинжихдээ, үр жимс нь аюултай, муу бус, харин ч таатай, сайхан хэмээн дүгнээд: *“Идэхэд ч сайхан, хамгийн гол нь биднийг ухаантай болгох!”* хэмээн бодож.

Эргэцүүлэл нь Еваг орчин тойрондоо таг сохор болгожээ. Тэрбээр ганц тэр модон дээр төвлөрөхдөө, Бурханы хангаж өгсөн бусад элбэг хангамжийг умартав. Эмэгтэй: *“Энэ модонд бидэнд хэрэгтэй сайн сайхан зүйл байх. Гэтэл Бурхан биднээс нуужээ. Үүний үр жимс нь гагцхүү биднийх болж болох байж. Бурхан юунд бидэнд ингэж хандана? Тэр биднээс энэ модны сайн сайхныг нуусан бол, өөр нууж хаасан олон зүйл байж л байгаа”* хэмээн элдвийг эргэцүүлнэ.

Ийнхүү Ева Бурханы зан чанар, шударга чанар, сайн сайхан, хор хохирлоос хамгаалах хамгаалалтанд эргэлзсэн тул цаашид Бурханы эрх мэдэл дор байгаад байх нэгээхэн ч шалтгаангүй болов. Эмэгтэйн дур хүсэл олгойдон, жолоо алдраад, тэрбээр Бурхан Аавынхаа хүслийг гишгэлжээ. Ева жимсийг барьж аваад, эргүүлж тойруулж хартал, ямар ч муу юм болсонгүй. “Могой худлаа хэлээгүй байна!” Тэгээд Ева өөрөө ч идээд, нөхөртөө ч идүүлэв.

Идсэнийх нь дараа гэнэт тэр хоёрын нүд нээгдэж, тэд өөрсдийгөө шалдан байгааг ухаарахдаа айдас, ичгүүрт автав. Ийнхүү тэдний дуулгаваргүй зангийн гайгаар сүнсний үхэл ирж, тэд махан бие хэмээгч хүчит эзний эрхшээлд очив. Тэр хоёр Бурханы үгд эргэлзэж, эргэцүүлэл хэмээгч замаар уруудан мэхлэлд унахдаа, амь амьдралаа дуулгаваргүй байдлын эзэнд дэлгэж, тэр нь тэдний хар санаат эзэн болжээ. Бичээс “Та нар өөрсдийгөө дуулгавартай боол болгон хэн нэгэнд өгөхдөө, үхэлд хүргэх нүгэл ч бай эсвэл зөвт байдалд хүргэх дуулгавар ч бай, дагах нэгнийхээ боол нь болдогоо мэдэхгүй гэж үү?” (Ром 6:16) хэмээн батаггадаг. Үхлийн эзэн тэр хоёрын амьдралд төдийгүй, дэлхийд нэвтрэх эрхийг олж авчээ. Учир нь Бурхан энэ бүрэн эрх мэдлийг хүнд өгсөн байв. Гэтэл Адам тэр эрх мэдлийг

ийнхүү Сатаны гарт шилжүүлжээ. Паул үүнийг “Нэг хүнээр ертөнцөд нүгэл нь, нүглээр үхэл нь орж ирсэн байхад бүгд нүгэл үйлдсэнээр үхэл нь бүх хүнд иржээ” (Ром 5:12) хэмээн тайлбарласан юм.

Эр, эм хоёрыг дуулгаваргүй авирлахаас өмнө үзэн ядалт, уур хилэн, үл уучлал, зөрчил тэмцэл, хов жив, ялзрал завхрал, залилан, гашуу хорсол, хуйвалдаан гэж байгаагүй. Бэлгийн завхайрал, хар тамхины дон, архидан согтуурах, аллага, хулгай ч гэж байсангүй. Хүүхэд, эмэгтэйчүүдийн хүчирхийлэл ч байгаагүй. Өвчин, эмгэг, ядуурал байгаагүй. Байгалийн гамшиг, хортон, тахал гэдгийг хүн төрөлхтөн мэддэггүй байлаа. Араатан амьтдын ертөнц эвтэй дөрвөн амьтан шиг л амар жимэр оршдог байв. Дэлхий тэр аяараа Бурханы бүхнийг эрхшээн захирах хүсэл дор төгс оршин байв.

Гэтэл хүний дуулгаваргүй авир хүн төрөлхтнийг нэрвэсэн, аймшигт үйлдлийг дагуулж, энэ нь үе улирах тусам улам л аймшигтай хэлбэрийг олон, үржих болжээ. Тэр хоёрын ганц дуулгаваргүй үйлдэл нь хуульгүй байдлын нууц хүчийг төрүүлсэн байна. Хүн мэхлэгдэхдээ, тэнгэрлэг хангамж хамгаалалтаа алджээ. Сатан эрх мэдлийг гартаа оруулахдаа, өөрийнхөө ноёрхол, сүйрэлд үүд дэлгэснээс хойш тэрслэл хэвшин тогтов. Сатан Бурханд захирагдах бус, харин Бурхантай эгнэх бүх боломжоо тулгал нь дайчилжээ. Сатан Бурханы бүтээлийг боолчилсноороо, өөрийгөө өргөмжлөв. (Исаиа 14:12-14)

## **Энэ схем өнөөдөр ч ажилласаар**

Сатаны үйл ажиллагааны хэлбэр яльгүй өөрчлөгдсөн л дөө. Тэрбээр биднийг Бурханы эрх мэдлийн өөдөөс босгохын тулд Бурханы мөн чанарыг муучлан завхруулсан хэвээрээ л байна. Гэтэл Иаков ном энэ тухай тун тодорхой хэлдэг: “Хайрт ах дүү нар минь, бүү мэхлэгдэгтүн. Аливаа сайн соёрхол ба аливаа төгс бэлэг нь дээрээс, гэрлүүдийн Эцэгээс бууж ирдэг. Түүнд өөрчлөлт ч, өөрчлөгдөх сүүдэр ч үгүй” (Иаков 1:16-17).

Бичээч биднийг Ева шиг хуульгүй байдлын нууц хүчинд унахаас маань аминчлан сэрэмжлүүлжээ. Биднийг хамгаалах гэсэндээ л Паулаар дамжуулан анхааруулсан байна. Тиймээс бид Паулын үгийг нарийн анхаарч, зүрхэндээ суулгаад, Бурханы хүслийн гадна сайн сайхан юм гэж байдаггүйг тогтоож авах ёстой. Яахав, сайн сайхан харагдаж болох ч, Бурханы хүсэлтэй эгнэхгүй аливаа зүйл нь бидэнд



сайныг авчрахгүй гэдгийг эндэлгүй тогтоож авна уу.

Бурханы хангамжаас гадуур сайн сайханд хүрч болно гэж итгэдэг хүн нь Еватай адил мэхлэгджээ гэдгийг Иаков ахин дахин хэлсэн. Энэ үгийг анхааралтай тунгаагаарай. Тухайн зүйл нь ямар ч сайхан төрхтэй, амттай санагдаж, таныг баян тансаг, баялаг дүүрэн, ухаалаг, амжилттай болгож чадах байсан ч, Бурханаас л биш бол, яваандаа уй гашуу, харууслын замаар хөтөлсөөр, адагтаа үхэлд хүргэх жамтай. Мэхлэл хүнийг тэнгэрийн хангамж, хамгаалалтаас буруулахад хүргэдэг. Төгс хийгээд сайн бэлэг болгон нь Бурханаас ирдэг бөгөөд Бурхан л үүний эх үүсвэр нь болой. Үнэнийг хүлээн авч, зүрхэндээ нутаглуулбал, та үзэмжинд мэхлүүлэхгүй! Ева тэгсэн бол, ганхахгүй байж! Тэрбээр Бурханы хангамжаас гадуур орших зүйлээр хүслээ хангахыг хүсчээ.

Хичнээн хүн буруу шалтгаанаар буруу хүнтэй гэрлэдэг билээ? Бурхан тэдэнд аав ээж, пастораар нь дамжуулж эсвэл шууд зүрхэнд нь хэлээд байхад, тэд тэр дуу хоолойг өөрийнхөө эргэцүүллийн ухаанаар нам дардаг. Магадгүй ганцаардаж, ханьсах хүн хайсандаа л тэр байх. Магадгүй нөгөө хүн нь жигтэйхэн хөөрхөн байсан нь эргэлт буцалтгүй шийдэхэд нь нөлөөлсөн байх. Тэгээд тэд Бурханы хүслийг биш, өөрийнхөө хүслийг сонгоод, үлэмжийн зовлонд ойчих нь даанч их.

Мэдээж Бурхан бидний буруу зөрүүг засч залрууран, авран сэргээдэг. Батшебаг авсан Давидын нүгэл хожим Соломон гэдэг нуган үрээр нь илааршсан байдаг. Тийм боловч, Давидын дуулгаваргүй зан гэр бүлд нь төмөр илд авчирсны улмаас, тэрбээр үлэмжийн уй гашуу хураасан юм. Давид гурван хөвүүнээ цэл залуугаар нь алдсан. Бид дуулгавартай байхыг сонгодог бол, хичнээн сайхан!

Хүмүүс удирдлагатайгаа таарахгүй байна гэдэг шалтгаанаар Бурханы тарьсан газраас буюу ажил мэргэжил, чуулган, хотоос зугтдаг. Эсвэл амьдрал нь өөдлөхгүй байна, тэр газарт ирээдүй алга гэж үздэг. Тийнхүү эхний боломжоор л Ариун Сүнснээс ч үг дуулалгүй, зоргоороо яваад өгнө. Хамгийн харамсалтай нь, тэд энэ явдлаараа Бурханы дуудсан ариун байдлыг хөсөрдүүлдэг. Тэд: *“Би энэ тавиур дээр дэндүү удлаа. Тиймээс одоо л хөдлөхгүй бол, оройтох нь”* гэж бодно. Тэгээд эцэстээ Бурханы хүслийг сөрөн, өөртөө сайн гэж бодсон зүйлтэйгээ хөөцөлдөөд алга болно. Яахав, санхүүгийн хувьд хөл дээрээ босч болох ч, зүрх нь Эзэнтэйгээ тогтоох гал халуун,

дотно харилцаанаасаа тасарна.

Энүүхэндээ л ярихад, хичнээн хүн Бурханы хүслээс зөрж, дуулгаваргүй авирладаг билээ? Тэд Бурханы хүслээс гадуур санхүү, амжилтанд хүргэх зүйлсийг олдог. Үүнийгээ дагаад, нэг хэсэгтээ жигтэйхэн хөгжилтэй, жаргалтай, баясалтай болно. Бурханы нөгөө “болохгүй” гээд байсан юмс чинь тун ч “сайхан” юм байжээ гэж бодогдоно. Тэгээд Бурхан тэднээс өөр олон сайхан юмсыг нууж хааж байх бий гэж айна! Тэд Бурханыг өөрсдийнх нь хэрэгцээ, хүслийг ойшоодоггүй, хэрэгсдэггүй гэж бодно. Залбирал нь өөрсдийнх нь товлосон хугацаанд биелэхгүй бол, Бурханыг итгэмжгүй гэж үзнэ. Тэгээд “Тэр сайхан, таатай юмсыг одоо л өөрийн болгодог хэрэг! Хүлээх юун?” гэсэн шийдэлд хүрнэ.

## Есүсийг бодоод үз

Тэгвэл Есүсийг бодоод үз. Есүс цөлд хоол ч үгүй, ус ч үгүй, тав тух ч үгүй дөч хоносон. Өлсгөлөндөө тарчилж, өлөн ходоод нь хурц мэсээр хүүлэх мэт исгэгдэж байсан байх. Тэр хоол, ундгүй дахиад жаахан удсан бол, үхэх байсан биз. Ийм байдалд байгаа Есүст хангамж, өдөөлтийн аль нь түрүүлж ирсэн бэ?

Яг энэ үед Сатан: “Чи Бурханы Хүү мөн аваас энэ чулуунуудыг талх бол гэж тушаа” (Матай 4:3) гэсээр ирэв. Дайсан мөн л Бурханы маш тодорхой мэдэгдэлд асуулга тавьжээ. Иордан голын эрэг дээр Аав нь Есүсийг Өөрийнхөө Хүү хэмээн ил тод мэдэгдсэн. Сатан: “Та Бурханы Хүү мөн аваас, Бурхан яахаараа Таныг энд авчраад, өлсгөдөг билээ? Яахаараа ганц Хүүгийнхээ хэрэгцээг хангадаггүй билээ? Одоо Та Өөрөө Өөрийнхөө төлөө хөдөлж, Өөрийнхөө хэрэгцээг Өөрөө хангах цаг болсон юм биш үү? Шаардлагатай шим тэжээлээ бушуухан авахгүй бол, удахгүй үхэж мэднэ. Үхдэггүй юмаа гэхэд оройтож, ямар нэгэн эмгэг өвчтэй болж мэднэ шүү. Эрх мэдлээ Өөрийнхөө төлөө ашиглаач. Энэ чулуунуудыг талх болгож хувирга” гэж хэлэхдээ бас л Бурхан Аавын мөн чанарыг завхруулах гэж оролджээ.

Гэтэл Есүс үүнийг нь эсэргүүцэн, Бурханыхаа л хангамжийг хүлээсэн юм. Есүс тархин доторх Бурханых нь зан чанарыг муучлан завхруулахыг дайсанд зөвшөөрөөгүй. Аав нь Түүний хэрэгцээг хангасныг Есүс мэдэж байсан. Тэрбээр тэр таагүй эгшинд ч Бурханыхаа эрх мэдэлд захирагдсаар байв.

Есүс Сатаны “бүхнийг гартаа ав” гэсэн өдөөлтийг ялсны дараа “диавол Түүнийг орхиход, гэнэт тэнгэрэлч нар ирж, Түүнд үйлчлэв” (Матай 4:11). Яагаад? Еврей номын зохиогч Есүсийг ийнхүү дүрсэлжээ: “Тэрээр махбодынхоо өдрүүдэд Өөрийг нь үхлээс аварч чадах Нэгэнд чанга хашхиран, нулимсаараа залбирал ба гуйлтаа өргөсөн. Тэр эмээдэг байсан тул Бурхан Түүнийг сонссон билээ. Тэрээр Хүү нь байсан хэр нь зовсон зүйлсээсээ дуулгаварт суралцсан.” (Еврей 5:7-8) Бурханлаг эмээхүйнх нь улмаас Бурхан Есүсийг сонсчээ. Есүс Аавынхаа сайн сайханд эргэлзээгүй. Есүс аймшигтай тарчилна гэдгээ мэдэж байсан ч, хэний ч үзээгүй тэр том өдөөлт, зовлонгийн нүүрэн дээр ч дуулгавартай байхыг сонгосон юм.

Есүс ийнхүү дуулгавартай байж, захирагдсанаараа амьдралд нь шургах гэсэн дайсанд бүх орцыг тас хаасан. Үүгээрээ Тэр Адам, Ева хоёроос ялгаатай. Тэрбээр: “Би та нартай олон юм дахиж ярихгүй. Учир нь ертөнцийн захирагч ирж байна. Түүний юу нь ч Миний дотор байхгүй. Харин Би Эцэгээ хайрлаж, Эцэгийн Надад тушаасан ёсоор хийдгээ ертөнцөд мэдүүлнэ. Босоцгоо, эндээс явцгаая” (Иохан 14:30-31) хэмээн гэрчилсэн буюу.

Сүүлчийн Адам гэгддэг Есүс маань Аавдаа төгс дуулгавартай амьдарч, Сатан Түүнээс юу ч олж долоогоогүйг батлан гэрчилснээрээ Адамаас ялгаатай. Иймээс л бидэнд: “Түүний дотор оршдог гэж яригч нь Түүний явсанчлан өөрөө бас тийн явах учиртай” (1Иохан 2:6) гэж анхааруулжээ. Есүс бол бидний үлгэр жишээ бөгөөд анхдагч болой. Тэр бидний төлөөсийг бүрэн төлж, бидэнд зам тавьж өгсөн билээ. Бид цаашид анхны Адамын болоод түүний хуульгүй байдлын замаар уруудах албагүй болж, харин сүүлчийн Адамын дуулгавартай замаар явахаар дуудагдан, хүчирхэгжсэн бүлгээ.

Энэ тухай Мессеж Библи тун сайхан хэлдэг:

Нүцгэлээд, зогсолгүй гүй (Бурхандаа дуулгавартай байхаар)! Сүнсний өчүүхэн ч илүүдэл таргагүй, ширхэг ч шимэгч нүгэлгүй. Бидний гүйж яваа уралдааныг эхлүүлж бас дуусгасан Есүсээс хараагаа бүү салга. Тэр яаж үүнийг хийж чадсаныг судлаж мэд. Тэрбээр зорьж буй зүгээ - Бурхантай хамт бөгөөд Бурханы доторх тэр догдлом бариаг хэзээ ч хараанаасаа алдаагүй учир замдаа таарсан загалмай, ичгүүр зэрэг алив бүхэнтэй эвлэрч чадсан. Тийнхүү эдүгээ Тэрбээр тэндээ Бурханыхаа дэргэд хүндэт суудалд залран буй. Итгэлдээ (дуулгавартай байдалдаа) нааш цааш савлах цагтаа дайсагналын гинжин хэлхээг зад

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

татсан Түүний түүхийг ахин дахин нэг бүрчлэн давтаарай. Тэр чинь л та нарын сэтгэлд гүйдэл авчирна! (Еврей 12:1-3)

Товчхондоо ийм л байна. Анхны Адамын алдаанаас сургамж аваад, сүүлчийн Адамын дуулгавартай байдлыг хичээнгүйлэн дага.

Дараагийн бүлгээрээ бүгдээрээ дуулгаваргүй байдлын үр дагаврыг хэлэлцэнэ. Үр дагавар нь тэр даруйдаа биш юмаа гэхэд, хожмоо заавал илэрнэ. Дуулгаваргүй байдал чинь тодорхой илчлэгдсэн бол, хайхралгүй, зөнгөөр нь орхиж болохгүй шүү.

## БҮЛЭГ 5

# ДУУЛГАВАРГҮЙ БАЙДЛЫН ҮР ДАГАВАР I

*Итгэл, дуулгавартай байдал нь салшгүй хоёр.*

*Учир нь дуулгавартай байдал нь  
жинхэнэ итгэлийн нотолгоо болдог.*

**Д**уулгаваргүй байдал нь олон үр дагавартай. Тэр даруй танигдахгүй эсвэл илрэхгүй байж болох ч, үр дагавар нь үрээс ургац гардагтай адил гарахдаа л гарна. Биднийг мэхэлж унагах гэсэн сэтгэлийн дайсан маань биднээс энэ мэдлэгийг тас нууж, дуулгавартай байдлыг аль болох хөнгөн хуумгай зүйл шиг үзүүлэхийг эрмэлздэг.

Зарим хүмүүс гаргасан шийдвэрийнх нь түргэн ашиг нь дуулгаваргүй байдлынх нь үр дагаврыг дарна гэж боддог. Энэ үхлийн аюултай, худал дүгнэлт өнөөдөр ямар их газар авсан нь даанч дээ гэмээр. Энэ чинь хуульгүй байдлын нууц буюу далд хүч шүү дээ. Дараагийн гурван бүлгийг үзээд, та цаашид дуулгаваргүй байдлаар хэзээ ч тоглохгүй гэдэг хатуу шийдвэрийг гаргаж, гаргасан шийдвэртээ үнэнч амьдрах болтугай хэмээн миний бие найдаж бас залбирч байна.

## АДАМЫН ХӨВГҮҮД

Бүгдээрээ хичээлээ Адамын ууган Каинаар эхэлье. Каин тариачин байв. Түүний дүү Абел нь хоньчин байв. Нэг удаа Каин Эзэний өмнө газрын шим болох үр жимсээрээ, харин Абел сүргийнхээ анхны төлөөр тахил өргөсөн тухай Бичээс өгүүлдэг: Абел бас хонин сүргийнхээ анхны төлийг болоод түүнийхээ өөх тосноос өргөжээ. ЭЗЭН Абелыг болон түүний өргөлийг ойшоон хүлээж авсан боловч Каиныг болон түүний өргөлийг ойшоосонгүй. Каин ихэд уурлан, уруу царайлав. (Эхлэл 4:4-5)

Ингэхэд энэ түүх өнөөдөр чуулганд маш их ярьдаг “Бурхан та нарыг байгаагаар чинь л хүлээж авна!” гэдэг үгийг няцааж байна. Энэ үнэн л дээ. Гэхдээ тэглээ гээд бид бахь байдгаараа байгаад байж болохгүй. Биднийг *гэмшсэн нөхцөлд* л Бурхан биднийг хүлээж авна. Бурхан биднийг байгаар минь хүлээж авна гэдэг мэдэгдлийг Ананиа, Сафира хоёр дээр хэрэгжүүлээд үз л дээ. Таарахгүй байгаа биз дээ - тэд үхсэн. (Үйлс 5:1-11)

Бурхан Каины тахилыг аваагүй - бүр тодруулбал, Бурхан Каиныг хүлээж аваагүй! Бурхан Каиныг хүлээж аваагүй гэдэг нь Каины хувь тавилан дууссан гэсэн үг биш, харин бидний “Бурхан хүнийг байгаагаар нь хүлээн авдаг” гэдэг теологи л худлаа болж таарч байна гэсэн үг. Энэ теологи нь бидний зүрхнээс Эзэнээс эмээн хүндэтгэх хандлагыг хуулж хаядаг учраас, тун аюултай билээ. Эзэнээс эмээхүй нь биднийг хамгаалж, биднийг нүглээс хол явахад хүргэдэг (Гэтлэл 20:20). Ананиа, Сафира хоёрын үхлийн дараа “Чуулган даяар, энэ бүхнийг сонссон бүгд дээр үлэмжийн айдас ноёлов” (Үйлс 5:11) гэж Библи хэлдэг. Дуулгаваргүй байдал зүгээр биш юм!

Би Адамын хоёр хүүгийн түүхийн хэрэгжилтийг ойлгомжтой болгох үүднээс өнөөгийн амьдрал дээр буулгамаар байна. Тэр хоёр Эзэний нэрийг дууддаг гэр бүлд өсч торнижээ. Тэгээд тус тусдаа өөр өөрсдийнхөө амьдралыг төлөөлсөн тахилыг Эзэнд авчирч өргөжээ. Библи биднийг биеэ амьд тахил болгон өргө (Ром 12:1) гэдэг. Бурханы өмнө тахил өргөнө гэдэг нь Түүнд үйлчилж байгаа амьдралыг илтгэж байгаа юм. Бид Бурханд үйлчилдэг Абелын тухай, Бурханд үйлчилдэггүй Каины тухай яриагүй. Каин казино, стриптиз клуб, баар саваас салдаггүй, цуглаанаас зайлж зугтдаг хүн байгаагүй. Каиныг

Бурханыг мэдэхийг ч хүсдэггүй хүнтэй бүү эндүүрээрэй. Тэр хоёрыг хоёуланг нь Бурхантай харилцаатай итгэгч нар гэж үзэж болно.

Тэр хоёр Эзэнд өргөл авчрах гэж хоёулаа л хичээнгүй хөдөлмөрлөсөн. Үнэндээ Каин Абелаас ч их хөдөлмөрлөсөн байх. Би тариалан, мал маллагааны талаар сайн мэдэхгүй ч, газар тариалангийн ажил нь мал маллахаас хүнд гэдгийг мэдэхтэйгээ. Малчин хүн өглөө, үдээс хойш их ажилтай байгаад, харин өдрийн халуунд сүүдэр бараадан амарч, идэж уудаг.

Тэгвэл газар тариалан бол хавьгүй эрчимтэй. Каин Бурханы хараасан яг тэр газартай барилдан байж, хөлсөө урсгасныхаа үр дүнд өргөлөө гаргаж авсан (Эхлэл 3:17-19). Каин газрыг чулуу, хожуул зэрэг хур хогоос нь цэвэрлэсэн. Дараа нь газраа хагалж, хөрсөө боловсруулсан. Дараа нь үрээ суулгаж, усалж, бордож, ургацаа хамгаалсан. Тэр өргөлөө гаргаж авах гэж нөр их хичээн зүтгэжээ.

### **Бурхан яагаад Каиныг хүлээж аваагүй вэ?**

Тиймээс бид “Бурхан Каиныг хүнд хүчир ажилласныг нь мэдсээр байж, яагаад өргөлийг нь хүлээн аваагүй вэ?” гэж асуух ёстой. Хариулт нь аав, ээжтэй нь холбоотой юм. Цэцэрлэгт Бурханы бүтээсэн бүхэн бүрхүүлтэй байсан. Ан амьтад үстэй, загас хайрстай, шувууд өдтэй. Жинстэй цагаан баавгай байхгүй. Түүнд нэмэлт бүрхүүл хэрэггүй.

Адам, Ева хоёрын хувьд ч ялгаагүй байв. Тэдэнд материаллаг бүрхүүл юмуу хувцас хэрэг байгаагүй. Тэд алдраар “титэмлэгдсэн” байсан (Дуулал 8:5). *Титэмлэгдсэн* гэдэг үг нь “дугуйлах юмуу хүрээлэх” гэсэн утгатай. Тэд алдраар хучигдсан байж. Тэдэнд тохоосон Бурханы алдар нь тэдний нүцгэн биеийг ч халхлахуйц яруу жавхлантай байжээ. Тиймээс л Бичээс “Хүн эхнэр хоёр нүцгэн байсан бөгөөд тэд *ичсэнгүй*” (Эхлэл 2:25) гэдэг. Амьдрал нь Бурханы өмнө байсан тул тэд ичгүүрийг мэддэггүй байжээ. Хувцас хэрэггүй байсан учраас, тэдэнд энэ тухай бодогдоо ч үгүй.

Гэтэл тэднийг дуулгаваргүй загнах үед энэ бүхэн өөрчлөгджээ. Тэднийг дуулгаваргүй авирлахаас өмнө сүнс нь бүрэн ноёлдог байсан бол, дуулгаваргүй авирласных нь дараа бие нь ноёлж эхэлжээ. Тэднийг идсэний дараа Бичээс шууд “Тэгээд тэр хоёрын нүд нээгдэн, хоёулаа нүцгэн байгаагаа мэдсэн” (Эхлэл 3:7) гэдэг. “*Тэд мэдсэн*” гэдэг үгд хамаг учир бий. Тэд урьд мэддэггүй байсан зүйлээ мэддэг болжээ.

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Сайн, муугийн талаарх мэдлэгийн зарчим нь зөв, буруугийн дагуу амьдрах юм. Нүглээс өмнө тэдний үйлдэл нь сайн муу, зөв буруугийн талаарх мэдлэгт бус, Бурханы мэдлэгт эрхшээгдэж байв. Тэд итгэл, хайраас төрсөн дуулгавартай байдлын мэдрэмжээр хөдөлдөг байв. Зөв буруу нь тэдний ухаанд бус, Бурханы мутарт байжээ. Библи:

Хад болсон Түүний үйлс нь төгс, зам нь үнэн. Үнэний Бурхан, хуудуу үгүй Тэрээр Зөвт бөгөөд шулуун шударга билээ (Дэд хууль 32:4) гэдэг.

Адам, Ева хоёр Бурхантай эвтэй найртай амьдарч байхдаа Бурханаас бүрэн хамааралтай байсан бол, сайн мууг мэдүүлэгч мэдлэгийн модны жимсийг авч идсэнээсээ хойш Бурханаас гадуур сайн, мууг жинлэх мэдлэгийн эх үүсвэртэй болжээ. Бид үүнийг учир шалтгааны зарчим гэж тодорхойлж болно. Тэд цаашид Бурханд захирагдах шаардлагагүй болж, зөв буруу гээчийг ялгадаг, дотоод мэдрэмжтэй болжээ. Тиймээс тэднийг нүгэл үйлдсэний дараа Бурхан хамгийн түрүүнд: “Хэн та нарт тэгж хэлээв?” (Эхлэл 3:11) гэж асуусан байдаг.

Бурхан асуулт асуухдаа мэдээлэл олж авах гэж бус, харин хэлэх үгдээ татах гэж асуудаг юм. Бурхан тэр хоёрыг модноос идчихээд, эдүгээ өөрсдийнхөө ухаанаар ярьж байгааг нь мэдэж л байсан. Тэд дуулгавартай байдлыг учир шалтгаанаар сольжээ. Бурхан үнэндээ: “Та нар Надаас гадуур зөв, буруугийн мэдрэмжээ хангадаг эх үүсвэртэй болжээ. Та нар Сайн мууг мэдүүлэгч модноос иджээ” гэсэн байна.

Адам, Ева хоёр дуулгаваргүй авирласныхаа дараа шууд л нүцгэн биеэ инжрийн навчсаар буюу *газрын үр жимсээр* халхлаад зогсохгүй, нүцгэнээсээ зовон нуугджээ. Тэгтэл Бурхан тэднээс: “Та хоёрыг нүцгэн гэж хэн хэлээв?” (Эхлэл 3:11) гэж асуусан. Тэр хоёр дөнгөж сая олж авсан зөв, буруугийн шинэ мэдрэмжээрээ нүдэндээ зөв харагдсан зүйлээ үйлдэх гэж оролдсон ч, нүцгэн санагдсан хэвээрээ л байжээ. Тэр хучлага нь Бурханы арга зам байсангүй. Тэгтэл Бурхан нүцгэн байдлыг нь арилгах зохистой бүрхүүл болж чадах тахилыг харуулжээ. Бурхан гэмгүй амьтныг нядлаад, арьсаар нь Адам, Ева хоёрыг нөмөрчээ. Энэ нь газрын үр жимс бус, Бурханы гаргаж өгсөн арга зам байв.

Тэр үед Бурхан чухам юу хүсээд байгааг Адам, Ева хоёр ойлгоогүй ч, Каин, Абел хоёр ойлгожээ. Тэр хоёр аав, ээжийнхээ амьдралаас Бурханд ямар өргөл тааламжтай байдгийг ойлгосон



байна. Каин Бурханд *газрын үр жимсийг* өргөсөн ч, энэ нь мөн л Бурханд тааламжгүй өргөл байв. Каин Бурханд өөрийнхөө арга замаар үйлчилсэн байна! Тэрбээр дүү Абел шигээ хүүхдийн цэвэр, дуулгавартай сэтгэлээр үйлдэхийн оронд учир шалтгааны арга замаар ажилладаг хараалд татагдан зөв, буруугийн учир зүйд урважээ.

## Чи үүнийг захирах ёстой

Бичээс “Итгэлээр Абел, Каиныхаас үлэмж дээр тахилыг Бурханд өргөв. Үүгээрээ тэр зөвт гэсэн гэрчлэлийг хүлээн авав. Бурхан түүний бэлгүүдийн тухай гэрчилсэн юм. Тэр үхсэн боловч итгэлээр ярьсаар байна” (Еврей 11:4) гэдэг. Шинэ гэрээний бичээч Абелын дуулгавартай байдлыг итгэлтэй тэнцүүлжээ. Жинхэнэ итгэл нь дуулгавартай байдалтай тэнцдэг бөгөөд үүн дээр л үндэслэдэг болохыг бид дараа дараагийн бүлгээрээ сурна. Жинхэнэ итгэл нь зөв, буруугийн мэдрэмжээр бус, харин дуулгавартай байдлаар үйлдэгддэг.

Бурхан өөрийнх нь хүчин зүтгэл, өргөлийг хүлээж аваагүйг Каин үзэхдээ “ихэд уурлан, уруу царайлав” (Эхлэл 4:5). Энэ нь үнэнтэй халз тулсан хоёр нүүртэй, шашинлаг хүний сонгодог хариу үйлдэл юм. Тэрбээр уурладаг. Бичээст ч энэ талаар дүүрэн бий. Энэ уур нь бардам зангаар хальж, харин бардам зан нь өөрийнхөө юмстай зууралдсаар байхын тулд Бурханы хүсэл, арга замыг няцаадаг.

Гэтэл өршөөнгүй Бурхан Каины нүдийг нээх гэсэндээ: “Чи юунд уурлана? Юуны учир уруу царайлна вэ? Хэрэв чи сайныг үйлдвэл тэргүүнээ өргөх биш үү?” (Эхлэл 4:6-7) гэж асуужээ. Бурханд зөвийг үйлдэхийн тулд дуулгавартай байх хэрэгтэй. Бурхан өргөлийг (тахилыг) бус, дуулгавартай байдлыг хүсдэг. Бурхан олон удаа хүмүүстээ дуугаа зогсоож, хөгжмөө зайлуулж, тахилаа болихыг хэлсэн байдаг. Яагаад? Учир нь “Би дуудсан боловч хэн ч хариулсангүй, Би дуугарсан боловч хэн ч чих тавьсангүй” (Исаиа 66:4) гэдэг. Тэд тахил өргөсөн боловч, Бурханыг үгээ айлдахад нь дуулгавартай дагаагүй. Дуулгавартай байдал нь хамгийн өндөр хүндэтгэл болой.

Үүнийг мэдсэн болохоор одоо бүгдээрээ Эхлэл дээрх *сайныг үйлдвэл* гэдэг үгийг *Намайг дуулгавартай дагавал* гэдэг үгээр утгыг нь өөрчлөлгүй, орлуулж үзье. Тэгвэл “Каин, чи юунд уурлана вэ? Уурлах шаардлагагүй. Үүнийг мэд. Хэрэв чи дүү шигээ Намайг дуулгавартай дагавал, Би Абел шиг чамайг ч, чиний тахилыг ч хүлээн

авна” гэж уншигдах байх.

Эзэн: “Хэрэв чи сайныг хийхгүй бол (дуулгавартай дагалгүй, одоогийнхоо учир шалтгааны шугам дээр байгаад байвал) гэм нүгэл үүдэнд чинь гэтэн, нүгэл хилэнц чамайг хүсэх болно. Гэвч чи түүнийг дийлэх ёстой” (Эхлэл 4:7) хэмээн анхааруулжээ. Эндээс хоёр зүйлийг тэмдэглэнэ үү. Нэгдүгээрт - нүгэл (дуулгаваргүй байдал) нь хүсэлтэй байдаг. Дуулгаваргүй байдлын нууц хүч нь үүний эзэн - Сатан юм. Адамын нэвтрүүлсэн энэ хүч нь ганц л зорилго тээж байжээ: бүх юм, бүх хүнийг хянан захирах. Дэлхийн агаар мандал даяар дийлдэшгүй их хэмжээний радио идэвхит хий цацсан хорон санаат эрдэмтэнтэй л адил. Эрдэмтэн өөрөө газар сайгүй байж чадахгүй ч, хорт хий нь газар сайгүй тархаж чадна. Тэрбээр үхлийн дийлдэшгүй хүчийг хөдөлгөөнд оруулжээ. Хамгаалалтын баг, хувцастай хүмүүс л тэр хорт хийгээс хамгаалагдана. “Бид Бурханых, харин бүх ертөнц нь ёрын нэгэн дор байдгийг мэднэ” (1Иохан 5:19).

Нүглийн хүслийг мөн газрын татах хүчний хуультай жишиж болно. Газрын татах хүч нь хэзээд байрандаа байж байдаг, тогтвортой хүч бөгөөд бүх юмст нөлөөлдөг болно. Та барилгын орой дээрээс уруугаа ганц алхахад л газрын татах хүчний хуульд автан, газар дээр бяцран унана. Та унамааргүй байсан ч эсвэл газрын татах хүчинд итгэдэггүй байсан ч, энэ хүчээс зайлахгүй.

Тэгтэл нэгэн өдөр эрдэмтэд өөр нэг хүчийг нээв - өргөлтийн хууль. Зөв нөхцлийг нь тааруулах юм бол, өргөлтийн хууль нь газрын татах хүчний хуулийг давдаг болохыг эрдэмтэд тайлжээ. Энэ өргөлтийн хууль дээр тулгуурлан шинийг сэдэгч - зохион бүтээгч нар онгоц бүтээсэн байна. Та онгоцонд суугаад нисэхдээ газрын татах хүчинд автан доошоо уналгүй, энэ хуулиас чөлөөлөгддөг. Бичээс “Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ” (Ром 8:2) гэдэг. Гайхмаар мэдээ!

Бимаших нисдэг. Дэлхий даяар гучгаруй жил Сайн мэдээг тунхаглахдаа, магадгүй арван зургаан сая км газар аялсан байх. Би онгоцонд суух үедээ намайг газрын татах хүчний хуулиас чөлөөлдөг өргөлтийн хууль байдаг талархдаг. Тийм боловч хэрэв нисгэгч мотороо унтраачихбал, онгоцны далавч бууж, онгоц тэр чигээрээ газрын татах хүчинд автан, хар эрчээрээ унана. Тэр үед бид газрын татах хүчийг эзэгнэж чадахаа больж, өмнө нь давуу эрхтэй байсан хүчнийхээ эрхшээл дор очно.

Мөнөөх л бүлэгтээ Бичээс цааш нь “Тиймд ах дүү нар аа, бид

махбодын дагуу амьдрахын төлөө байдаг махбодын өртөнгүүд биш. Учир нь хэрэв та нар махбодын дагуу амьдарвал үхэх ёстой. Харин та нар Сүнсээр биеийн үйлсийг үхэлд хүргэвэл амьдрах болно” (Ром 8:12-13) гэж мэдэгджээ. Хэдийгээр амийн Сүнсний хууль нь биднийг нүглийн хуулиас чөлөөлдөг ч, нүглийн хууль нь амьд оршсоор байна. Үүнээс хамгаалагдаж, үүнийг эрхшээх чадвар нь зүрхнээс маань ундарсан жинхэнэ итгэл, дуулгавартай байдлаас гардаг.

“Амийн Сүнсний хуулийг” бас “итгэлийн хууль” (Ром 3:27) гэдэг. Итгэлийн хууль нь нүглийн хуулийг давдгийг бид мэднэ. Жинхэнэ итгэл нь зохих ёсны үйлдлээ дагуулдаг (Иаков 2:19-23). Итгэл хийгээд дуулгавартай байдал нь жинхэнэ итгэлийн нотолгоо учраас, эдгээр нь салшгүй юм.

Абел нүгэл, үхлийн хуулийг буюу Бурханд дуулгавартай байхыг итгэлээр үйлдэж чадсан. Харин Каинд Бурхан “Нүгэл чамайг хүснэ (Газрын татах хүч аливаа биетийг соронзддог шиг). Хэрэв чи Намайг дуулгавартай дагавал, үүний эзэн байна (Газрын татах хүчийг эрхшээдэг шиг)” гэж анхааруулсан. Нүглийг дуулгавартай байдлаар захирна.

### Онгорхой үүд

Каинд зааж өгсөн Бурханы хоёр дахь зарчим “Хэрэв чи сайныг хийхгүй бол (Намайг дагахгүй бол) гэм нүгэл үүдэн дээр чинь гэтэн, нүгэл хилэнц чамайг хүсэх болно” (Эхлэл 4:7).

Бурхан үүд гэдэг үгийг хэрэглэсэн байгааг тэмдэглэнэ үү. Хүн бүрийн амьдралд хийсвэр хаалга бий: бид мэдсэн ч, мэдээгүй ч ийм хаалга бий. Тэр хаалга нь таны амьдрал руу нэвтрэх орц болдог. Бидний авч хэлэлцэж байгаа тохиолдол дээр энэ нь нүгэл, чөтгөрийн хүчний нэвтрэх орц болдог. Юу энэ үүдийг нүгэл, чөтгөрийн нөлөөнд нээж, хаадгийг Бурхан анхнаасаа л бидэнд хэлсэн. Дуулгаваргүй байдал нээж, дуулгавартай байдал хаадаг.

Каин эцэстээ яасан? Тэрбээр өөрийнхөө ухаан, учир шалтгаан дээрээ үлджээ. Зүрхэнд нь атаархал нэвтэрч, мөрөөр нь гомдол дагаад, эцэст нь үзэн ядалт орж ирсэн. Удалгүй аллага төлөвлөгдөж, төдөлгүй хилэндээ багтарсан Каин дүүгээ алжээ. Тэр дайсагнаж, Бурханаас айж эмээх сэтгэлээ алджээ. Бурхан дүүг нь хаа байгааг асуухад, Каин шууд л биеэ өмгөөлсөн бөгөөд үүгээрээ дээрх хандлагаа харуулжээ: “Би мэдэхгүй. Би дүүгийнхээ харгалзагч юм уу?” (Эхлэл 4:9) Каин Бурханд

худлаа ярьсан. Тэрбээр дүүгээ хаана байгааг сайн мэдэж байв.

Бурхан Абелыг хаана байгааг мэдэж байсныг эрүүл ухаантай хүн бүр мэднэ. Гэхдээ өөрийнхөө учир шалтгааны гаргалгаа руу эргэж, дуулгаваргүй байдлыг амьдралдаа нэвтрүүлсэн хүний амьдралд ийм л юм болдог. Тэрбээр бодит сүнсний юмсаас холбоо тасардаг. Тэрбээр Бурханы дүр төрхийг өөрийнхөө ухааны хэмжээ, хязгаар руу буулгаж, өөрийгөө Бурхантай адил цэц ухаантай - эсвэл магад Бурханаас ч илүү ухаантай гэж сэтгэдэг. Тэрбээр эрүүл ухаанаа алджээ. Ийм явдлын тэргүүн жишээ нь Люцифер бөгөөд нүглээс мэндэлсэн учир шалтгааны гаргалгаа нь түүнийг Бурханыг авч хаяж чадна гэдэгт итгэхэд хүргэжээ. Үнэн мунхаг! Харамсалтай нь түүний энэ мунхаг мөрөөр олон хүн дагасан юм (Исаиа 14:12-17).

Хэрэв та Каин, Абел хоёрын найз байгаад, болсон явдлыг мэдээгүй бол, чухам юу болоод байгаа талаар нилээд самуурах байсан байх. Яахаараа Бурханд тийм хичээнгүй үйлчилж эхэлсэн хүн яахаас ч буцахгүй алуурчин болчихдог билээ? Ийм юм байж болох уу даа? Гэтэл Каин дуулгаваргүй загнасаар байсныхаа гайгаар сэтгэлийнхээ үүдийг нүглийн хуульд дэлгэж өгчээ. Та “Гар бариад, бугуй барих” гэдэг үгийг мэдэх байх. Дуулгаваргүй байдал яг л ингэдэг. Та үүдээ нээхийн төдийд л - тэр даланд гарсан цуурхайгаар чинь яах ийхийн зуургүй ус үерлэн орж ирнэ.

Би Сайн мэдээний үйлчлэлд гуч гаруй жил зүтгэж явна. Энэ хугацаанд би уг хууль газар сайгүй, зогсоо зайгүй ажиллаж байхыг үзсэн. Хүмүүс Бурханы юмсын төлөө гал халуунаар эхлэхийг би харсан. Тэд чуулгандаа идэвхитэй үйлчилж, Есүсийн талаар хүмүүст байнга ярина. Яг л хичээнгүй эхэлсэн Каин шиг. Гэвч явцын дунд тодорхой нөхцөл байдал дор тэдний доторх “амин хүслүүд” нь ил гарч ирдэг. Энэ нь Каин шиг Бурханы Өөрийнх нь эрх мэдэлтэй юмуу эсвэл Бурханы төлөөний эрх мэдэлтэй юмуу - ер нь бүх эрх мэдэлтэй тэрсэлдэх явдал болж таардаг.

Тэд хувийн хүслээ захируулахаас татгалзаж, өөрийнхөө замаар гэжин явахыг би харсан. Тэгээд эрт орой хэзээ нэгэн цагт амьдралд нь хуульгүй байдлын үер бууна. Энэ нь заавал аллагаар илэрдэггүй юмаа гэхэд, ямар нэгэн замаар илрэхдээ л илэрнэ. Магадгүй шунал, үзэн ядалт, үл уучлал, зөрчил, хов жив, бэлгийн нүгэл зэрэг биеийг нь хүлэх янз бүрийн хэлбэртэй хүлээсийн үер бууна. Мэхлэгдэж, гомдсон тэр хүмүүс Бурхан л өөрийнх нь талд, бусад бүх эрх мэдэл

туйлширсан, хуульчлалд автсан, мэдрэмжгүй гэж боддог.

Каиншигбайдалтай хүмүүс шууд Бурхантай Өөртэй нь тэрсэлдэхдээ, Түүний дүр төрх, эрх мэдэл, хүчийг өөрийнхөө ухааны хэмжээнд доройтуулж, ямар ч хүндэтгэж эмээх сэтгэлгүй болдог. Тэд Бурхан бол Эзэн гэдгийг хүлээн зөвшөөрөх атлаа өөрсдийнхөө бүтээсэн “Есүс” гэдэг брэнддээ л үйлчилнэ. Тэд өөрийн мэдэлгүй зүрхэндээ Бурханы сэнтий, эрх мэдлээс дээгүүр өөрийнхөө учир шалтгааны гаргалгаа, үзэл бодлоо өргөмжилдөг. Тийнхүү яваандаа зүрхнийхээ мэхлэлээс болоод бодит байдлаа харах ямар ч нүдгүй болно.

Хэрэв Каиныг нас бага, цус шингэн, зүрх зөөлөн, Бурханд үйлчлэх дуртай байхад нь “Хожим чи дүүгээ ална” гэж хэлсэн бол, тэрбээр “Бүү үзэгд, хэзээ ч үгүй!” гэж хариулах байсан байх. Гэвч хожим тэрбээр өөрийгөө хуульгүй байдалд дэлгэж, хэзээ ч бодож яваагүй зүйлээ хийжээ.

Чуулганд явдаг, явдаггүй бүх хүн хожим Бурханы өмнө зогсоод, хуульгүй байдлынхаа төлөө шүүгдэнэ. Амьдралыг нь ухраагаад үзбэл, тэд яаж яваад тийм байдалд хүрсэнд нь мэл гайхмаар. Тэр хүмүүс хуульгүй амьдарч яваагаа одоо мэдэхгүй бөгөөд энэ байдал нь хожим Шүүх өдөр илчлэгдэх үед *“Би яаж яваад Бурханд дуулгавартай байх замаас ингэглээ холдоо вэ?”* хэмээн гайхна байх. Тэд Бурханы хамгаалалтан дор сахидаг үнэнийг хайрлаагүй бас хүлээж аваагүй учраас, тийм байдалд хүрчээ.

Мэхлэгдсэн хүмүүст ганц л найдвар бий: Бурхан өршөөлөөрөө нүдийг нь нээж, үнэнийхээ гэрлээр мэхлэлийн харанхуйг нь зайлуулж өгөх. Хүмүүсийг хуульгүй байдлын мэхлэгч хүчний эрхшээлээс хамгаалж, үүний атганд хэдийнээ орсон хүмүүс дээр үнэний гэрлийг гийгүүлэн чөлөөлөх нь миний зүрхний мэгшил бас энэ номын зорилго билээ. Би энэ үгийг дэлхий даяар зааж явахдаа, хичнээн хүн дуулгаваргүй байдалд унаад байгааг асуух үед бараг тавиас илүү хувь нь гараа өргөдөг нь үнэхээрийн гашуудмаар. Ихэнх хүмүүс “зүрхэнд нь үнэн гийх хүртэл тэрсэлж явснаа мэдээгүй” гэдгээ хүлээдэг.

Түүнчлэн миний бие өөрөө хуульгүй байдлын нууц хүчинд хэзээ ч хууртагдаж яваагүй, гэгээн амьтан болчихоод энэ номыг бичээгүй юм шүү. Би ч ялгаагүй өршөөлт Бурханыхаа ачаар л зүрхнийхээ алдаа, арга замыг ойлгож, хуульгүй байдлын аймшигт атганд орсноо мэдсэн. Тиймээс би та бүхэнтэй сурсан зүйлээ бас юунаас хэрхэн чөлөөлөгдсөн тухайгаа л хуваалцаж байгаа хэрэг. Би эрхэм Эзэнийхээ өр зөөлөн өршөөлд үнэн голоосоо талархана!

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Бурхан нигүүлсээрээ дуулгаваргүй талыг маань харуулахаар нүдийг маань нээх гээд байхад, бид өөдөөс нь даруусахгүй гэжөөд байвал, Каинтай адил үнэнийг ойлгохгүй. Дараагийн бүлгээрээ “чөлөөлөгдөхөд даруу зан амин чухал үүрэгтэй” байдгийг мөн “бардам зангийн үхлийн үр дагаврын” талаар үзэцгээе.

## БҮЛЭГ 6

# ДУУЛГАВАРГҮЙ БАЙДЛЫН ҮР ДАГАВАР II

*Дутуу дагах нь Бурханы мэлмийд  
дуулгавартай байдал огт биш ажээ.*

**Х**үн дуулгаваргүй байдалтай сээтэгнэх үед амьдрал нь хэрхдэгийг Израилийн анхны хаан Саулын амьдрал яруу тодоор харуулдаг. Түүний амьдрал нь итгэгч бидэнд олон талаар сургамж болсон, эмгэнэлт түүх билээ. Гол гол түлхүүр сургамж нь Эзэний Саулыг зэмлэн зассан үгд оршино. Бид Саулын амьдралыг хараад л тэнгэрлэг эрх мэдлийг бүрэн дагахгүй байхын сүнсний үр дагаврыг тодорхой ойлгоно. Хүн шиг хүлээж авсан хүнийг энэ ойлголт нь улам бэхжүүлж, түүний хувьд Саулын алдаа нь заавар, сэрэмжлүүлгийн аль аль нь болно. Бидэнд “Учир нь эрт үед бичигдсэн аливаа зүйлс нь биднийг сургахын тулд бичигдсэн юм” (Ром 15:4), “Энэ бүхэн жишээ болон тэдэнд тохиолдсон бөгөөд үүнийг үеийн төгсгөл тохиож буй бидэнд сануулга болгон бичжээ (1Коринт 10:11) гэсэн.

### Дутуу дагах

Израилийн тэргүүн эш үзүүлэгч Самуел Саулд Бурханы тушаалыг хүргэсэн түүхээр судлалаа эхлүүлье. Тэрбээр Саулд “Одоо явж

амалекчуудыг бут цохиод тэдний хамаг юмсыг бүрмөсөн сүйрүүлж, бүү өршөөгтүн. Эр эм, нялхас хүүхэд, үхэр хонь, тэмээ илжиг бүгдийг нь ал” (1Самуел 15:3) гэсэн Бурханы зааврыг хичээнгүйлэн биелүүлэхийг даалгажээ. Маш тодорхой, шулуун тушаал байна. Амалекуудын гэсэн бүхнийг - хүн, адгуустай нь нэгийг нь ч амьд үлдээлгүй хүйс тэмтрэх ёстой.

Гэтэл Саул юу гэж хариулсан? Тэрбээр: “Энэ чинь арай л харгис юм! Би чадахгүй” гэж хэлээгүй. Бид дуулгаваргүй байдлыг голдуу эрээ цээргүй тэрслэлээр л хязгаарлаж ойлгодог нь тоогүй. Гэтэл тийм байдаггүйг удахгүй үзнэ. Түүнчлэн Саул тухайн үедээ зөвшөөрсөн атлаа дараа нь санаагаа хувиргаагүй. Ийм төрлийн дуулгаваргүй авирыг бид бүгдээрээ мэднэ. Саул мөн тушаалыг эхлээд нухацтай авч үзээд, сүүлээрээ таг мартаад зөрчөөгүй. Ихэнх хүмүүс ийм авирыг яг ч дуулгаваргүй авир гэлгүй, “Яхав, алдаа гаргаж л дээ. Гэхдээ мань хүний сэтгэл нь цагаан юм даа” хэмээн өмөөрөх байх. Мэдээж эдгээр нь бүгдээрээ л дуулгаваргүй авирын хэлбэр гэдэгтэй дийлэнх маань санал нийлэх байх. Тэгвэл бүгдээрээ Саулыг анхааралтай харцгаая.

Саул тэр даруй цэргээ цуглуулаад, Амалек руу дайрахад бэлтгэжээ. Бүх зүйл онцсайн харагдаж байв. Саул Амалекийг довтлоод, эр эм, хүүхэд хөгшид, нялх нярайг нь хүртэл хядаж, хэдэн арван мянган хүн Саулын аугаа хүчирхэг цэргүүдийн илдний ирэнд амиа алджээ.

Тэгтэл Саул Амалекийн хааныг нь өршөөчихөж. Яагаад? Магадгүй тухайн үеийнхээ соёлын нөлөөнөөс санаа авсан байх. Тэр үед аль нэг улсыг булаан эзлэхдээ, удирдагчийг нь олзлоод, ордондоо авчран боол болгох нь нэгэн төрлийн амьд цом болдог байжээ.

Үүнээс гадна Саул хэдэн арван мянган мал амьтныг алсан. Тэгснээ хамгийн тарга тэвээрэг сайтай хонь, үхэр тэргүүтэй сүргийг нь үлдээгээд, Бурханд тахил болгон өргөөрэй хэмээн ард түмэндээ өгсөн нь үндсэндээ “Бичээсийн” үйлс шиг л харагдаж байв. Хүмүүс үүнд нь хэрхэн хандсаныг төсөөлж байна уу? Тэд Иехувад эдгээр малаар тахил өргөхдөө “Манай хаан ч Эзэнийг нэгдүгээрт тавьдаг мундаг хаан шүү” гэж бодох ёстой байв.

Гэтэл Саулын энэ үйлдэлд Бурхан тэс өөрөөр хандсан юм. Бурхан: “Би Саулыг хаан болгосондоо харамсаж байна. Учир нь тэр Намайг дагахаас буцан эргэж, Миний үг зарлигийг үл сахив” (1Самуел 15:11) хэмээн гашуудсан байдаг. Саул нэгээс бусдыг нь хядсан. Тэрбээр хүлээж авсан тушаалынхаа 99 хувийг гүйцэтгэсэн. Дийлэнх маань



Саулыг кампанит ажлаа тун дуулгавартай гүйцэтгэлээ л гэж үзэх байх. Гэтэл Бурхан Саулыг дуулгаваргүй авирлалаа хэмээжээ. Үнэндээ хэдхэн ишлэлийн дараа Бурхан эш үзүүлэгчээрээ дамжуулан Саулын үйлдлийг *тэрслэл* гэсэн байдаг. Ийнхүү дутуу дагах нь Бурханы мэлмийд дуулгавартай байдал огт биш ажээ. Ерэн есөн хувийн бараг л төгс дуулгавартай гэж хэлмээр үйлдэл нь дуулгавартай байдал байх нь бүү хэл, харин ч бүр тэрслэл байж.

Бид “Та яагаад миний хийснийг биш, хийгээгүйг л хардаг юм бэ?!” гэдэг үгийг их сонсдог. Саул ч ингэж хэлж болохоор байв. Тэгвэл энэ үг нь хүний учир шалтгааны гаргалгаатай таарч байгаа хэдий ч, тэнгэрийн үзэлтэй огт таарахгүй!

Самуел Саултай уулзахаар очтол, Саул: “ЭЗЭН таныг ерөөх болтугай! Би ЭЗЭНий үг тушаалыг сахилаа” (1Самуел 15:13) хэмээн хөөрцөглөн мэндчилжээ. Түүний дуу хоолойноос баяр хөөр дуулдаж, тэрбээр тушаалыг биелүүлсэн гэдэгтээ үнэн голоосоо итгэж байсан бол, Бурхан түүнийг *тэрсэллээ* гэсэн.

Тэгвэл бид Бурханы урьд шөнө айлдсан үг, Саулын зүрхний итгэл үнэмшил хоёрын тэнгэр, газар шиг ялгааг яаж гаргах вэ? Хариулт нь энэ байна: “Тэхдээ өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид бай” (Иаков 1:22). Хүн өөрт нь маш тодорхой илчлэгдсэн Бурханы Үгийг үл дагах эгшинд зүрхэн дээр нь бүрхүүл тогтдог бөгөөд тэр бүрхүүл нь үзэл бодлыг нь самууруулж, саад болдог ажээ. Үүнийг мэхлэл гэнэ. Саул учир шалтгааныхаа гаргалгаанд мэхлэгдэж, өөрийгөө зөв юм хийсэн гэдэгт итгэл төгс байсан ч, хэрэг дээрээ түүний буруу байжээ. Саулын итгэл нь хүний учир шалтгааны гаргалгаатай зөвшилцөж байсан ч, Бурханы бодит байдалтай зөрчилдөж байв.

Энэ нь Саулын Эзэний үгийг зөрчсөн анхны тохиолдол биш байв. Самуел өмнө нь Саулыг дуулгаваргүй авирлалаа хэмээн зэмлэж байсан (1Самуел 13:1-13). Дээрээс нь магадгүй Бичээс дээр тэмдэглэж үлдээгээгүй өөр олон тохиолдол ч байсан юм билүү. Саул дуулгаваргүй загнаад бүр дадчихжээ. Нэгэнт дадчихсан хүнд үнэнийг худлаас ялгаж салгах улам л бэрх болсоор байна.

### Мэхлэлийн бүрхүүл

Та аврагдсаныхаа дараа эхний удаа нүгэл үйлдсэнээ санаж байна уу? Би санаж байна аа. Яг л зүрхийг маань хутгаар бүлчих шиг л

болсон. Бурханы хүүхдүүд бид ийм мэдрэмжийг мэднэ. Энэ нь Ариун Сүнсний ятгалга бөгөөд зүрх маань биднийг буруушаадаг. Гэхдээ хэрэв бид хийсэн зүйлээ зөвтгөн, жинхэнэ гэмшлээс нүүр буруулбал, юу болох вэ? Хоёр зүйл болно. Нэгдүгээрт - бид нөгөө л дуулгаваргүй үйлдлээ давтан үйлдэх байраа эзэлнэ. Хоёрдугаарт - зүрхийг маань мэхлэл ороож, ятгалгын мэдрэмжийг намжаан, оронд нь учир шалтгааны гаргалгааг гаргаж ирнэ.

Дараа нь зүрхний маань бүрхүүлд тулсан ятгалгын ир тултал мэдрэгдэхээ больж, жаахан жаахан час хийсэн, таагүй мэдрэмж шиг л санагдаж эхэлнэ. Бид биеэ улам зөвтгөбөл - зүрхэн дээр минь давхар бүрхүүл тогтож, үнэний дуудлагыг улам намжаана. Тэгээд бид дараа дараагийн удаа зөрчил гаргах үедээ ёврох төдий ятгалгыг л мэдэрнэ. Тийм боловч биеэ өмөөрсөөр л байвал, зүрхийг маань өөр нэгэн үхлийн бүрхүүл зузаалаад авна. Тэгээд ч нүглээ хийсээр байвал, ямар ч ятгалга байхгүй, зөвтгөлөөр ханхалсан, зузаан гэгчийн бүрхүүл л үлдэнэ. Мэхлэл биднээс үнэнийг нууж, урьдын ухамсар, мэдрэмжийг маань мохооно.

Энэ үед хүн бүх төрлийн бурханлаг чанараас зайлах юмуу эсвэл бүр бурханлаг дүр төрхөө хадгалсан хэвээр байх атлаа Бурхантай гэрээ тогтоогоогүй хүмүүсээс бараг ялгарах юмгүй амьдарч эхэлнэ. Тэрбээр Христэд итгэдэг гэх боловч, эдүгээ сайн муугийн талаарх төөрөлдсөн мэдлэгээрээ амьдарна. Түүний зөв, буруугийн мэдрэмж нь Ариун Сүнсээр зүрхэнд нь үлээгдсэн Бурханы Үгээс бус, тэс өөр сурвалжаас эхээ авна. Тэрбээр зүрхнийхээ мэхлэл бүхий захирамжаар амьдарна. Энэ нь Бичээсийн хөнөөдөг үгс ч байж болох (2Коринт 3:6) эсвэл зөв, буруугийн талаарх нийгмийн хэмжүүр ч байж болох. Аль нь ч байсан тэрбээр амьд Бурхантай харилцаа тасарчээ. Одоо түүнийг хөндөж чадах ганц л зам үлджээ - Бурханы илгээсэн элч.

## **Гурван алхам бүхий үйл явц**

Бурхан хүнийг дуулгавартай байдал руу нь эргүүлэхдээ, шаталсан үйл явцаар дагуулдаг. Нэгдүгээрт - Бурхан хүнийг ямагт ятган ухааруулах гэж оролддог. Тэгтэл удаа дараалан дуулгаваргүй авирлаад байвал, тэрбээр мэхлэлийн бүрхүүлээсээ болоод Бурханы зүрх, чиглүүлэгтэй холбоо бүрэн тасрах учраас, Бурхан Саул руу Самуелыг явуулсан шигээ, Өөрийнхөө хэн нэг зарцад үг дайн, тэр

## ДУУЛГАВАРГҮЙ БАЙДЛЫН ҮР ДАГАВАР II

хүн рүү илгээнэ. Эш үзүүлэгч нь хүнд Бурханы арга замыг харуулах үйлчлэлтэй. Бурхан ямар ч хүнд эш үзүүлэх даалгавар өгч илгээж болно. Хүн заавал “төрмөл” эш үзүүлэгч байх албагүй. Үг нь пастор, аав ээж, дарга, хань, найз гэх мэтчилэн хэнээр ч ирж болно. Иаков: “*Ах дүү нар минь*, хэрэв та нарын нэг чинь үнэнээс гажаад, хэн нэг чинь түүнийг эргүүлэн авчирвал, хуурамч замаас нь нүгэлтнийг эргүүлж авчирсан тэр хүн түүний сэтгэлийг үхлээс аварч, тоо томшгүй олон нүглийг халхлах болно гэдгийг та нар мэдэгтүн” (Иаков 5:19-20) гэсэн. Иаков энэ үгээ нүгэл хийж байсан итгэдэг хүмүүст хандаж хэлснийг тэмдэглээрэй. Түүнчлэн “олон нүгэл” гэдэг үгийг анхаарна уу. Удаа дараалсан дуулгаваргүй байдлаас болж тэнүүчлэл эхэлдэг.

Эш үзүүлэх элчийг (эсвэл элч нарыг) илгээгээд ч, бид сонсохгүй байвал, Бурхан биднийг шийтгэлээр ухааруулах гэж үзнэ. Паул “Бид өөрсдийгөө нягталсан (*шүүсэн*) бол *шүүгдэхгүй* байхсан” (1Коринт 11:31) гэжээ. Шүүх гэдэг язгуур үг нь Бичээст хоёр удаа гардаг ч, тус бүр өөр Грек үг хэрэглэсэн байдаг. Эхнийх нь “Бид өөрсдийгөө шүүсэн бол” гэхэд “өргөн тусгаарлагдах” гэсэн утга бүхий *диакрино* гэдэг Грек үгийг хэрэглэсэн. (Бид ариун нандинаас бузрыг зайлуулахаар өөрийгөө шүүх үед ийм юм болдог) Үүнийг дуулгаваргүй байдлаа улайж гэмшсэнээр хийнэ. “*Шүүгдэхгүй байхсан*” гэдэг хоёр дахь тохиолдол нь “шийтгэх юмуу яллах” гэсэн утга бүхий *крино* гэдэг Грек үг болно. Паул цааш нь: “Харин бид шүүгдэхдээ (*крино*, шийтгүүлэхдээ) ертөнцтэй хамт яллагдахгүйн тулд Эзэнээр сахилгаждаг (и32) гэв. Бурхан биднийг дэлхийтэй хамт яллагчигүй юмсан гэсэндээ, дуулгаваргүй байдлаас маань ангижруулахыг хүсдэг (Матай 7:20-23, Лук 12:45-48).

Тэгэхээр хүмүүс нь Бурханы эш үзүүлэл бүхий анхааруулгыг эс тоох юмуу татгалзах үед Бурхан тэднийг яаж шийтгэдэг вэ? гэдэг асуулт ургана. Хариулт нь голдуу бэрхшээл, өвчин юмуу зовлонгийн хэлбэрээр ирнэ. Магтаалч:

Зовж шаналахынхаа өмнө би

Буруу зүгт явсан байжээ.

Харин одоо би Таны үгийг сахин биелүүлдэг.

Аяа ЭЗЭН, Таны шүүлтүүд зөв шударга бөгөөд

Та итгэмж дотроо намайг

Зовоон шаналгасан гэдгийг би мэднэ (Дуулал 119:67, 75) гэсэн.

Хэрэв бид Паулын тухайн чуулганд хэлсэн үгийг өөр орчуулгаас харах юм бол, маш тодорхой болж ирнэ: “Үүнээс болж та нарын дунд сул дорой, өвчтэй нь олон байгаа бөгөөд нэлээд нь нойрсож байна. Бид өөрсдийгөө нягталсан бол шүүгдэхгүй байхсан” (1Коринт 11:30-31).

## Яруу тод жишээ

Хүмүүс Бурханы засварын үйл явцсын эхний хоёр арга барилыг хайхраагүйгээсээ болоод шийтгүүлэхийг би олон харсан. Тийм нэгэн явдал 1990 онд Техасын нэгэн залуусын кэмп дээр номлох үед минь болсон юм. Нүглээс болж олон залуус Эзэнд хатуу ханддаг болоод байсан учраас, тэр долоо хоног томоохон хэмжээний нүүрэлдэх үйл ажиллагаагаар эхлэв. Цуглаан болгон дээр олон залуус, бүсгүйчүүд урагш гарч ирээд, нүглээ гэмшиж байв. Тэд гол төлөв бэлгийн харилцааны нүглээ улайж, Есүсийн цусаар сүр жавхлантайяа цэвэрлэгдэв. Би бүтэн долоо хоног үргэлжилсэн гэмшлийн улмаас төгсгөлийн өдөр тэсрэлт болно гэсэн хүлээлттэй байлаа.

Гэхдээ би төгсгөлийн цуглаанд орж ирэхдээ, миний хүсэн хүлээж байсан уур амьсгал байхгүйг ухаараад, дахиад л засвар, гэмшилд уриалан дуудах хэрэгтэй болов. Тэгээд миний номлох цаг ирэхэд, би микрофоныг аваад залбирч эхэллээ. Ариун Сүнс надад: “Энэ танхимд нэгэн тэрслүү хүн байна. Тэр хүнд дахин урагш гарах боломж олго” хэмээв. (Уг нь би өмнөх цуглаан дээр нь тэрслэлийн талаар номлосон байв) Намайг дуудахад, хэдэн залуус урагш гарч ирсэн боловч, тэдний дунд Ариун Сүнсний онилсон нөгөө хүн байхгүйг би зүрхээрээ мэдэрлээ. Тэд бол магадгүй өөр бас бус асуудлаа шийдэх гэсэн, зөөлөн зүрхтэй залуус байлаа.

Гэтэл Ариун Сүнс зүрхэнд маань дахиад л айлдав: “Тэр хүнд хэрэв өнөөдөр хариулахгүй аваас, амьдралд нь шийтгэл бууна гэж хэл.” Би ч миний зүрхэнд хэлсэн Ариун Сүнсний үгийг үгчлэн хэлтэл, дахиад хэдэн залуус гарч ирсэн боловч, Бурханы Сүнсний онилсон нөгөө хүн байхгүй байгаа нь мөн л мэдрэгдлээ.

Тэгтэл Ариун Сүнс дахиад л зүрхэнд минь өгүүлэв: “Тэрбээр гэмшихгүй аваас, ямар шийтгэл буухыг хэл.” Ариун Сүнс надад ийм зүйл мэдрүүлсний дараа би Түүний дууг дахин сонсов: “Тэрбээр өнөөдөр гэмшихгүй аваас, гурван долоо хоногийн дотор машины

*осолд орно гэж хэл.*”

Би ч айсандаа хамаг хөлсөө цутгуулсаар, Ариун Сүнсний зүрхэнд маань дуулгасан хатуу үгийг давтан хэллээ. Бүр ч олон залуус урагш гарч ирсэн боловч, тэдний нэг нь ч Эзэний онилсон хүн биш болохыг мэдрэв. Тэгээд Эзэн намайг урагшаа гарч ирсэн хүмүүсийн төлөө залбирахыг зөвшөөрсөнд би ч залбирч эхэлсэн бөгөөд үүний дараа миний хүсэн хүлээж байсан хүчирхэг үйлчлэл өрнөв. Эзэний мутар олон залууст хүрч бас олон залуус үйлчлэлд дуудагдав. Нэг хэсэг нь эдгэрч, амьдралдаа чиглүүлэг хүлээн авав. Энэ орой бидний нэг хэсэгтээ л мартахгүй - магадгүй бүр хэзээ ч мартахгүй орой байлаа.

Хэдэн сарын дараа залуусын пастор, бид хоёр утсаар яриw. Тэрбээр залуусын кэмпийн тайлангаа тавихдаа ингэж өгүүлсэн юм: “Жон, манай залуусын бүлэгт бидэнд хамгийн их төвөг учруулдаг нэгэн ахлах сургуулийн охин байдаг юм. Тэр цаг үргэлж биднээс зөрүүдэлж, асуудал тарьдаг. Тэр орой Ариун Сүнс яг түүний талаар ярьж байгааг би мэдсэн. Даанч тэр гэмшээгүй нь харамсалтай. (Харин би тэр охиныг хэн болохыг нь огт мэдээгүй байw)

Тэгээд цааш нь: “Кэмпээс гурван долоо хоногийн дараа тэр яг таны хэлснээр машины осолд орсон боловч, машин нь яагаа ч үгүй” гэw.

Охин яасан бол гэж бодохоос хамаг бие зарайгаад л явчихлаа. Би Бурханы Сүнсээр ярьснаа мэдэж байсан ч, хамгийн гол нь тэр хүн аюул гамшигт өртөхөөсөө өмнө Бурханы дуудлагыг бушуухан сонсоосой л гэж хүсч байсан юм.

Пастор цааш нь: “Бурхан түүнийг амьд үлдээсэн! Бие нь нилээд хүнд байсан ч, одоо овоо болсон. Одоо мань хүн шал өөр хүн болж, чуулганы маань хамгийн галтай охидын нэг болсон. Түүний амьдрал орвонгоороо өөрчлөгдсөн!” гэлээ. Миний санаа амарч, түүний төлөө баяслаа. Давид “Зовж шаналахаасаа өмнө би буруу зүгт явсан байжээ” гэж хэлснийг дахиад сонс.

Би танд маш тодорхой хэлье. Бурхан биднийг гуяа алгадаж ирээд л шийтгээд байдаг юм биш. Бурхан зүгээр л бидний дээрээс хамгаалагч мутраа татаад л, дайсанд дуулгавартай байдлын маань улмаас бидний дээр тогтож байсан аюулгүй байдал руу маань халдах зөвшөөрөл олгочихдог юм. Магтаалч:

Та толгой дээгүүр маань  
Хүмүүсийг мордуулсан.

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Бид гал ба усан дундуур гарсан.

Гэлээ ч Та биднийг

Элбэг баян газарт авчирсан (Дуулал 66:12) гэдэг.

Үүнийг өөр нэгэн орчуулга дээр: “Та биднийг баялаг биелэл рүү авчирсан” гэдэг. Тэр залуу бүсгүй осолд орж байж л ухаарчээ. Тэгээд эмнэлэгт байхдаа гэмшиж, баялаг биеллийн газарт гарч иржээ. Уг нь Бурхан анх ийм замыг тохоогоогүй. Харамсалтай нь эхний аргууд нь бүтэлгүй, эцсийн арга нь л бүтжээ.

Ийм явдал бүгдээрээ ийм сайхан төгсдөгсөн бол. Харамсалтай нь үгүй юм. Өөр нэгэн тохиолдол санаанд орж байна. Миний танил нэг үйлчлэгч нэгэн тэрслүү залууд анхааруулсаар байжээ. Залуу анхаараагүй явсаар байгаад, удалгүй машинтай мөргөлдөж, газар дээрээ нас барсан юм. Ийм жишээ маш олон - зарим нь гэмшиж ерөөгдсөн бол, зарим нь Саул хаан шиг л дууссан байдаг.

### Дуулгавартай байдал, тахилын ялгаа

Бүгдээрээ Саулын түүхээ эргэн үзье. Самуел Саулын мэхлэгдсэнийг үзээд, жинхэнэ эш үзүүлэгч хүнийхээ хувьд шууд л асуудлынх нь амийг багалзуурдаж авчээ. Самуел: “Тэгвэл миний сонорт буй хонины майлах дуу, надад сонсдож байгаа үхрийн мөөрөлдөх дуу чухам юу вэ?” (1Самуел 15:14) гэж асуусан байна.

Гэтэл Саул тэр даруй: “Эдгээрийг тэд амалекчуудаас авчирсан юм. Учир нь таны Бурхан ЭЗЭНД нядалж тахихын тулд хамгийн сайн хонь, үхрийг ард олон хэлтрүүлсэн юм. Гэвч бусдыг нь бид бүрмөсөн сүйрүүлэв” (1Самуел 15:15) гэж хариулжээ.

Саулыг үнэнтэй нүүрэлдүүлэхэд, тэрбээр бурууг биеэсээ зайлуулан, хүмүүс рүү чихээд: “Би дуулгавартай дагахыг хүссэн ч, хүмүүсийн шахалтаас болж аргагүйдлээ” гэжээ. Гэмшил байхгүй зүрхтэй хүн дуулгаваргүй авирлаж байгаад баригдахаараа, хийсэн хэрэгтээ хариуцлагаа хүлээлгүй, бусдыг буруутгадаг.

Адам Бурханыг бас Еваг буруутгасан. Ева могойг буруутгасан. Адам үнэн хэлсэн. Үнэхээр ч Бурхан түүнд эмэгтэйг өгсөн бол, эмэгтэй түүнд жимс өгсөн. Гэхдээ Ева Адамын ам руу чихээгүй. Адам дурандаа л идсэн. Тийм ээ, Ева мэхлэгдсэн. Гэхдээ тэр дуулгаваргүй байх сонголт хийсэн.

## ДУУЛГАВАРГҮЙ БАЙДЛЫН ҮР ДАГАВАР II

Саул хүмүүсээ удирдсанаас биш, хүмүүс түүнийг удирдаагүй. Тэрбээр өөрийнхөө төдийгүй, хүмүүсийнхээ дуулгаваргүй авирт хариуцлагатай байв. Удирдаж, заавар өгөх эрх мэдэлтэн нь Саул байсан. Удирдагч нар минь, анхааралтай сонс - та нар халамжилж буй хүмүүсийнхээ амьдралд нэвтрүүлсэн дуулгаваргүй байдлын төлөө хариуцлагатай.

Хөвгүүд нь Бурханы тушаалыг үл хэрэгсэж байгааг Самуелын харгалзагч, Израилийн удирдагч Ели мэдсэн ч, юу ч хийгээгүй юм. Тэрбээр хөвгүүдийнхээ баруун гарыг “бай - бай!” гэж цохисон боловч, эрх мэдлээ хэрэгжүүлэн, тэднийг зайлуулж буулгаагүй юм. Тиймээс Бурхан: “Түүний хөвгүүд өөрсдөдөө хараал авчирсан бөгөөд тэр тэднийг хазаарлаагүй тул түүний мэдсэн хилэнцийн учир өөрийнх нь гэрийг мөнхөд шийтгэхээр зэхэж байгаа хэмээн Би түүнд хэлсэн билээ” (1Самуел 3:13) хэмээн мэдэгджээ. Хөвгүүд нь шүүгдээд зогсохгүй, Ели ч шүүгдсэн байна.

Дараа нь Саул “хонь, үхрээр Эзэнд тахил өргөх гэсэндээ л...” хэмээн биеэ зөвтгөсөн. Тэрбээр дуулгаваргүй байдлаараа Эзэнийг баярлуулсан тахил өргөж, үйлчилж болно хэмээн сэтгэсэн нь цэвэр мэхлэгдэл байжээ. Энэ бол тэрслэлийн маш нарийн, зальжин хэлбэр.

Есүс: “Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага” (Матай 16:24) гэсэн. Зарим хүмүүс загалмайн золиостой амьдралыг төлөөлсөн, зовлонгийн дүр дээр л анхаараад байдаг. Гэтэл Есүсийн үг ганц энэ тал дээр төвлөрөөгүй байна. Та өөрийгөө няцааж амьдарсан ч, Бурханы зорилго юмуу хүслийг биелүүлэхгүй явж болох нь байна! Үнэндээ та өөрийгөө няцааж, золиос болсон ч, Бурханд тэрсэлсэн хэвээрээ байж болох!

Есүс *дуулгавартай байдал* гэдэг ганц зүйл дээр л төвлөрчээ. Бид үүнийг загалмайгаа тээж явснаараа л гүйцэлдүүлж чадна. Учир нь хүн хувийнхаа санаа, хүслийг үхүүлэхгүйгээр Бурханы хүсэл, хүний хүсэл хоёрын дунд цайчихсан царйлсаар яваад байж болно. Хэрэв бид хувийнхаа амьдралыг хойш тавихгүй бол, Бурханы хүсэлтэй сөргөлдсөн хүслээ биелүүлэх арга замыг олоод, үүнийгээ яг л Саул шиг бүр Бичээсээр батлан хамгаалах болно. Бид өөрөөсөө: “Дуулгаваргүй байдлаар Бурханд үйлчилж болох уу?” гэж асуух ёстой. Болдог юм бол, Сатан бидний “Бичээсийн” шашинлаг үйлээс юмуу тахилаас алдрыг нь булааж авна. Учир нь Сатан бол тэрслэлийн зохион бүтээгч бөгөөд эзэн билээ.

Гэтэл Саулын гаргалгааг Самуел нам болгов:

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Самуел, Саулд

—Хүлээгтүн. Урьд шөнө ЭЗЭН надад юу гэж айлдсаныг танд мэдүүлье гэхэд Саул түүнд

—Яригтун гэв. Самуел

—Хэдийгээр та өөрийн нүдэнд дорой байсан ч Израилийн овгуудын тэргүүн болсон бус уу? ЭЗЭН таныг Израилийн хаан болгож тосолсон биш үү? ЭЗЭН таныг аян замд илгээн “Явж, нүгэлтэн амалекчуудыг устган тэднийг бүрмөсөн устаж дуустал тэдэнтэй тулалд” гэсэн. Та юунд ЭЗЭНий дуу хоолойг дуулгавартай дагалгүй, харин олз уруу шунан дайрч, ЭЗЭНий мэлмийд ёрын мууг үйлдэв? гэжээ.

(1Самуел 15:16-19)

Самуел “Чи өөрийнхөө нүдэнд өчүүхэн байхдаа, Израилийн овгуудын удирдагч болгогдсон” гэжээ. Өөрөөр хэлбэл “Саул чи, анх хаан болж байхдаа, хичнээн даруу, номхон байлаа даа” гэжээ. Олон жилийн тэртээ Самуел Саулыг хаан болохыг нь анх зөгнөж байв. Саул үүнд нь итгээгүй. “Би Израилийн хамгийн жижиг овгийн бениамин хүн бөгөөд миний ураг Бениамин овгийн бүх ураг дотроос хамгийн дорой нь бус уу? Яагаад та надад ийм үг ярина вэ?” (1Самуел 9:21) Саул өөрийгөө хаан гэж хараагүй. Тэрбээр Бурхан яагаад өөр шиг нь өчүүхэн хүнийг хаан болгов хэмээн гайхширчээ.

Хожим Эзэн түүнийг Израилийн өмнө илчлэхийг хүсэхдээ, овог бүрийг шоджээ. Гэтэл Бениамин овог сонгогдов. Тэднээс Саулын гэр бүл сонгогдов. Тэгээд эцэст нь Саул сонгогдов. “Тэр Бениамины овгийг ургаар нь ойртуулсан бөгөөд Матрийн ураг тунасан билээ. Тэгээд Кишийн хөвгүүн Саул тунав. Харин тэд Саулыг эрж хайсан боловч олсонгүй. Тиймээс тэд ЭЗЭНээс

—Тэр хүн энд ирсэн үү? гэж лавлаж асуув. ЭЗЭН

—Харагтун, тэр хөсгөн дотор нуугдаж байна гэв” (1Самуел 10:21-22).

Саул Бурханы хүмүүсийг захирна гэхээс ухаан жолоогүй айжээ. Тэрбээр өөрийгөө өчүүхэн гэж үзсэн. Самуел Саулд энэ явдлыг нь сануулаад: “Эзэн чамд даалгавар өгөөд “Яваад, алаарай!” гэсэн. Чи өөрийгөө Эзэнээс илүү мэддэг гэж бодоо юу?” Хэзээнээс “таны” цэц ухаан Бурханыхаас давдаг болоов? Та Бурханы байрыг эзлэх болоо юу? Яахаараа чи Бурханаас гадуурх эх сурвалжаас буруу, зөвийг хайдаг болоов? Нөгөө бүрэг, даруу хүн яагаав?” гэжээ.

Бидний дунд Бурханаас илүү мэддэг хүн бий юу? Мэдээж байхгүй! Гэхдээ бид дуулгаваргүй байдлаараа Бурханд болоод бусдад нэгийг



хэлээд байдаг. Өөрийгөө алдрын сэнтийд суугаа Нэгэнээс ухаантай гэж сэтгэх нь хичнээн мунхаг байх билээ? Ертөнцийг бүтээсэн төдийгүй тогтоодог Нэгэнээс шүү. Бүтээгч маань хуруугаараа тэнгэрт оддыг өрдөг юм. Гэтэл бид Түүний зөвлөгөөг үл тоохдоо, хүний цэц ухааныг өргөмжлөх!

### Тэрслэл ба илбэ шид

Самуел эш үзүүлэгч хүний эрхээр Саулыг цоо хараад:

“ЭЗЭНий дуу хоолойг дуулгавартай дагах нь шатаалт тахил, нядлах тахилуудаас илүүгээр ЭЗЭНийг баярлуулах бус уу? Харагтун, дуулгавартай дагах нь нядлах тахилаас илүү, Анхааран үзэх нь хуцын өөхнөөс илүү. Тэрслэл нь мэргэ төлгийн адил нүгэл бөгөөд Гөжүүдлэх нь ёс бус агаад шүтээнд мөргөх адил билээ (1Самуел 15:22-23) гэжээ.

Самуел тэрслэлийг шууд илбэ шидтэй холбожээ: “Тэрслэл нь мэргэ төлгийн адил нүгэл.” Энд *адил* гэдэг үгийг ташуулдуулж бичсэн байгааг анхаарна уу. Эх бичвэр дээрээ байхгүй үгийг Кинг Жэймс Вержн, Нью Кинг Жэймс Вержн Библи гаргаж ирж хэрэглэхдээ, ийнхүү ташуулдуулан бичсэн байдаг. *Адил* гэдэг үгийг тухайн өгүүлбэрийн утгыг тодорхой болгох үүднээс хожим орчуулагч нар нэмсэн юмсанж. Угтаа зүгээр л “мөн” гэвэл ононо.

Энэ өгүүлбэр нь “Тэрслэл нь мэргэ төлгө мөн” гэж уншигдах ёстой юм. Ингэсэн тохиолдолд Бичээсийн агуулга маш тодорхой болж ирнэ. Тэрслэлийг илбэ шидтэй зүйрлэх нь нэг хэрэг бол, тэрслэл нь үнэндээ илбэ шид мөн хэмээн мэдэгдэх нь тэс өөр хэрэг билээ. Жинхэнэ итгэгч хүн санаатайгаар илбэ шидийг хэрэгжүүлэхгүй нь тодорхой. Гэвч тэрслэлийн мэхлэлээс болж хичнээн олон хүн санаандгүйгээр үүний нөлөөнд автдагийг мэдэх үү?

*Илбэ шид* гэхээр шүүр унаж, шившлэгэ уншсан эсвэл ил гал дээр буцалж байгаа тогоотой усан дээгүүр болор бөмбөлөг бөмбөрүүлэн, ирээдүйг үзэж харах хар хувцастай шулмууд санаанд буумаар. Одоогийнхоор бол нэр нөлөөний төлөө бусдыг шившиж, хараадаг хүн юмуу даа. Тэгвэл бүгдээрээ энэ хоёр ойлголтыг хойш тавиад, ер нь илбэ шид гэдэг зүйлийн амь юундаа байдгийг олж мэдье.

Энэ илбэ шидийг Еврейгээр *кэсэм* гэдэг. Англи дээр *мэргэ төлгө, илбэ шид, ховс увидас* гэж болно. Гэвч мэргэжилтнүүд, “энэ үг нь оккультизмтай яг яаж холбогддог нь тодорхойгүй” гэдэг бөгөөд тиймээс ч энэ үгийг тухай бүр янз бүрээр орчуулдаг ажээ. (*Theological Wordbook of the Old Testament*, vol. 3, p.805) Тийм боловч илбэ шидийн хэлбэр юмуу арга нь бус, харин үр дүн буюу зорилго нь л хамгийн чухал юм.

Илбэ шид нь шууд л чөтгөрийн аль нэг талбарыг нээдэг. Үүний зорилго нь нөхцөл байдал, тохиолдлыг юмуу хүмүүсийг янз бүрийн арга хэлбэрээр *хянан захиргаадах* явдал бөгөөд оролцогч хүн нь ихэвчлэн сүнсний ертөнцөд өрнөж байгаа үйл явдлын талаар ямар ч ойлголтгүй байдаг. Хүн өрнөж буй үйл явдлын талаар юу ч гадарлахгүй байж ч болно эсвэл ямар харын хүч оролцож байгааг сайтар мэдэж байх ч болно. Товчхондоо, илбэ шидийг бүрэн ухамсартайгаар юмуу бүрэн ойлголттойгоор үйлдэх боломжтой. Илбэ шид нь хянан захиргаадах зорилготой боловч, дээрээсээ чөтгөрийн нөлөөтэй учраас, хянан захиргааддаг этгээд нь өөрөө ямагт хянан захиргаадалт дор байдаг.

## Дуулгаваргүй байдлаар ирэх боолчлол

Залуусын пастораар үйлчилж явсан хүнийхээ хувьд миний бие нууц шүтлэгтэй (оккульт) нүүр тулж үзсэн билээ. Ахлах сургуулийн ахуй соёл их бага хэмжээгээр сүнсний үйлтэй хутгалдсан залуусаар дүүрэн байдаг. Ангийнх нь хүүхдүүд илбэ шидтэй юмуу сатанизмтай хутгалддаг талаар манай цуглааны хүүхдүүд бүлгийнхээ удирдагч нарт байнга ярьдаг байв.

Нууц шүтлэгийн үйлийн талаар би маш сонирхолтой нэгэн зарчим сурсан юм: Илбэ шидийн бүлэглэлийн толгойлогч нар хүрээндээ шинэ хүнийг элсүүлэхдээ мансууруулах, архидуулах, ёс бус бэлгийн харилцаанд оруулах зэрэг Бурханы юмуу улсын хуулийг зөрчсөн хэрэгт уруу татан, урвуулдаг байна. Бурхан надад “тэрслэл нь илбэ шид” болохыг илчлэхээс өмнө би үүний нарийн учрыг мэддэггүй байсан юм.

Учир нь тэдэнд тэрслэх тусам хүчирхэгжинэ гэж заадаг бөгөөд тэд өөрсдөө ч хүчинд улайрна. Тэрслэл нь илбэ шид учраас, энэ үнэн билээ. Хүмүүс тэрслэх тусмаа, чөтгөрийн нөлөө бүхий, хянан захиргаадагч, хүчирхэгжүүлэгч хүчинд нэвтрэх хууль ёсны эрхийг

олж авдаг. Тэд хууль дүрэм, Бурханы хууль, Бурханы төлөөний эрх мэдэлтэй тэрсэлдсэнээрээ, чөтгөрийн мэдлийн талбарт шууд нэвтрэх хууль ёсны эрхтэй болдог.

Энэ талаар ховсчдын “сатаны библи” гэж нэрлэдэг ном дээр өгүүлдэг. Хэдэн жилийн өмнө гэргий, бид хоёр цуглааны дараа буудлын өрөөндөө зурагтын суваг эргүүлж байгаад, сатанизм, илбэ шидийн талаар дагнасан сувагтай таарчихав. Миний хувьд сувгаа даруйхан солих нь зөв явдал байлаа. Учир нь сүнсний тулааны талаар Бурханаас л суралцах ёстой гэдэгт бид итгэдэг. Гэтэл би яагаад ч юм жаахан сонсоодхоё гэсэн санаандаа автав. Тэр нэвтрүүлгээр сатаны библийн талаар ярьж байлаа. Хөтлөгч нэгдүгээр тушаалыг уншлаа: “Хүссэн зүйлээ хий.”

Би анхаарав. Тэр даруй толгойд маань Бичээсүүд орж ирэв. Магтаалч:

Тэгэхэд би “Харагтун, би ирлээ.

Миний тухай хуйлмал номд бичигдсэн байдаг.

Бурхан минь ээ,

Таны тааллыг би

гүйцэлдүүлэх дуртай.

Таны хууль зүрхэнд минь бий” (Дуулал 40:7-8) гэсэн.

Есүс Өөрийнхөө талаар “Би Өөрийнхөө хүслийг бус харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг” (Иохан 5:30) гэсэн. Эзэн Өөрт нь дуулгавартай хүмүүст анхаардгийг би амьдралаас сурсан. Тэгвэл эсрэгээр - тэрслүү хүмүүст харанхуйн сүнснүүд татагддаг нь бас үнэн ажээ. “Хүссэнээ хий” гэдэг тушаал нь шууд Бурханы Үгийг тонгоруулсон явдал бөгөөд тэрслэлийн талаар хэлсэн Бурханы үгтэй яг таардаг.

Сайн дураараа Сатанд захирагддаг хүмүүс энэ зарчмыг мэддэг бол, нөгөөтэйгүүр зүгээр л мэхлэгдээд, толгой нь эргэчихсэн хүмүүс бас байна. Хайхрамжгүй хүмүүс хууль ёсгүй байдлаа эрх чөлөөтэй андуурдаг. Гэхдээ тэрслэлд эрх чөлөө байхгүй. Яг юу болдгийг Шинэ гэрээ тодорхой илчилдэг. Тэр хүмүүс завхралын зарц болдог. Петр тэдний алдааг: “тэдэнд эрх чөлөөг амладаг атлаа өөрсдөө ялзралын боол билээ. Учир нь хүн юунд дийлдэнэ түүндээ боолчлогддог ажээ (2Петр 2:19) гэжээ.

Үнэн илэрхий байна. Эрх чөлөө бус, харин сэтгэлийг чөтгөрийн дарамтанд нээж өгдөг хүлээс, хяналт л байна. Паул энэ санааг давтан цохжээ: “Та нар өөрсдийгөө дуулгавартай боол болгон хэн нэгэнд өгөхдөө, үхэлд хүргэх нүгэл ч бай эсвэл зөвт байдалд хүргэх дуулгавар ч бай, дагах нэгнийхээ боол нь болдогоо мэдэхгүй гэж үү?”

Есүс ч энэ зарчмыг цохсон: “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Нүгэл үйлдэгч бүр нүглийн боол мөн” (Иохан 8:34). Каин Эзэнд өргөл өргөх сонголт хийхдээ дуулгаваргүй авирласныг санаж байна уу? Гэтэл Бурхан түүнд сонголт нь хувь тавиланг нь шийднэ гэж хэлсэн. Тэрбээр Бурханы хүслийг сонгож, нүглийн захиргаанд (илбэ шидэд) үүдээ хааж болно эсвэл тэрслээд, өөрийг нь эрхшээж, хянан захиргаадахаар гэтэн мяраах нүгэлтэй тэнгэрийн ямар ч хамгаалалт, хүчгүйгээр гар нүцгэн нүүр тулж болно.

Бурхан Каинд анхааруулсан шиг Самуел ч Саулд анхааруулсан. Саул тэрслэлээсээ болж хянан захиргаадагч сүнсний нөлөөнд нээгдсэн тул эрүүл ухаантай байхдаа хэзээ ч гаргахгүй байсан авираа гаргахад хүрчээ. Саул жинхэнээсээ гэмшээгүй бөгөөд түүнийг тэрслэсний дараахнаас амьдралд нь тамлагч, муу ёрын сүнс ирээд, зовоодог болсон тухай 1Самуел 16:14 дээр хэлдэг. Түүнээс хойш ёрын сүнс түүний амьдралд нэвтрэх хууль ёсны эрхтэй болжээ. Саул гэмшээгүй учраас, амар амгаланг эс олов. Саул анхан үеийнхээсээ тэс өөр хүн болж хувирчээ.

Тэрбээр аав, эш үзүүлэгч Самуел тэргүүтэй эрх мэдэлтнийг дагадаг, Бурханы юмсыг хүндэтгэдэг даруухан залуугаас үнэ хүндтэй бүхнээ уландаа гишгэлсэн этгээд болж хувирчээ. Түүнийг бага залуу байхад нь хүрч очоод: “Саул аа, хожим чи хилэгнэхдээ, ямар ч гэм буруугүй наян таван тахилчийг гэр бүлтэй нь ална” гэж хэлсэн бол, тэрбээр таныг солиотой амьтан гэж үзээд: “Бүү үзэгд! Би хэзээ ч тийм юм хийхгүй” гэх байсан байх. Харамсалтай нь тэр үүнийг хийсэн (1Самуел 22).

Муу ёрын сүнс түүнийг атаархал, хилэн, үзэн ядалт, тэмцэл, аллага, мэхлэлд урвуулжээ. Энэ сүнс Саулыг гэмшил байхгүй дуулгаваргүй зангаар нь захирч байв. Саул Бурханы бөгөөд өөрийнх нь итгэмжит зарц Давидыг хөнөөхөөр мөшгижээ. Саул Давидыг урвагч гэж үзсэн атал үнэндээ Давид Бурханы зүрхийг мөшгидөг хүн байв. Чөтгөрийн хяналтын хороор Саул мэхлэлийн өтгөн үүлэн дундуур үнэнийг тодорхой харахаа больжээ. Үнэн нь худал болж, худал нь үнэн болсон байв.

## ДУУЛГАВАРГҮЙ БАЙДЛЫН ҮР ДАГАВАР II

Би ч ийм явдлыг үзэхээрээ л нэг болсон! Хүмүүс гэлтгүй би өөрөө ч ийм байдалд орж явсан. Би дуулгаваргүй зангаар дураараа авирлаж, мэхлэлд унаж ойчоод, нус нулимстайгаа хутгалдаж л явлаа. Тийм үедээ би бурханлаг эрх мэдлийг хуульчирхаг юмуу буруу хэмээн үзэж, бурханлаг найзуудыгаа дайснаа хэмээн үздэг байлаа. Тэгээд бусад тэрслүү хүмүүст татагдаж, хэдийнээ бадарч байгаа дуулгаваргүй зангийн түймрээ улам л дүрэлзүүлдэг байв. Бид өөрсдийгөө Эзэнтэй ойрхон амьдарч яваа, Бурханы гаргаж ирж буй “шинэ төрлийн” үйлчлэгч нар хэмээн үзнэ. Ээ Бурхан минь, над шиг хүнийг өршөөсөнд баярлалаа! Та бүхэн над шиг мэхлэгдэлгүй, мэлмий чинь нээгдэж, энэ замыг таних болтугай!

## БҮЛЭГ 7

# ИЛБЭДҮҮЛСЭН

*Бурханы Үгийн гэрэл мэхлэлийг ил гаргаж,  
хүний зүрхний бодол, санааг ангилдаг.*

**Т**эрслэл бол илбэ шид. Хуульгүй байдлын нууц зарчмын үр нөлөө нь нийгэмд ил тод байдаг шигээ чуулганд ч дутахгүй ил тод байдаг ч, нэвтэрч ордог хэсэг нь маш нарийн ээдрээтэй байдаг. Энэ бүлэг бидэнд тэрслүү итгэгч хүний амьдрал дээрх илбэ шидийн үр нөлөөг илүү нарийн ойлгож авахад тусална. Бүгдээрээ дуулгаваргүй байдлаас үүдэн тогтдог хяналтын хүч дээрх ажиглалтаа Хуучин, Шинэ гэрээнээс төдийгүй, амьдрал дээрээс ч хийх болно.

## Няцаагдсан хараал

Эхлээд Израилийг авч үзье. Их цөлд аяншсан Абрахамын үр сад түр Моабын тал газар буудаллажээ. Тэд саяхан өөрсдийг нь нутагтаа нэвтрүүлэхгүй гэсэн Башаны бас Аморичуудын бодийг хөтөлчихөөд явж байв.

Израильчуудыг Моабын талд буудаллахад, Балакаар удирдуулсан моаб, мидианчууд түгшиж, ард түмэн нь айдаст автав. Эзэн Израильчуудад: “Би аюумшиг юугаа түрүүнд чинь явуулна” (Гэтлэл 23:27) хэмээн амлаад байв. Израильчууд өөдөөс нь өрвөлзсөн бүх үндэстнийг ялаад, хамгийн хүчирхэг улс болох Египетийг түйвээгээд байсныг тэр ард түмэн мэдэж байлаа.

Балак хаан эш үзүүлэгч Балаамаас тусламж эрэн, бараа бологчдоо илгээв. Балаам болбоос сүнсний талбартаа жинхэнэ мэргэжилтэн байлаа. Түүний ерөөсөн нь ерөөгдөж, хараасан нь хараагддаг байв. Балаакаас хоёр ч удаа элч төлөөлөгч хүлээж авсныхаа дараа Балаам Израилийн хүүхдүүдийг хараахаар Балак хааны төлөөлөгчдийг даган явжээ. Балаам түүнд мөнгө, үүнийгээ дагаад үнэ хүндэтгэл амласан байлаа.

Маргааш нь Балаамтнууд Баалын өндөрлөг газар өөд гараад, Израильчуудыг ажиглаад, дараа нь хаанд долоон тахилын ширээ засч, дээр нь тахил өргөхөд бэлдэх заавар өгөв. Тэгээд Балаам Израилийг хараахаар амаа нээтэл, оронд нь тэдэн дээр баахан ерөөл дуудчихжээ.

Хаан хичнээн дургүйцснийг хэлэх илүүц! “Чи надад юу хийчихэв ээ? Би чамайг дайснаа хараалгахаар авчирсан атал, харагтун, чи тэднийг ерөөлөө” (Тооллого 23:11).

Тиймээс Балаам Балакийн хүслийг биелүүлнэ байх хэмээн найдсандаа, илүү өндөр газар өөд авирах санал дэвшүүлэв. Магадгүй илүү өндөрт гарбал, хараах хүч нь нэмэгдэх ч юм билүү? Тэгээд тэндээ дахиад л долоон тахилын ширээ засч, нэмэлт тахил юугаан өргөв. Дараа нь Балаам хараахаар амаа ангайтал, дахиад л Израилийг баахан ерөөчихөв.

Энэ явдал үргэлжилсээр байлаа. Балаам хараах гэх бүрийдээ өөрийн мэдэлгүй ерөөчихөөд байв. Балаамын хоёр дахь үгд “Иаковын эсрэг ямар ч ид шид алга, Израилийн эсрэг ямар ч мэргэ төлгө байхгүй” (Тооллого 23:23) гэсэн үг бий.

Ямар ч илбэ жатга, мэргэ төлгөчид нь Бурханы хүмүүсийг сөрж чадахгүйг Балаам мэдэгдэв! Ямар бишрэм, хүчтэй мэдэгдэл вэ! Энэ үнэнийг өнөө цаг дээр буулгах юм бол: “Бурханы хүмүүсийн эсрэг ямар ч ид шид байхгүй, Түүний чуулганы эсрэг ямар ч мэргэ төлгө байхгүй” (Тооллого 23:23 зохиогчийн хувилбар) гэх байх.

Энэ амлалт биднийг урамшуулж байна. Илбэ жатгачид, шидтэнүүд нь лаагаа асаагаад том, том хүүрнэлдэж, элдвээр дэмийрч болох. Тэд шившлэг, тарни, хараалаа шившлээ ч, Бурханы хүүхдүүдийг хорлож барахгүй. Тэд амьд Бурханы чуулганыг ялж чадахгүй. Энэ үгийг Сургаалт үгс 26:2 дээрх үг улам бататгах шиг: “Хүртгэх ёсгүй хараал эргэлдэх бор шувуу, нисэн одох хараацай мэт.”

## Буцсан хараал

Бүгдээрээ намайг залуусын цуглааны пастор байсан үе рүү дахин очъё. Ахлах сургуулийнхаа шуламсын бүлэглэлийн толгойлогч байсан нэг охин Есүс итгэв. Ээж нь түүнийг хэвлийдээ байхад нь л Сатанд даатгажээ. Тэрбээр Есүст итгэсэн хойноо туслахад маань туулсан амьдралаасаа хуваалцсан бөгөөд тэр охины нэг үг туслахын маань санаанд туссан байна. Тэрбээр: “Би Христэд итгэдэг хүмүүс дээр илбийн хараал хийж чадахгүй” гэсэн юмсанж.

Туслах маань: “Яагаад?” гэж асууж.

Охин: “Яагаад гэвэл хэрэв бид тэднийг хараах юм бол, хараал маань эргээд бидэнд тусна” гэжээ. Энэ үг туслахыг маань ихэд баясгаж.

Охины үг Балаамын үгтэй таарч байгаа биз. Балаам эхнийхээ үгээр: “Бурханы хараагаагүй хүнийг би хэрхэн хараах билээ?” (Тооллого 23:8) гэж асуусан. Балаам Израилийн хүүхдүүдийг харааж *чадсан байлаа ч*, энэ хараал нь эргээд түүний толгой дээр буух байж. Давид:

Намайг муу хүмүүсийн нууц чуулал,  
Ёс бусыг үйлдэгчдийн  
Үймээн шуугианаас (тэрслэлээс) нуугаач!  
Хэл юугаа илд мэт ирлэсэн нь  
Хорон үгсээ сум мэт тэд онилсон нь  
Өөлөх өөгүйг далдхан газраас харвахын тулд юм.  
Тэд түүнийг гэнэтхэн харваад эмээх ч үгүй  
(Дуулал 64:2-4) гэсэн.

Хараалыг тэрслүү хүмүүс (илбэ шидэд оролцдог хүмүүс) тавьдаг ч, тэдгээр нь зөвт хүмүүс дээр буухгүй. Харин хараасан хүмүүс эргээд яахыг үзнэ үү:

Харин Бурхан тэднийг сумаар харван  
Тэд гэнэтхэн шархадна  
Ингээд тэд түүнийг бүдрүүлнэ.  
Өөрсдийнх нь хэл өөрсдийнх нь эсрэг болно.  
Тэднийг харагчид бүгд толгой сэгсэрнэ. (Дуулал 64:7-8)

Тэд хэлдээ ороогдох нь байна. Бусдыг хорлохоор харвасан үгс нь буцаад өөрсдийнх нь дээр буух нь байна. Давид үүнийг



“Тэд хөлд минь тор тавив. Сэтгэл минь гонсойв. Өмнө минь тэд нүх ухав. Өөрсдөө тэгээд түүндээ унав” (Дуулал 57:6) хэмээн тодорхой хэлжээ.

## Дуулгаваргүй байдалд уруу татагдах

Балаам ийм янзаар Израильчуудыг харааж бүтэхгүйгээ мэджээ. Тэр хүсээд хүсээд Израильчуудыг харааж чадаагүй. Мосе тэр явдлыг: “Учир нь чамайг Египетээс гарахад замд чинь тэд талх ус барин та нарыг угтаагүй агаад чамайг хараалгахын тулд Месопотами дахь петор хүн Беорын хүү Балаамыг чиний эсрэг хөлсөлсөн болой. Гэсэн хэдий ч ЭЗЭН Бурхан чинь чамайг хайрладаг учир ЭЗЭН Бурхан чинь Балаамыг сонсохыг хүссэнгүй, харин хараалыг чиний төлөө ерөөл болгон эргүүлсэн” (Дэд хууль 23:4-5) гэж дүгнэсэн байдаг. Тэгвэл энэ үнэн бидэн дээр ч хэрэгжинэ.

Бачуурсан Балак: “Би дайснуудаа хараалгахаар чамайг дуудсан билээ. Гэтэл харагтун, чи тэднийг гурвантаа дараалан ерөөлөө. Иймээс өөрийн газар уруугаа зугтагтун. Би чамайг үлэмж ихээр хүндэтгэхээр зэхэж байсан. Гэтэл харагтун, ЭЗЭН чамайг хүндлэлээс буцаан татав” (Тооллого 24:10-11) хэмээн бархирчээ.

Балаам том асуудалд оров: Тэрбээр шан харамжийг үнэхээрийн хүсч байв. Иймээс ч тийшээ явж очсон бөгөөд одоо шагналаа алдах дээрээ тулаад байв. Тэгээд ийм гарз үзэхгүйн тулд Балаам Балак хаанд довтолгооны өөр нэг төлөвлөгөө ярьжээ. Балаам Израилийг харааж барахгүйгээ мэдэж байсан ч, нөгөөтэйгүүр хэрхэн өөрийнх нь гараар өөрийг нь хөнөөхөө бас мэдэж байв.

Балаам тэрслэл, илбэ шидийн хоорондох сүнсний холбоог ойлгож байсан учраас, Моаб хүүхнүүдийг Израилийн хуаран руу нэвтрүүлэхийг хаанд зөвлөжээ. Ингэхдээ тэдэнд шүтээнүүдийг нь дайж явуулаад, Израилийн эрчүүдийг бэлгийн нүгэлд уруу татаж, Бурханы Үгээс урван тэрслүүлжээ. Тэрслэл нь Израильчуудыг илбэ шидийн хараал дор оруулахыг Балаам мэдэж байлаа.

Энэ зөвлөгөө бүтсэн. Учир нь Мосе ч, Есүс ч хаанд өгсөн Балаамын зөвлөгөөг эш татан өгүүлсэн билээ. Мосе: “Харагтун, тэд *Балаамын зөвлөгөөгөөр* Пеорын хэрэг явдалд Израилийн хөвгүүдийг ЭЗЭНий эсрэг самуурахад хүргэсэн. Тиймээс ЭЗЭНий хотол түмэн дунд

гамшиг ирсэн” (Тооллого 31:16) хэмээн баталсан бол, олон жилийн дараа Есүс: “Балаам Израилийн хөвгүүдийн өмнө урхи тавиулж, шүтээнүүдэд өргөсөн юм идүүлэн садарлуулах гэж Балакийг сургаж байсан (Илчлэл 2:14) хэмээжээ.

Өөрөө өөр дээрээ учруулсан энэ хараалын талаар Бичээс өгүүлдэг. Балаамын эш үзүүллийн дараа “Израиль Шитгимд амьдарсан бөгөөд ард түмэн Моабын охидтой садарлаж эхлэв. Тэд бурхдынхаа тахилд ард түмнийг урьсан бөгөөд ард түмэн идэж, тэдний бурхдад мөргөжээ. Израиль өөрсдийгөө Пеорын Баалтай нийлүүлжээ. Тэгэхэд ЭЗЭНий уур хилэн Израилийн эсрэг дүрэлзжээ” (Тооллого 25:1-3). Тэгээд үүний гайгаар Израильчуудыг хэдэн төрлийн гамшиг нэрвэж, сүйрүүлжээ.

Хараах боломжгүй энэ үндэстнийг өөрсдийнх нь дуулгаваргүй зан гай гамшгийн хараал дор оруулсан байна: “Гамшгаар үхэгсэд хорин дөрвөн мянга болжээ” (Тооллого 25:9). Хорин дөрвөн мянган хүн! Энэ мэдэгдлийн жинг та мэдэрч байна уу? Өнөөдөр онгоцны ослоор эсвэл хар шуургаар хэдэн зуун хүн үхэхэд л дэлхий даяар мэдээллэдэг. Гэтэл бид хэдэн зуун хүний амийн талаар бус, харин хорин дөрвөн мянган хүний амийн талаар ярьж байна! Энэ бол Израиль цөлд байх хугацаандаа ганц удаагийн гамшгаар хамгийн олон хүнээ алдсан тохиолдол бөгөөд хүмүүсийн тэрслэлээс болжээ.

Эрс тэс дуулгаваргүй байдал нь эрс тэс гамшгийг дагуулна. Израильчуудын тэрслэл аймшигтай байв. Үнэндээ, Эзэний өмнө уйлан гашуудаж байгаа Мосе тэргүүтэй Израильчуудын нүдэн дээр улаан цагаандаа гарсан нэгэн Израиль эр Мидиан хүүхнээ гайхуулсан байдаг (Тооллого 25:6).

Тэр гамшгийг юу зогсоосон гэж бодож байна? Та таачихсан байх - эрс тэс дуулгавартай байдал зогсоосон!

Тахилч Аароны ач, Елеазарын хүү Финехас үүнийг хармагцаа хотол түмний дундаас босож, гаргаа жад авав. Тэрээр израиль эрийн араас майханд орж, израиль эрийг бас эмэгтэйн хэвлийг цоо сүлбэн, хоёуланг нь нэвт жадлав. Тийнхүү Израилийн хөвгүүд дээр байсан гамшиг зогслоо. (Тооллого 25:7-8)

Би дахин хэлье: Бурхан гамшиг, өвчнийг зохион бүтээдэг Нэгэн биш ээ. Израилийн хүүхдүүд Бурханы эрх мэдлийг эрээ цээргүй тэрслэн зөрчсөн. Тиймээс Эзэн хамгаалалтын бүрхүүлээ татахад

хүрсэн бөгөөд Эзэний зөвшөөрлөөр дайсан дайран нэвтрэх хууль ёсны эрхтэй болжээ. Энэ бүхэн нь тэрслэл нь илбэ шид мөн бөгөөд чөтгөрийн хүчнүүдэд хяналтыг булаахаар нэвтрэх хууль ёсны эрх олгодгийг баталж байна. Израиль төлгөчийн хараалаас бултсан ч, дуулгаваргүй байдалд хяргуулжээ.

## **Хэн чамайг хараал дор оруулав?**

Энэ бол тэрслэл нь илбэ шид болохыг батлан харуулсан Хуучин гэрээний үй олон жишээний нэг л билээ. Тэгвэл Шинэ гэрээг шалгая. Элч Паул Галатын чуулгануудад нилээд чанга захидал бичжээ. Тэр нь Галатын нийт ард түмэнд хандсан бус, чухамлан чуулганд хандсан захидал байв. Паулын мэдэгдлийг анхааралтай уншина уу: “Мунхаг галатчууд аа, хэн та нарыг ховсдов? Есүс Христ нүдэн дээр чинь нийтийн өмнө загалмайд цовдлогдсон бус уу?” (Галат 3:1)

Байзаарай! Паул чуулганыг илбэ шидийн хараал дор байна гэх! Та: “Бурханы хүмүүсийг ховсдож, илбэдэх боломжгүй гээ биз дээ?” гэх байх. Тэр үнэн. Дуулгавартай байдлын өмнө ямар ч хараал бүтэхгүй. Тийм боловч хүн өөрөө тэрслэл, дуулгаваргүй байдлаараа илбэ шид дор явж орох боломжтой.

Шулмын үйлд гар бие оролцож явсан итгэгч охин, манай туслах хоёрын өрнүүлсэн яриаг санаж байна уу? Христэд итгэдэг хүнийг хараах боломжгүй гэдгийг дуулаад хөөрсөн туслахыг маань харсан охин: “Тэхдээ пастор аа, бид чуулган дахь царцуу (дуулгаваргүй) хүмүүст нөлөөлж чадна шүү” хэмээн шууд нэмж хэлжээ. Үүнийг ч: “Хэн та нарыг үнэнийг дагах ёсгүй болтол чинь ховсдов?” (Галат 3:1) гэсэн Паулын үг бататгах.

Илбэдүүлэх явдалд илбэ жатгачийн хэлсэн дурын хараал багтах бус, харин Бурханы Үгд дуулгаваргүй авирлах явдал багтдаг юм. Яагаад? Яагаад гэвэл тэрслэл нь илбэ шид мөн! Үндсэндээ Галатын чуулган дуулгаваргүй байдлаараа илбэ шидийн хараал дор явж оржээ.

Цааш явахаасаа өмнө би нэг санааг тодруулах ёстой. Бид Бурханы бидэнд илчилж өгөөгүй зүйлд бус, харин маш тодорхой хэлж өгсөн зүйлд дуулгаваргүй авирлахдаа, илбэдүүлдэг юм. Энэ нь Паулын дараа дараагийн үгээс тодорхой харагдах: “Хэн та нарыг үнэнийг дагах ёсгүй болтол чинь ховсдов? Есүс Христ нүдэн дээр чинь нийтийн өмнө загалмайд цовдлогдсон бус уу?” (Галат 3:1)

Дээрх тохиолдол ертөнцийн үнэнд бууж өгч байна. Бурхан тэр

чуулгануудад Паулын номлолоор дамжуулан нигүүлслээрээ авралаа илчилжээ. Гэтэл төд удалгүй тэд бусдын учир шалтгааны үзэл гаргалгаа, уламжлалыг хүлээн аваад, нэгэнтээ өөрсөд нь Ариун Сүнсээр маш тодорхой илчлэгдсэн юмст дуулгаваргүй ханджээ. Тэгээд хуулийн үйлсийг сахиснаар аврал ирсэн гэдэг итгэлд урван, үүгээрээ амьдарч эхэлсэн байна. Үүнээс бидний авах шаардлагатай ертөнцийн сургамж нь дараах болой: *Бид Бурханы тодорхой илчилж өгсөн зүйлийг эс дагах бүрийдээ, өөрсдийгөө илбэ шидийн хараалын нөлөөн дор оруулдаг. Яагаад? Учир нь тэрслэл нь илбэ шид юм.*

Би үүнийг чуулгануудаас ч, гэр бүлүүдээс ч, хувь хүмүүсээс ч харсан. Би чуулганд явдаг атлаа аль нэг шалтгаанаар байнга дуулгаваргүй амьдардаг олон хүнтэй таарч явсан. Тэдний дийлэнх нь дуулгавартай байдлыг хэрэгсдэггүй нигүүлслийн талаарх, нэг талыг баримталсан сургаалд автсан байх бөгөөд хичнээн аюултай нөхцөл дор байгаагаа мэддэг ч үгүй. Амьдралыг нь хямрал ээлж дараалан самарна. Тэд аль нэг асуудал, нүглээсээ болоод ялалт байгуулж чаддаггүй. Тэд нэг урхинаас гараад, нөгөө урхинд унадаг. Ингэх тусам нөхцөл байдал нь улам л дордсоор байна. Асуудлууд тэдний цаг, эрч хүч, амьдралыг залгисаар. Аль нэг тал нь хууль ёсоор чөтгөрийн дарамт, нөлөөний эрхшээлд оржээ.

Гэрлэлт нь сүйрч, зарим нь бүр салж сарнихдаа тулдаг. Зарим нь тушаал дэвшихгүй байх юмуу эсвэл ажлаа алдахдаа тулдаг. Гэтэл зарим нь хулгай, санхүүгийн хямрал, эмгэнэлд өртөнө. Гутарч цөхөрсөндөө тэд буруутгах хүнээ хайна. Тэгээд аав ээж, пастор, дарга, хань ижил, үр хүүхэд, засгийн газар - ер нь тэдний үзэл бодолтой санал нийлэхгүй хүн болгоныг буруутгана.

Гэтэл тэдний амьдралд бие биеэ бойжуулагч хоёр хүчин ажиллаж байгаа ажээ. Эхнийх нь мэхлэл. Тэр хүмүүс Бурханы Үгийг дагалгүй хөсөрдүүлсэн учраас, зүрх нь харанхуйлжээ. Хоёрдугаарх хүчин зүйл нь дуулгаваргүй байдлаас нь болж амьдралыг нь дуртай цагтаа самарч байдаг, хянан захиргаадагч сүнсний хэрж орооцолдуулсан урхи юм. Паул итгэгч нэр зүүсэн тэрслүү хүмүүстэй үзэлцэж байгаа хүмүүст “зөрчилдөгсдийг дөлгөөнөөр сургамжил. Магадгүй, Бурхан тэдэнд үнэний мэдлэгт хүргэх гэмшлийг соёрхвол тэд ухаан орж, хүслээ үйлдэхээр тэднийг олзолсон диаволын урхинаас чөлөөлөгдөх буй за” (2Тимот 2:25-26) хэмээн зааварлажээ. Гол асуудал нь: мэхлэгдэж олзлогдсон хүмүүс дуулгаваргүй байдлаа хаацайлахын тулд бусдыг буруутгадаг бөгөөд ингэснээрээ эрх чөлөөнд хүрэх замаа харах

нүдгүй болдог байна.

Бидэнд Үгээ зааж өгсөн Бурхандаа гялайх минь. Үгийн гэрэл заль мэхийг ил болгож, хүмүүний зүрхний бодол, сэдлийг ангилдаг. Харамсалтай нь дуулгаваргүй байдалд урвасан ихэнх хүмүүс суралцах дургүй байдаг. Тэд цөлийнхөө замаар улам л гөжүүдлэн алхсаар, замд гаргасан алдаанаасаа суралцахаасаа илүү бусдыг буруутгасаар явдаг.

## “Чамд сэтгэл алга”

Нэгэн хүний амьдралын сургамжит түүх санаанаас гардаггүй юм. Би нэгэнтээ өөрийн гэсэн чуулган, Библийн сургуультай олон улсын томоохон үйлчлэлд номлодог байв. Би тус үйлчлэлийн тэргүүн болох амьдралд маань гүн нөлөө үзүүлсэн нэр бүхий тэр нэгэн удирдагчийг үнэн голоосоо хайрлаж, хүндэтгэдэг байлаа. Гэтэл нэг өдөр мань хүн намайг дуудаад: “Жон, би амьдралд маань өрнөх гэж байгаа нэгэн хэргийг дотныхоо бүх нөхдөд дуулгаж байгаа юм аа. Найз нөхдийгөө энэ тухай бусдаас дуулаасай гэж хүсэхгүй байна. Юу гэхээр - би эхнэрээсээ салж байгаа. Бид хоёр 18 жил амьдарлаа. Гэвчиг үзэл бодол, сэтгэлгээний ялгаанаасаа болоод зам салж байх шиг байна. Бид хоёр айлын эхнэр, нөхөр хоёр шиг хамтдаа урагшилдаггүй. Бас дур сонирхол маань дэндүү өөр. Уг нь сайн сайхан болгох гэж их хичээсэн ч, улам л дордлоо” гэх нь тэр.

Би чихэндээ ч итгэсэнгүй. Тэгээд дотроо: *“Ингэж болохгүй”* гэж үглэсээр байлаа. Би тэр хосод бас тэдний үйлчлэлд маш их хайртай байсан учраас, гүнээ цочирдож, хэлэх үггүй болов.

Намайг дуугүй зогсол, пастор цааш нь: “Жон, чи намайг Есүст үнэн голоосоо хайртайг мэднэ. Хэрэв би буруу зүйл хийж байгаа бол, Есүс надад хэлэх болно” гэлээ. Тэр удирдагч надтай нөхцөл байдлынхаа талаар дахин хэдэн минут ярьтал утасны дуудлага яриаг нь дуусгав. Би ч түүний яриаг шингээхтэй манатай - гүн цочирдоод, үг ч хэлж амжсангүй.

Би сонссон зүйлээсээ бүхэл өдөржин ангижирч чадалгүй, ахин дахин ухраан санасаар, жинхэнэ *“хар дарсан зүүд”* хэмээн бодсоор явлаа. Гэтэл энэ их шаналан дунд минь Ариун Сүнс надад “Тэр хүн рүү залгаад, үнэнийг хэл!” хэмээн айлдаж байгааг нь мэдрэв.

Тэгээд маргааш өглөө нь залгалаа. Би энэ тухай л бодсоор унтсан болохоор энэ нь түргэдсэн хариу үйлдэл шиг бус, харин Ариун Сүнсээр удирдуулсан хариу үйлдэл шиг харагдаж байв. Пастор

миний дууг таниад: “Сайн уу, Жон? За юу байна даа?” гэж мэндлэв.

Би ч: “Би тантай салалтын чинь талаар ярих гэсэн юм. Танай гэргий ямар нэг байдлаар ёс бус авирласан уу?” хэмээн яриагаа эхэллээ.

Пастор: “Ёстой тийм юм байхгүй!” гэв.

Тэгэхээр нь би: “Та буруу юм хийж байна. Есүс гагцхүү бэлгийн харилцаан дээр л итгэмжгүй байсан бол, салах талаар бодоорой (Матай 5:32) гэсэн бас Малахи ном дээр салалт нь бидний хувцсыг хүчирхийллээр буддаг учраас, Бурхан салалтыг үзэн яддаг (2:16) гэсэн. Та өчигдөр надад “Би Есүст хайртай болохоор, би буруу юм хийж байгаа бол, Есүс надад харуулна” гэж хэлсэн. Гэхдээ Есүс хүслээ хэдийнээ Үгээрээ илэрхийлчихсэн атлаа яагаад танд харуулна гэж? Та яаж Бурханы Үгийн мэдэгдлийг санаатайгаар зөрчинө гэж? Ингэхихээд яаж чуулганыхаа өмнө, Библийн сургуулийнхаа өмнө “нүглийг эсэргүүцээд ариунаар амьдар” гэж хэлэх юм бэ? Та өөрийгөө бас үйлчлэлээ асуудал, мэхлэлд нээж өгч байна” гэлээ.

Гэтэл пастор үгийг минь таслаад: “Жон Бивэр, чи миний амьдарлаар амьдраагүй. Чамд сэтгэл алга” гэв.

Тэгснээ бийб - бийб - бийб гэсэн чимээ гарав. Пастор утсаа тасалжээ. Гэтэл гучин минутын дараа манай ажлаас над руу залгаад, нөгөө газар надаар заалгах гэж байсан хичээлийн хуваариа цуцласан гэдгийг дуулгав. (Би гурван сарын дараа тэднийд хичээл заах хуваарьтай байсан юм) Тэгээд би гэргийдээ: “Би тэднийг ингэнэ гэдгийг мэдэж байсан. Гэхдээ ийм хурдан үйлдэх юм чинээ санасангүй” гэлээ. Тэд надаас бүх харилцаагаа тасалсан бөгөөд хожим тэнд очиж заасан, өөр нэгэн алдартай үйлчлэгч тэр газрынхан намайг бараг л хүний тооноос хассан талаар дуулгаж билээ. Харин би: “*Би найз шиг найз л байхыг хүссэн*” гэж бодсоор байв.

## **Шүүгдэж байж сэргээгдсэн нь**

Тэгж байтал долоон сарын дараа санаанд оромгүй явдал болж, мөнөөх пастор над руу залгах нь тэр: “Жон, би чамд сэтгэлээ уудалмаар байна. Утсаа таслаад, чамаас бүх харилцаагаа тасласны дараа юу болсон гээч? Сарын дараагаас миний бөөр өвдөж, надад амьд явах тавин хувийн л боломж үлдсэн. Хоёр дахь диализынхаа дараа би гэнэт ухаараад, өөртөө: “Би чинь салаад яах гэж байна аа?” гэж хэлсэн. Тэгээд том алдаа гаргаснаа ухаарсан. Гэргий рүүгээ утасдаад

гэмшсэн. Библийн сургууль дээрээ: “Жон Бивэр надад гэрлэлтээ цуцлуулах нь буруу гэж хэлсэн учраас, би түүний бүх хичээлийн цагийг цуцалсан. Харин одоо би түүн рүү яриад, буцаж ирээч гэж гуймаар байна” гэж хэлсэн. Тэгэхээр Жон, чи буцаж ирэх үү?”

Мэдээж! Би тэр хүний төлөө хязгааргүй баярласан бөгөөд түүнийг маш хурдан өссөнд нь хүндэтгэдэг. Дээрээс нь түүний эдгэрэл санаснаас хурдан явагдаж, жилийн дараа төгс тохирсон бөөрний донор олдсон юм. Энэ хооронд тэр пастор цуглаанаа нэг ч таслаагүй бөгөөд эмч нарыг ангайтал хурдан эдгэрч байв. Үүнээс гадна тэр удирдагчийн гэмшлийн ачаар амьдрал дээр нь хавьгүй аугаа эрх мэдэл, хүч бууж ирсэн юм. Тэр цагаас хойш олон жил өнгөрч, эдүгээ тэр пастор жаргалтай сайхан гэр бүлтэй, урьд хожид байгаагүй үр нөлөөтэй, эрэлт хэрэгцээтэй номлогч болоод байна. Тэр гэр бүлтэй нөхөрлөх бүрий, тэдний бие биеэ гэсэн хайр нь илхэн харагддаг. Хэдхэн жилийн өмнө тэр хоёрыг салдаг дээрээ тулаад байсныг хэн ч гадарлахгүй.

## **Гурван сар хагас өвдсөн минь**

Энэ явдлаас хэдхэн жилийн өмнө би өөрөө нэг иймэрхүү замаар туулсан учраас, миний хувьд тэр пасторыг учиргүй шүүж хатуурхаагүй юм. Би гэрлэлтийн харилцаандаа бус, үйлчлэлдээ дуулгаваргүй авирласан юм. Анх биднийг Мессенжер Интернэйшнэл байгууллагыг эхлүүлэхэд, Эзэн маань бидэнд маш тодорхой нэгэн заавар өгсөн юм: Түүний хүслийг баттай болгоогүй байж, аль нэг аятайхан, хосгүй боломж гэдэг шалтгаанаар ямарваа нэгэн тохиолдолтой орооцолдохгүй байх!

Тэгтэл хэдхэн жилийн дараа манай үйлчлэлд өргөжин тэлэх хосгүй боломж олдох нь тэр. Гэтэл биднийг залбирах үед Тэр саналыг хүлээж авч “болохгүйг” Бурхан гэргийд минь ч, надад ч маш тодорхой айлдав. Харамсалтай нь тэр хүмүүс намайг уран панаалдаж чадсан учраас, би тэдний арга найраанд ороогдон, чихээ дэлдийлгэж эхлэв. Төд удалгүй зүрхэнд минь хэлсэн Бурханы үгсийг түлхлэж эхлэх нь тэр. Миний дотор эргэлзээ хуралдаж, толгойд маань түмэн бодлын хур хог овооров. Гэргий минь надад үг хэлэх гэж оролдоод, нэмэргүй болсныг шууд ойлгожээ. Тийнхүү эцэстээ би тэр саналыг хүлээж авсан юм.

Би аврагдсанаасаа хойш ямар ч өвчин зовлон тусалгүй, эрүүл

саруул байсан нь Бурханы л алдар байв. Барагтай өвдөхгүй - өвдбөл ганц хоёр хоногийн дотор л эдгэрчихдэг байлаа. Есүс загалмай дээр үхэхдээ уучлал авчирсан шигээ эдгэрэл авчирсан гэдэгт би итгэдэг (Исаиа 53:4-5, Дуулал 103:2-3). Гэтэл тэр боломжийг хүлээж авсан өдрөө би гэнэт өвчин тусаад, өвчнөөс салахаа болив.

Анхандаа зүгээр л ханиадаар эхэлсэн юм. Би хамгийн сүүлд 19-тэй байхдаа л нэг бөөлжиж байсан бол, энэ удаа дахин бөөлжив. Хэдэн өдөр ханиадтай тэмцэлдсэний эцэст нэгэн төрлийн нянгийн халдвар аваадавав. Гэргий, бид хоёр хуримын ойгоо тэмдэглэхээр хотоос гарсан боловч, би хэдэн өдөр 38-аас дээш халуурсан учраас, баяртай манатай л боллоо. Бүтэн сайны цуглаан дээр би халуундаа чичирсээр номлов. Дараагийн долоо хоногт нь Канадад хийсэн цуглааны үеэр ч халуун буусангүй. Би халуунтай хэвээрээ номлочихоод, дараагийн цуглаан хүртэл өрөөндөө орон дотроо бөмбөгнөтөл чичирсээр хэвтсээр, хамаг тамир тэнхээгээ алдав.

Халуун гурав дахь долоо хоногтоо орлоо. Би хэзээ ч ингэж өвдөж байгаагүй учраас, учрыг нь ойлгохгүй байв. Би залбирч, Бурханы Үгээр тэмцэж байсан ч, өвчнөөс ерөөсөө салсангүй. Тиймээс эмчид хандав. Эмч хүчтэй антибиотик бичиж өгөөд, төдөлгүй би эрүүл боллоо.

Гэтэл антибиотик дууссаны дараа хамрын ханиад тусаад, хамаг бие маань сульдав. Ёстой аймшигтай. Хоолой өвдөж, толгой ангалзах гэх зэрэг хамаг л муу муухай шинж нь бүрдэв. Энэ хооронд би ажлаас хийж, үйлчилсээр байсан ч, энэ өвчин хэдэн долоо хоног үргэлжлэв.

Хамрын ханиадны дараа би хана давах гэж байгаад өвдгөө бэртээчихлээ. Хүнд гэмтээсэн учраас, аялахдаа тэргэнцэр дээр сууж, хэдэн долоо хоногийн турш гипстэй явлаа. Ингээд овоо эдгэртэл, өөр нэгэн төрлийн нянгийн халдвар авав. Биеийн халуун маань 38, 39 - ээс буусангүй. Тиймээс бас л хүчтэй эмээр дарав. Би өвчингүй нэг ч долоо хоносонгүй. Энэ байдал гурван сар хагас үргэлжлэв.

Энэ хугацаанд гэргий минь нэг ч удаа, нэг ч өдөр өвдсөнгүй. Биеийн асуудлаас гадна өөр бас баахан асуудал үүсэв. Би надаас хүчирхэг бас дээрээс нь огт хөдөлж өгдөггүй, шазруун өрсөлдөгчтэй үзэлцэж байлаа. Мэдсээр байж дуулгаваргүй авирласан явдал маань намайг хараал дор оруулжээ.



## **Жинхэнээсээ гэмшиж, газар дээрээ чөлөөлөгдсөн минь**

Дөрвөн сарын дараа би буруугаа хүлээв. Гэхдээ л буруу хэргийнхээ үр дагаврыг нэг мөр цэгцлэх ёстой байсан бөгөөд надад гайхамшиг л тус болохгүй бол, үнэхээр арга тасраад байв. Лиза, бид хоёр гар гараа барин залбирч, би гэмшиж, Бурханы өршөөлийг гуйлаа. Миний алдаанаас болж, биднийг бугуйлдсан урт бугуйлаас Бурхан биднийг чөлөөлөв.

Хэдэн жилийн дараа гэргий, бид хоёр болсон явдлын талаар ярилцаж, миний бүх өвчин дуулгаваргүй байдалтай маань холбоотой байжээ гэдэг дүгнэлтэнд хүрсэн юм. Намайг гэмшсэний дараа миний сайн эрүүл мэнд тэр даруй сэргэсэн юм. Бидэн дээр ирсэн бусад асуудал ч шийдэгдэн, арилав.

Энэ хугацаанд би Иаковын “Диаволыг эсэргүүц. Тэгвэл тэр та нараас зайлна” (Иаков 4:7) гэдэг үгийг яс махаараа сурсан юм. Урьд нь би дайсны довтолгоог мэдрэх бүрийдээ, харанхуйг Бурханы Үгээр эсэргүүцэн, заавал үр дүнд хүрдэг байв. Гэтэл тэр өдөр яаж ч чадаагүй юм. Энэ асуудал болоод өнгөрсний дараа би өөрийгөө Иаковын үгийг бүтнээр нь биш, харин: “Тиймээс Бурханд захирагдагтун” (Иаков 4:7) хэмээн таллаж эш татдаг байснаа ухаарч билээ.

Бид Диаволыг Бурханд дуулгавартай захирагдсанаар л эсэргүүцнэ. Бид Бичээсийг цэлдийж хөхөртлөө эшлэлээ ч, дуулгаваргүй байгаад байвал, үр дүн гарахгүй.

## **Чухал тодруулга**

Нэг зарчмыг ойлгоно уу: Бэрхшээл, өвчин, асуудал, зовлонд унасан хүн болгоныг дуулгаваргүй авирлажээ хэмээн дүгнэж болохгүй. Дуулгавартай хүмүүс ч зовлон үздэг. Тэдний нэг бол Давид. Давид тэрслээгүй. Тэрбээр удирдагчаа хилэгнүүлэх юм хийгээгүй. Тэгсэн хэрнээ олон жил агуй, цөл, зэлүүд газар орогнож, улс гэргүй тэнүүлчин шиг зүдэрсэн. Хүмүүс түүнийг дуулгаваргүй зангаасаа болж зовсон гэдэг. Гэхдээ Бурхан шинэ төрлийн хааныг бойжуулж, амьдрал дээр нь тааллаа зэхэж байгааг нүдтэй нэг нь харна. Үүнийг ч Давидын цэц ухаанаас үзэж болно.

Дуулгавартай атлаа зовж амьдарсан хүмүүсийн жишээ олон бий:

Есүс, Иосеф, Ханна, Иеремиа, Иов гэх мэт. Гэхдээ дуулгавартай хүмүүсийн зовлон нь дуулгаваргүй хүмүүсийн зовлонгоос нэг чанараараа ялгаатай: дуулгавартай хүмүүс нь зовлон дундаа сүнсээр өсч, яван чангардаг. Тэд зүгээр л ахин дахин ханаа мөргөөд байх юмуу нэг уулаа л тойрон эргэлдээд байдаггүй.

Харамсалтай нь Каины түүх өөр байв. Түүний дуулгаваргүй байдал маш их зовлон авчирсан. Тэрбээр гомдсондоо, гэмшихээс гөжсөн нь амьдрал дээр нь хараал авчиржээ. Каин амьдралаа оргодол, тэнүүлчин шиг л дуусгасан. Түүний зорилгогүй, мухар тэнүүчлэл нь хожмын үеийнхэнд сургамж, анхааруулга л болжээ.

Би дараах мэдэгдлээр бүлгээ өндөрлөе: Сүүлчийн хоёр бүлгийн үнэнээр далайлган бусдыг бүү шүүгээрэй. Бусдын туулж яваа зовлон нь эцэстээ Бурханыг алдаршуулах зорилготой шалгуур байж ч болох. Би энэ бүлгээрээ танд Бурханы эрх мэдлээс гөжих нь аль зэрэг ноцтой болохыг л ойлгуулахыг зорьсон юм шүү. Та дуулгаваргүй байгаа бол, энэ үнэнээр өөрийгөө шүүн цэгнээд, эргээд амийн зам дээрээ гараарай.

ХЭСЭГ 3



**БУРХАНЫ ТОГТООСОН  
БҮРХҮҮЛ**



# ХЭН ХАРИУЦАЖ БАЙГААГ БУРХАН МЭДЭХ ҮҮ?

*Бурханыг дуулгавартай дагаж сурсан хүн  
бусдын дээрх Бурханы эрх мэдлийг төвөггүй таньдаг.*

**Б**урханы шууд эрх мэдэлд захирагдах нь хичнээн чухал болохыг бид ойлголоо. Тэгвэл одоо Бурханыг төлөөлсөн эрх мэдэлд захирагдах нь дутахгүй чухал болох талаар үзье. Тэгээд тайзаа засахын тулд хоёрдугаар бүлгээрээ онцолсон Бичээсээр эхэлбэ.

Бурханаас гадуурх эрх мэдлүүд гэж үгүй бөгөөд Бурханы тогтоосноор л байгаа тул дээд эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд. Тиймд эрх мэдлийг эсэргүүцэгч нь Бурханы тогтоолыг эсэргүүцсэн хэрэг. Эсэргүүцсэн хүмүүс нь өөрсөдөө шийтгэл хүртэх болно.  
(Ром 13:1-2)

## Эрх баригчид

Нэгдүгээрт эрх баригчид гэж хэн бэ? Дээрх хэсэг дээр Паул нийгмийн болоод төр засгийн эрх баригчдыг нэрлэжээ. Гэхдээ энэ ятгалга нь дан ганц төр засгийн удирдагч нарыг багтаагаагүй, бүх талбарын эрх мэдлийг багтаасан болно. Дараах хэсгүүдээс сурах зарчим нь төлөөний эрх мэдэл дээр ч давхар хэрэгжинэ.

Шинэ гэрээ нь: иргэний, чуулганы, гэр бүлийн, нийгмийн гэсэн дөрвөн төрлийн төлөөний эрх мэдлийн талаар өгүүлдэг. Нийгмийн эрх мэдэл нь ажилчин албан хаагч, багш, дарга нарыг багтааж болно. Шинэ гэрээ энэ дөрвөн талбар тус бүр дээр тусгайлсан заавар өгдөг боловч, ихэнх тохиолдолд тухайн эрх мэдлийн хүрээ хязгаарыг зөвлөлийнхөн нь тогтоож өгдөг юм.

“...дээд эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд” гэсэн эхний мөрийг харна уу. “Захирагдахыг” Грекээр хапотассо гэжээ. Энэ нь “цэргүүдийг (анги салаагаар хувааж) командлагчийн удирдлага дор зохион байгуулалтанд оруулах” гэсэн утга бүхий, цэргийн үг ажээ. Цэргийн бус хэрэглээн дээр ярьбал, “сайн дураараа бууж өгөх, хамтран ажиллах, үүрэг хариуцлага хүлээх, ачаа үүрэх” гэсэн утгатай болно (Тайерын Грек толь бичиг). Товчхондоо, тус үг нь эрх мэдлийг бүрэн дагаж захирагдахаар эрх мэдлийн дор сайн дураараа орохыг хэлж байгаа ажээ.

Хүн бүр эрх мэдэлд захирагдана. Учир нь Бурхан бидний амьдрал дээр бүх төрлийн засаглах эрх мэдлийг тогтоосон. Бүх эрх мэдлийн эх нь Бурхан Өөрөө болой. Нэгийг ч алгасахгүй, бүх эрх мэдлийн шүү. Үнэндээ энэхүү эшлэл дээрх *томилогдсон* гэдэг Англи үг нь Грекээрээ “томилох, тавих, тогтоох” гэсэн утга бүхий *тассо* гэдэг үг болно. Энэ үгд “тохиолдлын” чанартай утга нэгээхэн ч алга. Өөрөөр хэлбэл шууд томилгоог илэрхийлж байна. Бурхан бүх эрх мэдлийг томилсон учраас, тэднийг үл хүндэтгэх юмуу тэдэнд эс захирагдах нь түүний цаана орших үндсэн эрх мэдлийг эсэргүүцсэн явдал болно. Санаатайгаар юмуу санаандгүйгээр Бурханы томилгоог болоод захиргааг эсэргүүцсэн хэрэг болно. Бурханыг төлөөж буй эрх мэдлийг эсэргүүцэх нь Бурханыг Өөрийг нь эсэргүүцсэн хэрэг бус уу?

Христэд итгэдэг хүмүүс бид аливаа эрх мэдэлтэй харилцан холбогдохдоо, тухайн хүн дээр нь юмуу авир үйлдэл дээр нь төвлөрөөд байлгүй, харин давуулан харж, тухайн хүний байр суурийг нь хүндэтгэх ёстой юм. Тэр хүмүүсийн дээр Бурханы эрх мэдэл байгаа учраас л, бид эрх мэдэлтнүүдийг хүндэтгэдэг. Бидэнд тухайн хүн өөрөө бас түүний удирдах хэв маяг таалагдана уу байна уу хамаагүй, бид түүнийг удирдах эрхтэй гэж үзнэ үү байна уу хамаагүй, зүгээр л хүндэтгэ. Итгэгч хүмүүс Бурханд захирагддаг гэдэг боловч, Бурханыг төлөөлсөн эрх мэдэлд захирагдахгүй байх нь даанч их. Тийм хүмүүс мэхлэгджээ!

## ХЭН ХАРИУЦАЖ БАЙГААГ БУРХАН МЭДЭХ ҮҮ?

Бурханыг дуулгавартай дагаж сурсан хүн бусдын дээрх Бурханы эрх мэдлийг төвөггүй таньдаг. Заримдаа бид Бурханыг дагах эсвэл Бурханы төлөөний эрх мэдлийг дагахын аль нэгийг сонгох ёстой болдог, тийм үү? Тийм ээ! Ийм тохиолдол гардаг ч, итгэгч - бидний боддог шиг элбэг биш юм. Нэг л онцгой тохиолдол байдаг бөгөөд энэ талаар бид дараа, дараагийн бүлгээрээ дэлгэрэнгүй үзнэ. Гэтэл Христэд итгэдэг олон хүн “ер нь бол захирагдах эсэх нь хувь хүний чөлөөт сонголт, гагцхүү онцгой тохиолдолд л дуулгавартай дагаж болно” гэж үздэг нь хамаг асуудлын үндэс болдог. Ийм төрлийн гаргалгаа нь биднийг сүйрэлд хүргэх жамтай. Ийм хандлага нь хайр найргүй үр дагавар авчирдгийг бид урьд урьдын бүлгээрээ үзсэн билээ. Ийм хандлага нь биднийг Бурханы шүүх дор оруулаад зогсохгүй, чөтгөрийн хүчинд хууль ёсоор нэвтрэх эрх олгодог. Бид Бурханд дуулгавартай байж, ерөөгдмөөр байгаа бол, зүгээр л төлөөний эрх мэдэлд дуулгавартай захирагдах ёстой.

### Муу ёрын эрх баригчдыг ч Бурхан томилдог үү?

Тэгэхээр бүх эрх мэдлийг Бурхан томилдог бөгөөд тухайн байр суурийг хүндэтгэж, тухайн эрх мэдэлд захирагдаж явах ёстойг бидэнд заавар болгон өгчээ. Яг энэ асуудал дээр хүмүүсийн тархинд том, том хана ургаад ирдэг. Хүмүүс: “Бид харгис хатуу удирдагч нарыг мэднэ. Тэднийг Бурхан томилсон гэж та яаж хэлж чадаж байна?” хэмээн эсэргүүцдэг. Тэгвэл нэг зүйлийг санаарай: Паул *Бурханаас гадуурх* эрх мэдэл гэж үгүй гэж хэлснээс биш, бүх эрх мэдэл *бурханлаг* гэж мэдэгдээгүй! Эрх мэдэл нь Бурханых боловч, зан үйлдэл нь бурханлаг биш байж болох. Бүгдээрээ Гитлер, Сталин тэргүүтэй адгийн хүмүүсээр жишээлж үзье. Тэд магадгүй өнгөрсөн зууны адаглагч удирдагч нар байх. Тэдэн шиг ёрын муу, харгис хүмүүс үгүй гэдгийг бид ч дуу нэгтэй дэмжих байх, тийм үү?

Тэгвэл Египетийн удирдагч Фараоныг авч үзье. Тэр ч бас адаглагч нарын ангилалд багтах байх. Түүний удирдлага дор Израиль үндэстэн шар махтайгаа хатсан. Фараон Израильчуудыг боолчилж, дарлаж, бие, сэтгэлээр нь тамлаж байсан ч, үүндээ ханалгүй хэдэн мянгаар нь хөнөөсөн. Фараонтан хүнийг ч, Эзэнийг ч юмын чинээ үздэггүй, дээрэнгүй, сэхүүн амьтан байв. Фараоны эрх мэдэл Хэнээс гаралтай вэ? Фараоны удирдлага дор Бурханы хүмүүс эцэстээ хэрхсэн бэ? Энэ

бүхэн санаандгүй тохиолдол байв уу?

Бичээсээс үзбэл, Бурхан Мосегоор дамжуулан Фараонд “Би... чамайг босгосон” (Гэтлэл 9:16) хэмээн айлджээ. Үүнийг нь Паул ч Ромд бичсэн захидалдаа бататгасан (Ром 9:17). Энэ нь алдаагүй, зөв бөгөөд хоёр гэрчийн гэрчлэлээр тогтоосон зүйл болохыг (Иохан 8:17) бид хоёрын хоёр эшлэлээс харлаа. Фараоныг диавол биш, харин Бурхан Өөрөө босгож ирээд, эрх мэдлийн байр сууринд тавьсан нь эргэлзээгүй байна. Өөрөөр хэлбэл, Фараон Абрахамын үр сад дээр эдлэх эрх мэдлээ Бурханаас хүлээн авчээ. Энэ нь ч “оршин буй эрх мэдэл болгон нь Бурханаар тогтоогдсон” гэдэгтэй төгс таарч байна.

Тэгвэл Бурхантай гэрээ тогтоосон хүмүүс яаж яваад тэр муу ёрын Фараоны эрх мэдэл дор орсон талаар ярилцъя. Абрахамыг далан тавтай байхад нь Бурхан үзэгдээд, дуулгавартай байвал, түүнээс аугаа үндэстнийг бий болгоно хэмээжээ. Абрахам ч дуулгавартай байж, түүний дуулгавартай зан Бурханы бахыг хангасан тул Тэрбээр Абрахамыг “итгэлийн эцэг” хэмээн нэрийдэв (Ром 4:11-12). Абрахамын дуулгавартай зангийн хариуд Бурхан Абрахамтай гэрээ огтолсон бөгөөд гэрээгээ огтлохдоо: “Чиний үр удам хүний нутагт ирмэл хүн болж тэнд боолчлогдох бөгөөд дөрвөн зуун жил дарлагдана гэдгийг мэдтүгэй” (Эхлэл 15:13) хэмээжээ.

*Дарлагдана* гэдгийг өөр нэгэн орчуулга дээр *зүдэрнэ* гэсэн байдаг. Хоолойгоор давшгүй хүнд үг байна! Үй олон хөвгүүд, ач зээтэй аав хүн үр удам нь ийм амьдрал үзнэ гэдгийг дуулаад, хэзээ ч баярлахгүй. Би л хувьдаа үүнийг урамшуулсан юмуу тайтгаруулсан эш үзүүлэл гэж хэлэхгүй. Бодоод үз. Бид шинэ мянганд аж төрж байна. Тэгвэл МЭ 2400 онд миний үр садад ийм явдал тохиох нь байна! Надад шууд л: *“Дуулгавартай дагасны минь хариуд ийм амлалт, ерөөл өгөх гэж?”* гэж л бодогдох байх. Хамгийн сонирхолтой нь энэ үгийг Исаакийг төрөхөөс ч өмнө зөгнөсөн байдаг.

## Муу авир үйлдлээсээ болоод энэ үү?

Зарим нь магадгүй “Абрахамын үр удам дуулгаваргүй байдал, муу авир үйлдлийнхээ гороор Фараоны дор шийтгүүлэх талаар урьдчилж хэлсэн нь тэр байх. Түүнээс биш Бурхан хүмүүстээ ийм юм төлөвлөх Нэгэн биш!” гэх байх л даа. Тэгвэл нарийн судлаад, энэ гаргалгаа зөв эсэхийг шалгая.



## ХЭН ХАРИУЦАЖ БАЙГААГ БУРХАН МЭДЭХ ҮҮ?

Үүнд хариулахын тулд эхлээд Израильчууд яаж яваад Фараоны дор орчихсныг мэдэх хэрэгтэй. Абрахамын хүү Исаак Бурханыг эмээн хүндэтгэж, дуулгавартай, ариун амьдарсан хүн. Исаак гэргий Ребекатайгаа Есав гэдэг ууган хүүтэй, Иаков гэдэг отгон хүүтэй байв. Хоёр хүү нь олон талаараа маш ондоо байжээ. Бурхан тэр хоёрыг мэндлэхээс ч өмнө: “Би Иаковыг хайрлаж, Есавыг үзэн ядсан” (Ром 9:13) гэж айлдсан байв.

Иаков хэдийгээр яльгүй буруу эхэлсэн ч, эцэстээ Пениелд байхдаа, Бурхантай нүүр нүүрээрээ уулзжээ (Эхлэл 32). Энэ уулзаагаар Бурхан Иаковтай ерөөлийн гэрээ тогтоож, Иаков гэдэг нэрийг нь “Бурхантай хамт байгч ханхүү” гэсэн утга бүхий Израиль гэдэг нэрээр сольжээ. Үүний дараа Иаков маш шулуун шударга хүн болж хувирдаг. Иаков гэр бүлдээ “шүтээнээ хаяж, Бурханы өмнө цэвэр байхыг” тушаасан. Тиймээс ч хожим тэдний гэр бүлийг хаа ч явсан үл итгэгч хүмүүс айдаст автдаг болжээ (Эхлэл 35).

Израиль арван хоёр хүүтэй байв. Израиль арван нэгдүгээр хүү Иосефтаа амь байсан учраас, ах нар нь агаархав. Бурхан Иосефт тэрбээр ирээдүйд аугаа удирдагч болж, ах нараараа үйлчлүүлнэ гэсэн утга бүхий хоёр янзын зүүд өгчээ. Зүүд нь ч ах нарыг нь нөхцөлгүй хилэгнүүлсэн болохоор, тэд дүүгээ хөнөөхөөр хуйвалдаад, эцэстээ Египет рүү боол болгоод зарчихжээ.

Иосеф Египетэд байхдаа, үгээр илэрхийлэшгүй уйтай ганцаардал, гутрал дунд ч Эзэндээ итгэмжтэй үлдэв. Фараоны албан тушаалтанд арван жил хүчин зүтгэснийхээ дараа Иосеф эзнийхээ гэргийг хүчирхийлэхээр завдсан гэдэг хилс хэрэгт гүтгүүлэв. Тэгээд хоёр жил шоронд суусан боловч мөн л үнэнч бөгөөд тэвчээртэй байлаа. Тэгтэл Эзэн Иосефаар дамжуулан шоронд байсан Фараоны хоёр зарцын зүүдийг хөрвүүлжээ. Үнэхээр ч Иосефын хэлснээр тэдний нэг нь цаазлуулж, нөгөө нь сэргээгдсэн боловч, сэргээгдсэн этгээд нь Иосефын: “Ах аа, намайг бодоорой!” гэсэн гуйлгыг нь таг мартав. Тийм боловч Иосеф итгэмжтэй хэвээрээ л байлаа.

Хожим Фараон муу зүүднээсээ болоод шаналанд автахад, мөнөөх сэргээгдсэн зарц нь хаандаа Иосефын талаар дуулгав. Тэр зүүд нь элбэг дэлбэг долоон жилийн дараа айсуу аймшигт гамшгийн талаарх анхааруулга байв. Бурхан Иосефт цэц ухаан хайрлаж, тэрбээр элбэг дэлбэг долоон жилийн хугацаанд хоол хүнсээ хэрхэн нөөцлөхийг Фараонд зөвлөжээ. Фараон Иосефын цэц ухааныг бишрээд, түүнийг

тэр даруй өөрийнхөө баруун гар - Египетийн хоёрдугаар хүн болгов.

Энэ хооронд нутагтаа суугаа Иосефын бурханлаг аав Израиль нь энэ талаар юу ч мэдээгүй байлаа. Учир нь Бурхан түүнд илчлээгүй ажээ. Бодоод үз. Бурхан юу болж байгааг Фараонд хэлсэн атлаа итгэмжит зарц Израилиасаа харин нуужээ. Яагаад гэвэл энэ үйл явдлаар дамжин Абрахамын үр удам Египет рүү шилжин суурьших ёстой байв. Гамшгийн хоёрдугаар жилд Израиль хөвгүүдээ үр тариа олоод ир хэмээн Египет рүү явуулав. Эс бөгөөс тэд өлсөж үхэхийн даваан дээр иржээ. Тэдэнд Эзэний ухаанаар гамшигт бэлтгэсэн байсан Египетээс өөр хандах газар байсангүй. Фараонд хүртээсэн Бурханы илчлэлийн ачаар Египет туйлын хүчирхэг, баян улс болжээ. Бурхан Египетийг хамгийн хүчирхэг, нэр нөлөө бүхий улс болгохоор тордож байсан нь өөр нэгэн зорилготой байв.

Израилийн хөвгүүд Египетэд ирээд, Иосефын өмнө зогссон боловч, төрсөн дүүгээ таньсангүй. Үүнд гайхах юмгүй. Боолыг сэнтийд зарарна гэж хэн санах билээ? Гэтэл Иосеф тэднийг таньсан ч - магадгүй бүр хүлээж байсан ч - өөрийгөө илчилсэнгүй.

Түүнийг хэн болохыг нь мэдсэн ах нар нь үнхэлцгээ хагартал айжээ. Эдүгээ Иосеф урвагч ах нараасаа өш хонзонгоо ханатал авч болох байв. Гэтэл оронд нь Иосеф тэднийг тайтгаруулжээ:

—Надад ойрт гэсэнд тэд ойртон очжээ. Тэгээд Иосеф

—Би та нарын Египет уруу худалдсан тэр дүү Иосеф чинь байна. Та нар намайг энэ газар худалдсандаа бүү санаа зов, бүү харамс. Бурхан амийг аврахаар та нараас өмнө намайг илгээжээ. Энэ нутагт хоёр жилийн турш өлсгөлөн болсон бөгөөд бас дахин таван жил газар хагалж ч чадахгүй, ургац хурааж ч чадахгүй. Бурхан их авралаараа та нарыг амь хэлтрүүлж, үр удмыг чинь газар дэлхий дээр үлдээхээр та нараас өмнө намайг илгээжээ. *Тийм учраас намайг нааш нь та нар явуулаагүй, харин Бурхан явуулсан.* (Эхлэл 45:4-8)

Энэ хариултыг үзээд, та Иосефыг Египетэд хэт удаан амьдраад, орон гаран болчихож хэмээн гайхаж байж магадгүй. Нөгөө олон жилийн шаналал, урвалт, ганцаардлаа мартчихаж! Тэгээд ч Бурхан чинь хайрын Бурхан байж яахаараа түүнд ганц хүнд ахадсан гэмээр их зовлонг зөвшөөрдөг байна аа? Израилийн хамгийн итгэмжтэй, дуулгавартай хүүг арван хэдэн жил боолчилж, орон шоронд хатаадаг байна аа? Цаашлаад яахаараа Бурхан гэрээнийхээ хүмүүсийг бүр

## ХЭН ХАРИУЦАЖ БАЙГААГ БУРХАН МЭДЭХ ҮҮ?

дагуулж ирээд л үе үеийн хамгийн харгис дарангуйлагчийн гар дор тавьчихдаг байна аа? Бурхан энэ бүхнийг зөвшөөрөхөөр барахгүй, үнэндээ бүр төлөвлөсөн гэж Иосеф хэлсэн байгаа бус уу?

Үг болгон нь хоёр гэрчийн амаар байгуулагддаг гэдгийг санаарай. Үүнээс олон жилийн дараа магтаалч юу гэж хэлсэн байгааг сонсоно уу:

Түүнчлэн тэр нутагт өлсгөлөнг дуудан ирүүлж,  
Талх тарианы иш бүрийг Тэр хугалсан.  
Үүнээс өмнө Тэрээр нэг хүнийг буюу  
Боол болон худалдагдсан Иосефыг илгээсэн.  
Хөлийг нь тэд дөнгөнд оруулж,  
Өөрийг нь төмрөөр гинжилсэн.  
Түүний үгс биелэгдэх хүртэл тийм байсан.  
ЭЗЭНий үг түүнийг шалгасан.  
Хаан илгээж, түүнийг суллаж,  
Үндэстнүүдийн захирагчдыг явуулж түүнийг сул тавьсан  
(Дуулал 105:16-19).

Пөөх, нээрээ Иосеф даалгаврынхаа талаар дэмийрээгүй байна! Энэ хэсгийг илүү нарийн харцгаая. Нэгдүгээрт - энэ гамшгийг чөтгөр юмуу нөхцөл байдал бус, Бурхан төлөвлөжээ. Хоёрдугаарт - Бурхан түүнийг түрүүлж илгээсэн болохыг Иосеф хэлсэн байна. “Бурхан илгээсэн” гэдэг нь энэ нь өөр хэний ч үйлдэл биш болохыг хэлж байна. Иосеф ч үүнийг баталсан. Тэрбээр Бурханы Сүнсээр ярьсан. Гуравдугаарт - Иосефын бүх зовлон нь түүнийг шалгаж, цэвэршүүлэх үйл явц байжээ. Эцэстээ тэрбээр төмрөөр дөнгөлүүлж, гинжлүүлсэн. Гяндан гэдэг нь манай өнөөгийн шоронгуудтай зүйрлэхийн аргагүй аймаар газар. Гэхдээ Иосеф хамгийн бурханлаг хүү байв! Тэгэхээр сайн хүмүүс ч хатуу харгис эрх мэдэл дор зовж зүдэрч болох бөгөөд энэ бүхэн нь зүгээр нэг тохиолдлын чанартай явдал юмуу Дяаволын төлөвлөгөө бус, харин Бурханы төлөвлөгөө хийгээд хангамж байж болно гэсэн үг үү?

## Их чөлөөлөлт

Эдгээр чухал асуултад үргэлжлүүлэн хариулъя. Иосефын үгийг дахин харна уу. Тэрбээр тэнгэрийн онгодоор өгүүлснийг санаарай: “Бурхан их авралаараа та нарыг амь хэлтрүүлж, үр удмыг чинь газар дэлхий дээр үлдээхээр та нараас өмнө намайг илгээжээ. Тийм учраас намайг

нааш нь та нар явуулаагүй, харин Бурхан явуулсан. Бурхан намайг Фараоны эцэг, түүний бүх гэрийн эзэн, Египетийн бүх нутгийн захирагч болгосон билээ (Дуулал 45:7-8).

Их чөлөөлөлт! Байзаарай. Абрахамын үрсэд дуулгаваргүй авирласандаа Фараоны захиргаа дор ороогүй, энэ бүхэн нь Бурханы төлөвлөгөө байжээ. Үүнээс гадна Иосефыг нас барсны дараа өөр нэгэн Фараон гарч ирээд, Израильчуудыг харгислан хатуурхахыг Бурхан урьдаас мэдэж байв (Гэтлэл 1:8-14). Ийнхүү үр сад нь дөрвөн зуун жил зовохыг олон жилийн тэртээ Бурхан Абрахамд хэлжээ. Тэгвэл Эзэний тэр их чөлөөлөлт нь юу байв? Ийм зовлон туулж байхад юуных нь чөлөөлөлт байх билээ?

Зарим хүн “Бурхан долоон жилийн гамшгийн үеэр хэрэгтэй хоол хүнсийг нөөцлөн базаах цэц ухаанаа Египетэд бус, Абрахамын үр садад өгчихгүй? Тэгсэн бол, Иосеф энэ бүх зовлонгоос хэлтрэх байсан” гэж хэлэх байх. Гэхдээ өгөөгүйн шалтаан нь тодорхой юм: “Бурхан Израилийг Фараоны гарт оруулахыг хүссэн. Бүр төлөвлөсөн! “Гэхдээ Фараон чинь эртний Гитлер шүү дээ. Тэр Бурханы мянга, мянган хүнийг алж, тамлан тарчлаасан” гэж үү? Тийм ээ, тэр үнэн. Гэхдээ Бурхан юу юунаас илүүтэй биднийг тав тухтай байлгаж, бидэнд энэ дэлхийг эдлүүлэхийг бус, харин биднийг авран сэргээхийг зорьдгийг сана! Фараонд хэлсэн Бурханы цэц ухааныг л үз: “Харин Би хүчээ чамд үзүүлж, Өөрийн нэрийг бүх дэлхий даяар тунхаглахын тулд үүнд чамайг босгосон юм (Гэтлэл 9:16).

Эдгээр цуврал үйл явдлаас өмнө Эзэнийг гагцхүү Абрахам, Исаак, Иаков болоод тэдний үр сад л мэддэг байжээ. Абрахам, Исаак, Иаковын Бурханыг дэлхий мэддэггүй байв. Тиймээс л Мосе Фараон дээр ороод, Израилийг явуулахыг Эзэний нэрээр тушаахад, Фараон: “ЭЗЭН гэгч хэн болоод Израилийг явуул гэсэн үгийг нь би дагах ёстой юм бэ? Би ЭЗЭНийг мэдэхгүй, Израилийг ч явуулахгүй” (Гэтлэл 5:2) гэсэн юм. Фараон болоод бүх Египет Бурханыг мэддэггүй байжээ. Гэтэл Бурхан хүмүүсээ чөлөөлөхөөр тэмдгүүдээ үйлдэх үед энэ байдал эргэсэн юм.

Хэд хэдэн гамшгийн дараа зарим Египетчүүд Бурханы Үгийг сонсож эхэлсэн. Мөндөр буухын өмнө “Фараоны зарим түшмэд ЭЗЭНий үгнээс айж, боол ба малаа гэртээ бөөгнүүлжээ” (Гэтлэл 9:20). Төдөлгүй гэд Фараоноос “Энэ хүн хэр удаан бидэнд урхи болох юм бэ? Хүмүүсийг нь явуулаач! Тэд Бурхан ЭЗЭНдээ үйлчлэг. Египет сүйрсэн болохыг та мэдэхгүй байна гэж үү?” (Гэтлэл 10:7) хэмээн улиглан гуйжээ. Египетийн илбэчид ч хаандаа “Энэ нь Бурханы хуруу байна” (Гэтлэл 8:19) гэсэн.

## ХЭН ХАРИУЦАЖ БАЙГААГ БУРХАН МЭДЭХ ҮҮ?

“ЭЗЭН египет хүмүүсийн нүдний өмнө ард түмнийг таалан соёрхож, Мосе гэгч хүн Египет улсад, Фараоны албат нар хийгээд ард түмний нүдэнд үлэмж агуу болов” (Гэтлэл 11:3) гэснээс нь Иехувагийн талаарх шинэхэн мэдлэг нь тодорхой харагдаж байна. Тэд Эзэнийг мэдсэн учраас, Бурханы хүнийг гүнээ хүндэтгэжээ. Тэгээд Египетчүүд Израильчуудад алт, мөнгө, хувцас тэргүүтнээ хүссэнээр нь өгчээ (Гэтлэл 12:35-36). Тэр бүү хэл Фараон ч эцэстээ: “ЭЗЭН зөвт юм. Би болон ард түмэн минь буруутан билээ” (Гэтлэл 9:27) гэсэн.

### Бүх дэлхий мэдэх болов

Иехува бол жинхэнэ, амьд Бурхан гэдгийг Египет төдийгүй, даян дэлхий мэдэв. Учир нь тэр Бурхан дэлхийн хамгийн хүчирхэг улсыг дарж аван, даруу болгожээ. Бурхан тэр үндэстэнд Иосефаар дамжуулан цэц ухаан хайрлаж, дэлхийн орой дээр гаргасан нь хожим Израилийн боолуудаар ниргүүлэхийн төлөө л байсан юмсанж. Тэр боолууд зүгээр нэг ядарсан, буурай үндэстнийг буулгаж аваагүй болохоор Египетийн ялагдал нь үзэгч - дэлхийд маш хүчтэй нөлөөлжээ. Ийнхүү Бурхан даян дэлхийд хүчтэй нөлөөлсөн учраас, хэдэн жилийн дараа Израилийг цөлөөр аялж явахад нь улс үндэстнүүд тэдний Бурханаас айж, Израилийн өмнө бэмбэгнэж байсан юм.

Үр нөлөө нь бүхэл бүтэн нэг үеийн дараа ч илэрсээр байв. Мосегийн залгамжлагч Иошуа Иерихо хэмээх хүчирхэг хот руу хоёр тагнуулаа илгээхэд нь тэднийг Рахаб гэгч янхан угтаад:

ЭЗЭН энэ газрыг та нарт өгснийг, та нараас айх айдас хүйдэс биднийг нөмөрснийг мөн энэ нутгийн бүх оршин суугчдын зориг та нарын өмнө мохсоныг би мэднэ. ...Бид үүнийг сонсоод та нараас болж бидний зүрх үхэж, хэн хүнгүй зориг мохов. Учир нь та нарын Бурхан ЭЗЭН бол дээр тэнгэр дэх, доор газар дээрх Бурхан мөн билээ (Иошуа 2:9-11) гэж хэлжээ.

Рахаб Эзэнийг Бурхан хэмээгээд, тэр нутгийн “бүх оршин суугчид” айсныг мэдэгдсэн байна. Эзэний нэрийг даян дэлхий мэдэв!

Энэ мэдлэг нь зөвхөн Бурханы алдрын төлөө байгаагүй, харин хүмүүсийн аврал сэргэлтийн төлөө байв. Тэгээд харь үндэстэн янхан хүүхэн гэр бүлтэйгээ аврагдахад, анхны үр жимс нь гарч эхэлсэн юм.

Үүгээр зогсохгүй Рахаб Давид хааны эмэг эхийн ээж болж, алсдаа тэр ургаас Есүс Христ мэндэлсэн болой. Хэрэв Бурхан Өөрийгөө дэлхийд мэдүүлж, Израильчуудыг захируулахаар гаргаж ирсэн Фараонаа Өөрийнхээ нэрээр номхруулаагүй бол, ийм зүйл өрнөхгүй байв.

Израильчууд Египетээс чөлөөлөгдсөн явдлаас хэдэн зуун жилийн дараа ч Бурханаас айх айдас улс үндэстнүүдийн дунд оршсоор байж. Израилийн тахилч бөгөөд шүүгч Елигийн үед Бурханы нэр Фараонд үйлдсэн үйлсээрээ ахин дуурсагджээ. Израиль Филистинчүүдтэй байлдаад, эхний өдрөө ялагдав. Маргааш нь Израильчууд дайны талбарт гэрээний авдрыг авчрав. Тэднийг цугларахад “Израиль газар доргион хүнгэнүүлсэн их дуугаар уухайлан хашхирчээ” (1Самуел 4:5). Филистинчүүд энэ их чимээнд баахан гайхсан ч, Израилийн хуаранд Эзэний авдар орж ирснийг хожим ойлгожээ:

Филистчүүд

—Бурхад тэдний хуаранд залран ирлээ хэмээлдэн түгшицгээв. Тэгээд —Урьд нь ийм юм тохиолдож байгаагүй тул бид золгүй еэ! Бид золгүй еэ! Хэн биднийг энэ агуу хүчит бурхдын (*элохим*) мутраас мултлан аврах вэ? Эдгээр нь египетчүүдийг элдэв төрлийн гамшгаар цөлд цохисон бурхад (*элохим*) мөн билээ (1Самуел 4:7-8).

Энд “бурхад” гэхэд *элохим* гэдэг Еврей үгийг хэрэглэжээ. Хуучин гэрээ энэ үгээр бидний үйлчилдэг Эзэн Бурханыг мянга гаруй удаа дуудсан байдаг. Тухайлбал, Эхлэл номын эхний бүлэгт л гэхэд, энэ үгээр бидний Бурхан бөгөөд Бүтээгчийг гучин хоёр удаа дуудсан. Тиймээс энэ үгийг “бурхад” биш, “Бурхан” гэж орчуулбал ононо. Хэдэн зуун жилийн дараа Бурханд үйлчилдэггүй Филистинчүүд хүртэл жинхэнэ, амьд Бурхан гэж хэн болохыг мэдэж байжээ.

## Бурханы ёроолгүй цэц ухаан

Бурхан ёрын Фараоныг гарч ирэхэд юу ч мэдээгүй юм биш. Учир нь: “Бурханаас гадуурх эрх мэдлүүд гэж үгүй бөгөөд Бурханы тогтоосноор л байгаа тул дээд эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд” (Ром 13:1). Хүн төрөлхтний түүхнээ гарч ирсэн сайн, муу удирдагчдыг бүгдийг нь Бурхан зөвшөөрөн томилдог. Бурхан тохиолдлоор бус, заавал тодорхой шалтгаанаар томилдог юм.

Та: “Сталин, Гитлер мэтийн удирдагч нар ямар сайн сайхан юм

## ХЭН ХАРИУЦАЖ БАЙГААГ БУРХАН МЭДЭХ ҮҮ?

авчирсан юм?” гэж асууж болох. Үүнд хариулахын тулд элч Паулын үгийг эш татъя:

Тэгэхлээр Тэр Өөрийн хүссэн хүнээ өршөөдөг, хүссэн хүнээ хатууруулдаг. ...Аяа, Бурханы мэргэн ухаан болон мэдлэгийн баялаг нь юутай гүн бэ! Түүний шүүлтүүд нь ямар ойлгож баршгүй, Түүний замууд нь ямар олж илрүүлшгүй вэ? Эзэний оюун ухааныг хэн мэдсэн бэ? Хэн Түүний зөвлөгч нь болсон бэ? (Ром 9:18, 11:33-34).

Бурхан бидний хяналтаас талийсан зүйлсийг үйлддэг. Түүний илчлэхгүй байхаар шийдсэн юмсыг бид зүгээр л үг дуугүй хүлээн зөвшөөрөх ёстой.

Паул Бурханы цэц ухааны талаар “Харин Бурханы эсрэг хариу хэлдэг хүн чи хэн юм бэ? Баримал нь «Та яагаад намайг ингэж хийв?» гэж барималчинд хэлдэг үү?” (Ром 9:20) хэмээн дахин асуусан байдаг. “Чи хэн юм?” гэдэг үгийг дахин харна уу. Өөрөөр хэлбэл бид Бурханыг байцаан шалгах эрхтэй гэж үү?

Бурхан бидэнд сургамж болгох гэж бас биднийг Өөрийнхөө цэц ухаан, сайн сайханд итгүүлэхээр гэгээрэл, ойлголт хайрлах гэсэндээ л Фараоныг гаргаж ирсэн гэдгээ харуулсан. Гэхдээ Бурхан удирдагч болгон дээр ингэж тайлбар өгөхгүй. Бурхан биднийг Өөрийнх нь цэц ухаан, сайн сайханд итгээсэй л гэж хүсдэг.

Бурхан хэзээ ч зорилгогүй, хоосон зовлон зөвшөөрдөггүй нь Түүний л мэргэн ухааных. Тухайн үед бид тэр зорилгыг нь харахгүй байсан ч, Бурхан ямагт зовлон болгоныг авран сэргээх зорилгынхоо төлөө эргүүлэх төлөвлөгөөтэй байдаг. Тэр төлөвлөгөө нь цаг хугацааны явцад бас өнө мөнхийн ойлголтоор заавал илчлэгддэг. Бурхан сайн учраас, хэзээ ч бидэнд мөнхийн хор хохирлыг зөвшөөрөхгүй. Та: “Гэхдээ завхарсан удирдагч нарын дорх ард түмэн маш их зүдэрдэг” хэмээн маргаж болох. Энэ нь махан биеийн хувьд үнэн боловч, Бурхан сүнсний юмсыг биеийн юмсаас дээгүүр шүүдэг юм. Абелийн үхэл гарз мэт байсан ч, түүний цус нь ярьсан (Еврей 11:4). Урьд хождын завхарсан удирдагч нараас болж мянга, мянган Христэд итгэдэг хүмүүс алуулсан боловч, тэдний цус хоосон урсаагүй юм. Тэдний цус ярьсаар байгаа.

Удирдагч нартаа даруу зан, дуулгавартай байдал, залбирлаараа нөлөөлөх боломж бидэнд бий. Бурханы хүмүүс өөрсдийгөө даруусгаж, залбирч, ёрын муу замаасаа эргэхэд, Бурхан тэнгэрээс

сонсож, газрыг нь эдгээнэ гэсэн. Жишээ нь Шүүгч ном дээр бурханлаг удирдагчийн томилгоо гардаг. Шинэ гэрээ “Тиймээс бүх хүний төлөө гуйлт, залбирал, зуучлан залбирал хийгээд талархал өргө гэж юуны өмнө чамайг ятгая. Хаад болон эрх мэдэлтэй бүхний төлөө залбир. Тэгвэл бид итгэл сүсэгтэй бас хүндлэлтэй, тогтуун, төвшин амьдрах болно. Энэ нь бидний Аврагч Бурханы мэлмийд сайн бөгөөд нийцтэй” (1Тимот 2:1-3) гэдэг.

Бид залбирлаараа одоогийн удирдагч нартаа нөлөөлж чадна. Үр нөлөө нь удирдагч нарын сонгууль, томилгоо зэрэг өргөн цар хүрээг хамарна. Гэхдээ энэ бүхнийг зүй ёсоор нь үйлдээд байхад ч, онцгой тохиолдол бас гарна аа. Эртний чуулганы элч нар бөгөөд ариун хүмүүс байнга өөрсдийг нь хавчих харгис хатуу эрх мэдэлтнүүдийн нүүрийг үзэж байсан. Тэд бурханлаг амьдраагүй эсвэл залбираагүйгээсээ болж зовлон эдэлсэн бус, харин тэдгээр удирдагч нар Бурханы авран сэргээх зорилгод үүрэг гүйцэтгэсэн билээ.

## **I Херод Агриппа**

Тэдний нэг болох I Херод Агриппаг авч үзье. Херод гэдэг нэрээр Есүсийг төрөхөөс өмнө, Есүсийг үйлчлэх хугацаанд бас Есүсийг амилсан хойно Палестины нутаг дэвсгэрийг захирч байсан Ромын хэд, хэдэн захирагчийг нэрлэж байсан юм. I Херод Агриппа нь Есүсийг амилсны дараа МЭ 37 онд төрийн эрхэнд гарчээ. Тэрбээр хамаг л холч ухаан, овжин сүйхээ, арга чарга юугаан хэрэглэн байж, эрийнхээ сайнд дээшээ гарчээ. Ромын эзэн хаан Калигулаг алуулсны дараа Кладиуст хаан ширээнд суухад тусалсан нь Агриппагийн улс төрийн гол маневр байлаа. Кладиус Агриппагийн ухаалаг улс төрийн нүүдлийг нь шагнаан, өөрийнхөө оронд томилоод, дээрээс нь Иүдеа Самарийн нутаг дэвсгэрийг нэмж өгчээ. Тэгээд Агриппа Аугаа их өвөг эцэг Херодтайгаа ижил хэмжээний том хаанчлалыг захирах болов.

I Херод Агриппа энэ хугацаандаа Иүдеизм - Христийн сект дундын зөрчилд хавчуулагджээ. Тэгээд эргэлт буцалтгүй Христэд итгэдэг хүмүүсийг хавчдаг хүний дүрийг бүтээсэн юм. Үйлс номд “Энэ үед Херод (Агриппа) хаан тэднийг хорлох зорилгоор чуулганаас заримыг нь баривчлав. Иоханы ах Иаковыг тэр цавчин алуулжээ. Иудейчүүдэд энэ нь таалагдсаныг ажигласан тэрээр Петрийг ч мөн баривчлахаар шийдэв” (12:1-3) гэдэг. Захирагч - тэрбээр итгэгч хүмүүст харгис



## ХЭН ХАРИУЦАЖ БАЙГААГ БУРХАН МЭДЭХ ҮҮ?

хатуу хандсан нь түүний улс төрийн зорилгод нийцэж, Иудейчүүдийн (иргэдийн дийлэнх хувийн) тааллыг олов. Тэрбээр Есүсийн хамгийн дотны гурван дагалдагчийн нэг Иаковыг алчихаад, дараа нь Петрийг алахаар санаархжээ.

“Агриппагийн эрх мэдэл хаанаас ирсэн бэ?” гэж асуух ёстой. Хэдийгээр тэрбээр өргөө зөв өрж, нүүдлээ зөв хийснээрээ эрх хүчинд хүрсэн ч, цаанаас нь Бурхан зөвшөөрөөгүй бол, төрийн эрхэнд хэзээ ч гарахгүй байсан юм.

Гэтэл Агриппагийн гарт зовсон Петр итгэгч хүмүүст: “Бурханаас эмээ, хаанаа хүндэтгэ” (1Петр 2:17) гэж хэлжээ. Юу гэнэ вэ? Иаковыг алсан хааныг хүндэтгэх гэж үү? Бурхан яагаад үй олон хүүхдийнхээ дээр ийм харгис хатуу удирдагчийг тавихаар барахгүй, дээрээс нь “түүнийг хүндэтгэ” хэмээнэ вэ? Бичээсээ үргэлжлүүлэн уншвал, тал хариуг нь олно: “Петрийг шоронд хоригдож байхад чуулган Бурханд хандаж түүний төлөө тасралтгүй залбирч байв” (Үйлс 12:5). Үүний үр дүнд Бурхан тэнгэрэлчээ илгээсэнд, тэнгэрэлч гайхамшиг үйлдэн Петрийг шоронгоос чөлөөлж, залбирч байсан айлд нь аюулгүйгээр дагуулан авчирдаг. Итгэгч хүмүүс Бурханы эрх мэдлийг төлөөлсөн хаанаа хүндэтгэлгүй, Бурханы тушаалд тэрсэлдсэн бол, Бурханы гайхамшиг үйлдэхгүй байх байжээ.

Чуулганы дуулгавартай үйлдэл, залбирал Петрийг хөнөөх Агриппагийн төлөвлөгөөг тасалдуулав. Энэ үйл явдал итгэгч хүмүүсийг илт зоригжуулжээ. Фараонд тохиолдсон шиг энэ удаа ч бас Бурхан хүчээ авран сэргээх төлөвлөгөөнийхөө төлөө ашиглажээ. Үүнийг Бичээс өөрөө аугаагаар гэрчилдэг: “Харин Эзэний үг түгэн түгсээр байлаа” (Үйлс 12:24).

Ариун хүмүүсийн үргэлжилсэн залбирал, эрх мэдлийг хүндэтгэх дуулгавартай байдал нь дараа дараагийн үйл явдалд хүчтэй нөлөөлсөн байна. Цааш нь уншбал, нэгэн өдөр I Херод Агриппа хүмүүсийн өмнө гараад, сүр хүчээ гайхуулан сэнтийдээ залраад, олонд хандан үг хэлжээ:

Ард олон —Хүний дуу биш, бурхны дуу байна гэж хашхирч байлаа. Бурханд алдрыг өргөөгүй тул түүнийг тэр даруй Эзэний тэнгэрэлч цохижээ. Тийнхүү тэр өт хорхойд идүүлж үхэв (Үйлс 12:22-23).

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Шүүх буужээ. Гэхдээ Бурханы хүмүүсээр бус, харин Бурханы илдээр иржээ. Гагцхүү Бурхан Өөрөө л эрх мэдлийг шүүдэг талаар бид удахгүй үзнэ. Бид удирдагч нарынхаа төлөө залбирч, тэдний эрх мэдэлд захирагдах зарлигтай. Шүүх ёстой бол, Бурхан Өөрөө л шүүг.

Библийн олон үйл явдлаар баталгаажсан энэ бүлгийн сургаалыг өнөөдөр чуулганд явдаг олон хүн эсэргүүцдэг нь тоогүй. Өөрийнхөө тав тухыг Бурханы авран сэргээх ажлын үйл явцаас дээгүүр тавьдаг хүмүүс Бурхан тухайн талбарт юу үйлдэж байгааг харах нүдгүй байна. Бурханы цэц ухаанд зүрхээ нээе. Бурхан бидний эсрэг бус, бидний төлөө байдаг юм шүү.

## ХААНЫГ ХҮНДЭТГЭХ

*Бид эрх мэдэлтнүүдийг хүндэтгэх ёстой - эмээж, хүндэтгэж, өмгөөлж, захирагдаж, тэдний өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой.*

**Ө** нөөдөр аж төрж байгаа хүмүүс бид өмнөх бүлэгт товч дурьдаад өнгөрсөн элч Петрийн хатуу ятгалгад нухацтай анхаарах ёстой. Энэ Бичээсийг авч үзэхээсээ өмнө эхлээд үүнийг өмнөх мэдэгдлийг бүтэн агуулгатай нь уялдуулан шалгая: Хайртууд аа, сэтгэлийн чинь эсрэг дайтдаг махбодын хүсэл тачаалуудыг цээрлэхийг ирмэл агаад түр суурьшигч та нараас би гуйя. Харийнхан дунд биеэ зөв авч яв. Ингэснээр тэд та нарыг муу муухайг үйлдэгчид хэмээн гүтгэвч, сайн үйлсийг чинь хараад Түүний харгалзлын өдөр Бурханыг алдаршуулах болно” (1Петр 2:11-12). Эрх мэдэлд захирагдах нь Петрийн өгүүлсэн зүй зохистой зан авир мөн болохыг бид одоо харна. Энд эрх мэдэлд дуулгаваргүй хандах тэрслүү хүсэл хийгээд дуулгавартай байдлын хоорондын тэмцлийн талаар ярьжээ. Гэтэл бид эсрэгээр нь бодоод байдаг; бид дуулгавартай дагахгүй байх хүслээ хамтрагчаа хэмээн, захирагдах хүслээ дайснаа хэмээн боддог ч, үүн шиг худлаа юм байхгүй.

Бид захирагдаж, дуулгавартай дагалаа ч, “буруу хийлээ” хэмээн яллагдах боломжтой гэж Петр бичсэн байдгийг бүү мартаарай. “Захирагдах нь хэнд хэрэгтэй юм? Захирагдлаа гээд би хийгээгүй

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

зүйлийнхээ төлөө яллагддаг шүү дээ” гэж хэлж болох. Гэхдээ ингэж хэлж байгаа хүн чухам Эзэнд л дуулгавартай хандаж байгаа бөгөөд шагнал нь чухам Эзэнээс л ирдэг гэдгийг харахаа больжээ. Мессеж Библи энэ санааг маш уран сайхан гаргадаг:

Зарц нар аа (ажилчид, чуулганы гишүүд, иргэд гэх мэт) дэлхийн эздээ (ажил олгогч нар, чуулганы удирдагч нар, эрх баригчид гэх мэт) хүндэтгэлтэйгээр дуулгавартай дага - гэхдээ хараагаа хэзээд жинхэнэ Эзэнтэн Христ дээр л тавиарай. Аливаа зүйлийг ёстой учраас хийх бус, харин Христийн зарц хүн Эзэн - Бурханыхаа хүссэн бүхнийг үйлддэг шиг л зүрхнээсээ ажилла. Түүнчлэн чи тушаалыг хэнээс хүлээж авснаасаа үл хамааран, ямагт Бурханд үйлчилж байгаа тул нүүрэндээ мишээлтэй ажилла. Чи боол уу, чөлөөт хүн үү гэдгээс чинь үл хамааран, сайн үйлс чинь Эзэнээс сайн хөлс л авчирна (Ефес 6:5-8).

“Эзэний төлөө өөрсдийгөө хүний бий болгосон аливаа бүтцэд захируул. Эрх мэдэл бүхий нэгэн болох хаанд ч юмуу эсвэл зөвийг үйлдэгчдийг магтаж, мууг үйлдэгчдийг шийтгэхийн тулд түүний илгээсэн захирагчдад захируул” (1Петр 2:13-14) гэсэн Петрийн ятгалгыг эргэн харцгаая. Ариун Сүнс биднийг бүх эрх баригчдад захирагдаарай хэмээн Паулаар дамжуулан сэнхрүүлсэн шигээ мөн Петрээр ч дамжуулан сэнхрүүлжээ. Петрийн өгүүлсэн хаан нь маш харгис хатуу хүн байсан бөгөөд тэр хааны захиргаан дор итгэгч хүмүүс ихэд хавчигдан зүдэрч байсныг бүү мартаарай. Гэтэл Петр ч мөн Паултай адил хүнийг нь бус, харин хүнд өгөгдсөн Бурханы эрх мэдлийг хүлээн зөвшөөрөхөд биднийг ятгажээ. Петр I Херод Агриппа хааны байр суурийн цаад Бурханы эрх мэдлийг ойлгож, хүлээн зөвшөөрсөн учраас л, хаанд захирагдсан байна. Бурханы эрх мэдлийг мэддэггүй хүн Бурханы төлөөний эрх мэдэлд захирагдаж чаддаггүй. Жинхэнэ эрх мэдлийг олж хараагүй хүн хичнээн хичээсэн ч, улам л бэрх болсоор байна.

Петр үл захирагдах явдал нь антихристийг юмуу Христэд итгэдэг хүмүүсийг эсэргүүцэгч сүнсийг хөхүүлэн, түүнд зам засдаг болохыг мэдэж байсан учраас л бидэнд анхааруулжээ. “Тэр бол эсэргүүцэгч төдийгүй, бурхан буюу шүтээний зүйл гэгдэгч бүгдийн дээр өөрийгөө өргөмжлөн, Бурханы сүм дотор сууж, өөрийгөө Бурхан гэж харуулах” (2Тесалоник 2:4) бөгөөд жинхэнэ амьд Бурханы зам, арга барил, ажиллагаа, томилгоо - бүгдийг нь эсэргүүцнэ. Итгэгчид бид өөрөөсөө: “Бид хуульгүй байдлын үйл ажиллагааг дэмжиж байна уу,

эсэргүүцэж байна уу?” гэж асуух ёстой. Дэмждэг бол, Бурханы бус, харин Сатаны (тэрслэлийн) зарчим дор ажиллаж байгаа ажээ.

Петр цааш нь “Бүх хүнийг хүндэл. Ахан дүүсийн барилдлагаг хайрла. Бурханаас эмээ. Хааныг хүндэл” (1Петр 2:17) гэсэн байна. Тэрбээр биднийг эрх мэдэлд захирагдахаар барахгүй, бүр хүндэтгэ гэжээ. “Хүндэтгэхийг” Грекээр *тимао* гэх бөгөөд “хүндэтгэх, хүндэтгэл дотор орших, эмээн хүндэтгэх, оройлон дээдлэх” гэсэн утгатай. Есүс “Надад чөтгөр шүглээгүй. Харин Би Эцэгээ хүндэтгэдэг, та нар Намайг хүндэтгэдэггүй” (Иохан 8:49) хэмээхдээ, тимао гэдэг үгийг хэрэглэсэн. *Хүндэтгэх* гэдэг үгийг (1828 оны) *Вебстерийн толь бичигт* “эмээн хүндэтгэх, хүндэтгэх, дуулгавар, захирагдах хандлага бөгөөд хүлээсэн үүрэг хариуцлагаа гүйцэтгэх” хэмээн тодорхойлсон байдаг. Нэгэн зүйлийг дахин тодруулмаар байна: Петр тухайн үеийн итгэгч хүмүүсийг хорсолтойёо хавчиж хяхдаг хааны талаар ярьж байсан юм шүү! Петр биднийг хааныгаа хувь хүн гэдэг утгаар нь бус, харин Бурханы тохоон томилсон эрх мэдэлтэн гэдэг утгаар нь хүндэтгэхийг ятгажээ.

## Элэг эмтлэм ярилцлага

Хэдэн жилийн өмнө би Өмнөдийн нэгэн томоохон хотын алдартай Христэч радио дээр шууд ярилцлага өгсөн юм. Бид миний бичсэн нэгэн номын талаар ярилцав. Нэвтрүүлэг эхлээд арваад минут өнгөрсний дараа хөтлөгч завсарлага авав. Завсарлагааны цагаар би эфирээс гарчихсан байсан тул цаана сул дуугаар явж байсан хэд хэдэн суртчилгаа, зарлалыг хальт сонслоо.

Тэгтэл гэнэт цаг уурын мэдээ дамжуулж байгаа нэгэн эрийн яриа миний анхаарлыг олзлов. Тэрбээр олон зуу мянган сонсогч нарт хандан, Умард мужийн нэгэн нутагт “тэр мужийн захирагчийн амыг тас хөлдтөл цочир хүйтэрнэ” гэх нь тэр. Хөтлөгч тухайн захирагчийг нэр усаар нь дуудаад, ам нь тас хөлдөөд ирэхээр нөгөө тэнэг яриагаа чалчихаа болино гэв.

Би шоконд оров. Чихэндээ ч итгэсэнгүй. Толгойд “Энэ чинь Христэч радио биш үү? Биш болтой” гэсэн бодол эргэлдэж байлаа. Тэгээд “Христэч радио мөн бол, цаг уурын мэдээгээ Ассосийтэд Прессийн мэдээнээс хуулчихсан болтой” гэж бодлоо. Тэгээд хөтлөгчийг буцаж орж ирэх үед сонссон зүйлийнхээ шокноос гарч

амжаагүй сууж байв.

Шууд ярилцлага эхэлмэгц, хөтлөгч надад ямар ч ойлгомжгүй, бөөрөнхийлсөн асуулт тавьсан бөгөөд хариуд нь би хийсэн бүхэндээ Бурханы зүрх сэтгэлээр хандаж байхыг л хэлэв. Тархи минь сонссон зүйлдээ түүртсээр байсан тул би: “Сая завсарлагаанаар сонссон зүйл маань сайн жишээ болох байх” гэж бодоод: “Энэ Христэч радио мөн үү?” гэж асуулаа.

Хөтлөгч “Мөн” гэлээ.

–“Тэгвэл, миний сая сонссон зүйл дэлхийгээс эх сурвалжтай болтой. Учир нь хэдхэн минутын өмнө энэ үгийг хэлсэн хүнд Бурханы зүрх сэтгэл огт алга.”

Хөтлөгч: “Та юун тухай ярина вэ?” гэв.

Би: “Захирагчийн амыг тас хөлдөөх тухай мэдээний талаар ярьж байна” л гэлээ.

Хөтлөгчийн дуу хувирснаа: “Тэрийг чинь би хэлсэн” гэв.

Би: “Бичээс биднийг Бурханаас эмээж, хаадыг болоод эрх мэдэлтнүүдийг хүндэтгээрэй гэсэн” гэлээ.

Гэтэл хөтлөгч дуугаа өндөрсгөөд: “Тийм ээ, гэхдээ жаахан хошигноход буруудахгүй” хэмээн биеэ өмөөрлөө.

Тэгэхээр нь би шууд л: “Хошигнож болно. Гэхдээ Бурханы хүндэтгээрэй гэсэн хүмүүсийг доромжилж хошигнохгүй. Учир нь Элч Паул “Ард түмнийхээ удирдагчийг бүү муул” (Үйлс 23:5) гэсэн байдаг” гэлээ.

Хөтлөгч: “Тэгэхээр Жон, бид хоёр зарим юман дээр санал нийлэхгүй болтой” гэсэн үгээр ярилцлагаа цагаас нь өмнө дуусгав.

Энэ ярилцлага миний элгийг эмтлэсэн юм. Энэ бүхэн захирагчаа хүндэтгэсэн, эмээсэн, дээдэлсэн явдал мөн үү? Тэр захирагч магадгүй хүндэтгэл хүлээм хүн биш байж болох ч, захирагчийн албан тушаал дээр байгаа хүн. Христэд итгэдэг хүнийхээ хувьд бид эрх мэдлийг нь хүндэтгэх ёстой. Хөтлөгчийн хүндэтгэлгүй хошигнол хичнээн олон итгэгч хүнд нөлөөлөх бол? Итгэгч хүмүүс нийгмийн маш олон талбар дээр нэр хүндээ алдаж байгаад ч гайхах явдалгүй болжээ.

Энэ нь хавчигдаж байсан анхны чуулганы зан үйлдлээс тэнгэр, газар шиг ялгаатай байна. Анхны чуулган эрх мэдлийг хүндэтгэсэн. Харин бид энэ янзаараа үйлдэж, яриад байвал, өнөөдөр эрчээ авсан хууль ёсгүй байдлын хүчийг л зузаатгана. Гэтэл Библи “Учир нь ёс бусын нууц нь хэдийнээ ажиллаж байна. Гагцхүү эдүгээ хязгаарлан баригч дундаас нь

зайлуулагдах хүртэл ажээ” (2Тесалоник 2:7) гэдэг. Энэ зан үйлдэл нь Ариун Сүнсний хориг хүчтэй дайсагнадаг юм. Энэ бол Сатаны зарчим!

## Эзэнээс эмээхүй нь хүндэтгэлийг үржүүлдэг

“Бурханаас эмээ, хааныг хүндэтгэ” гэсэн Петрийн үгийг дахин харцгаая. Бурханыг эмээн хүндэтгэдэг хүмүүс нь өмнөө Эзэний өргөгдсөн, өндөр, алдрын байр суурийг тавьдаг. Тэд Бурханы хязгааргүй эрх мэдлийг үзсэн, үүнд автсан хүмүүс. Тэд Бурханы үнэлдгийг үнэлж, үзэн яддагийг үзэн яддаг. Бурхан эрх мэдлээ төлөөний хүмүүстээ даалгадаг учраас, тэд амьдралын давхарга давхаргын удирдлагыг гүнээ эмээн хүндэтгэхийг мэддэг.

Эрх мэдлийг хүндэтгэдэггүй хүн эмээн хүндэтгэлийн Сүнсгүй байгаа нь илэрхий харагддаг. Есүсийн талаарх Исаиагийн дүрслэлийг санана уу:

ЭЗЭНий Сүнс,  
Мэргэн ухааны ба ухаарлын сүнс,  
Зөвлөгөөний ба хүч чадлын сүнс,  
Мэдлэгийн хийгээд *ЭЗЭНээс эмээхүйн сүнс*  
Түүн дээр оршино.  
*Таалал нь ЭЗЭНээс эмээхүйд.*  
*Тэр нүдэндээ үзэгдсэнээр шүүхгүй,*  
*Чихэндээ сонсогдсоноор шийдэхгүй.* (Исаиа 11:2-3)

Есүс Эзэнээс эмээх дуртай байж. Эзэнээс эмээхүй нь л Есүсийг харж байгаагаараа юмуу сонсож байгаагаараа шүүхгүй байх чадвартай болгожээ. Мөнөөх радиогийн хөтлөгч Эзэний тохоон томилсон эрх мэдлийг үл хүндэтгэсэнээрээ Эзэнээс эмээдэггүй болохоо харуулсан. Нөгөө захирагч нь хүндэтгэл хүлээмээр зан байдалгүй хүн байсан тул радиогийн хөтлөгч захирагчаа чихээр сонссон, нүдээр харснаараа л шүүсэн бөгөөд хүний нүдэнд зөв харагдахаар л байв. Тийм боловч хэрэв тэр хөтлөгч Эзэнээс эмээхүйн нүдээр харсан бол, тухайн захирагчийн амьдрал дээр тогтож буй Бурханы эрх мэдлийг харах л байсан. Төр засгийн эрх мэдлийг гутаан доромжлох нь яав ч бурханлаг үйлдэл биш.

Иохан Баптист Херод гэдэг эрх мэдэлтэй тулсан боловч, хөтлөгчөөс маш ондоо хандсан билээ. Нэгдүгээрт - Иохан Херодод: “Хероdiag та авах нь хууль бус юм” (Матай 14:4) гэж хэлжээ. Иохан хааныгаа элдвээр

гутаалгүй, шууд нүглийнх нь талаар ярьжээ. Хоёрдугаарт - Иохан Херодтай Бурханы эш үзүүлэгч хүнийхээ эрх мэдлээр нүүрэлдсэн. Эцэст нь Иохан хааныхаа талаар элдэв гутаан доромжилсон хошигнол хэлээгүй.

Библи дээр удирдагч хүнээр даажигнасан цорын ганц бурханлаг хүн гардаг нь Елиа юм (1 Хаад 18:27). Елиа Баал, Ашерагийн хуурамч эш үзүүлэгч нарыг болоод бурхдыг нь элэглэсэн. Жинхэнэ эрх мэдлийг хүндэтгэдэггүй тэдгээр хуурамч этгээдүүд үй олон Израильчуудыг харанхуй руу дагуулсан юм. Бурхан тэднийг тохоон томилоогүй. Тэд бол хүндэтгэл, дуулгавартай байдалд зохисгүй хүмүүс. Гаж урсгалын байгууллагыг удирддаг хүмүүст захирагдаж, тэднийг дагаж болохгүй.

Тэгвэл Бурханы төлөөний удирдлагын тухайд - Эзэнээс эмээхүйн нүдээр хараагүй тохиолдолд энэ эрх мэдлийг хүндэтгэж, дуулгавартай дагах бас л хэцүү. Гэтэл Бичээс “Ялангуяа ялзарсан хүсэл тачаалд махбодоо өөгшүүлдэг, *эрх мэдлийг үл тоомсорлодог*, шазруун, дур зоргоороо авирлагч тэд тэнгэрлэг сүр хүчийг доромжлохдоо айдаггүй байхад...” (2Петр 2:10) гэдэг. Хамгийн аймшигтай нь Петр, Иуда хоёр чуулганы хүмүүсийн талаар ингэж ярьсан юм шүү дээ (Иуда 12; 2Петр 2:13-15).

Бид Бурханы хаанчлалыг ардчилсан “нүдээр” хардаг учраас, ийм үг сонсох амаргүй байна гэдгийг би номынхоо эхэнд анхааруулсан. Тиймээс л бидэнд “оюун санааныхаа сүнс дотор шинэчлэгд” (Ефес 4:23) хэмээн тушаажээ. Хэрэв радиогийн хөтлөгчийн үзэл бодол өөрөөс нь хальдаггүй бол, хамаа байж уу. Гэтэл тэр сэтгэлгээ чуулганыг залгиж байна. Үүнийг би Билл Клинтоньг ерөнхийлөгч байхад ойлгож билээ.

## **Хоёр буруу зөвийг бүтээхгүй**

Билл Клинтон 1992 онд ерөнхийлөгчөөр сонгогдох үед миний бие гурав хоног гүн дарамтанд орсон юм. Тэгтэл гурав хоногийн дараа Бурхан надтай нүүр тулаад, Түүний мэдлээс гадуур эрх хүчинд гардаг хүн нэг ч үгүй бөгөөд эрх мэдлийн байр сууринд байгаа хүмүүс бүгд Түүгээр тохоон томилогдсон байдгийг маш тодорхой харуулж билээ. Энэ илчлэлээс хойш би хүний хувийн амьдрал дээр бус, харин түүн дээр буй Бурханы эрх мэдэл дээр төвлөрдөг болсон юм. Тэгэх тусам, зүрхэнд минь тэр удирдагчийг хайрлах чин хайр, түүнийг худлаас чөлөөлөгдөж, үнэн дотор алхахыг харах халуун хүсэл ургасаар байв.

Иохан Баптист ч Херодод яг ийм зүрхээр хандсан гэдэгт би



итгэдэг. Иохан хэдийгээр хатуу хэлдэг байсан ч, завхарсан удирдагчаа Бурханы зүрх сэтгэлээр хайрлаж байсан нь тодорхой. Тиймээс л Иеремиа хатуу зэмлэсэн хүмүүсийнхээ төлөө уйлдаг байсан юм. Дутуу хагас зүрхээр, хуульчирхаг хандлагаар ярьдаг хүмүүс байдаг бол, дүрэлзсэн хайраар Эзэний үгээр засч ярьдаг хүмүүс бас бий.

Өөрийгөө зөвтгөж, өрөөлийн “алдааг чичлэдэг”, шүүмжтэй хүмүүст Эзэн үнэн голоосоо дургүй. Чуулганд явдаг олон хүн Билл Клинтонд яг ингэж хандахыг би нүдээр үзсэн. Гэхдээ эхлээд би түүний төлөө нэг ч удаа санал өгөөгүй бөгөөд тэр хүний манай улсад хор хохирол авчирсан авир үйлдлийнх нь төлөө элэг эмтэрч явдгаа хэлмээр байна.

Намайг 1992 онд аялж үйлчилж явахдаа, очсон газар бүрийд итгэгч хүмүүс надад хэт - консерватив нэгэн хүнийг зурагтаар заавал үзээрэй л гэж захиад байв. Тэр хүн манай улсын либерал удирдагч нарын талаар буюу нэн ялангуяа ерөнхийлөгч, түүний гэргийн талаар олон зүйл ярьдаг юмсанж. Би энэ тухай бараг л очсон газар бүрийдээ сонсдог байв. Дэмжигчид нь: “Жон, та тэр хүний яриаг сонсоорой. Тэр хүн Вашингтоныг ёстой ниргэж байна” гэцгээнэ. Тэгээд би ч тэдэнд итгэж, “*Би тэр хүний үгийг нь олж сонсох хэрэгтэй юм байна*” гэж бодох болов. Тийм боловч би бараг зурагт үздэггүй болохоороо есөн сарын дараа л нөгөө хүнийг нь олж сонссон юм.

Калифорнид үйлчилснийхээ дараа би зочид буудлынхаа өрөөнд эргэж ирээд, зурагтаа асаатал нэг хүн ярьж байлаа. Тэрбээр хошин бөгөөд их өвөрмөц зангиатай хүн байв. Нөгөө хүний яриа ерөнхийлөгч Клинтон руу орж байна аа. Тэгэхээр нь л би *Аа, энэ нөгөө хүмүүсийн яриад байсан хүн мөн байна* гэж мэдлээ. Тэгээд тэр алдарт хүнийг олж сонсондоо олзуурхан баярлаж, тухлан суугаад, анхааралтай сонслоо.

Тэгтэл нөгөө хүн хориод минут шахуу ерөнхийлөгчийг баалж, хошигнон тохуурхав. Тэрбээр хурц үгээр, хөгжилтэй хошигнож байсан ч, түүний яриаг сонсох хугацаанд миний огиудас хүрч байлаа. Тэгээд “*Яагаад? Тэр үнэн л ярьж байна. Манай ерөнхийлөгчийн либерал сэтгэлгээг онож л хэлж байна*” гэж бодоод: “Эзэн минь, зүрх минь яагаад тавгүйрхэнэ вэ?” гэж асуулаа.

Гэтэл Ариун Сүнс надад тэр даруй: “Ард түмнийхээ удирдагчийг бүү муул” (Үйлс 23:5) хэмээн хариулав.

Өөр нэгэн эшлэл санаанд орж ирсэн нь оюун санааныхаа сүнс дотор шинэчлэгдэж, “Тиймээс бүх хүний төлөө гуйлт, залбирал, зуучлан залбирал хийгээд талархал өргө гэж юуны өмнө чамайг ятгая. Хаад

болон эрх мэдэлтэй бүхний төлөө залбир. Тэгвэл бид итгэл сүсэгтэй бас хүндлэлтэй, тогтуун, төвшин амьдрах болно. Энэ нь бидний Аврагч Бурханы мэлмийд сайн бөгөөд нийцтэй” (1Тимот 2:1-3) гэдэг үг байлаа. Дээрээс минь яг л овоолсон тоосго дарчих шиг болов. Бурхан биднийг эрх баригч хүмүүсээ хүндэтгэж, тэдний төлөө залбирч, зуучилж, талархахыг тушаасан. Түүнчлэн Бурхан тэдний эсрэг ярихгүй байхыг бидэнд тушаасан. Бурхан биднийг тэднийг баалж, шүүмжилж, тэдэнтэй тэмцэлдэж, тэднээр тоглоом тохуу хийгээрэй гэж хэлээгүй. Зурагтын тоймчийн үг үнэн байсан ч, хоёр буруу зөвийг бүтээхгүй!

Гэхдээ би тэр хүнээс илүүтэй тэр хүний үгийг сонсоод, гуяа алгадан хөөрч байгаа итгэгч хүмүүст гутрав. Тэр тоймч яахав - үүнээс дээрийг хийж мэддэггүй хүн байж болох ч, итгэгч хүмүүс түүний үгийг дэмжиж, уухайлаад байгааг би ёстой ойлгосонгүй. Тэд яаж “хааныг хүндэтгэв?” Бурхан биднийг Христэд итгэдэг хүнийхээ хувьд “залбир, зуучил, таларх” гэсэн. Паул хууль ёсгүй байдлыг элдвээр хэрэгжүүлдэг хүмүүс төдийгүй мөн “тэдгээрийг хэрэгжүүлдэг хүмүүсийг хүлээн зөвшөөрдөг хүмүүс” ч шүүгдэх талаар ярьсан юм шүү (Ром 1:32).

## Бид ямар хуулиар амьдарч байна?

Зочид буудалд болсон тэр явдлын талаар би Америк даяар заадаг болов. Олон хүн ухаарч гэмшсэн бол, зарим нь надад хилэгнэж, тэр тоймч төр засгаас олгосон үг хэлэх эрхээ эдэлж, зөв сайхан амьдралын төлөө л дуу хоолойгоо өргөсөн хэмээн маргав. Үнэн, үнэн. Гэхдээ бид энэ зан авираас хол явах тушаалыг хүлээн авсан хүмүүс юм. Бид ардчилсан дүрмээр амьдарч байна уу эсвэл Бурханы хаанчлалын хуулиар амьдарч байна уу? Манай улсад архийг зөвшөөрдөг учраас - эсвэл бүр зарим мужид марихуан зөвшөөрдөг учраас, итгэгч хүмүүс дураараа ууж идэж, татдаггүй биз дээ?

Бид чинь дээд хуультай улс. Ромын нэгэн үл итгэгч хүн Нэгдүгээр зууны чуулганы талаар ингэж бичжээ: “Тэд хорвоогийн бор хоногуудыг төөрүүлж байгаа ч, тэнгэрийн иргэд ажээ. Тэд хууль дүрмийг дуулгавартай дагах атлаа хуулиас хол өндөр амьдрах юм (*Диогнетуст бичсэн захидал, 5-аар бүлэг*).

Доромжлогчийг сонсох ямар ашигтай? Үүнээс ямар үр жимс гарах вэ? Бид тэр хүний үгийг анхаарч, түгээн дэлгэрүүлэхэд цагаа үрэхийн оронд улсынхаа удирдагч нарын төлөө зуучлан залбирах нь илүү үр нөлөөтэй бус уу? Дуулгавартай зангийн үр дүн нь “бид итгэл сүсэгтэй бас хүндлэлтэй, тогтуун, төвшин амьдрах” хэмээн Бурхан хэлээгүй билүү?

## ХААНЫГ ХҮНДЭТГЭХ

Ерөнхийлөгч Клинтонтой уулзаад: “Тэмгүй нялхсын аллагыг хуульчилж өгдөг хэнбугай нь ч Бурханы шийтгэлийг авч, тамд шатна” гэж хэлсэн үйлчлэгчийг би мэднэ. Тэр үйлчлэгч Херодтой тулсан Иохан Баптист шиг л үйлдсэн юм. Бурханы тэр элч төрөөгүй хүүхдүүдийн төлөө мөн ерөнхийлөгчийн өөрийнх нь ч төлөө зөв хилэн, жинхэнэ хайраар ярьжээ. Элч ерөнхийлөгчийн эрх мэдлийг хүндэтгэнгээ, үнэнийг хэлжээ. Тэр хүн хэзээ ч ерөнхийлөгчөөрөө наадахгүй. Эрх баригчдыг донгоддог зурагтынхныг сонсоод байвал, эцэстээ эрчүүд, эмэгтэйчүүд бид зүрхээ гээгээ. Доромжлол мөнхийн үр жимсийг бүтээхгүй.

### Эрх мэдлийг хүндэтгэдэг зүрх сэтгэл

Эрх мэдлийг хүндэтгэх зүрхний маань сэдэл бидний үйлдэлд нэвчинэ - бид Эзэний тохоон томилгоонд хүндэтгэлтэй хандана. Паул биднийг ийнхүү ятгажээ:

Учир нь сайныг үйлдэхэд захирагч нар нь айдас болдоггүй, харин мууг үйлдэхэд айдас болдог. Та эрх мэдлээс айхгүй байхыг хүсэж байна уу? Сайныг үйлд. Та түүнээс магтаал хүртэх болно. Тэр таны сайн сайхны төлөөх *Бурханы үйлчлэгч* юм. Хэрэв та муу муухайг үйлдвэл айгтун. Илдийг тэр дэмий зүүгээгүй. Тэр бол муу муухайг үйлдэгчдээс Бурханы уур хилэнгийн өшөө авагч, Түүний үйлчлэгч мөн. Тиймээс зөвхөн уур хилэнгийн улмаас бус мөн мөс чанарынхаа учир захирагдах хэрэгтэй. Ийм учраас та нар ч гэсэн татвар төлдөг. Учир нь захирагч нар *Бурханы зарц нар* бөгөөд энэхүү *ажилд өөрсдийгөө зориулдаг* юм. Бүгдэд өгөх ёстойгоо өг. Татвар авах ёстой хүнд татвараа, гаалийн татвар авах ёстой хүнд гаалийн татвараа төл, айж эмээвэл зохих хүнээс айж эмээ, хүндэтгэл хүлээх ёстой хүнийг хүндэл (Ром 13:3-7).

Би нэгэн клубд бэлтгэл хийж байхдаа, төгс бие бялдартай эрэгтэй, эмэгтэй хоёртой танилцсан юм. Тэдэнтэй хэдхэн минут ярилцтал, тэд Колорадо Спрингсийн цагдаагийн ажилтнууд болж таарав. Тэгэхээр нь би шууд л: “Би та нарыг чин сэтгэлээсээ хүндэтгэдэг шүү. Учир нь Библи та нарыг *Бурханы зарц нар* гэсэн байдаг!” хэмээн дуу алдлаа.

Тэгтэл цагдаа эр жигтэйхэн гайхаж, цочирдсон царай гаргаснаа, хөөруу дуугаар: “Пөөх, тийм үү? Библи намайг Бурханы зарц гэдэг гэж үү?” гэлээ.

Би түүнд дээрх эшлэлүүдийг үзүүлэн, асуултыг нь баталгаажуулж өгөв.

Тэгтэл тэрбээр: “Наад эшлэлийг чинь нуруун дээрээ шивүүлнэ ээ!” гэх нь тэр.

Хэдэн долоо хоногийн дараа мөнөөх залуутай бэлтгэл дээр таартал, тэрбээр цамцаа суга татан, нуруун дээрх шивээсээ харуулсан юм. Энэ үг түүнд маш гүнзгий тусчээ.

Энэ үнэнийг хичнээн ч хэллээ гээд туйлширна гэж байхгүй. Бурхан эрх мэдэлд байгаа хүмүүсийг хүндэтгэл ёслолыг хүлээн авах зохистой, Өөрийнхөө “зарц нар” гэсэн билээ. Цагдаа, гал сөнөөгч, захирагч, зөвлөх, дарга, мужийн хууль тогтоогч, шүүгч, зөвлөлийн гишүүн тэргүүтэй төр захиргаанд ажилладаг хүмүүсийг харах бүрийд зүрхэнд минь хүндэтгэл асдаг юм. Хот, муж, төрийн байгууллагуудаар орж гарах бүрийд дотор минь хүндэтгэл төрдөг. Надад сенатор найзууд бий. Гэхдээ би тэдэнтэй уулзахаараа нэр хочоор нь бус, харин: “Сенатор аа!” гэж хэргэм зэргээр нь дууддаг. Би тэр хүмүүсийн Бурханаас зөвшөөрсөн байр суурийг нь хүндэтгэхийг хүсдэг. Тэд бол Бурханы хүмүүст үйлчлэх үүрэгтэй Бурханы зарц нар юм.

Цаашилбал, дээрх эшлэлд эрх баригчид үүргээ биелүүлэхдээ, “Бурханы төлөө ажилладаг” гэсэн байгааг тэмдэглээрэй. Ингэж төсөөлье л дөө. Та хурд хэтрүүлэн давхиж явснаа, машиныхаа толинд цагдаагийн машины гэрэл улалзахыг харбал, диаволыг хөөж залбирах хэрэггүй. Цагдаа диаволын төлөө ажиллаагүй, харин Бурханы төлөө ажилладаг! Тиймээс та өршөөлийн төлөө залбирсан нь дээр!

Би хэд хэдэн удаа хурд хэтрүүлсэн хэргээр торгуулж явсан бөгөөд торгуулийн хуудас гардаж авах болгондоо: “Эрхэм ээ, миний буруу. Та бүхэн үүргээ онцсайн гүйцэтгэж, хотынхоо төлөө зүтгэж байгаад баярлалаа. Намайг уучлаарай” гэж хэлдэг юм. Та тэр цагдаа нарын царайг харсан ч болоосой. Нэг цагдаагийн хандлага бүр орвонгоороо өөрчлөгдөж билээ. Тэрбээр эхэндээ нилээд ширүүлсэн боловч, эрх мэдлийг нь хүндэтгэж байгааг минь үзээд, эцэстээ жигтэйхэн зөөлөрсөн. Би бүр түүнийг торгохоо болих нь уу даа гэж бодсон шүү - гэхдээ би аргалуулах гэж худлаа магтаагүй ээ.

Захирагчаараа даажигнадаг хөтлөгчтэй радио байдаг мужид миний нэг найз пастораар үйлчилдэг юм. Тэрбээр хотынхоо төлөө залбирахдаа, яаж жинхэнэ өөрчлөлт авчрахыг Бурханаас асууж л дээ. Тэр үед чуулган нь цөөхөн хэдэн итгэгчтэй л байж. Гэтэл Бурхан

## ХААНЫГ ХҮНДЭТГЭХ

зүрхэнд нь хотынхоо эрх баригчдыг хүндэтгэх хүндэтгэлийг суулгасан байна. Пастор найз маань удирдагч нартайгаа нийлж байгаад, хотынхоо хамгийн том хэрэгцээг олж мэджээ. Тэр нутгийн гал сөнөөгчдөд түймэр дунд тодорхой хардаг баг хэрэгтэй байсан боловч, энэ зардал тухайн жилийнх нь төсөвт багтаагүй байв. Нэг баг нь л \$25,000 - ын үнэтэй байсан нь мөнөөх жижиг чуулганы хувьд тоймгүй том тоо байжээ.

Пастор алсын хараагаа хүмүүстэйгээ хуваалцаад, нэг удаагийн өргөлөөр хэрэгцээтэй бүх мөнгийг цуглуулж чаджээ. Тэгээд чуулганыхаа удирдагч нартайгаа хотын захиргаан дээрээ очоод, мөнгөн чекээ гардуулсан байна. Тэрбээр надад ингэж ярьсан юм: “Жон, энэ үйлс хотын удирдагч нарт яаж нөлөөлсөн гээч. Тэд чуулганыг ийм өгөөмрөөр үйлдсэнд итгэж ядаж байсан. Тэд хүмүүс төр засгаасаа л шаардаад байхаас бус, төр засагтаа өгөөмрөөр өргөдөггүй байдалд бүр дасчихжээ гэсэн.”

Тэр цагаас хойш найзын маань чуулган огцом өссөн юм. Чуулган шинэ байраа Эзэнд даатгах ёслолд хотын захиргааных нь олон албан тушаалтан оролцсон бөгөөд зарим нь одоо ч явсаар байгаа гэсэн. Энэ пасторын үр жимсийг нөгөө радиогийн хөтөлгчийнхтэй харьцуулаад үзээрэй.

Олон итгэгч их татвар төлж байна гэж гомдоллодог. Татвараа яаж төлөхгүй байх аргыг “нээж олсон” хүмүүс Чуулганд байдгийг би харсан. Тэд үүнийгээ үндсэн хуулийнхаа эрхийг эдэлж байна гэж үздэг. Би тийм хүмүүст: “Гэхдээ үндсэн хуулиас Бурханы ятгалга илүү өндөр шүү дээ. Бурхан таныг татвараа төлөөрэй гэсэн. Тухайлбал таны ашигладаг замын өртгийг хэн төлөх үү? Биднийг хамгаалдаг цагдаа, гал команд, хууль сахиулагчдын мөнгийг хэн төлөх үү?” гэж хэлдэг юм. Итгэгч хүмүүс яаж татвараас бултдаг талаар нягтлангууд надад ярьдаг. Үнэхээр гашуудмаар. Харин би тэдэнд: “Би өөх ч биш, булчирхай ч биш амьдрахгүй. Би татвараас бултахгүй” гэж хэлдэг юм. Татвараа төлөх нь бидэнд үйлчилсэн төр засгийнхаа ачийг хариулах боломж юм. Хүн сайн дураараа өгч байгаа зүйлээ хулгайд алдах боломжгүй! Итгэгч нар бид энэ үнэнийг хэзээ хүндэтгэж эхлэх вэ?

Христийн бие ийм сэтгэлгээгээр явбал, үндэстнүүдэд болоод дэлхийд илүү хүчтэй гэрч болно. Бид хүндэтгэх - эмээн хүндэтгэх, ёслох, дээдлэх, захирагдахад суралцаж, эрх мэдлийн өмнө үүрэг хариуцлагаа хүлээх ёстой. Ингэснээрээ бид тэнгэрийн Аавыгаа хүндэтгэнэ. Бид хааныг хүндэтгэхдээ, Эзэнийг эмээн хүндэтгэж байгаагаа харуулдаг.

## Эрх мэдлийн бүх талбартай адил

Хааныгаа хүндэтгэ гэсэн тушаал нь иргэний эрх мэдэлд хамаатай үг бөгөөд бүх талбарын эрх мэдлийг хамардаг болохыг би өнгөрсөн бүлэгтээ хэлсэн. Хэнийг хүндэтгэх ёстойг дараах эшлэлд ийнхүү заажээ. Гэр бүлийн тал дээр Бурхан “Эцэг эхээ хүндэл” (Ефес 6:2) гэсэн бол, Ефес 5:33 дээр “өөрийгөө хайрладгийн адил эхнэрээ хайрла. Эхнэр нь нөхрөөсөө эмээж бай” гэжээ. Нийгмийн эрх мэдлийн тал дээр “Боолын ёсоор буулган доор байгаа бүгд өөрсдийн эздийг хүндэлбэл зохистой хэмээн үз” (1Тимот 6:1) гэсэн байна. Чуулганы эрх мэдлийн тал дээр бидэнд “Сайн удирдаж байгаа ахлагчид, ялангуяа үг ба сургаалд зүдэн зүтгэж буй нь давхар хүндэтгэл авах зохистой хэмээн үз” (1Тимот 5:17) гэжээ.

Миний бие гуч гаруй жил үйлчлэх хугацаандаа залуучууд аав, ээжийнхээ талаар хүндэтгэлгүй ярьж байхыг олон удаа харсаар ирсэн. Тэд дээдлэх нь бүү хэл, хүндэтгэдэг ч үгүй. Аав, ээж нь зааж өгдөггүй учраас, би засч өгөхөөс өөр аргагүй үе ч гарч байлаа. Тэд үнэндээ өөрийгөө хорлож байгаагаа мэдсэн бол, ийм юм хийхгүй л байх. Бурхан “Эцэг эхээ хүндэлдэггүй хүн нь хараагдсан!” (Дэд хууль 27:16) гэдэг. Бидний өмнөх бүлгүүдэд үзсэн төрөл бүрийн хараал нь аав, ээжийгээ хүндэтгээгүй хүмүүс дээр буудаг юм.

Нөгөөтэйгүүр Бурхан аав ээжийгээ дээдэлдэг хүмүүст ерөөл амласан: “Эцэг эхээ хүндэл.” Энэ бол амлалт бүхий эхний тушаал агаад “Энэ нь чамд сайн бөгөөд чи дэлхий дээр урт наслах болно” (Ефес 6:2-3).

Бурхан үнэндээ аав, ээжээ хүндэтгэдэг хүүхдэд хоёр онцгой ерөөл амлажээ. Нэгдүгээрт - тэрбээр сайн сайхан амьдарна. Аав, ээжээ хүндэтгэдэггүй хүн сайн сайхан амьдарна гэж байхгүй. Тэр хүн хараагдсан (Энэ талаарх гэрчлэлийг би дараа, дараагийн бүлэгтээ бичнэ).

Хоёрдугаар амлалт нь урт удаан амьдрал. Аав, ээжээ хүндэтгэдэг хүнд зориулсан юутай сайхан амлалт вэ! Та “*Байзаарай, гэхдээ аав ээжийгээ хүндэтгэдэг боловч, залуугаараа явчихсан хүмүүс байдаг шүү дээ*” гэж хэлэх байх. Тийм боловч энэ бол амлалт дагуулсан эхний тушаал гэж Бурханы Үг өөрөө хэлснийг л би баттай мэднэ. Бид эргэн тойрныхоо юмсын талаар эргэцүүлэхдээ, Бурханы амлалтыг няцааж эхлэхдээ асуудалд ордог. Бодоод үз: Аав маань хүүхдүүдээ аймшгаас бүрэн хамгаалахаа амлажээ: “Зөвт байдал дотор чи байгуулагдан,

Айхгүй тул дарлал зовлонгоос хол байж, Аюул чамд ойртохгүй учраас Сүйрэл хүчирхийллээс чи хол байна” (Исаиа 54:14). Тэгтэл ийм нандин итгэгч хүмүүс маань айдас дотор амьдарсаар л байдаг. Амлалт нь автомат байсан бол, яагаад тийм олон хүн ийм их зөрчилд амьдардаг юм бэ? Хариулт нь: Бурханы амлалтыг залбирлаар, итгэлийн сайн тэмцлээр олж авдаг юм.

Үүний сайн жишээ нь Абрахамын хүү Исаак болно. Бурхан Исаакийн талаар Абрахамд: “Би түүнтэй гэрээ байгуулж, түүний үр удамтай энэ гэрээгээ мөнхийн гэрээ болгон байгуулна” (Эхлэл 17:19) гэжээ. Бурхан амлалтаа мэдэгдсэн боловч, Исаакийг гэрлэсний дараа гэргий Ребека нь хүүсэр гэдэг нь мэдэгдэв! Тийм ээ! Амлалт нь автомат бус, харин хэрэгжилттэй байх ёстой. Бичээсийг үз: “Эхнэр нь хүүсэр учир Исаак түүний төлөө ЭЗЭНд залбирсанд ЭЗЭН хариулж, эхнэр Ребека нь жирэмсэлжээ” (Эхлэл 25:21).

Исаак амлалтыг биелэл болгохын тулд Эзэн рүү хашхиран тэмцэх хэрэгтэй байжээ. Тэрбээр Бурханы хүслийн дагуу залбираад, хариултаа хүлээн авав. Биднийг “Бид Түүний хүслийн дагуу юу ч гуйсан, Тэр биднийг сонсдог нь Түүний өмнө бидэнд байгаа итгэл зориг юм. Бид юу ч гуйсан, Тэр биднийг сонсоно гэдгийг бид мэдвэл, бид Түүнээс гуйснаа авсан болохоо мэднэ” (1Иохан 5:14-15) хэмээн урамшуулсан байдаг. Бурхан хүслээ гэрээндээ тодорхой айлдсан. Бидэнд Бурханы амлалт байгаа бол, бид Бурханы хүслийн дагуу залбирч болно.

Та аав, ээжийгээ хүндэтгэснээрээ, залбирлаараа Бурханы гэрээний хоёр амлалт дээр зогсон, урт удаан, үр жимстэй, сайн сайхан амьдралыг хүртэнэ. Итгэлээ бусдын амьдрал дээр бус, Бурханы гэрээн дээр тавь.

Та аав, ээжээ хүндэтгэдэггүй учраас айж байна уу? Тэгвэл гэмшил гэдэг шийдэл бий. Бурханаас залбирлаараа уучлал гуй, аав, ээжээсээ биечлэн уучлал гуй. Дараа нь хүндэтгэж амьдар. Тэгээд амьдралд чинь Бурханы гэрээний амлалт бодитоор биелэхийн төлөө залбир.

Энэ зарчим дарга, ажил олгогч, багш зэрэг нийгмийн бүх эрх мэдэлтэн дээр хэрэгжинэ. Тэднийг хүндэтгэх нь бидэнд л сайн бөгөөд бид Эзэнээс шагнал хүлээн авна. Паул дагалдагч нартаа “Та нар юу ч хийсэн, хүмүүсийн төлөө бус, Эзэний төлөө чин зүрхнээсээ хийгтүн. Учир нь та нар Эзэнээс өв залгамжлалын шагналыг хүлээн авахаа мэддэг. Та нар Эзэн Христэд үйлчилж байгаа юм. Бурууг үйлдэгч

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

нь хэн ч бай ялгаагүй, үйлдсэн буруугийнхаа уршгийг хүртэнэ” (Колоссай 3:23-25) гэсэн байна.

Дараагийн бүлгээрээ чуулган Бурханы зарц нарт найрсаар хандан, зохих ёсоор хүндэтгэдэг байх нь ямар холын ач холбогдолтой байдаг, хэрэв бид Бурханы илгээсэн хүмүүсийг танихгүй, хаа хамаагүй хандбал, ямар алдагдал хүлээдэг талаар суръя.



## БҮЛЭГ 10

# ДАВХАР ХҮНДЭТГЭЛ

*Бурхан бидэнд хэрэгтэй зүйлийг маань  
дургүй зүйлтэй маань нэг богцонд хийгээд өгөх нь олонтаа.*

**Б**үгдэд өгөх ёстойгоо өг. Татвар авах ёстой хүнд татвараа, гаалийн татвар авах ёстой хүнд гаалийн татвараа төл, айж эмээвэл зохих хүнээс айж эмээ, хүндэтгэл хүлээх ёстой хүнийг хүндэл (Ром 13:7).

Бурхан эрх мэдэлтнүүдийн эрх ашгийг бус, харин бидний сайн сайхныг бодолцсондоо л бидэнд “эрх мэдэлтнүүдийг хүндэтгээрэй” хэмээн тушаажээ. Энэ тушаалыг гүйцэтгэсний шагнал нь ерөөл юм. Үүний жишээг 1Самуел номоос үзэж болно.

## Ерөөл болж хувирсан доромжлол

Израилийг шүүгч нар захирч байхад Ханна хэмээх нэгэн хүүсэр эмэгтэй байжээ. Тэрбээр Елкана гэдэг эрийн бага эхнэр байв. Ханна нөхрийнхөө зүрхийг дүүргэж, харин нөгөө эхнэр Пенина нь нөхрийнхөө гэрийг дүүргэв. Елканагийнх гэдэг айл жил бүр Бурханыг хүндэтгэхээр Шило руу аялах бөгөөд яг тэр үеэр Пенина Ханнаг гоочилж, нус нулимстай нь хутган, бах таваа хангана. Хөөрхий Ханнаг эр нөхөр нь ч тайтгаруулж дийлсэнгүй.

Нэгэн удаагийн Шилогийн аяллаар энэ байдал хэрээс хэтэрсэнд, Ханна Эзэний өмнө ирээд, хэнхдэг цээжээ зулгаан байж: “Та надад хүүхэд өгөх юм бол, би түүнийг Танд өргөө” (зохиолч өөрийнхөөрөө эшлэв) хэмээн уйлан хайлан андгайлжээ.

Ханнаг залбирч байхад Израилийн тэргүүн тахилч бөгөөд шүүгч Ели түүнийг ажиглаад: “Хэдий болтол чи согтуу байх юм бэ? Дарснаасаа сал” гэжээ (1Самуел 1:13-14).

Аймшигтай доромжлол! Ели эмэгтэй хүний зовлонд тоомжиргүй хандахаар барахгүй, Ханнаг хөлчүүрхсэндээ л бүсгүй хүнд зохимгүй үйлдэл гаргаж байна гэж бодохдоо тултлаа сүнсээр таглаа байжээ. Ханна яншаа дайснаасаа зугтаж, амар амгаланг олохоор Эзэний оршихуйд ирчихээд, улсынхаа тэргүүн сүнсний эрх мэдэлтнээр журам, цадиггүй эмээрээ гоочлуулав. Ханна жил бүр Эзэний өмнө үзүүлэх хүүхэдгүй, гар хоосон ирдэг. Жил бүр түүнийг хүмүүсийн харц, гөлрөө, шивнээ, жиг жуг яриа жанчина.

Таныг том зовлонд унаад байхад пастор чинь яллабал, та яах уу? Магадгүй та: “Энэ хүн жинхэнэ пастор мөн үү? Намайг мацаг барин, Бурхан руу хаширч байгааг мэдэх үү? Ямар сүнсний мэдрэмжгүй амьтан бэ! Би энэ чуулганд дахиж үзэгдэхгүй, гайгүй!” гэж бодох байх.

Ингэж бодсон хүн: “Хүний зовлонг мэдэхгүй хэвтэж бас өөрийгөө Бурханы хүн гэнэ ээ! Миний яаж залбирч байгааг мэдэх үү? Ямар өөдгүй пастор вэ! Ямар сонин чуулган бэ! Би явлаа. Хүмүүст бас Бурханы юмст арай мэдрэмжтэй чуулган олох минь!” гэж хэлэх амархан. Өнөөдөр чуулганд ийм явдал байнга. Хүмүүс пасторынхаа яг улаан нүүрэн дээр ингэдэггүй ч, ар нуруугаар нь ингэдэг.

Тэгвэл маш муухай доромжлуулсан Ханна юу гэж хэлснийг үз: “Үгүй, эзэнтэн минь, би сүнсээрээ цөхөрсөн эмэгтэй байна. Би дарс ч, сархад ч уугаагүй, харин ЭЗЭНий өмнө сэтгэлээ уудалж байна. Шивэгчнээ үл бүтэх эмэгтэй гэж бүү үзэгтүн. Зовлон шаналал, гашуудлаасаа болоод ийм удаан ярилаа гэв” (15-16).

Ханна тахилчийг дээдлэн хүндэтгэсэн сэтгэлээр хариу өчжээ. Хэдийгээр Ели зохисгүй үйлдэл, үг хэлсэн боловч, Ханна Елигийн эрх мэдлийн байр суурийг хүндэтгээд, өөрийгөө өөдгүй муу хүн биш болохыг батлан харуулсан байна.

Үнэндээ тухайн тохиолдолд зохисгүй авир гаргасан хүн нь Ели байсан бөгөөд түүний толгой дээр шүүх хариугүй буухад бэлэн байв. Гэтэл Ханна Елигийн бус, өөрийнхөө авир үйлдэл дээр төвлөрчээ.

## ДАВХАР ХҮНДЭТГЭЛ

Ханна Эзэнийг үнэн голоосоо эмээн хүндэтгэдэг эмэгтэй байв. Удирдагч буруутай аваас, Бурхан Өөртөө түүнтэй тооцоо бодно. Өнөөдөр бидэнд яг ийм даруу чанар, захирагдах хандлага дутаж байна даа.

Тэгтэл Елигийн Ханнад хандах хандлага өөрчлөгдөв: Амар тайван явагун! Израилийн Бурхан чиний гуйсан гуйлтыг биелүүлэх болно гэв. Тэр эмэгтэй —Шивэгчин тань таны нүднээ тааллыг олох болтугай! гэв. Ийнхүү тэр эмэгтэй явж, хоол унд идэн, нүүр царай нь уйтгар гуниггүй болов (17-18).

Ханна Елид үргэлжлүүлэн захирагдсаар л байв. Ханна Елиг Бурханы хүн гэдэг утгаар нь хүндлэн дээдлэхээр барахгүй, ерөөлийн үгд нь талархлаа илэрхийлжээ.

Тэгээд юу болсныг үзнэ үү: “Тэд өглөө эрт босож, ЭЗЭНий өмнө мөргөөд, Рамад байдаг өөрсдийн гэртээ буцаж ирцгээв. Елкана өөрийн эхнэр Ханнатай унтсан ба ЭЗЭН түүнийг санав.

Ханна жирэмсэлсний дараа цаг нь болоход нэгэн хөвгүүн төрүүлэв. —Би энэ хөвгүүнийг ЭЗЭНээс гуйсан юм гээд түүнийг Самуел гэж нэрлэв. (1Самуел 1:19-20)

Бурхан махан толгой, мэдрэмжгүй удирдагчийн амаар амлалтыг амьдруулах үгийг хэлүүлжээ. Үнэндээ Бурхан төдөлгүй: “Тиймээс Би Елигийн гэрийн хилэнц нь өргөлөөр ч, тахилаар ч мөнхөд арчигдан цэвэрлэгдэхгүй гэж Елигийн гэрт андгайлав” (1Самуел 3:14) хэмээн хатуу мэдэгдсэн юм. Өөрийнхөө талаар, гэр бүлийнхээ талаар Бурханаас ийм үг дуулахыг хэн ч, хэзээ ч хүсэхгүй. Бурхан өр зөөлөн, өршөөнгүй боловч, Елигийн талаар болоод гэр бүлийнх нь талаар “Харагтун, Би чиний тэнхээг, чиний эцгийн гэрийн тамирыг тасалж, гэрт чинь өвгөн настан үгүй болох өдөр айсуй.

Израильд сайнаар соёрхдог бүхний дунд [Миний] орших газар гамшиг болохыг чи үзнэ. Чиний гэрт настай хүн үүрд үгүй болно (1Самуел 2:31-32) хэмээн айлдсан тул Ели бурханлаг сүнсний удирдагч байгаагүй нь тодорхой ажээ.

Битүү умай онгойж, харанхуйллаас шинэ амь мэндлэв. Хойтон жил нь Ханна энгэртээ өөдсийн чинээ Самуелийг тэвэрсэн байлаа. Жаалхүү эхийн хэвэлд олдохоосоо ч өмнө Израильд сэргэлт авчрахаар тусгаарлагджээ. Ханна өөрийг нь гүтгэн доромжилсон, мэдрэмжгүй тахилчийг хүндэтгэх хүртлээ олон жил хүсэн залбирсан зүйлээ авч

чадаагүй байна. Энэ түүхийн гол оньс нь Елигийн авир үйлдэлтэй бус, харин эрх мэдэлтнийг мэхийн хүндэтгэж, захирагдсан Ханнагийн үйлдэлтэй холбоотой байжээ.

## **Шүүгч нь хэн бэ?**

Дээрх түүхээс бид маш сайн зарчмыг сурна: Бид Бурханы тохоон томилсон хүнийг хувь хүн гэдэг утгаар нь харалгүй, харин Бурханаас илгээгдсэн хүн гэдэг утгаар нь харбал, тэр хүнийг хүлээн авч чадна. Ханнагийн тохиолдол шиг олон хүн завхарсан удирдагч нараар дамжин “ерөөгдөнө” гэдгийг Есүс тодорхой айлдсан: “Тэр өдөр Надад олноороо “Эзэн минь, Эзэн минь, бид Таны нэрээр эш үзүүлж, Таны нэрээр чөтгөрүүдийг хөөж, Таны нэрээр олон гайхамшгийг үйлдэж байсан бус уу?” гэх болно. Тэгэхэд нь Би тэдэнд “Би та нарыг танихгүй. Ёс бусыг үйлдэгч та нар Надаас зайл” гэж хэлнэ” (Матай 7:22-23).

Бид энэ эшлэлийг уншихдаа, хамаг хараагаа Есүсийн нэрээр гайхамшиг үйлдсэн олонх дээр л тавиад байдаг. Энэ нь тун сэрдхийлгэм, ноцтой зүйл боловч, бүгдээрээ бас нөгөө талыг нь харцгаая: тэдгээр нүгэлтэй ажилчдын үйлчлэлээр хүмүүс жинхэнээсээ ерөөгджээ. Яагаад ерөөгдсөн гэвэл - тэд яг Ханна шиг завхарсан удирдагч нараар дамжин Бурханд хүрэлцэж чаджээ. Есүсийн өгүүлсэн хүмүүс нь Елитэй адил гэр бүлээрээ Бурханаар мөнхөд шийтгүүлэх хүмүүс байв!

Завхарсан бөгөөд бурханлаг гэсэн хоёр янзын удирдлага байдгийг Бичээс маш тодорхой хэлжээ. Би энэ номоо завхарсан удирдагч нарт зориулж бус, харин эрх мэдэл дор байгаа хүмүүст зориулж бичсэн юм. Эрх мэдэл дор байгаа хүмүүс хүзүүн дээрх шүүхийн буулгаа авчихбал, цаашдаа удирдагч нараа шүүсэн, хэнд ч захирагдахыг мэдэхгүй этгээдүүд болно. Бурханы суулгаж өгсөн зүрх хагдарч, оронд нь бардамналдаа өөхлөсөн зүрх чангарна. Тэд өөрсдийгөө Бурханы зөвлөгөө томилгооноос дээгүүр тавина. Наанаа ил гаргаж хэлэхгүй ч, цаанаа бол үндсэндээ Бурханд: “Та зөв шүүж чадахгүй байна. Тэгэхээр би асуудлыг өөрийн гарт авъя!” л гэж хэлж байгаа юм.

Ханна Елигийн амьдрал дээрх эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, хүндэтгэсэн. Ели Ханнаг шүүж, бүр гутаан доромжилсон байтал, Ханна Елиг хүндэтгэсэн. Хэрэв Ханна харсан, сонссоноороо амьдарсан бол, Елигийн эрээгээ алдсан авирыг шүүх л байсан биз.

Гэтэл Ханна хүний ухаанаар амьдраагүй, харин Эзэнээс эхтэй, тэнгэрээс ирсэн эрх мэдлийг эмээн хүндэтгэх ухаанаар амьдарчээ. Ханна үнэн мөнөөр шүүдэг Бурханд итгэжээ.

Ханна Есүсийн батлан хэлсэн зүйлийг мэдэж байжээ: “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Миний илгээх хэнийг боловч хүлээн авч буй нь Намайг хүлээн авдаг. Намайг хүлээн авдаг нь Намайг Илгээгчийг хүлээн авдаг” (Иохан 13:20). Есүс Иудасыг гайхамшиг үйлдэх, чөтгөрийг зайлуулах хүчээр боловсруулан илгээснийг бүү мартаарай. Тийм атлаа Иудасын муу ёрын чанар адагтаа ил болно гэдгийг Есүс мэдэж байсан: “Би та нарыг, арван хоёуланг чинь сонгосон биш үү? Гэтэл та нарын нэг нь диавол байна” (Иохан 6:70). Иудасын нүгэл нүдээр нь гарахаас өмнө ч Есүс түүний хэн болохыг Эзэнээс эмээхүй дотор орших ялгах нүдээрээ таньжээ. Иудас гайхамшиг үйлдэж, Есүсийн нэрээр чөтгөрүүд түүнд захирагдаж байгаад бусдынхаа л адил хөөрцөглөсөн (Марк 6:7-13, Лук 10:17). Хүмүүс Иудасын гараас ач тус хүртсэн үү? Хүртсэн! Гэтэл бас Иудасын тэр л гар үйлчлэлийн сангаас хумсалсан уу? Хумсалсан!

### **ХЭЗЭЭД НЬ ЯВАХ ВЭ?**

Тэгэхээр ийм байна. Чуулганы эрх мэдэл эрээ цээрээ алдаж, нүгэлтэй хутгалдсан нь ил болбол, бид цаашид өмхий ундаргаас уух ёсгүй. Биднийг шууд биеэ татаж авахыг зааварласан байдаг. Удирдагч чинь завхайрсан, ижил хүйсийн харилцаанд орсон, дээрэм, хулгай, худал сургаал зэрэг нүгэл үйлдсэн нь олон нийтэд ил болчихоод байхад, гэмшихгүй гүрийгээд байвал, түүний үйлчлэл дороос гар. Бичээс энэ талаар тодорхой заасан. Биднийг бүр ийм хүмүүстэй хамт хооллож ч болохгүй гэсэн (1Коринт 5:9-11). Елигийн хувьд -хөвгүүд нь завхарсан, зальхай хүмүүс байсныг Ханна мэдэж байсан эсэх нь тодорхойгүй. Иудасаар үйлчлүүлсэн хүмүүс түүнийг урвасан хулгай дайсан байсныг мэдээгүй.

Чуулганы удирдагчийн талаар Паул: “Зарим хүмүүсийн нүгэл шүүлтээс нь өмнө илэрхий болжээ. Харин заримынх нь хожим илрэх болно” (1Тимот 5:24) гэсэн юм шүү.

Гол санаа нь: завхарсан, зальхай удирдагч чинь ямар ч шүүх шийтгэлгүй, сул задгай дургиж явж байгаа бол, Бурханы шүүх нэг бол хожим энэ амьдралд нь бууна, нөгөө бол ирэх амьдралд нь

бууна. Сайн мэдэхгүй зүйлээ шүүх юмуу илчилж болохгүй. Олон хүн хардаж сэрддэг ч, энэ нь худлаа болж таарах нь олонтаа. Тиймээс тэд өөртөө ч, өрөөлд ч ноцтой хохирол учруулдаг. Тэд хий хар сэрээ шууд амаараа асгажээ. Тэгээд үүнийгээ сүнсний ялгах хараа гэж өмөөрнө. Тэдний гайгаар удирдагч нараасаа сайн сайхныг хүртэх гэсэн, гэмгүй хүмүүс хохирч, гарз хүлээх нь олонтаа. Тиймээс Бурхан: “Хоёр, эсвэл гурван гэрч байхгүй л бол ахлагчийн эсрэг буруутгалыг бүү хүлээж ав” (1Тимот 5:19) хэмээн анхааруулжээ. Гэрч гэдэг нь явган яриа ярьдаг бус, харин баттай нотолж чаддаг хүн юм.

Бурхан бүгдийг зохих цагт нь шүүдэг бөгөөд удирдагчийн гэмшээгүй алдааг илчлэх шаардлагатай цаг нь боллоо гэж шийдбэл, та тэр талаар заавал олж мэдэх бөгөөд тэр хүний эрх мэдэл дороос гарах цаг нь иржээ гэсэн үг юм. Паул: “Нүгэл үйлдсээр байгаа хүмүүсийг бүгдийн өмнө зэмлэ. Тэгвэл бусад нь эмээх болно” (1Тимот 5:20) гэж мэдэгдсэн. Анхааруулга: Тэдний нүгэлд бүү оролц. Дээрээс нь тэр хүмүүс жинхэнээсээ гэмшихгүй бол, тэдний эрх мэдэл дороос гар.

Миний нэг удирдагчийн эрээ цээргүй нүгэл эцэстээ ил болсон юм. Тэр үеэр нь би өөр мужид байдаг чуулганд залуусын пастораар үйлчлэхээр хэдийнээ гэр бүлтэйгээ нүүчихсэн байсан болохоор дэргэд нь байсангүй. Биднийг явснаас хэдэн жилийн дараа тэр пастор итгэгчдийн биеийн өмнө зогсоод, цаашид гэргийтэйгээ хамт амьдрах аргагүй болсон учраас, салах гэж байгаагаа мэдэгджээ. Хэсэг хугацааны дараа тэрбээр илүү залуу хүүхэнтэй гэрлэх төлөвлөгөөгөө ч задлав. Түүний гэргий нь ямар нэгэн бэлгийн гаж буруу зүйлд хутгалдаагүй, цэвэр эмэгтэй байсан бөгөөд зүгээр л нөхөр нь өөр хүүхэнтэй гэрлэхийг л хүсчээ.

Үүнээс болж олон мянган хүн цуглаанаасаа явав. Тэд зөв шалтгаанаар л явсан. Сайхь удирдагч, түүний шинэ гэргий хоёр доктрин, сургаалыг өөрсдийнхөө санаа зорилгоор завхруулах болсон тул үлдэж хоцорсон хүмүүс тун халгаатай нөхцөлд оржээ. Явсан хүмүүсийн дунд пасторынхаа эсрэг дуугараагүй хүмүүс нь үнэхээрийн цэцэглэн хөгжиж, харин пасторыгаа дайрч давшилсан нь бүтэлгүйтснийг би мэднэ.

Хэдэн жилийн дараа манай гэр бүл өөр нэгэн алдартай чуулганд явах болов. Манай пастор бас л аймшигтай юм хийж байсан боловч, энэ бүхнийг нь Бурхан хэсэгтээ л хаацайлж байв. Нэгэн зүйлийг онцлон тэмдэглэмээр байна: Эзэн дэндүү гэмээр тэвчээртэй Бурхан.

Эзэн тэр удирдагчийг эрээ цээргүй нүглээсээ эргэнэ хэмээн найджээ. Бурхан тэр удирдагчийг хайрласандаа л гэмших хугацаа олгожээ. Эцэстээ Бурханы тэвчээр алдарч, манай пасторын нүгэл ил гарав. Тэрбээр ижил хүйсийн янхантай уулзаж, хууль бус мансууруулах бодис хэрэглэдэг байжээ. Тэр хүн Евангелийн чуулгануудын үндэсний холбооны удирдагч байсан учраас, энэ нь маш том хүрээг хамарсан, аймшигт мэдээ байв.

Гэтэл энэ эмгэнэл өмнөх тохиолдлоос тэс өөрөөр шийдэгдсэн юм. Тэр даруй чуулганы харгалзагч нар - дөрвөн өөр чуулганы пасторууд тус чуулганд туслахаар хөдөлж, мөнөөх пастораар уучлал гуйж, ажлаасаа халагдах хүсэлт тавьсан захидал бичүүлэв. Хараа хяналт, аюулгүй байдал мэдэрсэн гишүүдийн дийлэнх нь чуулгандаа үлдэв. Шинэ пастор томилогдож, яваандаа тус чуулган өмнөх пасторын дор байснаасаа ч олон хүнтэй болж өсөв.

Би гучин таван жил үйлчлэхдээ ийм эмгэнэл үгүй мөн олныг үзсэн дээ. Дампуурсан удирдагч нарын дор байгаа хүмүүс туйлын бурханлаг ухаанаар хариу үйлдэх хэрэгтэй байдаг. Тухайлбал Давидыг үүний онцсайн жишээнд тооцмоор. Давид чөтгөрийн нөлөөллөөр хагас галзуурсан Саул хаанаас амиа авран зугтахаас өөр аргагүй болсон ч, хааныгаа үхэн үхтэл нь хүндэтгэсээр байжээ. Саул бол Эзэний тохоон томилсон удирдагч гэдгийг Давид ойлгож байж. Миний хувьд - хэдийгээр би дээрх хоёр удирдагчийн явдалд элэг эмтэрч, хийсэн сонголтынх нь үр дагаварт гашууддаг ч, өнөөдөр ч хоёуланг нь хүндэтгэдэг. Гэхдээ хүндэтгэлээ гээд тэдний доктрин, үйлчлэлийг үг дуугүй хүлээн зөвшөөрдөг гэсэн үг биш. Учир нь эхний хүн нь сэргээгдээгүй бол, хоёр дахь хүн нь сэргээгдэх явц дундаа хаяад явчихсан юм.

Цагтаа би тэр хоёр хүний хэн, хэнээр нь ерөөгдөж явсан. Гэтэл тэд тэр үеэс л ийнхүү бурханлаг бус авирлаж эхэлснийг хожим мэдсэн юм. Хэн, хэнийх нь үйлдэл эргэлзээтэй байсан ч, ил болоогүй ажээ. Би ч эхнийхээ пасторыг шүүмжилснээсээ болоод Бурханд зэмлүүлж л байлаа (Энэ тухай дараагийн бүлэгтээ ярина). Магадгүй Бурхан түүнийг ухааралд хүргэх гэж оролдож байсан байх. Ухааруулах нь миний ажил биш. Бурхан намайг тэр хүний дор тавьсан бөгөөд надад тэр хүнийг шүүх эрх мэдэл байсангүй. Тухайн үед олон хүн тэр пастораар яг л Елигээр дамжин ерөөгдсөн Ханна шиг ерөөгдсөн юм.

## Сүнсний эрх мэдлийн тогтолцоо

Бүгдээрээ дахин Есүсийн үгийг гаргаад, Ели шиг удирдагчаар бус, харин бурханлаг удирдагчаар нэвтрүүлэн харъя. Матай номд хэлсэн Есүсийн үгийг үзнэ үү:

Та нарыг хүлээн авах нь Намайг хүлээн авсан хэрэг юм. Намайг хүлээн авах нь Намайг Илгээгчийг хүлээн авсан хэрэг юм. Эш үзүүлэгчийн нэрээр эш үзүүлэгчийг хүлээн авах хэн боловч эш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна. Зөвт хүнийг зөвт хүний нэрээр хүлээн авах хэн боловч зөвт хүний шагналыг хүлээн авна. Үнэнээр Би та нарт хэлье. Ийм өчүүхнүүдийн нэгэнд, шавийнх нь хувьд уух аяга хүйтэн ус өгсөн хэн ч шагналаа эс алдана гэв (Матай 10:40-42).

Есүс дээрх эшлэлд хоёр санааг хэлжээ. Нэн тэргүүнд Ааваас эхтэй эрх мэдлийн урсгал гэж бий. Аав л Есүсийг илгээж, Түүнд бүх эрх мэдлийг олгосон. Есүс Өөрөө “Тэнгэр газар дээрх бүх эрх мэдлийг Надад өгсөн” (Матай 28:18) гэсэн. Есүс чуулганы тэргүүн бөгөөд цаг нь болохоор Тэрбээр бүх эсэргүүг улан дороо оруулсныхаа дараа хаанчлалаа Аавдаа эргүүлж өгнө (1Коринт 15:24-26).

Эрх мэдлийн дараачийн хүн нь эш үзүүлэгч юм. Эш үзүүлэгчийг Бичээс анх Эзэний “хэвлэлийн төлөөлөгч” гэсэн (Гэтлэл 4:16, 7:1). Энэ нь Есүс үхлээс амилуулагдсаныхаа дараа чуулгандаа бэлэглэсэн таван талт үйлчлэлийн нэг юм (Ефес 4:8-13). (Тэд бол Чуулганы хэвлэлийн төлөөлөгч юм). Бид үйлчлэлийн бэлэгийг хүлээн авахдаа, Эзэний тохоон томилсон албан тушаалтнаараа дамжуулан өгч байгаа зүйлийг нь хүлээн авдаг.

Дараа нь Эзэн зөвт хүмүүсийг дурьдахдаа, нялхсыг ч орхиогүй байна. Нялх итгэгчдийн төлөө өчүүхэн ч болов сайн зүйл хийсэн үл итгэгч хүмүүс ч ерөөгдөж байхыг би үзсэн. Үл итгэгч хүмүүс Эзэнд үйлчилдэггүй боловч, Эзэнд маань хүндэтгэл үзүүлжээ. Бид ариун хүмүүсийг хүлээн авч, ерөөхдөө угтаа Аавыг хүлээн авч, Аавыг ерөөдөг. Дагалдагч нар - үүнд нялх итгэгч нар ч багтана - Бурхан Аавын хүслийн илэрхийлэл болсон Есүсийн удирдлага дор чуулганы таван талт эрх мэдэлд захирагддаг. Тиймээс аврагдаагүй хүмүүс нь Христ доторх нялхсын ерөөл дор оршдог юм.

Учир нь хаанчлалын хамгийн дорой нь ч аврагдаагүй хүмүүсээс хавьгүй өндөр сүнсний эрх мэдлийг эрхшээдэг юм. Бид Есүсийн үгээс тогтоогдсон эрх мэдлийн тогтолцоог харж байна.



## Сүнсний эрх мэдлийг хүлээн авахын шагнал

Эдгээр эшлэл нь хоёрдугаарт - Бурханы үйлчлэгч нарыг хүлээн авч, зохих ёсоор хандбал, хожим зохистой шагналаа хүлээн авахыг хэлжээ. Үүнийг Есүсийн үйлчлэл онцсайн дүрсэлдэг.

Нэгэн хотынхон тухайн үе нь Мессаиагийн ирж үйлчлэх цаг мөн болохыг Бичээсээс мэдэхийн дээдээд мэдэж байсан ч, Есүсийн үйлчлэлээр олигтой ерөөгдөж чадаагүй. Гэтэл Есүс тэдэнд “Эш үзүүлэгч нь төрөлх нутаг, төрөл садангийнхаа дунд болон гэрийнхнээсээ өөр газар хүндлэгдэхгүй байх нь үгүй” хэмээн айлдсан байдаг (Марк 6:4-5-ыг үзнэ үү).

Бид хүний байр суурь, албан тушаалыг хүндэтгэхдээ, түүний Бурханаас эхтэй томилгоог хүлээн зөвшөөрдөг. Бурхан Мосегоор дамжуулан хүмүүстээ айлдсан: “Би ах дүү нарынх нь дундаас чам шиг нэгэн эш үзүүлэгчийг гаргаж, Өөрийнхөө үгийг түүний аманд өгнө. Миний түүнд тушаах бүхнийг тэр тэдэнд хэлнэ” (Дэд хууль 18:18). Гэтэл тэд Есүсийг Бурхан Ааваас ирсэн Төлөөлөгч юмуу Аврагч гэдэг утгаар нь хүлээн авч, хүндэтгээгүй юм.

Тэд яагаад Түүнийг хүндэтгээгүй вэ? Учир нь Есүс тэдний хүссэн арга замаар ирээгүй. Тэд Есүсийг бодит байдлаас нь тэс өөрөөр хүссэн. Тэд Исаиагаас ингэж уншсан байв:

Учир нь бидний төлөө Хөвгүүн төрж,  
Бидэнд Хүү өгөгдсөн аж.  
Засаглал Түүний мөрөн дээр байж,  
Түүний нэрийг Гайхамшигт Зөвлөгч,  
Хүчит Бурхан, Мөнхийн Эцэг, Энхийн Жонон гэж дуудна. Давидын сэнтий дээр Түүний хаанчлал дээгүүр засаглал хийгээд амар тайван нь тэлэхүйд эцэс үгүй. Шударга ёс, үнэн зөвөөр үүнийг өдгөөгөөс өнө мөнхөд тогтоон тулна. Түг түмдийн ЭЗЭНий зүтгэл үүнийг гүйцэлдүүлэх болно. (9:6-7)

Тиймээс тэд улс орныг нь Ромын дарлалаас чөлөөлж, Иерусалимд хаанчлалаа байгуулах дайчин баатар хаанаа хүлээж байжээ. Гэтэл Аврагч нь мужааны хүү болж ирээд, загасчидтай, экс янхнуудтай, татвар хураагч нартай нөхөрлөсөн. Тиймээс хүмүүс өөр хоорондоо: “Бид ийм Мессаиаг хүсээгүй!” гэлцжээ.

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Түүнээс гадна Есүс тэдний дунд бараг гайхамшиг үйлдэж чадаагүйг Бичээс хэлжээ. Есүс хүсээгүй учраас хийгээгүй юм биш, саадтай байсан болохоор “хийж чадаагүй” ажээ. Бодоод үз дээ. Бурханы Сүнсээр цалгисан Бурханы Хүүгийн үйлс хязгаарлагджээ. Яагаад тэр вэ! Хоёр шалтгаанаар: Нэгдүгээрт - Аврагч нь тэдний хүсэн хүлээж байснаар ирээгүй. Хоёрдугаарт - тэд Есүсийг дэндүү сайн мэддэг байсан болохоороо хүлээн авч, хүндэтгээгүй. Юу хэлснийг нь л сонс:

Амралтын өдөр Есүс синагогт сургаал зааж эхлэхэд, сонссон олон гайхаж —Хаанаас энэ хүн эдгээрийг авав? Түүнд ямар мэргэн ухаан заяасан юм бэ? Гараас нь ямар хүчит гайхамшгууд гарна вэ? Энэ чинь Мариагийн хүү, мужаан биш бил үү? Иаков, Иосеф, Иуда, Симон нарын ах биш үү? Охин дүү нар нь бидний хамт байгаа биз дээ? гэж Түүнд бүдрэн унтууцав. Есүс тэдэнд —Эш үзүүлэгч нь төрөлх нутаг, төрөл садангийнхаа дунд болон гэрийнхнээсээ өөр газар хүндлэгдэхгүй байх нь үгүй гэж айлдав. (Марк 6:2-4)

Эш үзүүлэгч хаана үл хүндлэгддэг билээ? Голдуу гэртээ буюу өөрийнхэн дундаа. Давид гэртээ ирээд, гэр бүлээ ерөөхдөө яг ийм байдалд ордог. Түүний ялалтыг гудамжинд тэмдэглэсэн бол, гэр бүлийн хүн нь үл тоожээ. Үүнээсээ болоод гэргий Михал нь Бурханы ерөөлийг алдсан юм. Давидад гэр бүлээ ерөөх хүч байсан. Тэгвэл Есүст Өөрийнхнөө ерөөх хичнээн хүч байв! Есүс ерөөх хязгааргүй хүчтэй байсан ч, хүмүүсийнхээ төлөө өчүүхэн багыг л хийж чаджээ (2Самуел 6).

Гагцхүү Бурханы араас явдаг, өлсөж цангасан, сурахын хүслэн болсон, даруу зүрхтэнүүд л Есүс дээр орших Бурханы мутрыг харж, Түүнээс хүлээн авчээ. Есүс бол хүмүүсээ хэн нь үнэхээр Бурханы араас явдаг, хэн нь бурханлаг дүртэй атлаа бурханлаг бус зүрхтэй, сохор хүмүүс болохыг ангилан тусгаарлагч Илд байжээ. Симеон Есүсийн ижий Мариад: “Харагтун, энэ Хүүхэд Израильд олныг унагах, босгох бөгөөд эсэргүүцүүлэх тэмдэг болон томилогджээ. Сэтгэл чинь хүртэл илдэнд нэвт сүлбэгдэх болно. Эцэст нь олон түмний зүрхний бодлууд илчлэгдэнэ” (Лук 2:34-35) гэсэн байдаг.

Иохан 1:11-12 дээр энэ хоёр ялгаатай бүлгийг нарийн харуулсан байна: “Тэр өөрийнхөндөө ирсэн боловч өөрийнхөн нь Түүнийг эс хүлээн авчээ. Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх

нь нэрэнд итгэгчдэд Тэрээр Бурханы хүүхэд болох эрхийг өглөө.” Энд бидэнд хандсан суурь үнэн агуулагдаж байна. *Олонтаа Бурхан бидэнд хэрэгтэй зүйлийг дургүй зүйлтэй маань хамт багцлаад өгдөг.* Яг энэ үг бидний зүрхний үнэн төрхийг илчилж, Бурханы эрх мэдэлд захирагдаж байна уу, эсэргүүцэж байна уу гэдгийг маань илчилдэг. Есүс “Та нар Намайг ч, Эцэгийг минь ч танихгүй. Хэрэв та нар Намайг таньсан бол, Эцэгийг минь ч мөн таних байсан” (Иохан 8:19) гэсэн. Бурхан Аавыг мэддэг хүн Бурхан Аавын илгээсэн хүмүүсийн эрх мэдлийг танин, хүлээн зөвшөөрдөг! Энэ эрх мэдлийг түүнд тайлбарлаж, зааж, батлаад байх шаардлагагүй.

Ийм учраас л үйлчлэгч хүнийг Африкт очиж үйлчлэхэд сохор нь нүд орж, хөлгүй нь явж, дүлий нь сонсдог атлаа Америкт үйлчлэхэд нь ганц, хоёр толгойн өвчин, нуруу нугасны яльгүй асуудал л эдгэрдэг. Ийм жишээ олон бий. Африкт Бурханы эрэгтэй, эмэгтэй зарцыг зүс царайнаас нь үл хамааран, Бурханы зарц гэдэг утгаар нь хүлээн авдаг. Африкчууд Бурханы хүмүүсийг ингэж хүлээж авдаг учраас Бурханы хүч, оршихуйгаар ерөөгддөг. Америкт бол аятайхан савлагаатай л биш бол, авч хэлэлцэхгүй. Тэгвэл та Бурханы элчийг Бурханы илгээсэн хүн гэдэг утгаар нь хүлээн авч, хүндэтгэж байгаа хэм хэмжээгээрээ л тэр хүнээр дамжуулан Бурханаар ерөөгдөнө. Хүндэтгэхгүй байх нь таны л үзэл бодол. Харин хүндэтгэлийг өргөбөл - эргээд та хүндэтгэлийг хүртэнэ.

## **Та миний найз болох уу?**

Би шинэхэн пастор байхдаа, “Тим” гэдэг арван таван настай залуутай танилцаж билээ. Намайг үйлчлэлд орохоос өмнө Тим миний өмнөх пасторын удирддаг байсан бүлэгт явдаг байжээ. Тэр пастор бүлгээ гол төлөв зугаалга, спорт, хөгжөөнт үйл ажиллагаагаар дамжуулан босгосон байна. Залуусын дунд дуулгаваргүй дураараа байдал, өсвөр насны жирэмслэл тэргүүтэй ёс суртахууны асуудал их байв. Эцэстээ тэргүүн пастор нь хуучин пастораа чөлөөлөөд, оронд нь намайг авчээ. Гэтэл хуучин пастор нь үнэнч хэдэн залуустайгаа нийлэн хэдэн гудамжны цаана өөрийн гэсэн цуглаанаа эхлүүлсэн байна. Түүнийг дагаж яваагүй залуусын нэг нь Тим байлаа.

Хэдийгээр залуусын дийлэнх хувь нь үлдсэн ч, би суурийг нь шинээр тавих ёстой болсон юм. Эзэн надад эхний зургаан сар номлож, залбирч, хүндэтгэхээс өөр юм хийхгүй байх заавар өгсөн

учраас, би тэр хэдэн сар ямар ч үйл ажиллагаа зохион байгуулсангүй. Би олон хүний хувьд ёстой санаж бодоогүй илгээмж байжээ. Үүний үр дүнд Эзэний илд исгэв. Нэг хэсэг нь явж, нөгөө хэсэг нь сониуч зандаа хөтлөгдөн үлдэж, үлдсэн нь баяртайгаар дагасан бөгөөд тэдэн дундаас өнөөдөр Эзэнд үйлчилж яваа хүн олон бий.

Би тэр байр сууринд дөрвөн сар орчим байхдаа нэгэн орой цуглааны дараа Тимтэй ярилцсан юм. Тим надаас: “Пастор аа, та миний найз болох уу? Өмнөх пастор маань миний найз байсан” хэмээн чин сэтгэлээсээ асууж билээ. Би түүний хүсэн хүлээж байсан илгээмж байгаагүй ажээ.

Түүний асуултыг аргалаад өнгөрч болохгүй учраас, би юу гэж хариулах ёстойгоо мэдэхээр дотогшоо өнгийлөө. Гэтэл хариулт нь тэр дороо асуулт маягаар орж ирэв: “Тим, Есүс “Эш үзүүлэгчийн нэрээр эш үзүүлэгчийг хүлээн авах хэн боловч эш үзүүлэгчийн шагналыг хүлээн авна. Зөвт хүнийг зөвт хүний нэрээр хүлээн авах хэн боловч зөвт хүний шагналыг хүлээн авна” (Матай 10:41) гэсэн. Энэ нь залуусын пасторт ч хамаатай үг. Хэрэв чи пасторыг пастораар нь хүлээн авбал, пасторын шагналыг хүлээн авна.”

Тэгээд цааш нь асуулаа: “Тим, чи олон найзтай, тийм үү?”

Тэрбээр: “Тийм ээ, эрхэм ээ” гэлээ.

-“ Гэхдээ чамд ганц л пастор байдаг, тийм үү?”

Тэрбээр: “Тийм ээ, эрхэм ээ” гэлээ.

Би түүнээс: “Тэгвэл чи найзын бэлэгийг хүсч байна уу эсвэл залуусын пасторын шагналыг хүсч байна уу? Яагаад гэвэл чи намайг хүлээж авч байгаагаараа Бурханаас хүлээж авна” гэж асуулаа.

Түүний дотор гэрэл асчих шиг л болов. Нүднээс нь илчлэл цагарч, тэрбээр тэр дороо: “Би залуусын пасторын шагналыг хүсч байна” гэж хариулсан юм. Тэр цагаас эхлэн Тим цэцэглэв. Хэдэн жилийн дараа тэднийх нүүчихсэн боловч, Тим манай хотод ирэх бүрийдээ надтай уулздаг байв.

## **Миний өөрийн туршлага**

Би энэ талаар “Honor’s reward” (Хүндэтгэлийн шагнал) гэдэг бүхэл бүтэн ном бичсэн. Хүмүүс Бурханы зарцыг хүлээн авч, хүндэтгэл үзүүлэхгүйгээсээ болоод Бурханаас хүлээн авч чадахгүй байгааг харах элэг эмтэрмээр. Бурханы зарц нарыг үл тоодог хүмүүст хүрэх хамгийн хэцүү байдгийг би үйлчлэлээс үй олон удаа харсан. Тийм

хүмүүс Америкийн чуулган, Христэч сургуульд олон бий. Тэд тасралтгүй уван цувах үйлчлэгч хүмүүсийн дуусашгүй цуваанаас залхсан байдаг бөгөөд тэдний хувьд би тэр цувааны нэг л ажээ.

Магадгүй эрх мэдлийг ойлгодог цэргийн хүмүүст л номлох хамгийн амархан байх. Дараа нь шоронгийн хоригдлууд юмуу хөгжиж байгаа орнуудын хүмүүс. Учир нь тэд өлсөж, цөхөрсөн хүмүүс юм. Бурхан Езекиелд яг ингэж хэлжээ:

Чи, ойлгомжгүй яриатай эсвэл хэцүү хэлтэй ард түмэн уруу илгээгдээгүй. Харин Израилийн гэр уруу илгээгдэж байна.

Чи үгийг нь ойлгож чадахгүй, ойлгомжгүй яриатай эсвэл хэцүү хэлтэй олон ард түмэн уруу илгээгдэж буй бус, харин чамайг сонсох ёстой хүмүүс уруу Би чамайг илгээсэн. Гэсэн ч Израилийн гэр Намайг сонсох хүсэлгүй байдгаас хойш чамайг ч сонсох хүсэлгүй байх болно. Үнэхээр Израилийн хамаг гэр зөрүүд, гөжүүд юм. (Езекиел 3:5-7)

Израиль Езекиелийг зүгээр л ээлжит нэгэн эш үзүүлэгчээ л гэж үзсэн бөгөөд Езекиел тухайн үеийн эш үзүүлэгч нар шиг бурам шиг үгийг бус, хатуу үг хэлсэн учраас, хүмүүс түүнийг хүлээж аваагүй.

Бурхан нэг өдөр намайг: *“Би чамайг хүмүүс хүлээж авахгүй газрууд руу илгээх болно”* хэмээн сандаргаж билээ.

Би: “Байзаарай. Та намайг өмнө илгээж байсан газрууд руугаа дахин илгээх болж байна уу? Яагаад? Тэд чинь миний үгийг сонсохгүй гэдгийг Та мэдэж байгаа шүү дээ.”

Гэтэл Эзэн надад: “Хожим тэднээр “Бурхан бидэнд хоёр дахь боломж олгоогүй!” гэж хэлүүлэхгүйн тулд” гэж хариулж билээ.

Би тэр газруудад нь дахиж очсон бөгөөд тэнд байхад: “Энэ хүмүүс надад ийм дургүй байж, яах гэж урьсан юм бол?” гэж бодогдож билээ. Гэтэл зарим газар намайг онгоцны буудлаас угтаж аваад, гаргаж өгөх хүртлээ цуглааны өмнө ч, дараа ч тун элгэмсэг, эелдэг, хүндэтгэлтэй ханддаг. Гоёмсог бүтээлэгтэй, жимс, амтантай сагстай барьсаар зочид буудлын өрөөнд угтаж, юм л бол: “Гэртээ байгаа юм шиг байгаарай, хэрэгтэй зүйл байвал, хэлээрэй!” гэдэг сэн. Би ч хариуд нь зурагдсан пянз шиг л: “Өө зүгээр, зүгээр, зүгээр!” гэж давтана. Эргээд харахад, амьдрал, чуулган өөрчлөгдсөн хамгийн аугаа гэрчлэл ийм л газраас дуулдсан байдаг. Намайг танилцуулах үед хүмүүс баярлаж, алга ташиж байгаад эхэндээ би эвгүйцдэг байлаа. “Ингэх шаардлагагүй. Би чинь та нартай л адилхан хүн” гэж бодогддог

байсан ч, төдөлгүй энэ хүндэтгэлийн нарийн учир нь би биш болохыг ухаарч ойлгосон юм.

Бурхан надад *“Хүмүүсийн хүндэтгэл нь чиний тусын тулд бус, тэдний өөрсдийнх нь тусын тулд учраас, зүгээр л хүндэтгүүл”* гэдгийг алхам алхмаар ойлгуулж билээ. Тэд намайг биш, харин миний амьдрал дээрх Бурханы бэлэгийг хүндэтгэж байгааг ойлгосныхоо дараа би эвгүйцэхээ больсон. Хүмүүсийн эерэг хандлагаар нь дамжин зүрх сэтгэл нь надаар дамжин ирэх Есүсийн ерөөлд нээгддэг ажээ. Миний дотор бардамналын оронд гүн даруусал, хамаарал бий болов. Энэ нь миний чадвар бус, Бурханы сонголт гэдгийг би мэдэж байлаа. Бид хүмүүсийн хүндэтгэлийг Бурхан руу чиглүүлэхдээ, Бурханаас хамаарах хамаарлаа шууд хүлээн зөвшөөрнө. Хүндэтгэж чаддаг хүмүүс хүлээж авахдаа амархан байдаг бол, хүндэтгэхийг мэддэггүй хүмүүс хүлээж авч чаддаггүй.

### Давхар хүндэтгэл

Паул Тимотод “Сайн удирдаж байгаа ахлагчид, ялангуяа үг ба сургаалд зүдэн зүтгэж буй нь давхар хүндэтгэл авах зохистой хэмээн үз” (1Тимот 5:17) гэж заажээ. Паул “давхар хүндэтгэл” гэхдээ, нийгэмд эрх мэдэл эзэлж байгаа хүмүүсийг хүндэтгэдгээсээ хоёр дахин хүндэтгэлийг өргөх талаар хэлжээ.

Энэ эшлэлийг агуулгаар нь харах юм бол, үнэндээ үйлчлэгч нарыг санхүүгээр хүндэтгэх тухай ярьж байгаа юм. Цааш нь уншбал, Паул: “Учир нь Бичвэр “Тариа цайруулж байгаа үхэрт хошуувч бүү хий”, “Ажилчин хөлсөө авах нь зохистой” гэж хэлдэг” гэжээ (18-аар ишлэл). Амплифайд Библи дээр үүнийг маш тодорхой хэлсэн: “Албан үүргээ онц гүйцэтгэж буй - тэр дундаа номлох бөгөөд заах үйлсэд итгэмжтэй хөдөлмөрлөж буй ахлахуудыг давхар хүндэтгэлд (бөгөөд зохих ёсны санхүүгийн дэмжлэгэд) зохистой хэмээн үзэг. Учир нь Бичээс... Ажилчин нь хөлсөө авах зохистой гэдэг (1Тимот 5:17-18). Тэгвэл ЭнЭлТи дээр “Ажлаа хийж байгаа ахлахууд хүндэтгэл, хөлсөө сайн авах хэрэгтэй” гэдэг.

Энэ зарчим хэзээ ч цуцлагдахгүй. Чуулган өөрт нь үйлчилж буй пастор, удирдагч нараа халамжилбал, гэр бүлүүд, бизнесийнхэн болоод гишүүд нь ерөөгдөж, хөгжин цэцэглэнэ. Тэд тэнгэрийн эдийн засгийн өгөөжийг эдэлнэ. Харин харамлаад байвал, өөрсдөө ч хулгай,

гачигдлаас салахгүй байх юмуу өнөөгийн эдийн засгийн таагүй нөхцөлд нэрвэгдэнэ.

Энэ үнэнийг нэн ялангуяа Барууны үйлчлэгч нар их хөсөрдүүлдэг. Үйлчлэгч нар байнга мөнгө, эдийн талаар ярих нь даанч гашуудмаар. Тэд үнэнийг тээдэг хүмүүс атлаа үйлчлэлийнхээ зүрхний цохилтыг гээж, хөлсний ажилчдын зам руу алдуурчээ. Фарисайчууд тэгж л амьдарсан. Тэдний худлаа амьдралыг харсан хүмүүс Бичээст өгүүлдэг хүндэтгэлийн зарчмаас олноороо татгалзжээ. Энэ байдлаасаа болоод Фарисайчуудын халамжин дор эрүүл саруул байдлаар үнэнийг сурах ёстой байсан тэр хүмүүс эргээд асар их хор хохирол үзсэн байна.

Би энэ эмгэнэлийг аяллынхаа эхний жилд буюу 1990-ээд онд харсан юм. Би зуу гаруй хүнтэй жижиг чуулганд заав. Цуглаан сайн болж, хүмүүс ч хангалуун байв. Бид тэр чуулганы пастор, түүний гэргий хоёртой уулзаад, тэдний гэр бүлийн санхүү тун хүнд байгааг ойлгосон юм. Гэргий нь онгоцны үйлчлэгч учраас, чуулгандаа хүссэн шигээ үйлчилж чадахгүй байжээ. Тэрбээр чуулганаас цалин авна гэдэг даварсан хэрэг болно гэж бодсондоо, онгоцны үйлчлэгчийнхээ ажлаас гарч чадахгүй байсан юмсанж. Би тэр хоёрыг ямар чуулганаас угшилттай болохыг нь сайн мэддэг байв. Тэр пастор, бид хоёр хуучин нэг цуглаанд явдаг байлаа. Манай пастор санхүү, өргөлийн тал дээр хэт туйлширсан сургаал заадаг байсан учраас, энэ тал дээр бид хоёрын хэн хэн нь болгоомжилж, тийм зүйл хийхээс сэрэмжилсэндээ, өөрөө ч мэдэлгүй нөгөө туйл руу хадуурчихсан байв. Гэтэл аль ч төрлийн туйлшрал сайн биш болохыг Бурхан бидэнд зааж өгсөн юм. Бурхан жинхэнэ тэнцвэрийг хүсдэг.

Конференц маань Бүтэн сайны өмнө эхлээд, гурав дахь өдрийн шөнө хүртэл үргэлжлэв. Эхний гурван цуглаан сайн байсан ч, тэр чуулганд ямар нэгэн тушаа байгаа нь мэдрэгдэв. Хоёр дахь өдөр нь Эзэн өдөржин зүрхэнд минь мөнөөх пасторын санхүүгийн байдлыг санагалзуулав. Энэ бодлоос салж чадахгүй байсан ч, нөгөөтэйгүүр бас юу хийж чадахаа мэдэхгүй байлаа.

Цуглааны өмнө пастор тэр оройны өргөлөөр манай үйлчлэлийг ерөөмөөр байгаа учраас, өргөлийн цагийг удирдахыг надаас хүсэв. Тэрбээр цуглааны үйл ажиллагааг надад шилжүүлэхдээ: “Би чамд өргөлийн эрх чөлөөг олгож байна” гэх шиг л болж билээ.

Би ч баяртай байлаа. Бурхан надаар Өөрийнхөө хүслийг гүйцэтгүүлэхийн тулд энэ үүдийг нээж өгсөн гэдэгт би итгэдэг юм. Тэгээд төлөвлөсөн зүйлээ л номлолоо. Би 1Тимот дээрх бичээсийг

уншаад, тэр пасторын гэр бүлд санхүүгийн зохистой халамж дутагдаж байгааг хүмүүст хэлэв. Пасторын гэргий нь гэр бүлээ тэжээхийн тулд 3-4 хоноод л холын замд гарч байгаа нь арай л биш байгааг тодорхой хэлэв. Пастор надад өргөл авах эрх чөлөө олгосон ч, би үүнийг нь өөрийнхөө үйлчлэлд зориулан хүлээж авахгүй, оронд нь тэр пасторын гэр бүлд зориулмаар байгаагаа хэллээ. Хүмүүс нь ч пасторыгаа ерөөх энэ завшаанд баярлав. Тэр оройн өргөл жирийн өргөлөөс гурав дахин их байв! Пасторын гэргий нь уйлж, пастор өөрөө зог тусав.

Тэгээд дараагийн хорин дөрвөн цагийн дотор ямар, ямар гайхамшиг болсныг дэлгэрэнгүй бичвэл, та итгэж ядах байх. Нэгэн хос маргааш нь арван мянган долларын чек хүлээн авсан бол, өөр нэгэн хос мянга таван зуун доллартай дугтуй үүднээсээ олжээ. Энэ бүхэн зөвхөн эхлэл нь шүү. Дараагийн Бүтэн сайн нь гэхэд, бөөн бөөн гайхамшигтай гэрчлэлээд дүүрээд байсан тул пасторт нь номлох ч цаг олдоогүй юмсанж. Бурхан тэр долоо хоногт бизнест нь болоод хувийнх нь амьдралд ямар, ямар гайхамшигтай санхүүгийн ерөөл авчирсныг хүмүүс ам уралдан гэрчилжээ. Энэ төлөвлөөгүй цуглааны бичлэгийг пастор дараа нь надад илгээж билээ.

Дараагийн хоёр жил нь тэр чуулган тэсрэнгүй өсөв. Тэд шинэ байр буюу бүхэл бүтэн сургуулийн кампус худалдаж аван, сэргээн засаад, хязгааргүй өсчээ. Гэтэл тэд олон жил зуун хүнээс хэтрээгүй явсан юм. Энэ тэргүүтэй олон жишээгээрээ Бурхан бидэнд бидний төлөө хөдөлмөрлөж байгаа хүмүүсийг хүндэтгэхийг хүсдгээ зааж өгсөн билээ.

Миний бие гуч гаруй жил аялахдаа, Библийн энэ үнэнийг хэзээ ч үл хэрэгсэж явсангүй. Пасторгаа хариугүй цалин өгдөг олон чуулганд би зочилж байлаа. Тэд *“Пастортаа их мөнгө зарахгүй байвал, илгээлтийн төлөө ихийг хийж чадна”* гэж үзнэ. Ийм чуулган жил бүр илгээлтэд хэдэн зуу, мянган доллар өгдөг.

Түүнчлэн би пасторгаа дөмөг цалин өгчихдөг чуулганд ч очиж байсан. Тэд жил тутам илгээлтэд сая, саяыг өгдөг. Тэгэхээр хэн нь илгээлтэд ихийг өгч байна гэдэг асуулт тавигдана. Хариулах амархан. Пасторгаа сайн цалин өгдөг нь. Яагаад? Яагаад гэвэл тэр чуулган Бурханы Үгийн зааврыг дуулгавартай дагаж байгаа бол, нөгөө чуулган нь өөрийнхөө ухааныг Бурханыхаас дээр гэж үзжээ!

Би хөгжиж байгаа орнуудад зочлохдоо, тэндхийн чуулган надад хэрхэн хандаж байгааг үзээд уйлмаар болж билээ. Тэдний мөнгөн дүн нь Америкийн жишгээр өчүүхэн. Намайг үл тоодог Америк



чуулганууд надад хавьгүй ихийг өгч л байсан. Гэтэл тэр өчүүхэн бэлэгийн цаана ямар аугаа талархал оршиж байсан гэж бодно. Яг л Есүсийн “хамгийн багыг өгсөн ч, хамгийн ихийг өргөлөө” гэж хэлсэн нөгөө ядуу бэлбэсэн авгай шиг. Тэр авгай Бурханыг бэлэгээрээ хүндэтгэсэн. Үүнтэй адилхан тэр нандин ариун хүмүүс өөрсөд рүү нь илгээсэн Бурханы зарцыг юу байна - түүгээрээ хүндэтгэн хүлээн авсан юм. Энэ үгийг зүрхэндээ нэвчээ. Тантай Бурханы Үг дотор мөр зэрэгцэн хөдөлмөрлөж яваа эрчүүд, эмэгтэйчүүдийг хүндэтгэж сур.

### Удирдагч нарын томилдог хүмүүс

Есүсийн “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Миний илгээх хэнийг боловч хүлээн авч буй нь Намайг хүлээн авдаг. Намайг хүлээн авдаг нь Намайг Илгээгчийг хүлээн авдаг гэж айлдлаа” (Иохан 13:20) гэсэн үгийг дахин харна уу. Матай номд Есүс үнэндээ тогтолцооны хэлхээг дүрсэлсэн юм: Аав нь Есүсийг илгээсэн бол, Есүс таван талт үйлчлэгч нарыг илгээсэн. Бид Эзэний томилсон үйлчлэгч нарыг хүлээн авбал, Эзэнийг Өөрийг нь хүлээн авах бөгөөд Эзэнийг хүлээн авснаараа Аавыг хүлээн авна.

Тогтолцооны хэлхээ нь таван талт үйлчлэлээр хязгаарлагдахгүй, үйлчлэгч нараар томилогдсон хүмүүс рүү ч тэлнэ. Нэгэн Бүтэн сайны өглөөний цуглаан дээр амнаас минь сугарсан үгийг би хэзээ ч мартажгүй. Тус чуулган мундаг чуулган байв. Пастор нь хүмүүсээ хамгаалахын төлөө эрх мэдэл дотроо явж, хүмүүс нь ч түүнийг хүндэтгэдэг байв. Тийм боловч энэ хүндэтгэл нь бусад ажилчид, үйлчлэгч нарт очдоггүй ажээ. Гишүүд нь угтагч, зогсоолын зохицуулагч, заалны зохицуулагч, туслах, туслах пастор зэрэг пасторынхаа томилсон хүмүүсийг үл тоож байв.

Тэр цуглаан дээр би эш үзүүллийн үйлчлэл хийв. Эш үзүүлэх үед эш үзүүлсэн үгээ сүүлдэж сонсох нь олонтаа. Би чуулганы нэг ажилчин руу заагаад “Та нар энэ хүнд яаж хандана - пастортаа тэгж л хандана. Та нар энэ хүнд яаж хандана - Есүст ч тэгж л хандана” гэж хэлэв.

Тэр чуулганы зарим хүмүүсийн нүдийг харсан ч болоосой. Илчлэлийн гэрэл цацарч, тэр хүмүүсийн хандлагыг ил болгожээ. Гэхдээ тэр чуулган эрүүл ухаантай чуулган байсан учраас, хүмүүс нь Бурханы засвар үгийг хүлээж авсан юм. Тэр эш үзүүллийн үг намайг ч сэрээв. Би өөрийн ч байна уу, хүний ч байна уу - ямар ч чуулганд

үйлчилсэн, тэнд үйлчилж байгаа хүмүүсийг хүндэтгэдэг. Тэд Аавын томилсон - Есүсийн томилсон - пасторын томилсон хүмүүс болой. Тиймээс Бурханы зарц нарт буй Бурханы эрх мэдлийг харж байгаарай.

Үүний онцсайн жишээ бол Бичээс дээр гардаг, Сирийн цэргийн дарга Нааманы түүх юм. Тэрбээр уяман өвчин тусаад, бараг л найдвар тасраад байв. Гэтэл түүнийг Израилийн Бурхан Эзэний хүчээр эдгээж чадах эш үзүүлэгч Израильд байгааг Еврей зарц охин нь дуулгажээ.

Сирийн хаан зөвшөөрөл олгоод, Нааманыг Израилийн хаан руу илгээтэл, Израилийн хаан Нааманыг Елишагийн гэр рүү чиглүүлэв: “Ингээд Нааман морьд, тэрэгнүүдтэйгээ ирж, Елишагийн гэрийн үүдэнд зогсов. Елиша түүнд элч явуулан —Явж, Иорданд долоон удаа угаа. Тэгвэл махбод чинь эргэн сэргэж, цэвэршинэ гэж хэлүүлэв” (2Хаад 5:9-10).

Тэгтэл Нааман уурсаад: “Харагтун, Тэр над уруу гарцаагүй гарч ирж, зогсоод, өөрийн Бурхан ЭЗЭНий нэрээр дуудан өвчтэй газар дээгүүр гараа даллан уяман өвчнийг эдгээнэ гэж би бодсон юм” (11) гэжээ.

Нааман буруу төсөөллөөсөө болоод золтой л Бурханы хангамжийг алдчихаагүй. Нааман өндөр зиндааны хүн учраас, Елишаг зарц, албатаа явуулалгүй, өөрөө гарч ирээд угтана гэж бодож л дээ. Гэтэл Елиша түүнийг хүлээж аваагүй нь Нааманы дургүйг хүргэжээ. Тийм боловч Нааман цэргийн том дарга учраас, төлөөний эрх мэдэл гэдэг зүйлийг мэддэг байв. Золоор Нааман мэргэн зарцынхаа үгэнд орж, Иордан голд долоон удаа булхсаныхаа дараа төгс эдгэрчээ. Яг л зарцын хэлснээр болов. Тэгээд ч Нааман Бурханы эрх мэдэл дорх хүний дор байв.

Пасторынхаа эзгүйд чуулганы ирц буурдаг тухай сонсохоор гашуудмаар болдог. Тэр хүмүүс жинхэнэ эрх мэдлийг ойлгох ухаангүй байдлаа л харуулж байгаа юм. Зөв зүрхтэй хүмүүс том пастораас хүлээн авдаг ерөөлөө туслах пастораас ч хүлээн авна. Учир нь тэдний хэн, хэн нь пастораар томилогдсон юм. Пастор хүн Есүсийн байранд зогсдог. Хаанчлалын эрх мэдлийг ойлгодог хүн энэ бүхэн нь их, багаа шалгаруулах өрсөлдөөн бус, харин Есүсээс эхтэй бөгөөд хүнд бүслэгдсэн эрх мэдлийн асуудал болохыг мэднэ.

Итгэгч бид нийгмийн удирдагч, ажилтан, багш тэргүүтэй томилгоот хүмүүсийг хүндэтгэх ёстой. Бид орон нутгийнхаа эрх мэдлийг хүндэтгэх ёстой бөгөөд үүний маань төлөө бидэнд шагнал амласан. Эцэст нь чуулганд үйлчилж байгаа хүмүүст - ялангуяа

## ДАВХАР ХҮНДЭТГЭЛ

Бурханы Үгийн үйлчлэлд хөдөлмөрлөж байгаа хүмүүст давхар хүндэтгэл өргөө.

## ДУУЛГАВАРТАЙ БАЙЖ, ЗАХИРАГДАХ

*Дуулгавартай атлаа захирагдахгүй байх боломжтой.*

**З**ахирагдах гэдэг ойлголт нь итгэгч хүмүүсийн дунд баахан ээдрээ тарьдаг. Бүгдээрээ дараагийн гурван бүлгээрээ нилээд хүнд, хүнд асуудлыг авч үзнэ. Гучин таван жил Бурханы батлан хамгаалалт дор амьдарч, үйлчлэхийг сурах явцдаа би дараах асуултыг олонтаа сонсдог:

- Ямар ч болзолгүй дуулгавартай дагах ёстой юм уу?
- Удирдагчийнхаа шийдвэртэй санал нийлэхгүй бол, яах вэ?
- Эрх баригч нар муу шийдвэр гаргаж байвал, яах вэ?
- Эрх баригч нар надаар буруу зүйл хийлгэх гэвэл, яах вэ?
- Яг хаагуур нь зааг татах вэ?

Эдгээр нь онцсайн асуулт бөгөөд эрх мэдэлд захирагдах хүсэлтэй хүмүүс хариултыг нь заавал мэдэх ёстой. За ингээд, Еврей номоор эхэлье:

Удирдагч нараа дагаж, тэдэнд захирагдагтун. Учир нь тэд тооцоо хийгчид адил сэтгэлийг чинь сэрэмжилдэг. Тэд үүнийг санаа алдалгүйгээр, баяртайгаар хийг. Эс бөгөөс та нарт ямар ч ашиг болохгүй. (Еврей 13:17)

## ДУУЛГАВАРТАЙ БАЙЖ, ЗАХИРАГДАХ

Бичээч биднийг хоёр зүйлд ятгасан нь тодорхой байна: 1) Биднийг захирч байгаа хүмүүсийг дуулгавартай дагах, 2) Биднийг захирч байгаа хүмүүст захирагдах. Эдгээр нь хоёр өөр заавар бөгөөд үүн дээр хүмүүс маш их будилдаг. Бид дуулгавартай дагаж болох ч, захирагдахгүй байх боломжтой ажээ. Үүнийг би амьдралынхаа жишээгээр тайлбарлая.

### Ерөөгдөхгүй байна

Би хорь гараад, хэсэгхэн хугацаанд инженерээр ажиллаад, дараа нь Америкийн Өмнөдийн томоохон чуулганд дөрвөн жил хагас пасторынхаа хувийн туслахаар ажилласан тухайгаа өмнө ярьсан. Би пасторыгаа болоод гэр бүлийг нь харж хандан, хүүхдүүдийг нь халамжилдаг байлаа.

Энэ хугацаанд би асар их юм сурсан бөгөөд эхнийхээ жил “Бурхан минь, надад хаанчлалын төлөө ингэж үйлчлэх завшаан олгосонд баярлалаа” гэж ирээд л энгүй талархдаг байлаа. Бүр надад ийм боломж олгосон пасторынхаа ачийг яаж хариулна даа л гэж боддог байв. Нэг удаа пасторынхаа гэр бүлийн хоол хүнсийг цуглуулчихаад, дэлгүүрийн зогсоол дээр суугаад, асгартал уйлж билээ. Манай чуулган найман мянга давсан хүнтэй. Гэтэл над шиг өчүүхэн хүнд ийм завшаан олдох гэж? Бал сарын энэ баяр хөөр маань жил хагас үргэлжлээд гундаж эхэлсэн юм. Эхлээд дотроо дургүйлхдэг байснаа сүүлээрээ гаднаа эрс эсэргүүцдэг болов.

Пастортаа ойртох тусам, улам л их өө сэв олно. Ёстой л сонин дээрээ соохолзоод, сониноо буухаар ёхолзоно гэдэг л болов. Би харсан зарим нэг зүйлээсээ болоод дотроо зөрчилдөж байснаа, сүүлдээ дийлдэв. Тэр хүний арга барил, асуудлыг шийдвэрлэх ухаан, шийдэл нь улам л дургүй хүргэсээр.

Тэрбээр хүмүүсийн санал гомдолд яг л Америкийн корпорац шиг л хандана. Санал гомдлоо илэрхийлсэн ажилчдыг шууд ажлаас нь халах юмуу халагдах өргөдлөө өгөхөөс өөр аргагүй байдалд хүргэж, оронд нь уран яриатай, зальхай хүмүүсийг тавьдгийг нь би мэддэг байлаа. Ажилд дөнгөж шинээр орж ирж байгаа хүмүүс менежмент зэрэг чухал, чухал орон тоо руу шууд дэвшинэ. Пастор маань эргэн тойрондоо бурханлаг хүмүүсийг бус, өөрийг нь тахин шүтдэг, тал засдаг хүмүүсийг л тавиад байх шиг санагдана. Тэрбээр тэр

хүмүүсийн ямар ч утгагүй, шал худлаа ярианд учиргүй инээх атлаа үнэнч итгэлтэй хүмүүсийг үл тоон, дөлдөг байв. Түүний энэ авир байдал намайг хэлэх үггүй болгосоор, сүүлдээ би шүүмчлэгч болж хувирлаа.

Пастор үүгээр барахгүй, гайхмаар гайхмаар зүйл үйлддэг байсан бөгөөд тэр болгон нь миний жигшлийг бадрааж байв. Манайх чинь Америк даяар алдартай, олон улсын үйлчлэл байсан шүү дээ. Тиймээс тэр хүчирхэг машиныг ажиллагаатай байлгахын тулд асар их хэмжээний хүн хүч, мөнгө шаардагдана. Манай чуулган 250 гаруй ажилчинтай байсан бөгөөд бид хамгийн сүүлийн үеийн бүхнийг ашигладаг байлаа. Одоогийн болоод ирээдүйн хөтөлбөрт зориулж мөнгө босгохдоо зөвлөгөө авахаар мэргэжлийн зөвлөх, туслахуудыг урьж авчирна. Харин би тэднийг нь халамжлах ажилтай. Тэдний дунд ороод, пастортой ярьж байгаа зүйлийг нь сонсох тусам: *“Энэ бүхэн чинь бизнесийн ашигийн төлөө юм уу эсвэл үйлчлэлийн төлөө юм уу? Энэ чинь заль. Энэ хүмүүс үнэхээр хүмүүст санаа тавьж байна уу эсвэл мөнгө бодож байна уу? Пастор яагаад ийм хүмүүсээр өөрийгөө хүрээлнэ вэ?”* хэмээн бодогдоно.

Энэ үеэр намайг бас яг адилхан шүүмжлэл тээсэн хэсэг нөхөд тойрон хүрээлдэг байлаа. Нэг удаа Лизатай хамт нэгэн найзындаа зочилж, оройн хоол идсэнээ сайн санадаг юм. Бид хоёр пастор, түүний гэргий хоёрын талаар бас тэдний үйлчлэлээр огт ерөөгдөхөө больсноо яриу. Тэгээд би: “Би сүүлийн зургаан сар пасторын номлолоор нэг ч ерөөгдөөгүй” гэж хэлсэнээ сайн санаж байна. Бид бүгдээрээ л дуу дуугаа авалцан зөвшөөрсөн боловч, гэргий маань л юм хэлсэнгүй.

Тэр орой *“ерөөгдөхөө больсон”* гэдэг үг их дуулдав. Тэгээд “ер нь бидний тэнд үйлчлэх хугацаа төгсөж байх шиг байна” гэдэг дээр бид санал нийлэв. Бид энэ асуудлыг бүхлээр нь сүнслэгжүүлж, Бурхан биднийг өөрийн гэсэн үйлчлэлд гаргахаар бэлтгэж байгаа гэдэгтэй итгэл дүүрэн байлаа. Тэнд үйчлэх хугацаа маань дуусч, удахгүй дэвшинэ гэдэгтэй бид бардам байв.

## **Асуудал нь надад байв**

Хэдэн өдрийн дараа залбирч байтал, Бурхан намайг нигүүлсэж, тэр хосын гэрт өрнөсөн яриаг маань сануулав. Тэр орой би “ерөөгдөхөө больсон” гэдэг үгийг олон удаа хэлсэн боловч, сүүлийн зургаан сар Бүтэн сайны цуглаан дээр пасторынхаа номлолыг сонсох

## ДУУЛГАВАРТАЙ БАЙЖ, ЗАХИРАГДАХ

болгондоо гэргийдээ ингэж үглэдэг болоод байсан юм. Намайг энэ “өлсгөлөнгийнхөө” талаар эргэцүүлж байтал, Ариун Сүнс надад: “*Асуудал пасторт чинь бус, чамд бий!*” гэж хэлэв.

Би итгэж ядан, зог тусав: “Бурхан надад ингэж хэлнэ гэж үү?” Ер нь би иймэрхүү зассан үг сонсохоороо хэсэг зогсоод, зөв зүйл сонссон эсэхээ нягталж шалгадаг л даа. Тэгээд: “*Та хүн андуураагүй биз?*” гэж асуулаа. (Бид төлөвших тусмаа, өөрийгөө үнэндээ юу ч мэдэхгүй байгааг ухаарч, өсөх ёстойгоо ойлгодог учраас, янз бүрийн асуулт тавих маань багасдаг)

Би: “Яахаараа надад байдаг билээ?” гэж ирээд л чангаар асуув.

Гэтэл Эзэн надад: “*Чи ерөөгдөхөө байлаа гэж үглэж байна. Тэгвэл Исаиа 1:19-20 дээр “Уриалгахнаар та нар дагах аваас уул газрын сайныг иднэ. Эсэргүүцэж харин тэрсэлвээс илдэнд өөрсдөө идүүлнэ” хэмээн ЭЗЭНий ам айлдаж байна*” гэдэг” гэв.

Би энэ эшлэлийг сайн мэддэг учраас, Бурханы өөдөөс: “Би маш дуулгавартай байсан” хэмээн эсэргүүцлээ илэрхийллээ.

Гэтэл Ариун Сүнс: “Чи хэлсэн бүгдийг хийж үйлчилдэг. Гэхдээ Би “Дуулгавартайгаар дагах аваас, уул газрын сайныг иднэ” гэж хэлээгүй. Би “Дуртайяа дагах аваас, уул газрын сайныг иднэ” гэж хэлсэн. Хүсэл чинь хандлагыг чинь шийдвэрлэнэ. Гэтэл чиний хандлагад авах юм алга!” гэв.

Тэгээд дараа нь надад нэгэн түүхийг сануулав. Би итгэж, дахин төрөхөөсөө өмнө буюу ахлах сургуульд байхдаа Гурав дахийн үдэш болгон Баретта гэдэг Нью-Жерси мужийн Ньюварк хотын мөрдөгчийн тухай кино үздэг байсан юм. Гэтэл дөрөв дэхийн өглөөгүүр эрт хогны машин ирж, хог ачдаг байв. Тиймээс би өмнөх орой нь хогоо гаргаж тавих үүрэгтэй байлаа. Гэтэл дандаа кино ид дундаа орж, Баретта хэргийг шийдэх эгзэгтэй эгшин дээрээ явж байхад, ээж хүрч ирээд: “Миний хөө, хогоо гаргаж хаясан уу?” гэж асууна.

Би ч ээждээ: “Хаяагүй” гэж хариулна.

Тэгэнгүүт ээж: “Одоо гаргаад хаячих” гэнэ.

Тэгэхээр нь би: “Хаяна аа, ээж ээ!” гэнэ.

Хажуугаас харсан хүн намайг худлаа ярьдаггүй, дуулгавартай, магадгүй бас их хүсэлтэй хүү байна гэх л байсан байх. Гэтэл би дотроо: “Ээж гэж нэг ядаргаатай юм. Яг дуртай киногоо үзэж байхад дандаа л ингэхийм. Кино дуустал аравхан минут хүлээчихэж болдоггүй л юм байх даа” гэж боддог байлаа.

Ариун Сүнс “*Чи дуулгавартай байна. Тэр бүү хэл хүсэлтэй юм шиг харагдаж байгаа ч, үнэндээ чамд хүсэл алга. Чи ээждээ зөв хандаагүй. Энэ чуулганд ерөөгдөхгүй (Миний хаанчлалын сайныг идэхгүй) байгаа чинь хэдийгээр дуулгавартай боловч, хүсэлгүй байгаатай чинь холбоотой!*” гэлээ.

Би пастортаа буруу хандсанаасаа болоод Бурханаар ерөөгддөггүй, аюултай газар нэвтэрчээ. Үүнийг Еврей 13:17 дээр: “Удирдагчдаа дагаж, тэдэнд захирагдагтун. Учир нь тэд тооцоо хийгчид адил сэтгэлийг чинь сэрэмжилдэг. Тэд үүнийг санаа алдалгүйгээр, баяртайгаар хийг. Эс бөгөөс та нарт ямар ч ашиг болохгүй” хэмээн дүгнэсэн байна.

Нүд маань нээгдэж, би тэр даруй гэмшив. Дараагийн Бүтэн сайнд нь чуулгандаа очоод, суудалдаа суугаад нөгөө л пасторынхаа нөгөө л номлолыг сонссон ч, энэ удаа тэс өөр санагдаж байлаа. Тэнгэр нээгдэж, би пасторын маань сургаалаар дамжиж ирсэн Бурханы илчлэлийг бишрэв. Дээр минь Бурханы тавьсан эрх мэдлийг үл хүндэтгэсэн хандлагаасаа болоод өнгөрсөн зургаан сар хичнээн их зүйлийг алдсан бол гэхээс уйлах шахлаа.

Би пасторыгаа, чуулганыхаа үйл ажиллагааг шүүмжилж, дургүйцснээсээ болоод зургаан сар зүдэрчээ.

Бид дээрх эрх мэдэлдээ захирагдахгүй байснаараа, Бурханы Өөрийнх нь эрх мэдлийг эсэргүүцдэг. Учир нь Бурхан л тэр хүмүүсийг томилсон! Бурхан биднийг Өөрийнхөө хүмүүсээр дамжуулж Өөрийнх нь бэлтгэж өгсөн найрын ширээнээс чөлөөтэй хүртэж, ашиг тусыг нь эдлээсэй гэж хүсдэг.

Дуулгавартай байдал нь эрх мэдэлд хариулах үйлдэл бол, захирагдах нь эрх мэдэл хандах хандлага юм. Чухам захирагдах тал дээр л олонх маань алддаг. Бурхан бидний гадаад үйлдлийг ч, дотоод далд хандлагыг ч хардаг. Давид хүү Соломондоо хаан ширээгээ дамжуулахдаа: “Миний хүү Соломон оо, эцгийнхээ Бурханыг таньж мэдэн, хоёргүй сэтгэл, хүслэнт зүрхээр Түүнд үйлчлэгтүн. Учир нь ЭЗЭН зүрх бүрийг шалгаж, бодол санаа бүхнийг мэддэг юм. Хэрэв чи Түүнийг хайвал, Тэр чамд олдоно. Харин чи Түүнийг орхих аваас, Тэр чамайг мөнхөд үл хэрэгсэнэ” (1Шастир 28:9) гэж хэлсэн билээ.

Энэ шалтгаанаар Еврей номын бичээч биднийг дээрх хүмүүсээ дуртай дургүй дагах бус, харин тэдэнд захирагдаж явахыг ятгасан буй. Паул “дээд эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд” гэж хэлэхдээ, дуулгавартай байдлыг хүсэлтэй сэтгэлтэй хавсарчээ.



## Захирагдах хандлагатай боловч дуулгаваргүй

Еврей номын бичээчийн үгийг өөр нэгэн орчуулгаас авч үзье: “Удирдагч нараа дуулгавартай дагаж, тэдний эрх мэдэлд захирагд” (13:17 ЭнАйВи). Хүн захирагдах хүсэлгүй атлаа дуулгавартай дагаж болдгийг бид үзсэн. Үүнийг 3-аар бүлэгт Есүсийн ярьсан хоёр хүүгийн сургаалт үлгэр маш сайн жишээлэн харуулдаг. Нэг хүү нь: “Эрхэм ээ, би усан үзмийн талбай дээрээ очоод ажиллана аа” гэж ирээд л жигтэйхэн дуртай байсан ч, дуулгавартай дагаагүй. Тэрбээр мундаг хандлагатай, чих зөөлөнтэй байсан ч, аавынхаа хүслийг биелүүлээгүйг Есүс хэлсэн.

Өнөөгийн чуулган ийм хандлагаар дүүрээд байна. Бид аугаа хандлага тээж, толгой дохиж, мишээж, эрх мэдэлтнүүдтэй зөвшилцөж - ер нь л “Би хийнэ!” гэсэн мундаг хандлагатай байдаг. Гэхдээ нэг их чухалчилдаггүй учраас, зүгээр л хийдэггүй. Би үүнийг *елдэг тэрслэл* гэнэ. Бүү хууртагд: елдэг тэрслэл нь эрээ цээргүй тэрслэлтэй л адил үхлийн эд мөн. Эдгээрийн аль нь ч Бурханы хаанчлалд зохицохгүй.

Илчлэл ном дээр чуулгандаа хэлсэн Есүсийн үг үүнийг баталдаг. Тэрбээр чуулган бүрт хандсан үгээ “Би чиний үйлсийг мэднэ”, “Би чиний ажлыг мэднэ” гэж эхэлсэн (Илчлэл 2-3). Тэр чуулганууд сайн санаа сэдэлтэй байсан. Нэг чуулган нь бүр өөрийгөө *амьд* гэсэн боловч, Есүс тэднийг ажилдаа дуулгаваргүй учраас, *үхмэл* гэсэн юм. Есүс бол “хүн бүрд үйлсийнх нь дагуу хариуг өгөх” (Ром 2:6) Нэгэн гэдгийг бүү мартаарай. Сайн санаа нь Бурханы шүүхийг тэсч гарахгүй. Гагцхүү зохих дуулгавартай үйлдлээр илэрхийлэгдэх итгэл л тэсч гарна.

## Хаагуур нь зураас татах вэ?

Бурхан дахиад л “Та нарыг захирч байгаа хүмүүсийг дуулгавартай дагаж, захирагд” хэмээн тушаажээ. “Тэгвэл хаагуур нь зураас татах юм бэ?” гэж хүмүүс надаас олонтаа асуудгийг би хэлсэн. Тэд “Бурхан биднийг эрх баригч нарын хүссэн бүгдийг биелүүлээсэй гэж хүсдэг болж таарч байна уу? Буруу юм хийлгэх гэвэл, яах болж байна?” хэмээн чин сэтгэлээсээ асуудаг юм. Библи биднийг эрх баригч нартаа болзолгүй захирагдаасай гэж хүсдэг боловч, болзолгүй дуулгавартай дагаарай гэж заадаггүй. Захирагдах нь хандлагатай холбоотой,

дуулгавартай байдал нь бидэнд даалгасан зүйлийн биелэлтэй холбоотой байдгийг санаарай.

Бид цорын ганц тохиолдолд (би *цорын ганц* гэдэг үгийг тодруулж байна) эрх баригчдыг дагахгүй байж болно. Ямар тохиолдолд гэхээр - бидэнд Бурханы Үгийг зөрчихийг даалгасан тохиолдолд. Өөрөөр хэлбэл, удирдагч нар биднээр нүгэл үйлдүүлэх гэвэл, бид дагахгүй байж болно. Гэхдээ тийм тохиолдолд ч даруу бөгөөд захирагдсан хандлагаа хадгална.

Вавилоны хаан Небухаднеззар харгис хатуу авирлан, Израильчуудыг хүйс тэмтэрсэн. Тийм боловч Бурхан түүнийг “*Миний зарц*” гэсэн байдаг нь (Иеремиа 25:9, 27:5-7) гагцхүү Бурхан Эзэн л хүмүүнд эрх мэдэл олгодог болохыг баталж байгаа юм. Небухаднеззар хааны Вавилонд тууж авчирсан Еврейчүүдийн дунд Даниел, Шадрах, Мешах, Абед-Него нар байсан билээ.

Небухаднеззар хөгжмийн дуунаар ард түмэн нэгэн зэрэг алтан шүтээнд мөргөх зарлиг гаргасан бөгөөд энэ зарлигийг зөрчсөн хүмүүсийг халуун зууханд хаях тушаал гаргав. Гэтэл зуухнаас илүү Бурханаас эмээдэг Еврей залуус Бурханы Мосегоор дамжуулж Тора дээр бичүүлсэн хоёрдугаар тушаалыг зөрчсөн мөнөөх зарлигийг нь дагаагүй юм.

Энэ мэдээ тэр даруй Небухаднеззар хааны сонорт хүрэв. Хаан Шадрах, Мешах, Абед-Него гуравт хилэгнэж, үтэр түргэн өөрийнхөө өмнө авчруулан байцаажээ. Гэтэл тэд юу гэж хариулсныг сонсоно уу: “Небухаднеззар аа, энэ хэргийн талаар танд хариулах хэрэг бидэнд байхгүй. Бидний үйлчилдэг Бурхан биднийг аврах бол дүрэлзсэн галтай зуухнаас ч хаантан таны гараас ч биднийг Тэр аварна. Хэдийгээр тэгэхгүй байсан ч, өө хаантан, бид бурхдад тань үйлчлэхгүй мөн таны босгосон алтан хөрөгт мөргөхгүй гэдгийг та мэдсүгэй гэв. (Даниел 3:16-18)

Тэд Бурханы тушаалыг дуулгавартай бат дагасан ч, хаандаа хүндэтгэлтэй өгүүлсэн. Тэд хаандаа: “Мал аа, чиний хэлснийг хэзээ ч хийхгүй, за!” гэж хэлээгүй, харин “Хаантаан!” хэмээн эрхэмлэн дээдэлсэн. Доромжилж гутаасан үгээр ярих нь тэрслүү явдал. Бид эрх баригчдынхаа тушаалыг дуулгавартай дагахгүй байсан ч, эрх мэдэлд нь захирагдах ёстой.

Энэ байдал эхнэрүүдэд өгсөн Петрийн зааварт ч бий: “Түүнчлэн эхнэрүүд ээ, та нар нөхөртөө захирагд. Ингэх нь нөхрүүдийн чинь

## ДУУЛГАВАРТАЙ БАЙЖ, ЗАХИРАГДАХ

зарим нь үгийг дагахгүй байгаа ч гэсэн, тэд үггүйгээр эхнэрүүдийнхээ биеэ авч явах байдлаар аврагдана.

Тэд та нарын журамт байдал болоод эмээхийг чинь ажиглана шүү дээ” (1Петр 3:1-2). Эхнэр хүн дуулгавартай даган (Тит 2:5), захирагдсанаараа нөхрөө хүндэтгэх ёстой. Петр зан үйлдэл болоод захирагдлын хооронд мөн л параллель шугам татаж байна. Эдгээр нь дараа нь цэвэр бөгөөд хүндэтгэлийн амьдралын хэв загвартай хослох ёстой. Нөхөр нь итгэгч биш байсан ч, нөхрийнхөө эрх барих эрх мэдэлд хүндэтгэлтэй хандахыг эхнэрүүдэд ятгасан байх юм. Эхнэрүүдэд нөхрийнхөө үгээр үг дуугүй нүгэл үйлдээд бай гэж хэлээгүй, харин нөхрийнхөө эрх мэдэлд үг дуугүй захирагдаж, хүндэтгэж гэжээ.

Жишээлбэл нэг иймэрхүү явдал тохиолддог. Утас дуугарч, гэргий нь утсаа автал, нөхрийнх нь ярих дургүй хүн залгасан байсан тул нөхөр нь: “Намайг байхгүй гэхих” гэсэн заавар өгөв.

Тэгвэл гэргий нь ийм маягаар зохистой хариулж болно: “Би худлаа ярихгүй ээ. Чамайг одоохондоо завгүй байна, завтай болохоороо эргээд залгана гэж хэлье. Эсвэл тантай ярихгүй гэнэ ээ гээд хэлчих юм уу?” Гэргий нь нөхрийнхөө эрх мэдлийг хүндэтгэж байгаа ч, худлаа хэл гэсэн зааврыг нь хүлээн авсангүй.

Петр цааш нь ингэж хэлжээ:

Гоёл чинь үс сүлжилт, алтан эдлэл зүүх, эсвэл хувцаслалт гэх мэт гадна талынх бүү байг. Харин зүрхэнд нуугдсан хүнийг дөлгөөн ба даруу сүнсний мөхөшгүй чанараар гоё. Энэ нь Бурханы өмнө асар үнэтэй болой. Учир нь ийнхүү урьд цагт Бурханд найдвараа тавьсан ариун эмэгтэйчүүд нөхрүүддээ захирагдан өөрсдийгөө гоёдог байв. Түүнчлэн Сара Абрахамыг эзэн гэж дуудан, дуулгавартай дагасан юм. Та нар ямар ч аюулаас айхгүйгээр зөвийг үйлдвэл, тэр эмэгтэйн хүүхдүүд болно (1Петр 3:3-6).

Сарагийн Абрахамыг эзнээ хэмээн хүндэтгэж, дуулгавартай дагаж байснаас нь нөхрөө хичнээн хүндэтгэдэг байсныг нь үзэж болно. Эзэн гэдэг үг нь Сарагийн дуулгавартай хандлагыг харуулж байгаа бол, дуулгавартай хандлага нь Сарагийн айдасгүй байдлыг харуулж байгаа юм. Айдас бол аймшигтай эзэн. Айдас нь: “Би нөхөртөө юмуу хэн нэгэн эрх мэдэлтэнд захирагдах хэмжээнд Бурханд найдаж чадахгүй нь. Өөрийгөө би өөрөө л хамгаалах ёстой!” гэдэг. Захирагд гэдэг үгийг эрх хүчинд шунагсан хэн нэгэн хүн бус, харин

Бурхан Өөрөө тушаасныг санаарай. Бид Бурханыг дагахад, Түүний хамгаалалт биднийх болдог.

## **Тушаалыг завхруулах**

Үг дуугүй захирагдах тушаалыг үг дуугүй дуулгавартай дагах явдалтай андуурсан эмэгтэйчүүд тун харамсалтай. Тэр байтугай Есүст итгэдэг нөхрүүд нь бэлгийн дур таашаал эдлэх гэсэндээ эхнэрүүдээсээ бохир кино үзэхийг шахан шаардах үед эхнэрүүд нь Бичээс энэ тал дээр тэдэнд өмгөөлөл өгөөгүй гэж бодсондоо, эр нөхрийнхөө үгийг үг дуугүй дагадаг талаар би сонсож явсан. Би эхнэрүүдээсээ шударга бус авир үйлдэл гаргахыг шаардаж, үгэндээ оруулдаг нөхрүүдийг мэднэ. Би эхнэрүүддээ цуглаанд явахыг хориглож, гэрээс нь гаргадаггүй нөхрүүдийг мэднэ. Гэтэл уг нь эдгээр удирдамжийг дагах ёсгүй юм. Учир нь эдгээр нь Бичээсийг зөрчиж байгаа явдал болой.

Цаашаа явцгаая. Би эхнэр, хүүхдээ зоддог нөхрүүдийг, энэ талаар тас нуудаг эхнэрүүдийг мэднэ. Заримдаа хүүхдүүд нь бэлгийн хүчирхийлэлд өртөж байхад, эхнэрүүд нь юу ч хийдэггүй. Энэ нь Бурханы эрх мэдлээ тогтоосон илчлэл болгоныг зөрчсөн явдал бөгөөд энэ тохиолдолд Бурхан тэднийг юу ч хийлгүй, зүгээр байгаад байгаасай гэж хүсдэггүйг эмэгтэйчүүд ойлгох ёстой. Хэрэв нөхөр нь амь насанд нь аюултай зан авир гаргаж байгаа бол, эхнэр нь өөрийгөө болоод үр хүүхдээ нөхрөөсөө аварч, зайлаад, нөхрөө бүрэн төгс гэмштэл эргэж очих ёсгүй.

Хатан зоригт Давид хүртэл өөрийг нь Саул сүлбэж алах гэж байхад, ордноор эргэлдээд байлгүй, амиа авран цөл рүү зугтсан. Гэхдээ Давид эцсээ хүртэл Саулын эрх мэдлийг хүндэтгэсэн буюу. Давид Саулын дэргэдээс зугтаад, түүнийг жинхэнээсээ гэмшихийг эсвэл Бурханы шударга шүүхийг хүлээсэн болохоос Саулыг хүндэтгэхээ хэзээ ч болиогүй юм.

## **Нүгэл үйлдэх тушаалыг дагаагүй хүмүүсийг Бурхан ерөөдөг**

Эрх мэдлийг дагаагүй тохиолдол өөр олон бий. Фараон Еврей эх баригч нарт Еврей эмэгтэйчүүдээс төрсөн эрэгтэй хүүхдүүдийг алахыг тушаасан. Тийм боловч Библи “Гэтэл эх баригч нар Бурханаас

эмээж, Египетийн хааны тушааснаар эс үйлдэн, хөвгүүдийг амьд үлдээв” (Гэтлэл 1:17) гэдэг. Бурхан тэдний үйлдлийг таалсан. Учир нь Бичээс “Эх баригчид Бурханаас эмээсэн тул Тэр тэдэнд гэр бүл бий болгож өгчээ” (и21) гэсэн. Хааны тушаалыг дагаагүйнх нь төлөө Эзэн эх баригчдыг шагнажээ.

Санхедрин дагалдагч нарт “Есүсийн нэрээр огт ярьж, заахгүй байхыг тушаав. Гэвч Петр Иохан нар тэдэнд —Та нарыг Бурханаас илүү сонсох нь Бурханы өмнө зөв үү? Өөрсдөө шүүн тунгаагтун. Учир нь бид үзсэн, сонсоноо ярихаа зогсоож чадахгүй гэжээ (Үйлс 4:18-20). Есүс тэдэнд хэдийнээ “Бүх ертөнцөөр явж, сайнмэдээг хамаг бүтээлд тунхаглагтун” (Марк 16:15) гэж айлдсан байтал дагалдагч нар яаж тэр удирдагч нарын үгэнд орох билээ? Болохгүй! Санхедрин дагалдагч нарт Есүсийн тушаалыг зөрчихийг тушаасан учраас, дагалдагч нар хүндэтгэлтэйгээр таггалжээ. Тэдний шийдвэрээс гарсан үр дүнг Бичээс ийнхүү тэмдэглэсэн байна: “Элч нар Эзэн Есүсийн амилсныг агуу хүчээр гэрчилж байсан бөгөөд тэд бүгдийн дээр бялхам их нигүүлсэл байсан билээ” (Үйлс 4:33). Тэдний Бурханаас айх айдас нь аугаа ерөөл, хүчийг авчиржээ.

Паул ч бас тэр Санхедринд дагалдагч нарын л адил хүндэтгэлтэй хандаж, захирагдсан байдаг. Паулыг Санхедрины өмнө авчрахад тэрбээр өөрийгөө өмгөөлөн хамгийн түрүүнд: “Эрчүүд ахан дүүс ээ! Энэ өдрийг хүртэл би Бурханы өмнө сайн мөс чанартай амьдарч ирлээ” (Үйлс 23:1) гэж хариулжээ. Үүнийг нь сонссон тахилч Ананиа Паулын ойролцоо зогсож байсан хүмүүст түүний амыг алгад гэсэн. Тэгмэгц Паул: “Цагаанаар будагдсан хана чамайг Бурхан цохино доо!” (и3) гэж хэлтэл, “тэнд байгсад —Бурханы тэргүүн тахилчийг чи доромжилно уу? гэлээ. Паул —Ах дүү нар аа, би түүнийг тэргүүн тахилч гэж мэдсэнгүй. “Ард түмнийхээ удирдагчийг бүү муул” гэж бичигдсэн байдаг гэв (Үйлс 23:4-5).

Ананиаг тахилч гэдгийг нь олж мэдмэгцээ, Паул гаргасан авир, үгдээ гэмшжээ. Дагалдагч нар Бичээстэй сөргөлдсөн тушаалыг дагаагүй боловч, “эрх мэдэл нь Бурханаар тохоон томилогддог” болохыг мэдэж байсан учраас, захирагдах хандлагаа хадгалсан юм.

## **Илүү өндөр хуулийг дагахаар шийдсэн Даниел**

Даниелийн өдрүүдэд хаантнаас өөр бурханд юмуу хүнд мөргөсөн хүнийг арслангийн нүхэнд хаяна гэсэн хууль гарчээ. Энэ хуулийг

Даниелийг хөнөөх гэсэн атаархуу захирагч нар санаачилсан юмсанж. Завхарсан удирдагч нар хуулиа Дариус хааны гарын үсгээр хүчин төгөлдөр болгож амжжээ. Даниел тэр хуулийг биелүүлэх талаар бодсон ч үгүй, зүгээр л Бурханаа дагасан. Тэрбээр магтаалчийн төлөвлөгөөг сахив: “Үдэш, өглөө болон үд дунд ч би үглэн гонгинох бөгөөд Тэрээр дууг минь сонсоно” (Дуулал 55:17).

Даниелийн үйлдлийг харна уу: “Тэрхүү албан бичиг захирамжид гарын үсэг зурсныг *Даниел* мэдээд, дээд давхрын өрөөндөө Иерусалимын зүг харсан онгорхой цонхтой гэртээ орж, урьд хийж байсан ёсоор өдөр бүр гурван удаа өвдөг сөгдөн Бурханыхаа өмнө залбиран талархал өргөв” (Даниел 6:10).

Даниелийн дуулгаваргүй явдал хааны сонорт хүрч, хаан түүнийг арсланд хаяж өгөхөөс өөр сонголтгүй болов. Тийм боловч энэ шударга бус явдлын нүүрэн дээр ч Даниел захирагдах хандлагаа гээгээгүй юм. Бурхан Даниелийг өмгөөлж, өлөн арслангийн амыг үдсэн учраас, Даниел хор хохирол үзэлгүй, амар тайван унтжээ. Болсон явдлыг үзсэн хаан Даниелийн эсрэг хуйвалдсан этгээдүүдийг өөрсдийг нь догшин арсланд хаяж өгөв.

## Дандаа таатай үр дүн гарах албагүй

Бурхан эдгээр ариунтнуудыг чөлөөлсөн. Гэхдээ дандаа ингэх албагүй. Еврей ном дээр:

Эмэгтэйчүүд өөрсдийн үхэгсдийг амиллаар буцаан авч байв. Зарим нь илүү дээр амилалд хүрэхийн тулд чөлөөлөлтийг хүлээж авалгүй тамлагдсан юм. Зарим нь доромжлогдон, ташуурдуулсан. Тийм ээ, бас гинжлэгдэн, хоригдож байлаа. Тэд чулуугаар шидүүлэн, соригдож, тас хөрөөдөгдөн, илдэнд хөнөөгдөж, хонь ямааны арьс нөмрөн явж, хоосон тарчиг байн, зовж, ад үзэгджээ. Тэд цөл, уул, агуй болоод газрын гаваар тэнүүчлэн байлаа. Тэдний хувьд дэлхий зохисгүй байжээ (Еврей 11:35-38) гэдэг.

Удирдагч нар нь энэ эрчүүд, эмэгтэйчүүдэд шударга бус, харгис хандсан.

МЭ 140-230 онд аж төрж байсан, эртний чуулганы багш Тертуллиан Ромын удирдагч, иргэдэд тэдний хавчлага нь Христэд итгэх итгэлийн

үйл хэргийг улам бэхжүүлсэн болохыг сануулсан байдаг. Тэрбээр “Та нар биднийг алах тусам, бид улам л олширно. Христэд итгэдэг хүмүүсийн цус нь үр болой” (*Apology*, 50-аар бүлэг) гэжээ.

Би хавчигдаж зовсон итгэгч нарын талаар бичсэн нэр нь үл мэдэгдэх Ром хүний үгийг хуулж бичмээр байна:

“Тэд эх орондоо аянчид мэт амьдрах. Тэд махан биед орших ч, махан биетэй үл хөөцөлдөх. Тэд хорвоо дээр хоног өдрийг өнгөрөөж буй тэнгэрийн харьяатууд. Тэд бичигдсэн хуулийг дагах авч, хуулиас хол өндөр амьдрах. Үзэн ядагсад нь үзэн ядлынхаа учрыг ч хэлж эс чадах.” (*Диогнетуст бичсэн захидал*, 5-аар бүлэг)

Тэд зүгээр нэг дуулгавартай дагаагүй, харин үүнээс хол даван, дуулгавартайгаар захирагджээ. Петрийн ятгалгаас үзсэнээр, шударга бус удирдагч нартаа хандсан итгэгч нарын хандлага нь удирдагч нарыг гайхшруулж, Эзэн дээр ирэхэд хүргэж байжээ.

### Саарал тал байхгүй

Иргэний, гэр бүлийн, чуулганы, нийгмийн эрх баригч нар биднээс Бичээст нүгэл гэдгийг нь *тов тодорхой* хэлээд өгчихсөн зүйлийг үйлдэхийг шаардахаас бусад тохиолдолд Бурхан биднийг тэдэнд захирагдаж, дуулгавартай дагаж байгаасай гэж хүсдэг. *Тов тодорхой* гэдэг үгийг тайлбарлая. Дээрх жишээн дээр итгэгч нар Христийг няцаах, хүн алах, өөр бурхдыг дагах юмуу Есүсийн тушаалыг шууд зөрчих тушаалыг дагаагүй. Тэд үүнийг тухайн нөхцөл байдлаасаа хамаарах саарал тал юмуу эсвэл тэдний шүүх хэрэг биш гэж үзээгүй.

Чуулганы ажилчдын дунд дараах маягийн гомдол бүхий, саарал тал их явдаг: “Пастор надад ажлын цагаар хүмүүст зөвлөгөө өгч, тэдний төлөө залбирч болохгүй гэсэн. Гэхдээ тэр чинь Бурханы хайрыг үзүүлэхгүй байгаа хэрэг. Хайр дотор явахгүй байх чинь нүгэл. Тиймээс би зөвлөгөө өгч, залбирах л болно.” Энэ бол эрх мэдэл дор буй хүмүүсийн шүүх хандлага юм. Тэд өөрсдөө л ийм ташаа хөрвүүлэг хийдэг. Пастор нь тэдэнд Бурханы Үгийг зөрчихийг тушаагаагүй. Тэгээд ч тэд шивэх, бичиг баримт янзлах, дата цэгцлэх зэрэг ажил хийснийхээ төлөө цалин авч байгаа болохоос биш, залбирсныхаа төлөө цалин аваагүй.

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Үндсэндээ иймэрхүү хүмүүс нь захирагдах дургүйгээсээ болоод эцэстээ хулгай хийж төгсдөг. Хэрэв тэд үнэхээр л бусдын төлөө залбирах зүрхтэй бол, пастораасаа залбирах тусгай цагийн зөвшөөрөл авах юмуу эсвэл ажлаа тарсан хойноо залбирч болно. Гэхдээ пастор нь ажилчдаа хангалттай сайн сургагдаагүй учраас хүмүүст зөвлөгөө өгч, залбирч чадахгүй гэж үзсэндээ, зөвшөөрөл олгоогүй байж болох. Энэ тал дээр пастор буруу шийдвэр гаргасан бол, Бурханы өмнө пастор л хариуцлага хүлээхээс биш, пасторын дорх ажилчид шүүгдэхгүй. Олон төрлийн жишээ татаж болох ч, үндсэн санаа нь өөрчлөгдөхгүй: Бурханы Үгийг улайм цайм зөрчсөн нөхцөлд л бид эрх мэдлийг дагахгүй байж болно.

Гэлээ ч та: “Гэхдээ эрх мэдэлтнүүд надаар санал нийлэхгүй зүйлийг минь хийлгэх гээд байвал, би яах вэ? Эсвэл эрх мэдэлтнүүд надаар хараажийн тэнэг зүйл хийлгэх гэвэл, би яах вэ? Эсвэл эрх мэдэлтнүүд надаар залбиралдаа харснаас минь өөр зүйл хийлгэх гэвэл, би яах вэ?” хэмээн асуусаар байж болох. Тэгвэл үүнд дараагийн бүлэг маань Бичээсийн үндэслэлтэй хариулт өгнө.



## ЭРХ МЭДЭЛТНҮҮД НАДААР...?

*Бид Бурханы Өөрийнх нь илчлэл болох эрх мэдлийн илчлэлтэй л хөөцөлдөх ёстой. Учир нь Бурхан, эрх мэдэл хоёр салшгүй.*

**У**дирдагч нартаа сэтгэл дундуур байдаг хүмүүстэй зөндөө л таарна. Тэд техник үр нөлөөгүй байна, шийдвэр оновчгүй байна, эдгээр нь тэдний амьдралд сөргөөр нөлөөлж байна, удирдагчдынх нь амлалт биелэхгүй байна гэж гомдоллоно. Үнэндээ хамаг юм ухраад байна л гэнэ. Пастор нь алдаа гаргасан учраас, эрх мэдэл нь Бурханаас салсан л гэнэ. Энэ мэт шалтаг нь гомдолд үүд тайлдаг бөгөөд эцэстээ дуулгаваргүй зан авираар илэрнэ. Тэгээд эрт орой хэзээ нэгэн цагт заль мэхтэй сүлбэлдэн, тэднийг л аюулгүй байлгаж, өсгөж өндийлгөх гэсэндээ дээр нь тавьсан Бурханы эрх мэдлээс гажиж одно.

### **Тантай тангүй болно!**

Израилийн хүүхдүүд яг энэ загвараар явсан. Тэд Мосегийн удирдлагыг үр нөлөөгүй байтугай хор уршигтай гэж үзсэн. Гэхдээ анхнаасаа ингэж эхлээгүй юм. Мосе цөлд нэг хэсэг амьдарсныхаа дараа Египетэд эргэж ирээд, Фараонтай уулзахаасаа өмнө Израилийн удирдагч нартай уулзсан байдаг. Тэгээд Эзэн “тэднийг египетчүүдийн гараас чөлөөлж, тэр газраас гаргаад... сүү бал халгисан сайхан,

уудам нутагт аваачихаар” (Гэтлэл 3:8) түүнийг илгээлээ гэж хэлдэг. Израильчууд энэ гайхамшигт мэдээг сонсоод, Мосед итгэж, Бурханд мөргөсөн. Тэд өөрсдийг нь дарлалаас чөлөөлөх Бурханы амласан удирдагчаас барихдаа, баяр хөөрөөр цалгисан.

Мосе тэр уулзалтаас гараад, Фараон дээр очоод уулан дээр Бурханы айлдсан үгийг шууд дамжуулжээ: “Израилийн Бурхан ЭЗЭН “Миний ард түмнийг явуул. Тэд цөлд Надад баярын ёслол үйлдэг” гэж айлдаж байна.”

Фараон: “Тэр Эзэн чинь хэн болоод, би хэлснийх нь зоргоор Израилийг явуулдаг билээ? Би тэр Эзэнийг чинь мэдэхгүй, Израилийг ч явуулахгүй. Чи яахаараа хүмүүсийг ажлаас нь сатааруулдаг билээ?” гэж хариулаад, тэр өдрөө ажил үүргийг нь нэмэгдүүлэв. Тэгээд зарц нартаа хилэнтэйгээр: “Муусайнуудыг ажлаар булаад, шүүслээд өг!” гэжээ (2-9-ээр эшлэлийг утгачлан буулгав).

Израильчуудын өдөр бүр цохидог тоосгынх нь сүрэлний хангамжийг ч зогсоов. Тиймээс Израильчууд шөнөөр нь сүрлээ түүгээд, өдрөөр нь тоосгоо цохих ёстой болжээ. Сүрлийн хангамж зогссон ч, хийх ёстой тоосгоны тоо буурсангүй.

Израильчууд улс даяар сүрлийн эрэлд гарав. Харгалзагч нар нь ч хатуу харгис гэж жигтэйхэн. Тэд: “Хангалттай тоосго хийсэнгүй!” хэмээн Израиль боолуудыг толгой түрүүгүй ташуурдан жанчина.

Боолуудын өмнөөс ахлах нь хариуцлага хүлээнэ. Харгалзагч нар тэднийг “Өчигдөр бас өнөөдрийнхөө ажлын нормыг биелүүлсэнгүй” гэж жанчина.

Тиймээс Израильчуудын ахлахууд Фараон дээр очоод: “Бидэнд ингэтэл бүү хатуурхаач. Биднийг сүрлээр хангахгүй атлаа урьдын тоо хэмжээний тоосго шаардаж байна. Бид өөрийнхөө бус, өрөөлийн буруугаас болж зодуулж байна! Танай харгалзагч нар боломжгүй зүйл шаардаж байна” хэмээн гувшжээ.

Гэтэл Фараон: “Муусайн залхуус! Ажил чинь багадаад байна аа даа. Хийх ажилтай байсан бол, “Биднийг Эзэндээ тахил өргөхөөр явуулаач” гэж дэмийрэхгүй байхсан. Ажилдаа буцаад орцгоо! Та нарт ямар ч сүрэл өгөхгүй. Гэхдээ та нар урьдын тоо хэмжээний тоосго үйлдвэрлэх ёстой” гэв.

Фараонаас тусыг эс олсон Израилийн ахлахууд өөрсдийгөө тун горьгүй байдалд орсныг ухаарчээ. Тэд Фараоны ордноос гарч явахдаа, гадаа хүлээж байсан Мосе, Аарон хоёртой уулзаад: “Та нар Фараон

ба албат нарынх нь нүдэнд биднийг жигшүүр болгож, биднийг алуулахаар тэдний гарт сэлэм өгч байгаа тул *ЭЗЭН та нарыг хараад шүүх* болтугай!” (Гэтлэл 5:13-21-ийг утгачлан буулгав) гэж хэлжээ.

Ийнхүү Израилийн ард түмэн Мосегийн удирдлагад гонсойв. Түүний номлол, удирдамж тэдэнд баахан л зовлон болжээ. Тэд Мосегийн эрх мэдлийг Бурханы эрх мэдлээс салгасан нь Мосегийн дээр тэнгэрийн шүүхийг дуудсанаас нь харагдаж байна.

Энэ бүхэнд Мосе буруудав. Мосе тэднийг гэж ирээгүй байсан бол, Фараон тэдэнд хатуурхахгүй байж. Тэднийг самуурсан, муу удирдагч ийм байдалд орлуулаагүй, энэ бүхнийг Бурхан Өөрөө найруулан удирдаж байгааг тэд ухаараагүй. Эзэний их гарын төлөвлөгөө, урьдаас мэдэх мэдлэгээс гадуур өрнөдөг зүйл байхгүй. Эзэн Мосед Фараонтай ярилцахыг тушаасан. Эзэн Өөрөө Фараоны зүрхийг хатууруулсан! Диавол юмуу Мосе бус. Үүнийг дараах хэсгүүд маш тодорхой хэлдэг: “ЭЗЭН, Фараоны зүрхийг хатууруулсан тул тэр Израилийн хөвгүүдийг нутгаасаа явуулсангүй” (Гэтлэл 11:10, 9:12, 10:1, 20, 27). Фараоны зүрх хатуурах тусам, Абрахамын үр садын амьдрал улам хэцүүдэж байв.

Олон зовлон, гай гамшгийн дараа Израильчууд Египетээс чөлөөлөгдсөн ч, зах хязгааргүй цөлд тэнүүлчилж эхлэв. Хүнс, усгүй тэд дахиад л “Мосе бидэнд эрх чөлөө, элбэг дэлбэг байдлыг амлаагүйсэн билүү? Сүү балаар халгиж цалгисан, үржил шимтэй, уудам нутгийг? Тийм ээ, тэр цөл нь зах хязгааргүй гэдэг утгаараа уудам байсан ч, үржил шимийн хувьд - сүү, балын сураггүй тэр газрыг сайн сайхан гэх хэцүү байв! Эрх чөлөө, хангамжийн талаар Мосе санаанаасаа туучихсан уу? Тэр үнэхээр Бурханаар илгээгдсэн үү?

Хэд хоногийн хомсдлын дараа Мосе тэднийг Мара гэдэг газар авчирч, устай золгуулав. Хүмүүс “*За яахав, одооноос байдал дээрдэх ч юм билүү?*” гэж бодоо байх. Гэтэл тэдний олсон ус нь уухын аргагүй, гашуун ус байж таарав. “Арай ч дээ!” Ард түмэн итгэж ядсандаа бослого гаргахаас наагуур юм болов. Тэдний шүүмж улам л хурцдаж, тэд өөр хоорондоо бөгөөд Мосед гомдоллон үглэв. Гонсгор мэдрэмж нь ард түмний дунд тахал аятай тархжээ. Мосе магадгүй хүмүүсийг яаж гаргахаа мэддэг ч, яаж оруулахаа мэддэггүй байсан болтой.

Хүмүүс Мосе, Аарон хоёрт “Бид Египетийн нутагт махтай тогооны хажууд сууж, цадталаа талх иддэг байхдаа ЭЗЭНий мутарт алагдсан бол дээр байж. Та нар чуулганыг бүхэлд нь өлсгөлөнгөөр алах гэж биднийг энэ цөлд авчирлаа” (Гэтлэл 16:3) хэмээн гомдоллов.

Тэд туйлдаа хүрчээ. “Мосегийн удирдах ур чадвар хангалтгүй болох нь олон жил олон талаараа харагдсан. Түүнийг эрх мэдэлд гарахаас өмнө амьдрал арай дээр байсан бус уу? Мосегийн Египетийн дарлалаас чөлөөлөх үйл явц тэдэнд баахан зовлон, зүдгүүр л авчирсан. Энэ зовлон дуусахгүй нь болтой. Тэд нэг зовлонг гэтлээд л нөгөөд эзлэгдэж байв. Мосе тэдэнд сүү, балаар бялхсан газрыг амласан ч, тэд хатмал цөлд могой, хилэнцэт хорхой л үзэж байлаа. Мосе газраа андуурчихсан юмуу аль эсвэл өөдгүй, муу хүн болтой. Ядаж л Фараоньд тэд хоолтойгоо байсан. Гэтэл Мосе тэднийг яг өлсгөж алах гэж байна. Египетэд амьдрал болоод л байсан!” Тэдний энэ гомдол буцалсаар буцалсаар “Цөмөөрөө тэргүүлэгчийг томилоод Египет уруу буцацгаая” гэж хэлэхдээ тулжээ (Тооллого 14:4).

Гэтэл Бурханы томилж өгсөн удирдагчаас залхсан тэр хүмүүст Мосе юу гэж хэлснийг үзнэ үү: “ЭЗЭН орой нь та нарт идэх мах өгч, өглөө нь та нарт цадтал талх өгнө. Учир нь Өөрийнх нь эсрэг та нарын гонгинон гомдоллохыг ЭЗЭН сонссон. Бид юу юм бэ? Гонгиноон чинь бидний эсрэг биш, харин ЭЗЭНий эсрэг юм” (Гэтлэл 16:8).

Тэдгээр эрчүүд, эмэгтэйчүүд өөрсдийгөө Бурханы эсрэг бус, гагцхүү Мосегийн эсрэг гомдол гаргаж байна л гэж боджээ. Тэд өөрсдийгөө Бурхан, Мосе хоёрыг ялгахтайгаа гэж бодож. Тэд дуулгавартай байдлын зарчмаар бус, учир зүйн гаргалгаагаар амьдарчээ. Хараа, нөхцөл байдлаасаа ургуулдаг учир зүйн гаргалгаагаар явдаг хүмүүс нь мунхаглалын зам дээр гардаг. Тийм хүмүүс хувь тавиландаа хүрдэггүй бол, эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, дуулгавартай дагадаг Иошуа, Калев хоёр шиг хүмүүс нь амлагдсан газарт орно.

## **Хэрэв би ялгаж чадаж байвал, яах уу?**

Та өөрийгөө удирдагчийнхаа тодорхой бөгөөд шуурхай шийдвэрээр шүүгдсэн Израилийн хүүхдүүдээс хавьгүй ухаантай хэмээн сэтгэж болох. Та өөрийгөө магадгүй Иошуа шиг сүнслэг хэмээн үзэж байж болох. Та Мосег зөв гэж харж чадаагүй Израилийн хүүхдүүдтэй адилгүй учраас, Иошутай хамт зогсох байсан гэж бодож байгаа байх.

Магадгүй ээ. Гэхдээ яаран баталгаажихаасаа өмнө сэрэмжтэй байцгаая. Фарисайчууд “Бид эцэг өвгөдийнхөө үед байсансан бол эш үзүүлэгчдийн цусыг урсгахад, тэдний хамсаатан болохгүй л байсан” (Матай 23:30) хэмээн итгэл дүүрэн хэлцгээсэн ч, Есүс тэднийг эцэг

өвгөд шигээ л сүнстэй гэсэн. Бүх асуудал нэгэнт тодорхой болчихсон, ном бичигдчихсэн байхад тэр нь зөв, тэр нь буруу байсан гэж хэлэх амархан. Иошуа ялгах хараагаараа бус, чухам эрх мэдэлд захирагдах хандлагаараа л бусдаасаа ялгарсан билээ. Эрх мэдэлд захирагдсан хандлагаас нь ялгах хараа төржээ.

Өөрсдийгөө ялгах хараатай гэдэг хүмүүсийн дуу хоолойноос таагүй, дурамжхан өнгө аяс сонсогддог боловч, зүрх нь үл захирагддаг. Тухайлбал би яг одоо энэ ном дээр ажиллаж байхдаа, сүүлийн хорин дөрвөн цагийн дотор “ялгах харааны” тал дээр “Би санал нийлсэн тохиолдолд л захирагдана” гэдэг хандлагатай нэгэн захидал хүлээн аваад байна. Ийм үзэлтэй хүмүүс өөрсдийгөө захирагдахгүй байх хүндэтгэх шалтгаантай хэмээн эндүүрдэг болтой.

### **Хэн түүнийг энэ байранд тавьсан юм?**

Та “Хэрэв удирдагч маань онцгүй сонголт хийгээд байгааг нь би мэдээд байгаа бол, яах уу? Баларч дуусна гэдгийг нь мэдсээр байж, үгээр нь явсаар байх уу?” гэж асууж магад. Би ч өнгөрсөн хугацаанд “Тэд муу шийдвэр гаргаж байна! Тэд Бурханаас зөрж байна! Тэд сөрөг нөлөөнд ороод байна. Би үүнийг нь тэсвэрлэж чадахгүй!” хэмээн шаналах тохиолдол олон байсан. Тийм боловч эргээд харахад, ихэнх тохиолдолд миний бардам зүрх л өөрийнхөө бие даасан байдлыг тийнхүү илэрхийлдэг байжээ.

Би олон жил пасторынхаа гүйцэтгэгчээр ажилласан бөгөөд шийдвэрт нь эргэлзэх тохиолдол бишгүй гардаг байлаа. Пасторын маань удирдамж салбарын удирдагч нарт хүрэхээсээ өмнө миний ширээгээр дамждаг учраас, би хүссэн хүсээгүй тэдгээрийг нь үзнэ. Тэгээд би түүнийг мунхаг шийдвэр гаргаж байна гэж үзэн, зүрхэндээ бувтнан үглэнэ. Гэтэл нэг өдөр Сүнс надад: *“Би чамаас нэг зүйл асуумаар байна”* гэх нь тэр.

Бурхан надаас асуулт асуухаараа, ер нь бол миний алдааг ойлгуулах гэж байгааг би туршлагаараа сурсан юм. Тэгээд би: “За, Эзэн минь!” гэлээ.

-*“Би пасторын байр суурин дээр чамайг тавьсан уу, түүнийг тавьсан уу?”*

Би: “Та түүнийг тавьсан” гэлээ.

Гэтэл Эзэн шууд л: *“Тийм ээ. Тиймээс чиний харах шаардлагагүй*

*зүйлсийг би түүнд харуулдаг бөгөөд тэр Намайг дагадаг шиг, чи түүнийг дагах эсэхийг чинь харахын тулд түүний шийдвэрийн мэргэн ухааныг зориуд чамаас битүүмжлэх болно” гэв.*

Тэгээд голдуу хэдэн сарын дараа пасторын маань шийдвэрийн мэргэн ухаан ил болдог байлаа. Гэрэл тусах үед би үүнийг нь олж хараад, өөрийнхөө төөрөлдсөн гаргалгааг дуулгавартай байдлаас өндөрт тавьснаа ахин дахин хардаг байсан юм. Ийм хандлага чуулган, айл гэр, бизнесийг хагалдаг. Бурхан биднийг удирдлагынхаа цэц ухааныг харж, тэдэнтэй зөвшилцөж, тэдний хэлсэн үгд дуртай байсан нөхцөлд л эрх баригч нартаа захирагдаарай гэж хэлээгүй юм шүү. Бурхан зүгээр л “Дага!” гэдэг.

Хожим Эзэн зүрхэнд минь: *“Жон, хэрэв Би итгэгч бүрийг бүх мэдээлэл, цэц ухаан, чиглүүлгээ гагцхүү Надтай харилцах харилцаа, Надад хандсан залбирлаасаа аваасай гэж хүссэн бол, чуулган дотор эрх мэдлийн тогтолцоог хэзээ ч тогтоохгүй байсан. Би хүүхдүүдээ удирдагч нараараа дамжин Миний дуу хоолойг таньж, сонсоход сургахын тулд зориуд чуулганд эрх мэдлийн тогтолцоог бий болгосон юм”* гэж хэлж билээ.

Удирдлагынхаа шийдвэр дээр улаан гэрэл улалзуулах юмуу тэр байтугай шүүх нь бидний ажил биш ээ. Энэ ажлыг тэднийг томилсон Нэгэн Өөрөө хийх болно. Израильчууд Мосегийн шийдвэрийг шүүх эрхтэй байсан бол, Мосег таягдаж хаяад, өөрсдөө Египет рүү буцах байв.

Удирдагч нар шүүгдэнэ, бид ч шүүгдэнэ. Удирдагч нар шийдвэрийнхээ төлөө шүүгдэх бөгөөд тэд биднээс хавьгүй хатуу шүүгдэнэ. Тиймээс л Есүс: *“Харин үүнийг мэдээгүй бөгөөд ташуурын амт хүртэх хэрэг үйлдсэн нэг нь багахан хүртэнэ. Хэнд их өгөгдсөн байна, түүнээс ихийг шаардана. Хэнд их даалгагдсан байна, түүнээс ихийг нэхнэ”* (Лук 12:48) хэмээн анхааруулсан билээ. Энэ талаар Иаков ч анхааруулсан: *“Ах дүүс минь, багш нар бид үлэмж хүнд шүүлтэд орно гэдгийг мэдэн, та нараас олноороо багш бүү бол”* (Иаков 3:1).

Тэгвэл бидний хувьд, захирагдсанаараа шүүгдэнэ. Учир нь эрх мэдэл Бурханых болой. Бурханы төлөөний эрх мэдлийг эсэргүүцэх нь Бурханы эрх мэдлийг эсэргүүцэх явдал юм. Бид удирдагч хүн зөв үү, буруу юу гэдгийг таамаглах дарамтыг үүрэх ч хэрэггүй, дараа нь шүүх ч хэрэггүй. Энэ дарамт бидний бус, Бурханы мэдлийн зүйл. Зүрхийг мэдэгч нь гагцхүү Бурхан бөгөөд Бурхан л хүссэнээрээ өөрчилж чадна.

## Удирдагч хүний зүрх Бурханы мутарт буй

Пастор маань чуулганы гэрийн бүлгийн нөхөрлөлийг хаасан талаар би 2-аар бүлэгт өгүүлсэн. Би түүнийг буруу шийдвэр гаргахаар барахгүй, намайг мохоох гэсэндээ л зориуд ингэж байна гэдэгт итгэлтэй байлаа. Учир нь манай чуулганы “оффис менежер” пасторт хүчтэй нөлөөлдөг байсан талаар би яриагүй байх. Тэр хүн намайг үздэггүй байсандаа, ажлаас халуулахын тулд хамаг л ид шидээ хэрэглэж байсан юм.

Тэрбээр санаандаа хүрэхийн тулд тэргүүн пастор, бид хоёрт нэг нэгнийг маань муучлан, бидний хооронд хэрэм босгож байв. Хов жив нь дийлэнхдээ л ор үндэсгүй, худлаа юмс байлаа. Дээрээс нь тэрбээр ажилчдыг бүгдийг нь миний эсрэг тухиран эргүүлэх “кампанит ажил” гэж хэлж болохуйц зүйлийг эхлүүлсэн байв. Лиза тухайн үед мөн л чуулганд үйлчилдэг байсан болохоор, ажлын газрын хүмүүс маань Лизад “пастор яагаад миний нэрийг оруулаагүй” учрыг хэлдэг байсан юм. Би юу болоод байгааг мэдэж байсан ч, гар маань гавтай мэт байлаа.

Тэр менежерийн тариалсан худал, хардлага сэрдлэгээс болоод би гэрийн бүлгийг хаасан тэргүүн пасторын шийдвэрийг намайг чиглэсэн ээлжит довтолгоо гэж үзэхэд хүрсэн билээ. Би өөрийгөө болж буй үйл явдлыг бүгдийг нь нэвт шувт мэднэ гэж бодож байлаа. Тэгээд улам л өөрийгөө зөвтгөн, улам л пастортаа захирагдахаас гэжив. Тэгээд ч миний тооцоогоор пастор төөрөлдөж, буруу шийдвэр гаргасан шүү дээ. Бурхан юу гэж л олон хүнийг авралд хүргэх хүчин чадалтай, найман сарын нөр их хөдөлмөрийг хоосон урсгах билээ? Ингэж дүгнэсэн учраас л, би тэр хурал дээр бууж өгөлгүй, тэргүүн пастортайгаа хорин таван минут халз мөргөлдсөн юм. Би өөрийгөө зөвт бөгөөд зөвтөгдсөн гэдэгтээ бардам байсан ч, гэртээ хариад Ариун Сүнсэнд бангадуулсан юм. Тэр үед л би хамаг учрыг ухаарч билээ: Би хүний эрх мэдэлтэй бус, Бурханы эрх мэдэлтэй нүүр тулсан байжээ.

Төдөлгүй Эзэн зүрхэнд минь нэгэн бичээсийг асаасан бөгөөд тэр бичээс надад тиймэрхүү нөхцөлд яахыг зааж өгсөн юм:

Хааны зүрх ЭЗЭНий мутарт усны урсгал

Хаа таалсан зүгтээ Тэр түүнийг чиглүүлэх (Сургаалт үгс 21:1).

Хаан бол таны дээрх эрх мэдлийг төлөөлөгч. Тэр хүн бурханлаг байна уу, үгүй байна уу хамаагүй - зүрх нь Эзэний мутарт байдаг. Энэ эшлэлд “Сайн хааны зүрх Эзэний мутарт байдаг” гэж хэлээгүй, харин сайн, муугаасаа үл хамааран, зүрх нь Эзэний мутарт байдаг гэжээ. Учир нь энд “Хаан буруу зүг рүү эргээгүй л бол, Эзэн түүнийг чиглүүлэх” гэж хэлээгүй байна.

## **Муу шийдвэр гэдгийг нь мэдбэл, яах уу?**

Гэхдээ бид үнэхээр ялгаж таниагүй байж, зүгээр л удирдагчийгаа муу шийдвэр гаргаж байна гэдэгт мухраар итгээд байгаа бол яах уу? Эсвэл удирдагч маань бүтэхгүй амьтдын үгээр явж байгааг батлах хангалттай нотолгоо бидэнд байгаа бол эсвэл байхгүй бол, яах уу? Удирдагчдаа тусалж болохгүй гэж үү? Удирдагчдаа туслаж болно оо.

Үүний онцсайн жишээ нь Эстер юм. Абрахамын хүүхдүүд Персийн дарлалд оржээ. Ёрын Хамаан ёрын төлөвлөгөөгөө сэдэн, Персийн хаан Ксеркесээр Еврей хүн бүрийг хороох тушаал гаргуулж чаджээ. Хаан өөрөө өдрийг нь товлов.

Эстер хатан Абрахамын удам байсан боловч, авга ах Мордихай нь хориглосон учраас, энэ тухайгаа хэлээгүй байжээ. Гэтэл Мордихай Эстерээс ард түмнийхээ төлөө хаан дээр орохыг гуйжээ. Үүнээс болж Эстер амиа ч алдаж болохыг Мордихай мэдэж байсан. Эстер юу ч олохгүй, бүхнээ алдаж болох байсан ч, хатан байсан учраас, нууц нь баталгаатай байв.

Эстер хаан дээр орохоор шийдэн, гурван хоног мацаг барьсныхаа дараа Ксеркес хааны дотоод өрөөнд ороод очтол, Бурханы нөлөөгөөр хаан хатнаа таалан соёрхож, хэрэг зоргыг нь асуутал, хатан нь хаан, Хамаан хоёрыг зоогт урьжээ. Хаан ч зөвшөөрч, Хамааны хамт хатныхаа зоогт хүрэлцэн очив.

Тэр оройдоо хааны нойр хулжаад, зарц нараараа он тооллын бичгийг дуудуулахдаа, тэндээс Мордихай гэдэг Еврей хүн хааныхаа амийг аварсан атлаа шан харамж хүртээгүйг олж мэджээ. Хаан түүнийг хэрхэн хүндэтгэх талаар эргэцүүлэн, Хамаанаас зөвлөгөө сонстол, Хамаан өөрийнх нь талаар ярьж байна гэж эндүүрээд, тэр нэргүй баатрыг хүндэтгэх нарийн ёслолыг зааж өгчээ. Тэгтэл хаан тэр баатар нь Мордихай болохыг илчилж, Хамаан өөртөө зориулж сэдсэн хүндэтгэлээ Мордихайн төлөө өөрийн биеэр хорсолтойёо гүйцэтгэв. Энэ хооронд Бурхан хааны зүрхийг зоог дээр Эстерийн хэлэх үгд бэлтгэн ажиллаж байв.



## ЭРХ МЭДЭЛТНҮҮД НАДААР...?

Эстер хаан, Хамаан хоёрыг дахин нэг зоогт урихад, хаан мөн л хатныхаа хүслийг асуужээ:

Хаантан минь, хэрэв би таны нүднээ тааллыг тань олсон бөгөөд хаан үүнийг таалбал, гуйлтын минь хариуд миний амийг надад өгч, хүсэлтийн минь хариуд ард түмнийг минь надад өгөөч! Учир нь би ч, миний ард түмэн ч, бид устгуулж, алууулж, хүйс тэмтрэгдэхээр худалдагдаад байна. Хэрэв бид эр, эм боолууд болж худалдагдсан бол, энэ нь хаантан шархадсантай дүйх зовнил бус тул би дуугүй байх байсан (Естер 7:3-4).

Энд тэмдэглүүштэй хэд хэдэн зүйл байна. Нэгдүгээрт - хаан хараажийн аймшигтай, үндэслэлгүй шийдвэр гаргасан байсан ч, Эстер хааныгаа хүндэтгэсээр, захирагдсаар байсан. Хоёрдугаарт - Эстер цэц ухаанаа зөвхөн өөрийнхөө сайн сайхны төлөө бус бас хааныхаа сайн сайхны төлөө үнэхээрийн даруу байдлаар илэрхийлсэн. Эстер хүсэлтээ хэлсэн ч, эцсийн шийдвэрийг хаандаа үлдээсэн. Тэрбээр “Та алуурчны үгийг сонсдог, яасан дүүрчихсэн хаан бэ?! Энэ тушаалыг гаргаснаараа та ямар алдагдал хүлээхээ ойлгохгүй байна уу?” гэж хэлээгүй. Эстер нэг л зүйлд найдсан: Бурхан хааны зүрхийг эргүүлнэ гэдэгт. Тэгээд Эзэн түүний зөвлөгөөг эргүүлж, хаан ёрын Хамааныг дүүжилж, Еврейчүүд аллагаас аврагджээ.

Удирдагч нь үнэнийг мэдэхгүй байгааг Эстер зүгээр нэг таамаглаагүй, баттай мэдсэн. Тиймээс хаан дээрээ даруухнаар явж ороод, шийдвэрээ өөрчилтөл нь болж буй үйл явдлыг танилцуулж чаджээ. Тэрбээр хааныгаа доош хийгээгүй, дарамтлаагүй, хүчлээгүй, зүгээр л хааны зүрхийг чиглүүлэх Ариун Сүнсний хүчинд итгэсэн байна.

## Бүрэн ойлгоогүй байж

Дээрх бичээс дээр удирдагч нь буруу нөлөөнд автаад зогсохгүй, бүх асуудлыг бүрэн мэдээгүй, ойлгоогүй байж шийдвэр гаргажээ. Тэгвэл Давид, Саул хоёрын жишээ бий. Филистины үлэмж биетэн Бурханы цэргүүдийг дөч хоног доромжилсон. Тэрбээр “Дайраад ирэхийн давсаг байна уу? Гүйгээд ирэхийн гүзээ байна уу? Үхэх сэхэхээ ганц л тулаанаар шийдье!” хэмээн Израилийн ардын армийн цэргүүдийн зүрхийг үхүүлэн, тавлажээ. Гэтэл Давид хүү гүйж ирээд, цэргүүд нь

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

үлэмж биетэй цэргийн сүрдүүлгээс эмээн бэмбэгнэж байхыг үзэв. Бурхан Давидын зүрхэнд дайт гэсэн. Гэтэл Саул хаан Давидыг үзээд: “За хүү минь, чи байлдана гэж байхгүй. Чамайг ялагдахаар, бид чинь энэ улсын дор орно!” гэсэн утгатай үг хэлдэг.

Давид энэ үгэнд хэгжүүрхэж хэдэрлээгүй, зүгээр л учирлан гуйсан:

Гэвч Давид, Саулд —Боол нь эцгийнхээ хонийг хариулдаг байсан. Арслан юмуу баавгай ирээд, хонин сүргээс минь хурга авч явахад би араас нь хөөж очоод, түүнийг довтолж, түүний амнаас хургаа авардаг байсан. Хэрэв тэр над уруу дайрвал би сахлаас нь шүүрэн авч түүнийг цохиж алдаг байв. Таны боол би арслан, баавгайн аль алиныг нь алсан билээ. Тэр хозлуулаагүй филист хүн амьд Бурханы цэргийг шившиглэсэн тул тэдний нэгэн адил болох болно гэж хэлэв. Давид цааш нь —Арслан, баавгайн савраас намайг аварсан ЭЗЭН тэр филист хүний гараас ч намайг аварна гэв. Саул, Давидад —Явагтун, ЭЗЭН чамтай хамт байх болтугай гэж хэлэв (1Самуел 17:34-37).

Давид эрх баригчдаа мэдээлэл өгөхдөө туйлын хүндэтгэлтэй ханджээ. Тэрбээр хааныхаа шийдвэрт дутагдсан мэдээллийг хүндэтгэлтэйгээ танилцуулаад, хааных нь зүрхийг эргүүлэх ажлыг Бурханд даатгажээ. Тэрбээр зүрхэнд нь Бурханы суулгасан итгэл үнэмшил хааных нь шийдвэрийг давж гарахыг мэдэж байжээ. Давид даруу байж, захирагдсанаараа Бурханд ажиллах боломжийг нь олгосон бөгөөд Эзэн Саулын зүрхийг эргүүлэхэд Саул: “Яв, Эзэн чамтай байг” (1Самуел 17:37) гэжээ.

## Жинхэнэ зуучлал

Шийдвэрээ гаргачихсан удирдагчаасаа учирлан гуйсаар, шийдвэрийг нь өөрчлүүлж чадсан, Бичээсийн өөр нэгэн баатар бол Абигайл юм. Тэрбээр Набал гэдэг хахир, мулгуу баяны эхнэр байв. Саулаас амиа авран зугтаж явсан Давидад хоол хүнс хэрэгтэй байсан тул “Найр наадмын улирал тохиож байна. Өгөөмрөөр хангана байгаа” хэмээн найдсандаа Набал руу хүмүүсээ явуулжээ. Урьд Давид Набалын зарц нарыг хамгаалахдаа, түүнээс юу ч аваагүй байв.

Гэтэл Набал Давидын хүсэлтийг няцаагаад зогсохгүй, элдвээр гутаан доромжилжээ. Хилэгнэсэн Давид ч өшөө авч, Набалын голомтыг самрахаар дөрвөн зуун цэргээ цуглуулав.

## ЭРХ МЭДЭЛТНҮҮД НАДААР...?

Гэтэл энэ мэдээ Набалын гэргий Абигайлд хүрч, тэрбээр үтэр түргэн талх, дарс, буудай, үзэм, инжир тэргүүтнийг зэхээд, Давид тэргүүтэй цэргүүдийг тосон очжээ. Абигайл Давидыг үзэхдээ, унаанаасаа бууж очоод, өмнө нь сунан мөргөөд ингэж гуйжээ:

Эзэн минь, зөвхөн миний буруу. Өөрийн шивэгчнийг яриулж, өчгийг нь сонсоно уу. Эзэн минь, тэр хэдэр хүн Набалыг бүү хайхрагтун. Учир нь тэр өөрийнхөө нэртэй адил хүн. Тэр Набал нэрэндээ таарсан мунхаг нэгэн билээ. Таны шивэгчин би харин эзний илгээсэн залуусыг хараагүй юм. Тийм учраас одоо эзэнтэн минь, ЭЗЭН амьд мөн та ч амьд! ЭЗЭН таныг цус урсгахаар явахыг зогсоож, таны гараар өшөө авахыг нэгэнт болиулсан тул эзэнтэнд минь хор хөнөөл болохыг хүсэгчид болон дайснууд тань Набалтай адил болох болтугай. Эзнийг минь дагалдаж яваа хүмүүст өгөхөөр шивэгчнээс тань эзэнтэндээ авчирсан ерөөлийн бэлэг одоо энд байна. Та шивэгчнийхээ гэмт үйлдлийг өршөөн соёрх. ЭЗЭН заавал эзэнтэнд минь бат бэх гэрийг барьж өгнө. Учир нь эзэнтэн минь та ЭЗЭНий тулалдааныг хийж байгаа билээ. Насан турш бузар муу танаас бүү олдог! Хэн нэгэн хүн босон таныг мөшгөн хөөж, таны аминд халдахыг эрмэлзвэл эзэнтэн таны амь таны Бурхан ЭЗЭНий амийн баглаанд уягдах болтугай! Харин таны дайснуудын амийг ЭЗЭН дүүгүүрт хийж дүүгүүрдэн хаях болно. ЭЗЭН танд амласан сайн сайхан бүгдийнхээ дагуу эзэнтэнд минь гүйцэтгэж, таныг Израилийн ноёноор томилох цагт эзэнтэн минь шалтгаангүйгээр цус урсгасан эсвэл өөрийн гараар өшөө авснаас болсон харуусал, зүрх сэтгэлийн саад тоггор танд бүү байг. ЭЗЭН, эзэнтнийг минь сайн сайхан болгоход өөрийн шивэгчнийг санатугай гэж хэлэв (1Самуел 25:24-31).

Абигайл нөхрийнхөө төлөө, гэр бүлийнхээ төлөө бас Давидын төлөө юу хийснийг жагсаая:

1. Тэрбээр өөрийгөө Давидын зарц болохыг ахин дахин хэлэхдээ, Давидыг үнэн голоосоо хүндэтгэжээ.
2. Тэрбээр Давидад болоод түүний эрчүүдэд өгөөмөр бэлэг барихдаа, тэдэнд үнэн голоосоо санаа тавьжээ.
3. Тэрбээр бүх хариуцлагыг өөр дээрээ авснаараа гэр бүлийнхээ төлөө зуучлан гуйсан. Үнэндээ бүр “миний зөрчил - нүгэл” гэж хэлсэн.
4. Тэрбээр Давидыг цус урсгаж, гараа бузарлах нүглээс хамгаалсан.

5. Тэрбээр Давидад Бурхан түүний өмнөөс өшөө авч, амласнаа биелүүлэхийг сануулсан.
6. Тэрбээр Давидаас сайн явахдаа өөрийг нь мартахгүй байхыг гуйсан.

Та “Энэ эмэгтэй тэгээд нөхрөө яаж хүндэтгэсэн юм?” гэж асууж болох. Тэр нөхрийнхөө амийг аварсан. Нөхөр нь Бурханы тохоон томилсон эрчүүдийн өмнө нүгэл үйлдсэн. Абигайл нөхрөө өмөөрсөн бол, Давидад бүр ч их өшөө авах шалтгаан гаргаж өгөх байсан. Тэрбээр зүгээр л Давидын гал дээр тос нэмж, гарцаагүй үхлээ дуудах байсан. Үхэл авчрах хүндэтгэл ямар ашигтай гэж?

Абигайл Набалыг огт хүндэтгээгүй бол, “Эндээс зайлах минь. Энэ маанаг шангаа хүртээд алуулаг” гэх байсан биз. Эсвэл Давид дээр очоод: “Би энд хамаагүй шүү. Би таны хүссэнийг өгөх л байсан. Манай мангар хар юу хийснийг дуулаад, танд болоод танай эрчүүдэд жаахан хүнс авчирлаа. Гэхдээ та манай мангарыг албал ал. Та юу ч хийсэн, тэр шангаа л хүртэж байгаа нь тэр” гэх байсан биз. Нөхрийгөө үл хүндэтгэсэн хүн ингэх л байсан.

Хэн нэг хүний төлөө зуучлан гуйх нь тэр хүний зөрчлийг үл тоож байгаа явдал бус, харин ч хүлээн зөвшөөрч байгаа явдал юм. Тэгээд ялтан - шүүх хоёрын хооронд зогсоод, үндсэндээ “Тийм ээ, тэр хүн шүүгдэх ёстой хүн мөн боловч, түүнийг өршөөхийг гуйж байна. Би шүүхийг өөр дээрээ авч, түүний өмнөөс зогсож байна” гэж хэлж байгаатай л адил юм.

Абигайл яг л ийм зүйл хийсэн. Давид шүүхийг тогтоохоор ирсэн бол, Абигайл өршөөл гуйхаар ирсэн. Тэрбээр: “Шивэгчнийхээ нүглийг өршөөн соёрх” гэсэн.

Абигайл Давидыг өөрийнхөө гараар өшөө авч, аллага үйлдэх нүглээс хамгаалан өгүүлжээ. Бурхан “Чи ард олныхоо хөвгүүдийн эсрэг бүү хонзогно, аливаа зэвүүцлийг бүү хадгал” (Леви 19:18) гэсэн билээ. Абигайл бараг л амьдрал үхлийн хооронд хөндөлсөн зогсоод, Давидын төлөө шударга ёсыг эржээ.

Абигайл хөршүүд, найз нөхөддөө: “Манай мангар хар ёстой нэг бүтэлгүй амьтан” гэж яриагүй. Тэр бүү хэл Давидад ч нөхрийнхөө талаар ууртай, жигшилтэй, хүндэтгэлгүй, хорсолтой байдлаар яриагүй. Абигайл нөхрийнхөө амийг аврах гэж л ярьсан. Тэгээд түүний зуучлан залбирал юунд хүргэснийг үзнэ үү:

## ЭРХ МЭДЭЛТНҮҮД НАДААР...?

Өнөөдөр чамайг надтай уулзуулахаар явуулсан Израилийн Бурхан ЭЗЭН магтагдах болтугай. Мөн чиний саруул ухаан магтагдах болтугай. Намайг өнөөдөр цус урсгах болон өөрийнхөө гараар өшөө авахыг болиулсан чи магтагдах болтугай. Намайг чамд хор хөнөөл хийхийг болиулсан Израилийн Бурхан амьд! Хэрэв чи надтай уулзахаар яаран ирээгүй бол үүр цайх хүртэл Набалд ганц ч эр хүйстэн үлдэхгүй байх байсан гэж хэлэв. Ийнхүү Давид Абигаилын гараас түүний авчирсан юмыг авч, тэр эмэгтэйд —Гэртээ амар тайван буцагтун. Харагтун, би чиний хэлснийг сонсож, чиний гуйлтыг хүлээн авлаа гэж хэлэв (1Самуел 25:32-35).

Абигайл гэртээ эргэж иртэл, нөхөр нь өөртөө зориулан найр хийж байв. Тэрбээр болж өнгөрсөн үйл явдлын талаар юу ч мэдээгүй. Абигайл тэр орой нөхөртөө юу ч хэлсэнгүй. Маргааш өглөө нь Абигайл нөхөртөө амийг нь хэрхэн аварсан талаар хэлтэл, нөхөр нь үүнийг дуулаад чулуу шиг хөшжээ. Арав хоногийн дараа Эзэн Набалыг үхүүлэв. Тэр өөдгүй хүнээс Давидын юмуу Абигайлын гар биш, харин Бурханы гар өшөө авчээ.

## Эрх мэдэлд байгаа хүний төлөө

Мосе Эрх баригчийнхаа буюу Бурханы Өөрийнх нь шийдвэрийг эргүүлэв! Ийм явдал ганц бус удаа тохиолджээ. Эхний тохиолдлыг үзье. Израиль алтан тугал үйлдэн, үүнийгээ шүтэж, нүгэл үйлдсэнд Бурхан хилэгнэжээ. Тэгээд Мосед Израильчуудыг алж хаячихаад, Мосегоор дамжуулан шинэ үндэстнийг бий болгоно гэтэл, Мосе юу учирлан гуйсныг үзнэ үү:

ЭЗЭН, агуу хүч чадал, хүчирхэг мутраар Египет нутгаас гаргасан ард түмнийхээ эсрэг Таны уур хилэн яагаад шатна вэ? Юунд египетчүүдээр “Тэднийг ууланд алж, газрын хөрснөөс устгахын тулд Тэр тэднийг хөнөөлт санаагаар гаргасан юм” гэж яриулах ёстой билээ? Шатаж буй хилэнгээсээ эргэж, ард түмэндээ хор хөнөөл учруулах санаагаа өөрчлөөч. Абрахам, Исаак, Израиль хэмээх зарц нараа санаач. Та тэдэнд Өөрөөрөө тангараглан “Би үр удмыг чинь тэнгэрийн од шиг олшруулж, амласан бүх газраа үр удамд чинь өгч, тэд үүнийг үүрд өвлөх болно” гэж тэдэнд айлдсан шүү дээ гэв (Гэтлэл 32:11-13).

Эндээс хэд хэдэн зарчим тэмдэглэмээр байна. Нэгдүгээрт - Мосе эмээн чичирч, бүрэн захирагдсан байдлаар өгүүлсэн. Хоёрдугаарт - Мосе Бурханаас үнэн голоосоо учирлан гуйснаас биш, том дуугараагүй. Гуравдугаарт - Мосе нэн тэргүүнд хүмүүсийн тусын тулд бус, харин Бурханы тусын тулд гуйсан. Мосе үндсэндээ: “Таны дөрвөн зуун жил байгуулсан нэр хүнд тань яах билээ? Таны нэрийг одоо даян дэлхий мэддэг болчихоод байхад, Та эхлүүлсэн ажлаа дуусгаагүй Нэгэн хэмээн хэлэгдэж, нэрээ хугалах гэж үү?” гэжээ. Мосе Бурханыг л бодож хэлсэн учраас, Бурхан шийдвэрээ эргүүлжээ. Мосе өөрийгөө бодоогүй, бусдыг л бодож.

Тиймээс бид удирдагчаасаа учирлан гуйхаасаа өмнө эхлээд “Би хэнийг бодож гуйж байна?” гэж өөрөөсөө асуух хэрэгтэй. Мосе Бурханд Абрахамд өгсөн амлалтыг нь сануулахдаа ч, Бурханыг л бодож хэлсэн. Мосегийн зүрх зөв байсан учраас, зөв зүйл дээрээ төвлөрсөн. Тэр Бурханы зарц учраас, өөрөөсөө бөгөөд Израильчуудаас өмнө Бурханыг л боджээ.

Тэгтэл Бурхан ийн хариу үйлдэв: “Тиймээс ЭЗЭН ард түмэн дээр буулгана гэж айлдсан хөнөөлт санаагаа өөрчилжээ” (Гэтлэл 32:14).

Бурхан бодлоо өөрчилсөн! Шийдвэр эргэжээ. Би өөр нэгэн чухал зүйлийг хэлмээр байна. Мосе өөрийнхөө журамт чанараа ахин дахин, ахин дахин батлан харуулж чадсаныхаа улмаас л ийнхүү Бурхантай нүүр тулан ярилцсан юм. Тухайлбал, манай Мессенжер Интернэйшнэл байгууллагад олон жилийн турш Лиза, бид хоёрт үнэнч чанараа батлан харуулсан хүмүүс байдаг. Тэд дөнгөж шинээр ажилд орж байгаа хүмүүсийг бодохноо, бид хоёртой илүү ойр байж, арай өөр төвшинд харилцдаг. Удирдагчийнхаа амьдралд шууд хандах эрхийг олж ав. Үүнийг гагцхүү шударга журам, үнэнч итгэмжтэй зан чанараар л олж авдаг юм. Хүн бүрт ийм завшаан олдоод байхгүй.

Өөр нэг чухал зүйл нь Мосе Бурханы шийдвэрийн талаар бусадтай бус, шууд Бурхантай Өөртэй нь ярилцсан. Израильчууд юм л бол Эзэний арга замыг голж, шүүмжилж байсанд Эзэн уурлаж, энэ явдлыг нь үзэн ядаж байв! Энэ нь тун аюултай үйлдэл бөгөөд үүнээс боломжтой бүх аргаар сэргийлж явах хэрэгтэй. Бид эрх баригчдынхаа гаргасан шийдвэрийн талаар өөр хоорондоо гоншигнох юм бол, хагарал, тэрслэлийг тарина. Тэгээд үүнээсээ болж зайлшгүй шүүгдэхийг өөр бүлгээс үзсэн.

Би ажилчидтайгаа санал зөрдөг. Ажилчид маань намайг дутуу мэдээлэл дээр үндэслэн шийдвэр гаргалаа үзэх юмуу эсвэл тэдэнд

## ЭРХ МЭДЭЛТНҮҮД НАДААР...?

миний шийдвэр дээр нэмж болох шинэ санаа байвал, надад чөлөөтэй хандаж болно. Гэхдээ тэд санаагаа эхнээс нь дуустал сайтар эргэцүүлэн бодож байгаад, ойлгомжтой танилцуулах шаардлагатай байдаг. Би шинэ мэдээлэлтэй танилцахаараа, ямар ч асуудалгүй шийдвэрээ өөрчилдөг. Харин хэрэв бид ярилцсан ч, би хуучин шийдвэр дээрээ зогсбол, тэд зүгээр л намайг дагаад, урагшаа явдаг. Хэрэв бид нэгэн санаагаар хөдөлсөн ч, миний буруу байж таарбал, Бурхан биднийг хамгаалдаг. Би ч, миний хүмүүс ч цэвэр зүрхээр үйлдсэн учраас, Бурхан биднийг хамгаалдаг. Давид “Би Таныг хүсэн хүлээдэг учир Үнэнч шулуун шударга нь Намайг хамгаалаг” (Дуулал 25:21) гэсэн буй.

Юмс Бурханы надад харуулснаас эсрэгээр эргэбэл яах вэ?

Та бас л: “Удирдагч маань надаар Бурханд залбирч байхдаа мэдэрснээс минь өөр зүйл хийлгэх гэвэл, би яах уу?” гэж асуумаар байгаа байх. Энэ онцсайн асуултад хариулах хэрэгтэй. Үүнд хариулахын тулд хоёрдугаар бүлэгт өгүүлсэн жишээгээ дахин сөхье. Би “үдэшлэгийн” хөтөлбөрөө хэрэгжүүлэхээсээ өмнө Эзэнийг үнэн голоосоо хайн залбирсан болохоороо, энэ бүхэн Эзэний хүсэл мөн гэдэгт итгэл төгс байв. Үнэндээ би өнөөдөр ч итгэл төгс явдаг. Эзэн үнэхээр надад энэ бүхнийг зөвшөөрсөн. Тийм боловч үүнийг зөвшөөрсний хамаг зорилго нь намайг удирдагчаа дагах нь уу, үгүй юу гэдгийг л шалгахын тулд байсныг би хожим ойлгосон билээ.

Бурхан хүмүүсээ шалгасан жишээ Бичээст олон. Бурхан Абрахамд Исаакийг тахил болгон шатаа гэж хэлснийг нь Бичээс “Бурхан Абрахамыг шалгав” (Эхлэл 22:1) гэдэг. Эзэн үнэндээ Абрахамыг ганц хүүгээс нь салгаж, амьдын хагацал үзүүлэхийг хүсээгүй. Эзэн Абрахамыг хутгаа далайх хүртэл харсан. Тэгээд Абрахам Өөрт нь амин голоосоо үнэнч болохыг нь батлан харжээ. Тэгвэл биднээс ийм чанарыг харж байгаа болов уу?

Элч Паул эхний захидал дээрээ Коринтын чуулганд нэгэн зүйлийг хийх заавар өгсөн атлаа хоёрдугаар захидал дээрээ болиулсан байдаг. Паул тэр чуулганд болих тушаал өгснийхөө дараа маш чухал мэдэгдэл хийсэн байна:

Та нар бүх зүйлд дуулгавартай байдаг эсэхийн нотолгоог чинь мэдэхийн тулд би ийнхүү бичлээ (2Коринт 2:9).

Паул энэ тушаалыг ганц л зорилгоор өгчээ: Тэднийг эрх мэдэлд нь захирагдах эсэхийг харахын тулд. Надад олон жил пастораар үйлчилсэн, нэгэн ухаантай найз бий. Тэрбээр “Жон, ажилчид чинь аль хэр захирагдахыг олж мэдмээр байвал, тэдэнд ямар ч утгагүй чиглүүлэг өг. Тэгмэгц нэг их удалгүй тэрслүү хүмүүс гоншигнож эхэлнэ. Тэр цагт би тэр хүмүүсийг цэгцлээд, дараа нь хэвийн ажиллагааны чиглүүлэг өгдөг” гэж хэлж билээ.

Хүмүүс өөрийнх нь үгийг бүх талаараа дагах эсэхийг харахын тулд л Паул нөгөө тушаалыг өгчээ. Гол үг нь “бүх талаараа”. Тэгэхээр Паул зүгээр ч нэг хэцүү тушаал өгөөгүй байх нь. Хүмүүс нь Паулын тэр хэцүү тушаалыг дагабал, бусад бүх талаараа дагах байв.

Бурхан Абрахам дээр ийм л зүйл үйлджээ. Бурхан Абрахамаас үйлдэх ямар ч боломжгүй зүйлийг шаардсан. Бурхан Абрахамаас хорин таван жил хүлээсээр хүлээж авсан, амьдралынх нь хамгийн үнэтэй зүйлийг буцааж нэхжээ. Абрахам өөрөө тэр зүйлийг хүсээд, бий болгочихоогүй. Бурхан Өөрөө тэр зүйлийг Абрахамд амлан байж заяасан. Абрахамын хувьд өөрийгөө шатаачих нь илүү амар байсан боловч, Бурхан түүний үнэт эрдэнийг л хүсчээ. Абрахам үүнийг л дуулгавартай хийж чадбал, бусад бүх зүйл дээр дуулгавартай дагана!

Манай тэргүүн пасторын шаардсан зүйл тухайн үед миний хувьд биелүүлэхэд хамгийн хэцүү зүйл минь болж таарсан юм. Би үүний төлөө хэдэн сар хичнээн хөдөлмөрлөснийг бүгд мэдэж байв. Би үүнийг төөрсөн сүнснүүдийг Хаанчлалд оруулах амлалт бүхий боломж гэж харж байлаа. Түүнчлэн энэ ажлыг амжилттай гүйцэтгэх эсэхээрээ би хэр ирээдүйтэй залуусын пастор болохоо харуулах байв. Энэ бол Бурханы хүсэл мөн гэдгийг би хүн болгонд зарлачихсан байсан учраас, нэр хүнд маань ч эрсдэлд оров. Уг нь би залбирч байхдаа, Бурханаас энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвшөөрөл хүлээн авсан. Гэтэл энэ бүхэн шалгалт байсныг мэдээгүй юм. Бурханы шалгалт нь бидний зүрхний үнэн мөнгийг илчилтлээ ер нь танигддаггүй.

Тэр үдэшлэг магадгүй олон хүнийг Хаанчлалд оруулах л байсан байх. Гэхдээ Бурхан ажлын гүйцэтгэлээс илүү Өөрийнх нь эрх мэдлийг хүлээн авсан зүрхийг хүсдэг ажээ. Бурхан бол Бурхан. Тэрбээр төөрсөн сүнснүүдийг ямар арга замаар хэрхэн аврахаа мэднэ. Тэгвэл захирагддаг, дуулгавартай зүрхийг гагцхүү ийм л зарчмаар боловсруулдаг ажээ. Учир нь захирагдашгүй зүрхтэй хүн Хаанчлалд орж чадахгүй бөгөөд захирагдашгүй зүрхийг орлох зүйл үгүй.



## ЭРХ МЭДЭЛТНҮҮД НАДААР...?

Энэ амин чухал, хүнд зарчмыг бид зүрхэндээ хадгалах ёстой. Бурхан эрх мэдлээ хүмүүст тохоон томилдог бөгөөд үүнийг юу ч хүчингүй болгохгүй. Гагцхүү удирдагч хүн Бурханы бичигдсэн Үгийг буюу хуулийг шууд зөрчих үед л Бурхан Өөрийн биеэр оролцоно. Бурхан төлөөнийхөө эрх мэдлийг алгасдаггүй. Бид төлөөний эрх мэдлийг алгасаад, би зөвхөн Бурханд л захирагддаг хүн хэмээн гэжиж болно. Тэгвэл Мосе энэ талаар Израилийн овгуудын тэргүүдэд ингэж хэлжээ:

ЭЗЭНий тушаасан үг нь энэ болой. Хэрэв эр хүн сэтгэлээ үүрэгт хүлэхээр ЭЗЭНд ам өчиг өгч, тангараг өргөсөн бол тэр өөрийн үгийг зөрчих ёсгүй. Тэрээр амнаасаа гаргасан бүхний дагуу үйлдэх ёстой. Хэрэв эмэгтэй хүн залуу насандаа эцгийнхээ гэрт өөрийгөө үүрэгт хүлээд, ЭЗЭНд ам өчиг өгөх үед түүний ам өчиг болон сэтгэлээ хүлсэн үүргийг эцэг нь сонсоод, түүнд юу ч хэлэхгүй бол, охины бүх ам өчиг нь батлагдах бөгөөд сэтгэлээ хүлсэн үүрэг бүр нь батлагдах болой. Гэвч *эцэг нь сонссон өдрөө л түүнийг хориглох аваас охины андгай болон сэтгэлээ хүлсэн түүний үүргийн аль нь ч тогтохгүй. Эцэг нь түүнийг хориглосон тул ЭЗЭН тэр охиныг уучлах болно* (Тооллого 30:1-5).

Мосе энэ зарчмыг цааш нь эхнэр, нөхөр хоёр дээр хэрэгжүүлэн, бэхжүүлжээ. Дээдийн дээд бөгөөд шууд эрх мэдэлт Бурхан төлөөнийхөө эрх мэдлийн дэмжсэн зүйлийг дэмжиж, няцаасныг нь няцаадаг. Эзэн төлөөнийхөө эрх мэдлийг хүндэтгэдэг. Залуу эмэгтэй аавынхаа эрх мэдэл дор, эхнэр нь эр нөхрийнхөө эрх мэдэл дор байх тул Бурхан эмэгтэйг чөлөөлөөд, аавтай нь юмуу эр нөхөртэй нь ярилцана.

Бичээсийн ерөнхий зөвлөгөө болох энэ зарчим нь гэр бүлийн нэгж дотор төдийгүй, төлөөний эрх мэдлийн бүх талбар дээр хэрэгжинэ. Дахин хэлэхэд, эрх баригч нар биднээс Бурханы тушаалыг зөрчихийг шаардсан цорын ганц тохиолдол дээр л бид эрх баригчдаа дагахгүй байж болно. Үйлчлэл дээр байгаа хүмүүс: “Пастор надад үүнийг битгий хийгээрэй гэсэн. Гэхдээ тэр Бурханыг сонсохгүй байна. Тиймээс би тойруу замаар хийх л болно” гэж ярих нь даанч харамсаар. Та юу ч гэж сонссон гэж итгэж байж болно. Гэхдээ та дээр буй хүмүүсийнхээ чиглүүлгийг сөрж байгаа бол, Бурхантай Өөртэй нь сөргөлдөж байна гэж мэдээрэй!

Ийм жишээ дуусахгүй. Зүрхэнд маань нэгэнт илчлэл ассан бол, олон асуулт хариу авч, олон асуудал шийдэл олдог юм билээ. Энэ

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

ном залхмаар жишээ, тайлбарын цуврал шиг санагдах учиргүй. Бид Бурханаас өгсөн эрх мэдлийн илчлэлийг мөшгих ёстой. Учир нь Бурхан, Түүний эрх мэдэл хоёр салшгүй. Бурханлагаар захирагдах зарчмыг зүрхэнд чинь суулгаж өгөхийг Бурханаас үнэн голоосоо гуйгаарай гэж би танилцуулга хэсэг дээрээ ятган урамшуулсан. Эс бөгөөс та номынхоо адаг дээр номынхоо эхэнд байснаасаа ч олон эргэлзээтэй хоцорно.

Дараагийн бүлгээрээ эрх мэдэлтнүүдийн шударга бус, харгис хатуу хандлагыг хэрхэн хүлээн авах талаар сурч, энэ тохиолдолд Бурхан бидэнд ямар сүр жавхлантай төлөвлөгөө зэхсэн байдгийг олж мэднэ.

## ШУДАРГА БУС ХАНДЛАГА

*Эмтрэх нь сул дорой болох явдал бус,  
эрх мэдэлд захирагдах явдал юм.*

**Б**урхан Аавд маань бидний дотор нэг бүрчлэн биелүүлэх тодорхой зорилго бий. Энэ зорилго нь таатай, алдартай, амархан замаар биелэхгүй байж болох ч, бидэнд л тустай зүйл юм. Бурхан биднийг эмтлэхийг хүсдэг. Бичээс ч үүнийг тус тас хэлдэг:

Учир нь Та тахилд баярлахгүй. Тийм бишсэн бол би түүнийг өргөхсөн. Та шатаалт тахилыг таалахгүй. Бурханы авах тахил нь эмтэрсэн сүнс юм. Эмтэрсэн, гэмшсэн зүрхийг Бурхан Та жигшихгүй (Дуулал 51:16-17).

ЭЗЭН эмтэрсэн зүрхнүүдэд Ойрхон байх агаад Сүнсээрээ гэмшигчдийг авардаг (Дуулал 34:18).

Эзэнтэй ойр байхад эмтэрсэн зүрхтэй байхаас өөр аргагүй. Энэ мэдээж таагүй үйл явц боловчиг, дараа нь эдлэх Бурханы оршихуйн дэргэд юу ч биш гэмээр. Давид үүнийг хар залуудаа л сурчээ. Давидын зүрх эмтэрсний дараа түүний амьдралд юу ирснийг магтаалаас нь харж болно. Энэ бүхнийг тахилын амьдралаар юмуу өргөл барьцаар олоогүй, харин дуулгавартай амьдралаар олжээ.

## **Эмтэрсэн байх нь эрх мэдэлтэй хамаатай**

Тайлбарлахыг минь болгооно уу. Байлдааны морийг номхруулахаас нааш тулаанд хэрэглэж чадахгүй. Хэдийгээр тэр адуу бусад морьдоосоо хурдтай, хүчтэй, чадвартай боловч, түүнийг номхруулахаас нааш тулаанд оролцуулах боломжгүй. Түүнээс чадал муутай жүчээний бусад морьд байлдахаар явж байхад, тэр зэрлэг догшин адгуус ганцаараа үлдэнэ. Номхруулах нь сул дорой болгоно гэсэн үг бус, харин үгэнд ордог болгоно гэсэн үг юм.

Морийг эзэн нь л унана. Эзэн нь морио сайтар сургабал, морь нь ямар ч нөхцөлд итгэмжтэй, найдвартай байж чадна. Бууны сум исгэрэн нисэлдэх, байлдааны халуун цэг дээр итгэлт хүлэг нь дальдчихгүй. Илд сүх цавчилдах дайны талбар дээр итгэлт хүлэг ухрахгүй. Буу тас тас хийж, их буу пүн пан хийж байхад, хүлэг эзнийхээ хүслээс гажихгүй. Тэрбээр эзэндээ бат захирагдана. Хүлэг эзнийхээ тушаалыг биелүүлэхийн төлөө явахаас биш, амиа бодож, ашиг хонжоо хайхгүй.

Сургах үйл явц нь хувь хүн тус бүр дээр Эзэний зохиосон жорын дагуу ялгаатай байна. Энэ үйл явц хэзээ бүрэн болохыг Эзэн л мэдэх бөгөөд та танд зориулсан үйлчлэлийн загварын төлөө л бэлтгэгдэнэ. Шинэ төвшин болгон эмтэрлийн шинэ тойргийг авчирна.

Би сүүлд туулж гарсан үйл явдлуудаа сайн санаж байна. Тэр болгонд дандаа л өөрийгөө үйлчлэлийнхээ дараагийн төвшинд бэлэн мэт санаадаг байсан ч бас л түүхийгээрээ байдаг байж билээ. Их л итгэлтэйгээр: “Аугаа хүчирхэг Бурхан минь, би Танд бүрэн захирагдаж байна. Таны дуудсан дуудлагад бэлэн гэдгээ мэдэж байна” гэж ирээд л ам бардам ярина. Гэтэл эргэн тойрны маань төлөвшсөн итгэгч нар намайг яагаа ч үгүй байгааг мэддэг байж билээ. Тэгээд мэдээж, би эрхийнхээ төлөө тэмцэх дараагийн раунддаа орон, тийчигнэн, савсагнаж эхэлнэ.

## **Тэгвэл харгис удирдагч нарын тухайд яах вэ?**

Морьдын адил бидний сургагдах үйл явц ч эрх мэдэлд захирагдахтай маань холбоотой. Бурхан бидний хүн нэг бүрт хувьчилсан төгс үйл явцсыг зохиодог бөгөөд энэ үйл явц нь ямагт тодорхой хэмжээний удирдлагын хэлбэрт хамаатдаг. Иймээс л Петр:

## ШУДАРГА БУС ХАНДЛАГА

Эзэний төлөө өөрсдийгөө хүний бий болгосон аливаа бүтцэд захируул. Эрх мэдэл бүхий нэгэн болох хаанд ч юмуу...Боолууд аа, бүхий л хүндлэлээр зөвхөн сайн, дөлгөөн төдийгүй, бас гажууд эздэдээ ч захирагд (1Петр 2:13, 18) гэж хэлжээ.

Үүнийг орчин цаг дээр буулгаж үзье. Зарц нарыг ажилчид, оюутнууд, чуулганы гишүүд, иргэд хэмээн үзэж болно. Эзэд нь ажил олгогч нар, багш нар, дасгалжуулагч нар, удирдагч нар, эрх баригчид байж болно. Бид ихэнхдээ л зөөлөн ааштай, сайн удирдагч нартай таардаг бөгөөд тэднийг хайрлаж, захирагдах амархан байдаг. Гэтэл Бурхан биднийг сайн удирдагч нарт төдийгүй, харгис удирдагч нарт ч захирагд гэжээ!

Харгисийг Грекээр сколиос гэжээ. Тайерийн Грек хэлний толь бичиг дээр энэ үгийг “тахир, завхарсан, ёрын, шударга бус, түрэмгий” гэдэг. Вайнын толь бичигт энэ үгийг “дарангуйлалтай юмуу шударга бус эзэдтэй” холбон тайлбарладаг. Эзэн биднийг ийм удирдагч нарт захирагд гэж байгаа юм уу?

Бүгдээрээ өөр хэдэн орчуулгыг авч үзье. Нью Сентри Вержн дээр “Сайн бөгөөд эелдэг төдийгүй, шударга бус хүмүүст ч...” гэжээ. Орчин цагийн Англи Библи дээр “Үүнийг бодлоготой бөгөөд эелдэгт төдийгүй мөн харгис хүмүүст ч үйлд” гэдэг. Нью Американ Стандарт Библи “Сайн бөгөөд эелдэгт төдийгүй мөн ухаан муут хүмүүст ч...” гэдэг. Энэ тушаалыг хайхралгүй өнгөрч болохгүй учраас, үүн доторх Бурханы ухааныг хайя.

Петрийн үг амар болж байна гэхээсээ илүү улам л хүндрээд байна. Тэрбээр цааш нь “Учир нь хүн *шударга бусаар зовоходоо* Бурханд ханддаг мөс чанараасаа болж тэвчвэл энэ нь нигүүлсэл юм” (1Петр 2:19) гэжээ.

Одоо түр зогсоод, саяын уншсан зүйлээ эргэцүүлнэ үү. Бид бүгдээрээ Бурханд таалагдахыг хүсдэг. Энэ нь Бурханы жинхэнэ хүү, охин болгоны хүсэл болой. Аавд юу таалагддаг вэ? Шударга бус хандлагын өдөөс зөвөөр хариу үйлдэх үйлдэл таалагддаг.

Манай гэрт тохиолдсон нэг явдал санаанд орж байна. Нэг хүү маань түүнд дүүгээс нь бага хувь оногдлоо гэж үзээд: “Ээж ээ, наадах чинь шударга бус байна!” хэмээн эсэргүүцлээ илэрхийлжээ.

Тэгтэл гэргий маань: “Хүү минь, амьдрал угаасаа шударга бус!” хэмээн тун амарлингуй хариулсан юм.

Хүү маань ээж рүүгээ: “Та яаж ингэж хэлж чадаж байна аа? Та чинь миний ээж биз дээ?” гэх шиг л харж билээ.

Гэтэл Лиза: “Есүс ямар ч буруугүй байж, бидний шийтгэлийг Өөр дээрээ аваад, загалмай дээр үхсэн нь шударга хэрэг үү?” гэж асуув.

Хүү маань тэр цэц ухааныг ойлгосон болтой, чимээгүй болсон юм.

## Христийн хувийн үлгэр жишээ

Петр цааш нь “Учир нь та нар үүнд дуудагдсан билээ” гэжээ. Би энэ эшлэлээс заах бүрийдээ, хүмүүсийг над руу харж бай гэж байгаад, баяртай нь аргагүй: “Бүгдээрээ “Энэ миний дуудлага!” гэж хэлцгээе!” гэдэг юм. Бид дуудлагын талаар их ярьдаг. Тэгвэл нэг дуудлага маань энэ байна. Петр “Яагаад гэвэл та нарыг мөрөөрөө дагуулахын тулд та нарт үлгэр дуурайл үлдээн, Христ та нарын төлөө зовлон эдэлсэн” (1Петр 2:21) гэж хэлснийг харна уу.

Петр яаж зовсон бэ? Петр өмнөх эшлэлд нь “төлөөний эрх мэдэлтнүүдийн зүгээс ирэх шударга бус хандлагын талаар тайлбарласан. Заримдаа Бурхан биднийг яг л Давид, Иосеф, Даниел, элч Паул тэргүүтэй хүмүүсийн адил эрх мэдэлтнүүдийн зүгээс ирэх бурангуй явдалд өртүүлдэг. Тэгвэл бид энэ үед зөвөөр хариу үйлдэх дуудлагатай бөгөөд үүнийг хэрхэн хийхийг Есүс бидэнд Өөрийн биеэр үлгэрлэн харуулсан билээ.

Та “Харгис удирдагч нарын бурангуй хандлагаас үүдэх зовлон ямар ач тустай юм бэ?” хэмээн гайхаж болзошгүй. Энэ санаанд ямар ч учир зүй байхгүй учраас, хүний жирийн ухаантай нийцэхгүй байна. Тийм боловч ийм хандлагаар дамжуулан Бурханы цэц ухаан бидний зүрхийг гурван замаар хэлбэршүүлдэг юм. Нэгдүгээрт - энэ нь Христийн шударга шүүхэд орон зай өгдөг. Хоёрдугаарт - энэ нь бидний дотор Христийн зан чанарыг хөгжүүлдэг. Гуравдугаарт - бид ийм хандлагад захирагдсанаараа Бурханыг алдаршуулдаг.

Паул эрх баригчдад захирагдах талаарх яриагаа ийм үгээр эхлүүлжээ: “Хайртууд минь, хэзээ ч өөрийн өшөө хонзонг бүү ав. Харин Бурханы уур хилэнд зай гарга. Учир нь “Өшөө авалт нь Минийх, Би буцааж төлнө” гэж Эзэн хэлэв” гэж бичигджээ” (Ром 12:19). Хамгаалах, засварлах, өмгөөлөх зэрэг бүх зохистой хариу нь Бурханаас гарах болтугай. Өөрийнхөөрөө зүтгэж байгаа хүмүүс нь Христ доторх даруу зангүй хүмүүс юм.

Дэлхий дээр Есүс шиг эрх мэдлийг эзэгнэх хүн байхгүй боловч, Тэрбээр эрх баригчдын өмнө Өөрийгөө өмгөөлөөгүй билээ. Есүсийн шүүхийн талаар эш татсан Петрийн яг тухайн нөхцөл рүү орцгооё: “Ахлах тахилч нар Есүсийг олон зүйлд буруутгав (буруутгасан ч, Тэр юу ч хэлсэнгүй)” (Марк 15:3).

Шүүх танхимыг төсөөлнө үү - гэхдээ зүгээр нэг шүүх танхим биш - харин хамгийн дээд шүүх танхим - гэрчийн хэлсэн үг бүрийг Есүсийн эсрэг ашигладаг газар. Гэрч нар нь жинтэй үгтэй, нөлөө бүхий хүмүүс байсан ч, хэлж ярьсан зүйлс нь ямар ч үнэний оргүй байв. Тэд шал худлаа ярьсан ч, Есүс яллагч нарын өмнө Өөрийгөө зөвтгөлгүй, чимээгүй байв! “Пилат Түүнээс дахин асууж, —Та юу ч хариулахгүй юу? Тэд ямар олон зүйл Таны эсрэг тулгаж байгааг хараач гэв. Гэвч Есүс юу ч хариулсангүйд Пилат гайхав” (Марк 15:4-5).

Пилат бол тухайн газрын хамгийн дээд шүүгч байв. Хүмүүс шүүгдэж, шийтгэлээс зайлсхийхийн тулд өөрийгөө яаж өмгөөлж байгааг Пилат харахаараа л нэг болсон. Учир нь яллагдсан хүмүүс шоронд орох юмуу цаазлуулдаг байв. Давж заалдах илүү дээд шатны шүүх байхгүй. Тиймээс ч яллагдаж буй хүн дуугүй зогсохыг Пилат хэзээ ч үзээгүй. Шашны удирдагч нар атаархандаа л Есүсийг барьж өгсөн бөгөөд Түүнд ялын дээд хэмжээ оноож, цаазлуулахыг хүсч байгааг Пилат мэдэрсэн. Есүс тэдний яриад байгаа шиг Хүн биш гэдгийг Пилат мэдэж байсан. Тийм байтал Есүс Өөрийгөө өмөөрөөгүй. Есүсийн тайван байдал эрх баригчийг гайхшруулжээ.

Есүс яагаад Өөрийгөө өмгөөлөөгүй вэ? Аавынхаа шүүхийн дор үлдэж, тийнхүү Түүний хамгаалалт дор байх гэж л тэр. Петр “Тэр зүхэгдэж байхдаа, хариуд нь зүхээгүй. Тэр зовон тарчилж байхдаа заналхийлээгүй, харин шударгаар шүүдэг Нэгэнд Өөрийгөө даатгасаар байлаа” (1Петр 2:23) гэсэн.

Бид өөрийгөө хамгаалахаас татгалзахдаа, Бурханы нигүүлслийн болоод шүүхийн мутар дор байна. Харин Бурханы мутраас илүү аюулгүй газар байхгүй: “Хэн Бурханы сонгосон хүмүүсийг буруутгах вэ? Бурхан бол зөвтгөгч Нэгэн мөн” (Ром 8:33).

Тэгвэл эсрэгээрээ - өөрийгөө өмгөөлдөг хүмүүс нь яллагч нарынхаа хууль, шүүхийн дор орж, тийнхүү тэнгэрлэг оролцоог хаадаг. Би нэг удаа эрх мэдэлтнээс биеэ өмгөөлснөө санаж байна. Гэтэл дараа нь Бурхан зүрхэнд минь товч үзэгдэл үзүүлсэн юм. Би дэргэд минь нуруугаа үүрэн зогсож буй Эзэнийг харав. Бурхан надад хэрэгцээтэй

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

туслалцааг илгээхээс татгалзжээ. Харин намайг өөрийгөө зөвтгөхөө болих үед Эзэн миний төлөө ажиллаж эхэлсэн юм.

Есүс төлөөний удирдагч нарын өмнө зогсож байхдаа ч, хараагаа дээдийн дээд Шүүгч дээр л тавьсаар байжээ. Хааны зүрх Эзэний мутарт байдгийг санаарай. Есүс Өөрийгөө өмгөөлөхөөс татгалзсанаараа, энэ бүх үйл явдал дундуур Бурханы өмгөөлөл дор үлджээ. Та өөрийгөө зөвтгөж, өмгөөлж эхлэх эгшиндээ яллагчийгаа шүүгчийн байр суурин дээр гаргана. Та өмгөөлөл авах сүнсний эрхээ алдана. Учир нь та эрх мэдэлтний шүүмжлэлд хариу үзүүлэх үед тэрбээр сүнсний ертөнцөд таны дээр заларна. Та өөрийгөө аль хэр өмгөөлнө - түүний нөлөө тэр хэмжээгээр л өснө. Та өөрийгөө өмгөөлөх гэж оролдохдоо, яллагчийнхаа эрхшээл дор явж орно. Энэ шалтгаанаар Есүс биднийг:

Замд хамт яваа дээрээ арцалдагчтайгаа аль болох түргэн сайд. Эс тэгвэл арцалдагч чинь чамайг шүүгчид өгч, шүүгч түшмэлд хүргэж, чи шоронд хаягдах вий. Үнэнээр Би та нарт хэлье, чи эцсийн зоосыг төлтлөө тэндээс гарахгүй (Матай 5:25-26) хэмээн ятгасан билээ.

Энэхүү сургаалт үлгэрт зааснаар, та яллагчийнхаа нэхсэн нөхөн төлбөрийг барагдуулах ёстой болох нь ээ. Таны зүг гаргасан гомдол нь их байх тусам, танд үзүүлэх өршөөл нь бага байх нь байна. Шударга байна уу, үгүй юу хамаагүй - тэрбээр танаас эцсийн зоосоо авч байж л сална.

## ХҮҮХДИЙН ИТГЭЛ

Ууган хүү Аддисон маань гуравдугаар ангид байхдаа, хоолон дээрээ сургууль дээрх асуудлынхаа талаар Лиза бид хоёрт ярьсан юм. Хүүд маань нэг багш нь дургүй байгаад байх шиг санагджээ. Багш нь түүнд дургүйцэж, түүнийг хичээл дээрх яриа, эмх замбараагүй байдалд буруутгажээ. Энэ байдал даамжирсаар, бид хоёр Аддисоны талаар багшаас нь сөрөг зурвас хүлээн авав. Аддисон маань маш ухаалаг, гярхай хүүхэд учраас, түүний хувьд сөрөг зурвас бичүүлнэ гэдэг байж боломгүй зүйл байжээ. Тэрбээр нулимс дуслуулсаар аав, ээж хоёртоо гутрал, айдсаа ярьсан юм.

Бид хоёр ч хүүдээ итгэж байгаагаа хэлээд, яг юу болсныг дэлгэрүүлж асуутал, хүү маань: “Багш өөр хүүхэд оролцсон байсан ч, намайг л буруутгадаг. Би хийгээгүй байсан ч, буруутай болдог.



Өнөөдөр л гэхэд, би юу ч яриагүй, харин миний хажуудах хүүхэд юм яриад, инээгээд байсан. Тэгсэн чинь багш эргэж хараад, над руу хашхирсан” гэв. Тэрбээр энэ шударга бус явдалд гоморхон, өмөлзөж байлаа. Есхөн настай жаалд энэ бүхэн үнэхээр гомдмоор байжээ.

Бусад багш нар нь Аддисоныг онцсайн хүмүүжилтэй хүү гэдэг болохоор, энэ явдал ганцхан тэр багшийн ангид л тохиолдсон болохыг би мэдэж байлаа. Лиза хүүгээ тайтгаруулах гэж оролдох хоорондуур би: “Багш чинь чамайг засах үед чи юу гэж хариулсан бэ?” гэж асуулаа.

Аддисоны нүд бамбар шиг ассанаа: “Би багшдаа “Би яриагүй, тэр хоёр хүүхэд ярьсан гэж хэлсэн!” гэлээ.

Тэгэхээр нь би: “Хүн чамайг засч байхад, ингэж хариулах нь зөв билүү?” гэж асуулаа.

Аддисон: “Зөв, би угаасаа яриагүйм чинь!” гэлээ.

Би хүү рүүгээ хараад: “Тэгвэл, асуудал чинь үүнд л байна. Чи эрх мэдэлтний өмнө өөрийгөө зөвтгөөд, өөрийгөө өмгөөлөх юм бол, Бурхан чамайг хамгаалахгүй” гэж хэлэв.

Тэгээд хүүдээ энэ бүлгийн бичээсийг тайлбарлаад, илүү ойлгомжтой болгохын тулд нөгөө оффис менежертэй тохиолдсон дараах явдлыг (Энэ талаар өнгөрсөн бүлэгт дурьдсан) ярьж өгсөн юм.

## **Дарга чинь чамайг хорлохоор шийдэх үед**

Даргын маань хүү манай залуусын бүлэгт явдаг байв. Би ариун амьдрал, залбирал, Эзэнд захирагдах талаар хүчтэй заадаг байлаа. Үүний ачаар олон залуус өөрчлөгдөв. Нэг удаа тэр хүү манай гэргий дээр уйлагнасаар очоод, гэрт нь аймшигтай бурханлаг бус үйл явдал болж байхад, яаж цэвэр, ариун амьдрах юм бэ гэж асуужээ. Тэгээд нарийн ширийн юмсаа ярихад нь би эцэг нь яагаад намайг тэгтэл эсэргүүцэнийг ойлгосон юм.

Хэдэн сарын дараа би ажлаас халагдах гэж байгаагаа дөрвийн дөрвөн хүнээс олж мэдэв. Тэгээд энэ мэдээг эрэн сурвалжилсаар яваад, хүү дээр нь очтол, тэрбээр энэ тухай ааваасаа дуулснаа хэлэв.

Би аав дээр нь явж очтол, тэрбээр энэ мэдээг хүлээн зөвшөөрсөн боловч, тэргүүн пастор л чамайг халах санаатай байгаа хэмээн пасторыг буруутгасан юм. Өдөр хоногууд өнгөрсөөр, байдал хурцадсаар байв. Гэр бүл маань явах, үлдэхээ мэдэхгүй, байнгын түгшүүр дор байв. Бид орон сууц авчихсан, гэргий минь жирэмсэн,

дээрээс нь мөнгөгүй, очих газаргүй байлаа. Би танилцуулгаа ийш тийш нь илгээмээргүй байв. Учир нь Бурхан намайг тэнд авчирсан болохоор, ямар ч хувилбаргүй үлдэнэ гэдэгтээ итгэж байсан юм. Гэтэл гэргий минь түгшиж: “Жон, тэд чамайг хална. Хүмүүс бүгдээрээ л тэгж ярьж байна” гээд, ямар нэг алхам хийхийг ятгаж байв.

Лизагийн зөв байлаа. Тэргүүн пастор эцэстээ намайг халах шийдвэр гаргав. Нэгэн Бүтэн сайны өглөөний цуглаан дээр пастор залуусын бүлэгт томоохон өөрчлөлт гарах талаар зарлалаа. Энэ хооронд би түүнтэй нэг ч уулзаагүй байв. Тэгтэл пастор маргааш нь надтай уулзах цаг товлосноо мэдэгдэв. Бурхан надад: “Биеэ битгий өмөөрөөрэй!” л гэлээ.

Маргааш нь пасторын өрөөнд ортол, тэрбээр ганцаараа байж таарав. Тэгээд: “Жон, Бурхан чамайг ийш нь илгээсэн. Тиймээс би чамайг явуулахгүй” гэлээ. Бодлоо өөрчилсөн болтой. Эцсийн эгшинд Бурхан намайг хамгаалсанд би уужрав. Тэгтэл пастор: “Оффис менежер яагаад чамайг халуулах гээд байгаа юм?” гэлээ. Би ч мэдэхгүй л гэв. Тэгээд бүх асуудлыг амар тайвнаар шийдэхийн төлөө ажиллахаа пастортаа амлав.

Энэ уулзалтын дараа би оффис менежерээс хамаг санаагаа илчлэн хүлээсэн захидал хүлээн авсан юм. Би ч тэр захидлыг нь тэргүүн пастор дээрээ бариад ороход бэлэн байлаа. Түүний ар нуруугаар юу болж байдгийг мэдээсэй гэж хүсэв. Тэгээд дотоодын зөрчлөө ялах гэж дөчин таван минут орчим залбиран, наашаа цаашаа холхилоо. Би дотроо “Бурхан минь, энэ шударга бус хүнийг илчлэх ёстой. Ийм хүмүүс үйлчлэлийг сүйрүүлдэг. Түүнийг ямар хүн болохыг би тэргүүн пасторт илчлэх ёстой!” хэмээн маргаж байлаа. Би энэ үйлдлээ “Би худлаа хэлээгүй, үнэнийг хэлэх гэж байна. Энэ бол зүгээр сэтгэл хөдлөл биш. Энэ хүнийг таслан зогсоохгүй бол, завхарсан үйлдлээрээ чуулганыг самарч мэднэ” гэдэг санаагаараа зөвтгөж байлаа.

Тэгээд сүүлдээ: “Бурхан минь, Та үүнийг хүсэхгүй байгаа, тийм үү?” хэмээн бувтналаа. Үүнийг хэлмэгц, Бурханы амар тайван зүрхэнд минь халин орж ирэв. Би ч толгой сэгсрэн гайхширлаа. Би Бурхан надаар ямар нэг юм хийлгэхийг хүсээгүйг мэдсэн болохоороо, тэр нотолгоог утгасан юм. Хожим тэр явдлыг бодитоор харахдаа, би бусдыг хамгаалахаасаа илүүтэй зүгээр л өөрийгөө өмгөөлж, өшөө авахыг л хүсч байснаа ойлгосон юм. Би өөрөө өөртөө амиа боддоггүй хүн гэдгээ л итгүүлэхийг хүсчээ. Би үнэнийг өгүүлж байсан ч, сэдэл маань цэвэр бус байж.

Цаг хугацаа өнгөрсөөр, нэг удаа би ажил эхлэхээс өмнө чуулганыхаа гадаа уулан дээр залбирч байтал, нөгөө хүн машинаасаа бууж яваа харагдав. Бурхан намайг даруу сэтгэлээр очиж уулзаарай гэлээ. Би ч шууд л өөрийгөө өмгөөллөө: “Үгүй ээ, Эзэн минь. Тэр хүн над дээр өөрөө ирэх ёстой. Тэр л бөөн асуудал тарьсан.” Тэгээд үргэлжлүүлэн залбирсан ч, Бурхан чимээгүй байв. Хорин минутын дараа Эзэн намайг шууд түүн дээр очоод, өөрийгөө даруусга гэлээ. Бурхан ярьж байгааг би мэдэж байлаа. Би тэр хүн рүү утасдаад, өрөөнд нь очлоо. Гэхдээ хэлсэн үг, ярьсан маяг маань Бурхан надтай ярилцахаас өмнө байсан байдлаас минь тэс өөр байв. Би түүнийг шүүмжилж, шүүж байсандаа үнэн голоосоо уучлал эрлээ. Тэр ч зөөлрөөд, бид хоёр хэсэг ярилцав. Тэр өдрөөс хойш тэр хүн намайг дайрахаа больсон юм.

Зургаан сарын дараа намайг хотод эзгүй байх хойгуур тэр хүний үйлдсэн бүх буруу тэргүүн пасторт хүрчээ. Гэтэл тэрбээр миний бодож байснаас ч аймшигтай зүйлс үйлдсэн байв. Тэгээд надад хийх гэж байсан бүхэн нь өөрт нь тохиосон юм. Гэхдээ би үүнд нь баярлаагүй ээ. Би тэр хүний төлөө болоод гэр бүлийнх нь төлөө асар их гашуудсан юм. Би түүний шаналлыг ойлгож байв. Учир нь би өөрөө түүний гарт яг тэгж шаналж явсан юм. Гэхдээ би тэр хүнийг зургаан сарын өмнө суллаж явуулсан учраас, түүнийг хайрлаж, түүнийг зовоосой гэж хүсээгүй билээ.

Би тэр чуулганд дахин арван нэгэн жил явсан бөгөөд надад “үйлчлээч!” гэсэн хүсэлт их ирдэг байв. Над дээр тэр хүний авчирсан ичгүүр зайлж, хүндэтгэлээр солигджээ. Эргээд харахад, би тэр бэрх цагаар дамжихдаа өссөнөө ойлгодог бөгөөд эцэст нь Бурхан намайг миний талаар олон худлаа мэдээлэл хүлээж авдаг байсан хүмүүсийн нүүрэн дээр өргөсөн билээ. Бурхан Аав маань Есүсийг биеэ өмөөрдөггүй, дуулгавартай байдлынх нь улмаас өндөрт өргөсөн шигээ Есүсийг даган дууриаж буй хүүхдүүдээ ч бас өргөх болно.

## Оны шилдэг сурагч

Аддисонтай Бичээсийг болоод энэ түүхийг хуваалцсаныхаа дараа би хүүдээ: “Миний хүүд сонголт бий. Чи өөрийгөө өмгөөлсөөр, багшаараа шүүгдэж болно. Эсвэл багшийнхаа буруутгалд бурханлаг зангаар хариулаагүй болохоо ойлгон, өөрийгөө даруусгаад, багшийнхаа эрх мэдлийг хүлээн зөвшөөрч, түүнд хүндэтгэлгүй хандсандаа уучлал

гуйгаад, Бурханаар шийдүүлбэл яаж байна?” гэлээ.

Аддисон: “Намайг хийгээгүй хэргийн маань төлөө буруутгаад байвал, яах юм?” гэлээ.

–“Бурхан чамайг өмгөөлөг! Чи өөрийгөө өмгөөлж чадсан уу?”

Аддисон: “Чадаагүй. Бурхан намайг өмгөөлөөсэй гэж хүсч байна” гэж хариуллаа.

Маргааш нь Аддисон өөрийгөө даруусгаад, багш дээрээ явж очоод, өөдөөс нь өрөвзсөндөө уучлал гуйжээ.

Багш нь түүнийг уучилж, дараагийн долоо хоногт нь Аддисон маань долоо хоногийнхоо шилдэг сурагч болсон юм. Аддисонд дахиж асуудал тулгараагүй ээ. Хүү минь эцэстээ захирлаасаа тэр жилийнхээ шилдэг сурагчийн шагналыг гардан авч билээ.

Есөн настай хүүхэд өөрийгөө даруу болгоод, хямрал дунд Бурханы цэц ухааныг батлаж чадсан бол, бид бүр ч тэгэх ёстой бус уу? Миний бодлоор энэ түүх “Иймээс хэн өөрийгөө энэ хүүхэд адил өчүүхэн болгоно, тэр нь тэнгэрийн хаанчлалд хамгийн агуу нь болно” (Матай 18:4) гэсэн Есүсийн үгийг дүрслэх шиг.

## **Давид ухаан муутай эрх баригчтай тулгарсан нь**

Аддисон маань Иессегийн хүү Давидын сурсан зүйлийг сурчээ. Бурхан бол шударга шүүгч бөгөөд бид эрх баригчдаас ирэх шударга бус хандлагыг Түүний мутарт даатгабал, Бурхан хэзээд шударгаар шүүнэ. Бид Давидын тухай ярихдаа, түүнийг диавол биш, Бурхан Өөрөө ухаан муутайгаар барахгүй, эцэстээ харгис дарангуйлагч болж хувирсан Саул гэдэг хааны дор тавьсныг мартаж болохгүй.

Энэ бүхэн нь тэр хоёрыг Давидыг Бурханы ард түмний дараагийн хаанаар томилсон Израилийн тэргүүн эш үзүүлэгч Самуелтай уулзахаас ч өмнө эхэлсэн байдаг. Давид ч: “*Энэ чинь одоогийн хааныг томилсон хүн. Тиймээс би хаан болох нь!*” хэмээн хөөрсөн байх.

Саул Бурханд дуулгаваргүй загнаснаасаа болоод муу сүнсэнд тамлуулдаг байсан учраас, хэн нэг хүн босоо ятга тоглох үед л тайтгардаг байжээ. Тиймээс албатууд нь Саулын дэргэд суугаад, түүнд үйлчлэх залуу хүний эрэлд гарав. Тэгтэл нэг албат нь Иессегийн хүү Давидыг санал болгожээ. Саул хаан Давидыг авчруулж, өөртөө үйлчлүүлэхээр албатуудаа илгээв. Давид дотроо “*Бурхан эш*

*үзүүлэгчээрээ дамжуулан амлалтаа биелүүлэх гэж байх шиг байна. Энэ чинь нэвтрэх орц” гэж бодсон байх.*

Цаг хугацаа өнгөрсөөр, нэг өдөр Иессе Филистинчүүдтэй байлдаж байгаа том хөвгүүддээ жаал зугаа хүнс хүргүүлэхээр Давидыг гүйлгэв. Давид галын шугам дээр ирээд, Филистиний аварга цэрэг Голиат дөчин өдрийн турш Бурханы цэргүүдийг элэглэж байхыг олж мэджээ. Энэ аймшигтай цэргийг алсан хүнд Саул хаан охиноо өгөхөөр амлаад байгааг ч мэдэв. Тэгээд Давид хаан дээр ороод, тулалдах зөвшөөрөл хүссэн. Дараа нь Голиатыг алаад, Саулын охиныг авсан. Тэрбээр Саулын тааллыг олон, хүргэн нь болохоор сүй тавив.

Саулын ууган хүү Ионатан Давидтай андлалцаж, мөнхийн гэрээ тогтоов. Саулын Давидаар хийлгэх гэсэн бүхнийг Бурхан ерөөж, хөгжин цэцэглүүлж байлаа. Хаан ч хөвгүүдийнхээ хамт Давидыг ширээндээ урьжээ. Хэрэг явдал сайхан өрнөж, Давид ч баясч байсан байх. Давид ордонд аж төрж, хаантайгаа нэг ширээнээс зооглож, хааны охинтой гэрлэж, хааны ууган хүү Ионатантай андлалцаж, бүх ажил үйлсдээ амжилттай байж, ард түмний тааллыг ч олж байв. Эш үзүүлэл нүдэн дээр нь л дэлбээлж байлаа. Саул ч Давидыг бусад зарц нараасаа илүү таалж, бараг л зөвлөж, сургаад, нэг өдөр өндөр хүндэтгэлтэйгээр сэнтийд залах нь гэмээр л харагдаж байв. Давид Бурханы сайн сайхан, итгэмжтэй чанар дотор жаргаж байлаа.

## Гэнэтийн өөрчлөлт

Гэтэл нэг л өдөр энэ бүхэн өөрчлөгдөв. Саул, Давид хоёрыг тулаанаас зэрэгцэн ирж явтал, Израилийн хотуудын эмэгтэйчүүд: “Саул мянга мянгыг, Давид хэдэн арван мянгыг хөнөөв” хэмээн дуулж, бүжсээр угтжээ. Энэ явдал Саулыг гонсойлгож, тэр өдрөөс хойш тэрбээр Давидад хорсов. Саул Давид руу жад шидэж, түүнийг хороох санаа сэдэв. Саул Бурхан өөрийг нь орхиж, Давидтай хамт байх болсныг мэдсэн учраас, хорссон гэж Библи хэлдэг. Давид амиа аврахын тулд - зугтчих өөр газар байгаагүй учраас - цөл рүү зугтжээ. Давид “Амлалт дэлгэрч байснаа одоо хагдарч, удирдагч маань намайг алах нь. Би яах ёстой вэ? Саул чинь Бурханы тосолсон зарц. Ийм хүн намайг эсэргүүцэж байхад, би яаж амьд гарах билээ? Тэр бол хаан, Бурханы ард түмнийг захирдаг Бурханы хүн. Бурхан яагаад надад ийм зүйл зөвшөөрнө вэ?” гэж бодоо байх.

Одоо Саул Давидыг алах гэсэн ганц л зорилгоор Израилийн гурван мянган шилдэг дайчдыг дагуулан, цөлөөс цөл рүү, нэг агуйгаас нөгөө рүү элдэн хөөв. Одоо амиа аврах гэж зугтаж яваа Давидад Бурханы нөгөө амлалт зүгээр л сүүдэр болжээ. Одоо Давид хааны ордонд амьдрахаа больсон, хааны ширээнээс хооллохоо больсон. Тэр хүйтэн нойтон агуйд хоног төөрүүлж, цөлийн зэрлэг амьтдын сэгээр шахуу хооллож явсан. Тэр одоо хааны дэргэд оршилгүй, нэгэнтээ мөр зэрэгцэн тулалдаж явсан цэргүүдээсээ зугтаж явна. Түүнд дулаан хөнжил, албатууд, хааны тусгай хангамж байхгүй. Гэргий нь хүртэл хүнийх болсон.

Бурханы зөвшөөрсөн удирдагч яаж ийм юм хийдэг байна аа? Давид айдас, гутрал, янз бүрийн төөрөгдөлтэй тэмцэлдэж л байсан байх. *“Бурхан яагаад энэ талаар юу ч хийхгүй байна аа? Тэр намайг ер нь тоодог болов уу? Түүний амлалт яав? Тэр яагаад гэрээ байгуулсан хүмүүсийнхээ дээр ийм харгис хатуу удирдагчийг тавьдаг байна аа?”*

Энэ хооронд Саул улангасан галзуурч, Давидыг ямар ч үнээр хамаагүй алахыг хүссэн. Ноб хотын тахилч нар Давидыг хонуулж, хоол ундаар ханган, түүнд Голиатын илдийг өгчээ. Тэд Давидыг Саулаас оргож явааг нь мэдэлгүй, хааныхаа даалгаврыг биелүүлж яваа л гэж боджээ. Тэд Давидыг Эзэнд даатган залбираад, гаргаж өгөв.

Саул энэ тухай мэдээд хилэгнэн, ямар ч гэмгүй наян таван тахилчийг эрчүүд, эмэгтэйчүүд, хүүхэд, нялхас, мал сүрэгтэй нь илдээр хөнөөсөн. Саул Амалекчууд дээр гүйцэтгэх ёстой байсан шүүхээ гэмгүй хүмүүс дээр гүйцэтгэжээ. Энэ үед ийм хүнийг сонгосон Бурханы сонголтыг ёстой ойлгох аргагүй. Бурхан яаж алуурчин хүн дээр Сүнсээ тавив аа?

Олон хүн Саулыг ард түмний сонголт байсан, Давидыг Бурханы сонголт байсан гэдэг. Гэхдээ Бурхан харгис хатуу хүнийг удирдлагад тавьж чадахгүй гэдэг итгэл үнэмшилтэй хүмүүс л ингэж заадаг юм. Ард түмэн хааныг хүссэн нь үнэн. Гэхдээ Бурхан Саулыг ч, Давидыг ч сонгосон билээ. Бурхан: *“Би Саулыг хаанаар тогтоов”* (1Самуел 15:11) гэсэн байдаг.

Нэг удаа Саул Давидыг Енгидийн цөлд байгааг дуулаад, тийшээ гурван мянган цэрэгтэйгээ довтолгожээ. Тэгж яваад Давидын бүгэж байсан агуйн дэргэд орж амрав. Саул, цэргүүдтэйгээ усанд орохоор нүцгэлсний дараа Давидын эрчүүд: *“ЭЗЭН танд “Харагтун. Би чиний дайсныг гарт чинь өгнө. Түүнийг нүднийхээ тааллаар болгогтун” гэж айлдсан тэр өдөр нь болов”* хэмээн шивэгнэжээ.

Тэгтэл Давид сэм гэтэж очоод, Саулын нөмрөгийн үзүүрээс тасалж авсан ч, дараа нь хийсэн зүйлдээ машид гэмшин, хүмүүстээ “Түүнийг ЭЗЭНий тосолсон хүн гэдгийг мэдсээр байж, ЭЗЭНий тосолсон өөрийн эзэнд би ийнхүү үйлдэж, дахин гар сунгаж ийм хэрэг хийхийг ЭЗЭН надаас хол байлгаг” (1Самуел 24:4-7) гэж хэлдэг. Түүний гэмшлийн талаар Кинг Жэймс Вержн Библи “Давидын зүрх түүнийг шаналгав” гэдэг. Тэрбээр өөрийг нь амьдаар нь зовоож буй удирдагчдаа уян зөөлөн зүрхээр хандсаар байжээ. Тэр уур, айдас, гутралын бодлоо мэдээж эсэргүүцэн, захирсан байх.

Давид нэгэнт хааныхаа нөмрөгөөс таслаад авчихсан учраас, үүнийгээ Саулын өмнө буруугүй гэдгээ батлахын тулд ашиглажээ. Тэгээд хол газар сөгдөөд, Саул руу ингэж хашхирсан: “*Эцэг минь ээ, хараач! Гарт минь байгаа нөмрөгийнхөө үзүүрийг үзээч!... Таны дээлийн хормойг би огтлон авсан боловч таныг алаагүй нь хорон муу болоод гэмт үйлдэл нь миний гарт үгүй* гэдгийг танд мэдүүлэг. Таны эсрэг би нүгэл үйлдээгүй боловч та амийг минь авахаар мөрдөж байна” (1Самуел 24:11).

Саул өөрийг нь ёрын муу, тэрслүү гэж үзсэнд Давид шаналж байсан. Тэрбээр зүрхэндээ: “Би ямар буруу зүйл хийсэн юм бол? Яагаад Саулын зүрх ийм хурдан миний эсрэг эргэчихэв?” хэмээн эргэцүүлж байсан учраас л: “Зарим маань таныг алья гэсэн боловч би таныг өрөвдөж, “Би өөрийн эзний эсрэг гар сунгахгүй. Учир нь тэр ЭЗЭНий тосолсон хүн” гэж хэлсэн билээ. Хорон муу болоод гэмт үйлдэл нь миний гарт үгүй” гэж хашхирсан байх. Давид Саулыг өөрөө ийм зүйл хийнэ гэдэгт итгэж чадаагүй. Хэн нэг хүний хатгалгаар л Саулын зүрх өөрийнх нь эсрэг эргэсэн гэж бодсондоо Давид Саулд гэмгүй байдлаа батлах гэж оролджээ. Баталж чадах юм бол, Саул түүнийг дахин соёрхож, өршөөнгүй хандан, эш үзүүлэл биелнэ гэж бодоо байх.

Аавдаа юмуу удирдагчдаа гадуурхагдсан хүн бүх ялыг өөр дээрээ авдаг. Тэд “*Би юу хийчихсэн юм бол? Миний зүрх бохир байв уу?*” гэсэн тамтай бодолдоо дарлуудаг. Тэд буруугүй гэдгээ удирдагчдаа батлах гэж зогсоо зайгүй зүтгэдэг. Тэд үнэнч гэдгээ, үнэ цэнээ батлалчих л юм бол, хүлээн зөвшөөрөгдөнө гэж горьддог. Тийм боловч хичээх тусам, улам л гологдоно.

Давид өөрийг нь алж болох байсан ч, алаагүйг нь үзээд Саул уярсан. Давид “*Хаан намайг сэргээнэ. Тэгээд эш үзүүлэл биелнэ. Тэр миний зүрхийг хараад, надад сайн хандана. Тэр зөөлөн бөгөөд сайн удирдагч болно*” гэж бодсон байх. Гэвч тийм юм болоогүй.

## Тэр намайг сүйрүүлэхээр шийджээ

Төд удалгүй Саул Давидыг Хагилагийн ууланд байгааг хүмүүсээс дуулмагцаа дахиад л гурван мянган цэргээ аваад элдчихэв. Саул дахиад л Давидыг сүйрүүлэхээр шийджээ. Саулын буултгүй мөрдлөгө Давидыг цөхрөөсөн. Одоо Давид Саул андуурч эндүүрээгүй, харин түүнийг дуусгах гэсэндээ л ийнхүү санаатайгаар өдөөн хатгаж явааг ухаарчээ.

Саул Давидыг тэрслээгүй, хорон санаалаагүй гэдгийг нь мэдэж байсан ч, түүн рүү дайрсаар байжээ. Давидын битүүхэн горьдлого талаар болж, тэрбээр үнэхээр хорон удирдагчтай тулгарснаа ухаарав. Бурхан яахаараа ийм хүнийг тосолдог байна аа?

Нэг удаа Давид Иоабын дүү цусанд амташсан Абишайгийн хамт Саулын баазад сэм нэвтэрчээ. Бурхан Саулын цэргүүдийг гүн нойрсуулжээ. Тэр хоёр цэргүүдийн дундуур явсаар, Саулын хэвтэж буй газар ирэхэд, Абишай Давидыг “Бурхан өнөөдөр таны дайсныг гарт тань өгчээ. Тийм учраас энэ жадаар түүнийг нэгмөсөн газарт хатгаж алахыг надад зөвшөөрнө үү. Би хоёр дахин хатгахгүй” (1Самуел 26:8) хэмээн ятгажээ.

Абишай ч Давидаас Саулыг дуусга гэсэн тушаал хүсэх мундахгүй шалтгаантай байлаа. Хамгийн түрүүнд бөгөөд нэн тэргүүнд - Саул наян таван гэмгүй тахилчийг гэр бүл, иргэд, үр хүүхдүүдтэй нь харгислан алсан! Тэр харгис, галзуу хүн улс орноороо ч тоглож байв. Өнөөдөр олон хүн ялангуяа чуулганыхаа удирдагчид бараг л ийм дайны ял тулгадаг ч, удирдагч нь Саул шиг иймдээ тулсан хорон хүн биш байдаг.

Хоёрдугаарт - Бурхан Самуелаар дамжуулан Давидыг Израилийн дараагийн хаанаар тосолсон. Давидын хувьд өв залгамжлалаа нэхэмжлэх цаг нь ирчихээд байхад, юу ч хийлгүй явж байгаад алуулчихаад, Бурханы эш үзүүллийг хөсөрдүүлэх үү? Заримдаа чуулганд үйлчилдэг төөрөлдсөн хүмүүс ч ийм маягийн бодлогогүй шалтгаан гаргаж тавьдаг.

Гуравдугаарт - Саул чинь өөрөө Давидыг эрчүүдтэй нь хамт алахаар гурван мянган цэрэгтэйгээ элдэж яваа биз дээ? Тэгэхээр нэг бол алах, нөгөө бол алуулах гэсэн хоёр сонголт л үлдэж байна. Аргагүй хамгаалалт гэж бий. Абишай ямар ч шүүх танхим тэдний үйлдлийг зөвтгөнө гэдгийг мэдэж байв. Өнөөдөр бол ийм учир шалтгаантай хэн ч маргахгүй, шууд л хүлээн зөвшөөрнө.



Дөрөвдүгээрт - Бурхан Өөрөө Саулын цэргүүдийг гүн нойрсуулсан нь цаанаа л нэг зүйлийг хэлээд, боломж олгоод байгаа бус уу? Тэдэнд магадгүй дахиж хэзээ ч олодохгүй алтан боломж оллоод байна! Чуулганыхаа удирдагчийг унах үед нь хичнээн хүн ингэж боддог бол? Тэд “*Бурхан Өөрөө түүнийг байр сууриас нь авч хаялаа*” гэж боддог. Захирагддаггүй хүмүүс л ингэж боддог.

Эдгээр нь ул суурьтай, тун сайн шалтгаан бөгөөд Давидыг үнэнч дүү нь ч урамшуулж байна. Тиймээс хэрэв Давидын зүрхэнд хумсын чинээ тэрслүү зан байсан бол, тэрбээр тэр даруй Абишайд Саулыг хэрчих тушаал өгөөд, өөрөө буруугүй үлдэх байв. Гэтэл Давид юу гэснийг үз дээ: “Түүнийг бүү алагтун. ЭЗЭНий тосолсон хүний эсрэг гар сунгаад хэн шийтгэлгүй үлдэж чадах вэ?” (1Самуел 26:9) Өнөөгийнхөөр бол “Түүнд үгээрээ ч, үйлдлээрээ ч бүү хүр. Удирдагчдаа хүрчихээд, гэмгүй үлдэх хүн байхгүй” гэж хэлжээ.

Саул Давидыг төдийгүй, гэмгүй хүмүүсийг ч алахаас буцахгүй байсан ч, Давид Саулд хүрэхийг хүсээгүй. Давид өшөөг өөрийн гараар авахыг хүсээгүй, харин Бурханы гарт үлдээжээ. Тэрхэн эгшинд бүхнийг дуусгах нь Давидад ч, Израилийн ард түмэнд ч ашигтай байв. Израиль хоньчингүй сүрэг шиг болчихоод байгааг Давид мэдэхийн дээдээр мэдэж байсан. Хорон муу хүний амин хувийн хүсэл санаархал ард түмнийг нь түрэмгийлж байгааг мэдэж байсан. Өөрийгөө өмгөөлөхгүй байх хэцүү боловч, хайртай улсаа галзуу хаанаас чөлөөлөхгүй байх нь бүр ч хэцүү байсан байх!

Саул өөрийг нь алж байж л сэтгэл амрах юм байна гэдгийг Давид ойлгосон ч, хаандаа хүрэхгүй гэж шийджээ. Саул бол Бурханы тослон томилсон удирдагч, үйлчлэгч гэдгийг Давид мэдэж байсан тул түүнийг Бурханы шүүгч мутарт даатгасан. Энэ нь хүний ухаанд нийцэшгүй, хачин шийдвэр байсан ч, Давид үүний цаад учрыг ойлгох ухаантай байжээ.

“Бурхан Өөрийнхөө зарц Саулыг шүүхдээ хэнийг ашигласан бэ?” гэж асуубал, хариулья: Филистинчүүдийг. Эзэн чуулганыхаа удирдагч нарыг шүүхдээ, аврагдаагүй хүмүүсийг юмуу дэлхийн тогтолцоог ашиглаж байхыг би олон удаа харсан. Саул хөвгүүдийнхээ хамт тулаанд үхсэн. Гэхдээ Давид үүнийг дуулаад огт баярлаагүй, харин гүнээ гашуудсан!

Үнэндээ Давид Саулыг алаагүй атлаа алсан гэж хэлсэн хүнийг ч цаазалсан. Уг нь тэр хүн Давидыг баярлуулах гэсэндээ худлаа хэлсэн ч,

Давид баярлах нь байтугай: “Эзэний тосолсон хүний өөдөөс аймшиггүйгээр гараа өргөж зүрхэлнэ гэнэ ээ?!” гэж хэлээд, цаазласан хойно оо: ““ЭЗЭНий тосолсон хүнийг би алав” гэж ам чинь чамайг гэрчилсэн тул чиний цус толгой дээр чинь бууг” (2Самуел 1:16) гэсэн байдаг юм.

Дараа нь Давид Иудагийн хүмүүсээр дуулуулах гэж Саулын болоод түүний хөвгүүдийн гэгээн дурсгалыг хүндэтгэсэн дуу зохиогоод, дайснуудыг баярлуулахгүйн тулд Филистиний гудамжинд дуулахгүй байхыг зарлигджээ. Тэрбээр Саулын алуулсан газар дусал бороо ч унахгүй, өвс ногоо ч ургахгүй хэмээн мэдэгдээд, Израиль даяар гашуудал зарласан. Өшөө хорсол тээж, өс хонзон авахын дон туссан хүний зүрхийм байхгүй. Тийм хүн: “Болж муу хог!” гэж л баярладаг юм.

Давид үүгээр ч зогсоогүй. Тэрбээр Саулын удмыг алалгүй, харин ч өршөөл энэрлээ үзүүлсэн. Давид тэдэнд газар, хүнс өгч, хааны ширээнээс зооглох соёрхол хүртээсэн. Удирдагчийгаа шүүгдсэнд баярласан хүн ингэх үү? Тэрслүү зүрхтэй хүн сүнсний удирдагчийгаа унахад баярлан, “Болж!” гэж боддог. Тэд цуурхал, хатуу үгээрээ удирдагчийгаа улам л шийтгэл рүү цөлдөг. Давидад байсан зүрх тэдэнд байдаггүй. Тэдэнд Бурханы араас нэхсэн зүрх байхгүй.

## **Ерөөлийн байр суурь**

Бурхан биднийг эрх баригчдын шударга бус үйлдлээр оруулж байгаа нь эцэстээ сайн зорилготой гэдгийг үргэлж санаж яв. Бурхан үүнийг ашиглан биднийг ерөөдөг юм. Петр цааш нь: “*Ерөөлийг өвлөхөөр дуудагдсан* тул та нар мууг муугаар, эсвэл доромжлолыг доромжлолоор хариулахын оронд ерөөгтүн” (1Петр 3:9) хэмээн ятгажээ.

Ерөөл нь ихэвчлэн бодит юмс байдаг ч, заримдаа бас бодит юмс гэхээсээ илүү Христтэй адил зан занар, хаанчлалын өргөжилт, эрх мэдлийн дээд төвшин юмуу мөнхийн шагнал зэрэг илүү чухал талбар дээр ирж болно. Бурханы эрх мэдэлд захирагдах үед бидний сүнсний эрүүл мэндэд ямар ч хор хохирол учирдаггүй. Петр “Та нар сайны төлөө зүтгэгч болбоос хэн та нарт хор учруулах юм бэ?” (1Петр 3:13) хэмээн асуухдаа, маш тодорхой болгожээ. Түүний мэдэгдлийн агуулга нь Есүсийн хувийн үлгэр загварыг дагахад оршиж байна.

Христтэй адил зан чанарын тухайд Петр “Христ ч нэг удаа нүглийн төлөөнөөс үхэж, биднийг Бурханд аваачихын тулд зөвт нь зөвт бусыг орлосон... Иймээс Христ нэгэнтээ махбодоороо зовсон тул та нар

## ШУДАРГА БУС ХАНДЛАГА

ч гэсэн ижил санаагаар өөрсдийгөө зэвсэглэ. Учир нь махбодоороо зовсон нь нүглийг дуусгасан” (1Петр 3:18, 4:1) гэжээ.

Петр биднийг Христийн туулсантай адил зовлонгоор хуягла гэсэн нь чухам эрх баригчдын зүгээс ирэх шударга бус хандлагын талаар хэлснийг нь захидлынх нь агуулгаас харж болно. Гар хоосон цэргүүд байлдахаар явж байна гээд бод доо? Буу, сум, хутга - юу ч байхгүй! Хөгтэй биш үү? Гэтэл олон итгэгч шударга бус хандлагын эсрэг ямар ч хамгаалалтгүй явдаг. Тэгээд хавчигдахаараа цочирдож нэг бол галзуу мэт авирлана, нөгөө бол гөлийчихнө. Тэд эрх баригч нартаа Бурханы Үгийн дагуу *хандахын* оронд учир шалтгааныхаа эргүүлэг дотор л янз бүрийн реакц үзүүлээд байдаг.

Би танд хуягтай хүн гэж ямар байдгийг жишээ болгон хэлье. Онгоцны нисгэгчийн ажлын амин чухал хэсэг нь нислэгийн симулятор дотор хийдэг бэлтгэл сургууль юм. Нисгэгч хүн симулятор дотор суугаад, нислэгийн үеэр тохиолдож болзошгүй бүх төрлийн ослын нөхцөлд зохиомлоор орно. Эдгээр ослын нөхцөл нь нисгэгчдэд бүх төрлийн ослыг амжилттай даван туулах ур чадвар суулгах зорилготой юм. Бэлтгэл сургууль нь жинхэнэ ослын үеэр нисгэгчдийг хуягладаг байна. Жинхэнэ нислэгийн үеэр ямар нэгэн осол гарсан нөхцөлд нисгэгч хүн сандралгүй, хариу үйлдэж, гар нийлэн ажиллаж, бэлтгэл сургуулиар сурсан эрдмээ хэрэгжүүлнэ. Зорчигчид үймэлдэн сандарч, цочролд орж болох ч, нисгэгчид бүрэн хяналттай, тайван байдаг. Тэдний тайван байдал онгоцны хар хайрцгийн шинжээч нарыг гайхшруулдаг. Онгоц дэлбэртэл нисгэгчдийн дуу хоолойд айж сандарсан өнгө харагддаггүй. Тэд хуяглагджээ!

Тэгвэл энэ номыг нислэгийн бэлтгэл сургуулийн гарын авлага гээд л ойлгогчих! Энэ ном доторх Бурханы Үг таныг эрх баригчдын зүгээс ирэх амьдралын энхэл донхолд бэлтгэнэ. Зөвөөр хариу үйлдэх юм бол, та ерөөгдөнө. Христийг үлгэрлэн дагасан хүн, нүглээс сэргийлнэ гэж Петр хэлсэн. Энэ бол том мэдэгдэл! Өөрөөр хэлбэл эрх баригчдын шударга бус хандлагыг зөвөөр давдаг хүн сүнсний төлөвшилийн байр сууринд гардаг.

Тэгвэл үүнээс хавь илүү амлалт байна. Паул:

Энэ бол итгэмжит үг. Хэрэв бид Түүнтэй хамт үхсэн бол Түүнтэй хамт мөн амьдарна. Хэрэв бид тэвчвэл Түүнтэй хамт мөн хаанчилна. Хэрэв бид Түүнийг үгүйсгэвэл Тэр ч бас биднийг үгүйсгэнэ (2Тимот 2:11-12) хэмээн баталгаажуулжээ.

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Сүнсний эрх мэдэл нь Христ шиг зовдог хүмүүст амлагджээ. Том зовлон тэвчих тусам, Бурхан танд илүү том эрх мэдлийг итгэмжлэх болно. Дахин хэлэхэд, та ухаан муутай эрх мэдэлтнүүдтэй тулгарахдаа, Бурхан таныг ерөөлд бэлтгэж байгааг харна. Гэхдээ та зөвөөр үйлдээд, ерөөлийг хүлээн авах уу эсвэл хатууран гашуудах уу? Сонголт нь таных. Ялагч хүний замыг сонгоорой. Тэр нь амийн зам шүү!

## ӨӨР ДЭЭРЭЭ БУУЛГАСАН ШҮҮХ

*Эрх мэдлийг хүндэтгэгч нь өөрөө аугаа эрх мэдэлтэй байх бөгөөд түүнийг хүндэтгэл дагалдана.*

**У**дирдлагадаа хүн бүр Давид шиг ханддаггүй л дээ. Бид удирдагч нарынхаа өө сэвийг харахдаа баясч, биеэ өмөөрөн эсэргүүцдэг. Гэхдээ бусдын - буюу ялангуяа удирдагч нарынхаа нүгэлд хандах хандлага маань бидний сүнсний төлөвшлийг хамгаас сайн тодорхойлно. Тиймээс бидний зүрхний жинхэнэ төрхийг илчлэхийн тулд Бурхан эрх баригчдын алдааг ашигладаг юм. Үүнийг Ноагийн хүүгийн түүхээс харж болно.

### Зөв боловч буруу

Үерийн дараа Ноа хөрсөө боловсруулан, усан үзмийн цэцэрлэг тариалжээ. Гэтэл нэг өдөр согтуураад, майхандаа амарч байхдаа хувцсаа тайчсан чигээрээ тасарчихсан байв.

Ноагийн отгон хүү Хам аавынхаа хэвтэж байгаа газар явж ороод аавыгаа шалдан байхыг үзмэгцээ, гарч ирээд Шем, Иафет гэдэг хоёр ахдаа алтан хошуу хүргэжээ. Хам зөвхөн “гэр бүлийнхэндээ” л хэлсэн гэдгийг тэмдэглээрэй. Магадгүй: “Ах аа, цаана чинь нүдэндээ ч итгэмгүй зүйл болж байна” гэсэн ч юмуу эсвэл бүр ах нарыгаа дагуулан аваачиж үзүүлэх гэсэн байх.

Шем, Иафет хоёр энэ тухай дуулаад, нөмрөг аван, ухраагаараа майханд ороод, буруу харсан чигээрээ нүцгэн аавыгаа хучжээ. Ноа сэрээд, Хамын хийсэн хэргийг сонсоод юу гэж хэлснийг үзнэ үү:

Канаан хараал идэж, ах нарынхаа боолын боол болог! гэжээ. Бас тэрээр Шемийн Бурхан ЭЗЭНийг би магтъя. Канаан Шемийн боол болох болтугай! Бурхан Иафетыг үлэмж өсгөж, Иафетыг Шемийн майханд амьдруулж, Канаан түүний боол болох болтугай! (Эхлэл 9:25-27) гэжээ.

Бурханы эрх мэдэлд дуулгаваргүй байх нь ямар үр дагавартай болохыг бид номынхоо эхээр сурсан. Санаатайгаар тэрслэгч нь хараал дор ордог ажээ. Хам зовлон үзэж байж үнэнийг сурчээ. Тэрбээр аавдаа хүндэтгэлгүй хандахдаа, үүгээрээ Ноагийн дээрх Бурханы төлөөний эрх мэдлийг үл тоосноо харуулжээ. Хам тэрслүү, тэнэг байсан бол, хоёр ах нь хүндэтгэлтэй, энэрэнгүй байжээ. Ноа архидан согтуурснаараа сайн үлгэр жишээ үзүүлээгүй боловч, гол нь түүний авир үйлдлээр дамжуулан Бурхан Ноагийн удирдлага дорх хүмүүсийн хандлагыг ил гаргасан юм. Үүнийг хоёр том нь ойлгоод, аавдаа хүндэтгэлтэй хандсан бол, отгон нь аавынхаа алдаан дээр дөрөөлөн үл хүндэтгэн, ичээх гэж оролдохдоо, аав дээрээ авчрах гэж байсан тэр хараалаа өөр дээрээ буулгажээ.

Шем, Иафет хоёр аавынхаа алдааг харахыг хүсээгүй. Тэд аавынхаа нөхцөл байдлыг өөрсдөө ч харалгүй, бусдад ч (эхнэр, хүүхдүүддээ) харуулалгүй, хөнжлөөр хучсан. Тэд аавынхаа байр суурийг хүндэтгэсэн учраас, тэр байр суурийг нь зүрхэндээ хамгаалжээ. Гэтэл Хам аавынхаа захирах чадварыг үнэгүйдүүлэх оролдлого хийн, элэг доог болгон, доош хийжээ. Тийнхүү тэрбээр энэ явдлаар далимдуулан зориуд дуулгаваргүй авирласан байна. Зүрхэндээ захирагдах санаагүй хүмүүс үргэлж ингэдэг. Тэд эрх мэдэлтнийг үл хэрэгссэнээрээ өөрийгөө захирагдах үүргээс чөлөөлдөг. Тэрбээр эрх мэдлийг зүрхэндээ хэрэгсээгүй, бүх хоригийг цуцалсан учраас, захирагдах үүргийг үл хэрэгссэн байна.

“Бурханы алдрын танхимд” (Еврей 11) Бурхан Ноагийн итгэл, дуулгавартай байдлаар бахархсан бол, тэнд Хамын нэр харагддаггүй. Хам үнэнийг хэлээгүй гэж үү? Ноа согтуу, нүцгэн шалдан байгаагүй гэж үү? Байсан. *Хамын үг зуун хувь үнэн байсан ч, тэрбээр зарчим*

## ӨӨР ДЭЭРЭЭ БУУЛГАСАН ШҮҮХ

*дээрээ алджээ.* Учир шалтгаан нь түүний үйлдлийг зөвтгөж болно. Үнэхээр ч тэрбээр харсан зүйлээ буюу үнэнийг л илтгэжээ. Тийм боловч дуулгавартай байдал, хүндэтгэлийн зарчим талаас нь авч үзбэл, өөр асуудал яригдана. Шем, Иафет хоёр аавыгаа хүндэтгээд ерөөгдсөн юм.

Олон хүн Хамтай адил удирдагчийнхаа талаар яг л үнэнийг илтгэдэг боловч, Бурханы жишгээр ярихаар бурууддаг. Тэд удирдагчаа хүндэтгэхгүй учраас ерөөлөө алддаг. Тэд өөрийнхөө ойлголт, эргэцүүллийн мунхаглал дор явдаг. Тэдэнд Давид, Шем, Иафетийнх шиг зүрх дутдаг. Саулыг унахад, Давид:

Эл явдлыг Гагад бүү мэдээл, Ашкелоны гудамжинд ч бүү тунхаглуул. Эс бөгөөс филистчүүдийн охидыг баярлуулах гэж үү, Хозлуулаагүйчүүдийн охидыг хөөргөх гэж үү ... Хайрт эрхэм Саул Ионатан хоёр амьддаа ч, үхэхдээ ч эс хагацав. Тэд бүргэдээс ч хурдан, арслангаас ч хүчтэй байлаа. Израилийн охид оо, Та нарыг час улаан тансаг хувцсаар гоёж, Өмсгөлийн чинь дээр алтан чимгийг зүүж өгсөн Саулын төлөө уйлагтун (2Самуел 1:20, 23-24) хэмээн гашуудсан.

Давид тэр удирдагчаас болж арван дөрвөн жил зовсон. Хүний ухаанаар бодбол, Давид баярлан, баяраа тэмдэглэмээр. Гэтэл Давид эрх мэдлийн зарчмаар амьдардаг байснаа баталсан агаад энэ үлгэр жишээг нь албатууд нь өвлөн авчээ. Тийнхүү Давид аугаа удирдагч - хаан болсон. Эрх мэдлийг хүндэтгэдэг хүмүүс аугаа эрх мэдэл дор явдаг бөгөөд эргээд хүндэтгэл хүлээдэг. Тэд Бурханы ерөөлийг татдаг. Эрх мэдлийг хүндэтгэдэггүй эсвэл эрх мэдэлд хөнгөн ханддаг хүмүүс нь үл хүндлэлийн ургацыг тарьж, эцэстээ шүүхэд очдог.

## Өөр дээрээ буулгах шүүх

Төлөөний эрх мэдлийн суурь Бичээсийг үргэлжлүүлэн үзье:

Бурханаас гадуурх эрх мэдлүүд гэж үгүй бөгөөд Бурханы тогтоосноор л байгаа тул дээд эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд. Тиймд эрх мэдлийг эсэргүүцэгч нь Бурханы тогтоолыг эсэргүүцсэн хэрэг. Эсэргүүцсэн хүмүүс нь өөрсдөдөө шийтгэл хүртэх болно (Ром 13:1-2).

Эрх мэдлийг эсэргүүцдэг хүмүүс дээр шүүх бууна. Эрх мэдэлд гар

хүрдэг л юм бол, Бурханд Өөрт нь гар хүрлээ гэсэн үг. Би энэ үйлчлэлээ эхлүүлэхээсээ өмнө хоёр ч олон улсын үйлчлэлд ажиллаж байлаа. Тэгээд эрх мэдлийг эсэргүүцэгч хүмүүс дээр заавал шүүх буудгийг харсан. Шүүх нь янз бүрийн хэлбэрээр буух боловч, буухдаа л бууна. Ялангуяа хаалга савж гардаг ажилчид дээр. Удирдагч нь эсвэл нөхцөл байдал нь хичнээн буруу байсан ч, ажилчид нь удирдагчаа шүүмжилж, доромжилбол, хорслын ундаанаас уусан бол, эцсийн дүнд өөрсдөө л хэцүү байдалд ордог. Энэ нь санхүүгийн, ажил үйлчлэлийн, эрүүл мэндийн, хүүхдүүдийн, гэрлэлтийн зэрэг ямар ч бэрхшээлийн хэлбэрээр ирж болно. Энэ жагсаалт дуусахгүй. Сүнсний удирдлагаа хүндэтгээгүй хүн бүрийн амьдрал дундуур энэ ер бусын зовлонгийн утас гүйдэг.

Нөгөөтэйгүүр шударга бус хандагдан, хөөгдсөн боловч, өгөөмөр сүнсээ тээсээр гарч явах хүмүүсийг ч олонтаа харсан. Тэд хуучин удирдагчаа өөрөө ч муулалгүй, муулж байгаа хүмүүсийн яриаг ч сонсолгүй, энэ асуудал сөхөгдөх болгонд удирдагчаа хүндэтгэн, ерөөдөг. Тэднийг хангаж, халамжилж, өргөдөг Нэгэн бол Бурхан гэдгийг тэд мэддэг бөгөөд эцэстээ тэд хуучнаасаа ч өндөр байр сууринд очихыг нь би харсан. Тэдний заримтай нь олон жилийн дараа тааралдахад, тэд ерөөгдсөн хэвээрээ л байж билээ.

Яаж ийм өгөөмөр сүнсэтэй байх вэ? Есүс бидэнд нууцыг нь зааж өгчээ: “Харин Би та нарт хэлье, дайснуудаа хайрла, та нарыг хавчигчдын төлөө залбир” (Матай 5:44). Тэр биднийг хүчирхийлж, дарангуйлж байгаа хүмүүсийн төлөө залбир гэжээ. Залбирах үед зүрх маань эдгэрдэг учраас, шүүмжилж, шаналах боломжгүй.

## **Бэлэг авьяас, эрх мэдэл**

Эрх мэдлийнхээ эсрэг ярьдаг хүн толгой дээрээ тодорхой хэмжээний шүүх буулгадгийг миний бие Бичээсээр бөгөөд амьдралын туршлагаар сурсан юм. Тухайлбал Мириам, Аарон хоёр байна: “(Моше куш эмэгтэйтэй гэрлэсэн байсан тул) Мосегийн гэрлэсэн куш эмэгтэйн улмаас Мириам, Аарон нар түүний эсрэг яриа гаргав” (Тооллого 12:1).

Нэгдүгээрт - Мириам, Аарон хоёрыг авч үзье. Мириам бол Мосегийн эгч. Бурхан түүнийг эш үзүүлэгч гэж дуудсан (Гэтлэл 15:20). Аарон Мосегийн ах бөгөөд тэргүүн тахилч байв. Гиймээс бид томоохон байр суурь, хэргэм зэрэгтэй хүмүүсийн талаар ярьж байгааг хэлэх хэрэгтэй.



Тэр хоёр Мосег Куш эмэгтэйтэй гэрлэлээ гэж шүүмжилсэн. Кушууд нь эртний Куш нутгийн уугуул хүмүүс бөгөөд эрдэмтдийн хэлж байгаагаар Куш нь Зүүн умард Африкт байрладаг одоогийн Етиоп ажээ. Тэр эмэгтэй Абрахамын удам байгаагүй учраас, Абрахамын гэрээнээс гадуур хүн байв.

Мириам, Аарон хоёр Мосег удирдагч хүн байж Африк хүүхэнтэй гэрлэсэн нь наанадаж буруу шийдвэр, цаанадаж нүгэл гэж үзжээ. Тэдний санаа зөв байсан уу? Хуулийн үсгийг харах юм бол, яахын аргагүй зөв байсан. Бурхан Израилийн хүүхдүүдийг харь хүмүүстэй гэрлүүлэх дургүйгээ мэдэгдсэн. Гадаад эхнэрүүд Израильчуудын зүрхийг харийн бурхад руугаа эргүүлнэ гэсэн. Энэ тушаалыг Дэд хууль дээр хэлсэн. Тиймээс Мосе гадаад эмэгтэйтэй гэрлэсэн нь зөрчил шиг л харагдаж байжээ. Тэр хоёр магадгүй Мосегийн нөлөө хэт ил тод учраас, олон хүнийг яг тийм явдалд хүргэж болзошгүй гэсэн гаргалгаанд хүрсэн байх. (Жич: Өнөөдөр бидний цорын ганц тушаал нь үл итгэгч нартай нэгэн тэнцвэргүй буулганд орохгүй байх явдал юм. Учир нь энэ нь цусан холбооны бус, харин сүнсний холбооны сэдэв болоод явчихна. Галат 3:28-ыг үзнэ үү. Шинэ гэрээний дагуу хоёр гадаад хүн гэрлэх нь хэвийн юм)

Тиймээс Мириам, Аарон хоёр даалгавар дээрээ зөв байсан ч, хандлага дээрээ Хамын адил буруу байв! Мосе тэдний удирдагч байсан. Мосег шүүмжлэлээрээ шүүх нь байж болшгүй зүйл байв. Ах, эгч хоёр нь байж тэд энэ асуудлаа Мосетэй өөртэй нь гэр бүл дотроо ярьж болох байсан ч, хов живийн чанартай болгож, чуулган дундаа авч хэлэлцэх нь яриангүй нүгэл байв.

Тэд ийнхүү удирдагчийнхаа эсрэг шатах болсон нь ямар учиртай байв? Хариултыг нь дараах ишлэлээс харж болно: “Тэд —ЭЗЭН зөвхөн Мосед ярьсан гэж үү? Тэр бидэнд ч гэсэн яриагүй юу? гэхэд ЭЗЭН сонсов (Тооллого 12:2).

Бурхан тэднээр дамжуулан ярьсан уу? Тийм ээ. Бурхан Аароныг Мосегийн төлөөлөн яригч гэсэн. Аарон Бурханы Үгийг Фараонд дамжуулдаг байсан. Мириам өнөөгийн манай Бичээс дээр байгаа эш үзүүлийн магтаалыг авчирдаг байсан. Тэд мэдээж сүнсний бэлэгтэй байсан. Тийм боловч тэд сүнсний бэлэг, чадварыг эрх мэдлээс дээгүүр тавих алдаа гаргажээ. Тэд гурвуулаа л Бурханы гар хөл болж, сүнсний гүн гүнзгий юмсыг үйлдсэн хүмүүс. Тийм боловч Аарон, Мириам хоёр Мосег нүгэл үйлдсэн болохоороо, тэдний дээр ямар ч

эрх мэдэлгүй гэж дүгнэжээ. Тэд сүнсний бэлгээ Бурханаас олгогдсон эрх мэдлээс дээгүүр тавьжээ.

Шинэ гэрээн дээр Паул: “Бэлгүүд нь ялгаатай ч Сүнс нь ижил” (1Коринт 12:4) гэсэн байна. Энэ бөгөөд бусад бичээсүүд нь бэлгийн Эзэн бол Ариун Сүнс гэдэг. Зарим бэлгүүд нь удирдах чадвар, өгөх, эш үзүүлэх, эдгээх, сүнсүүдийг ялгах, гайхамшгуудын ажиллагаа зэрэг болно (1Коринт 12:7-10, Ром 12:6-8).

Паул цааш нь “Бэлгүүд нь ялгаатай ч Сүнс нь ижил. Үйлчлэлүүд нь ялгаатай ч Эзэн нь адил” (1Коринт 12:4-5) гэсэн байна. “Үйлчлэл” гэдэг нь Грекээр диакона ийм. Тайерийн Грек толь бичгээс үзвэл, энэ үгээр “элч нар, эш үзүүлэгч, Сайн мэдээ дэлгэрүүлэгч тэргүүтэй хүмүүсийн албан тушаал, үүний үйл ажиллагааг” тодорхойлох ажээ. Товчхондоо энэ үгээр чуулган доторх сүнсний эрх мэдлийн таван албыг дүрслэх ажээ. Энэ Бичээсээс бид Эзэн болоод Есүс маань эдгээр албан тушаалын дээр байхыг харж байна. Үүнийг өөр нэгэн бичвэр ч батална. Есүсийг амилуулагдахад, Паул “Тэр, заримыг нь элч, заримыг нь эш үзүүлэгч, заримыг нь сайнмэдээ тунхаглагч, заримыг нь хоньчин ба багш болгосон нь ариун хүмүүсийн үйлчлэлийн ажилд бэлтгэж, Христийн биеийг байгуулахын тулд юм” (Ефес 4:11-12) гэж бичжээ.

Есүсийг амилуулагдсаны дараа Аав нь хамаг эрх мэдлийг Есүст өгсөн учраас (Матай 28:18) бэлгүүд биш, хаанчлалын эрх мэдэл нь албан тушаалуудаар дамжин гүйдэг. Харин Есүс хариуд нь Ефесийн хэсэг дээр гардаг таван талт үйлчлэлийг эргүүлэн барьжээ. Тиймээс Бурханы тохоон томилсон албан тушаалаар Есүсийн эрх мэдэл гүйж байгаа юм. Хүн пастораасаа илүү бэлэгтэй байж болох ч, албан тушаалын талаасаа пастор нь хэзээд тэр бэлэгтэй хүний дээр оршдгийг хэзээ ч мартаж болохгүй.

Бэлэгтэй хүн өөрийгөө өргөмжилсний эмгэнэлт үр дагаврын талаар би олон жишээ тоочиж чадна. Жишээлбэл нэгэн чуулганд зааж, номлох мундаг бэлэгтэй туслах пастор байжээ. Түүний ангиуд дүүрч - зарим нь босоогоороо сонсож, Бурхан түүнд өндөр бэлэг авьяас заяасан нь хэнд ч тодорхой байв. Түүний долоо хоногт нэг удаа удирддаг залбирал нь ч дүүрдэг байв.

Харамсалтай нь тэрбээр алдарших тусмаа, чуулганыхаа бодлогыг - тэр байтугай тэргүүн пасторыгаа дураараа шүүмжилж болно гэж бодох болжээ. Тэгээд тэргүүн пасторынх нь бодлого Ариун Сүнсний урсгалд хориг болж байгааг эргэн тойрныхондоо зарлах болж.

Яваандаа тэр шүүмжлэлтэй хандлага нь өөр нэгэн туслах пасторт халдварлав. Нэг удаа тэр хоёр ээлжит оройн залбирлын цуглааныг хамтран хөтөлж байтал, тэргүүн пастор нь танхимын ард сэм орж ирээд, хоёр туслах пастор нь түүний битгий хийгээрэй гэсэн зүйлсийг зориуд хийж байхыг үзжээ. Тэд чуулган, хот, төөрөгсдийн төлөө зуучлан залбирахын оронд хүмүүсийг өөр маягийн залбиралд татаж, санал нийлээгүй хүмүүсийг зандарч, олныг гайхшруулав.

Хоёр туслах пастор хоёулаа л бэлэгтэй үйлчлэгч байсан боловч, чуулганыхаа эрх мэдэлд захирагдаагүй юм. Тэд энэ ноцтой зөрчлөө Эзэн тэднээр дамжуулан хүмүүст хүрч байна гэдэг баримтаар хаацайлжээ.

### Шүүгдээд ирэхээрээ захирагдахыг сурах

Мосе гэгч хүн газрын хөрсөн дээрх хэнээс ч илүүгээр маш даруу нэгэн байлаа. ЭЗЭН гэнэт Мосе, Аарон, Мириам нарт —Та гурав уулзалтын майханд хүрч ир гэж айлдав. Тэр гурав ч хүрч ирлээ (Тооллого 12:3-4).

Бурхан Өөрийнхөө удирдагч нараас ямар зан чанар хүсдгийг энэ бичээс халт харуулж байна: Даруу зан. Мосе дэлхий дээрх хамгийн даруу хүн байж. Гэтэл Мириам, Аарон хоёр түүнийг тэгж дүрслээгүй. Тэдний үзлийг “Тэрбээр (*Мосе*) өмдөндөө багтаааргүй болжээ” гэсэн үгээс нь харж болно.

Эзэн тэр гурвыг майхан сүмд дууджээ. Зарим орчуулагч нар *тэр даруй* гэдэг үгийг *гэнэт* гэж орчуулсан байдаг. Шүүх голдуу анхааруулгагүй ирдэг. Тийшээ явах зуураа магадгүй Мириам Аароныг зогсоогоод: “Бэлтгэлтэй байгаарай. Мосе харь хүүхэнтэй гэрлээд баларчихлаа. Бурхан чамайг зөв үйлдэлтэй байсны чинь төлөө удирдагчаар томилох байх” гэсэн байж мэдэх. Бид эрх мэдэлтэй тэрсэлдэн, заль мэхд нээгдэхдээ нэг иймэрхүү сэтгэлгээтэй болдог.

Тэгтэл мэдээж хэрэг явдал үүнээс тэс өөрөөр эргэсэн. Бурхан Аарон, Мириам хоёрыг урагш нь гаргаж ирээд, гэрээ бүхлээр нь Мосед л даатгасан бөгөөд түүнтэй олны нүдэн дээр бус, харин хоёулханаа нүүр нүүрээрээ ярилцсанаа сануулаад: “Тэгтэл та нар юунд Миний зарц Мосегийн эсрэг ярихдаа эмээсэнгүй вэ?” (и8) хэмээн асуужээ. Бид эрх мэдлээ шүүмжлэхдээ, Эзэнээс эмээхгүй байгаагаа харуулдаг. Тэгээд юу болсныг сонс: “Ингээд ЭЗЭНий уур хилэн тэдний эсрэг

шатаж, Тэр салж явав. Үүл асрын дээрээс салж явахад, харагтун, Мириам цас мэт уяман өвчтэй болов. Аароныг Мириам уруу эргэхэд, харагтун, тэр уяман өвчтэй болсон байлаа” (Тооллого 12:9-10).

Эрх мэдлийг эсэргүүцсэнээрээ бид толгой дээрээ шүүх буулгадаг. Энэ шүүх нь Бурханы оршихуй холдох зэрэг янз бүрийн эмгэнэлтэй үр дагавартай. Бүгдээрээ нөгөө хоёр туслах пасторын түүх рүүгээ эргэж орьё. Төд удалгүй тэр хоёр чуулганаасаа явжээ. Нэг нь ойролцоо газар өөрийн гэсэн чуулган эхлүүлсэн ч, чуулган нь зуун хүнээс даваагүй бөгөөд тэрбээр үйлчлэлдээ нилээд зүдэрчээ. Гэтэл тэрбээр туслах пастор байхдаа, зургаан зуу давсан хүнийг хариуцдаг байж. Дээрээс нь түүнийг явсны дараах нь гэр бүлд нь эмгэлэнт явдал тохиолдсон юм.

Тэгвэл хоёр дахь пастор нь хотоосоо яваад, нэг хэсэгтээ амжилт эдэлжээ. Чуулган нь олон зуун хүнтэй болтлоо өссөн байна. Гэвч мань хүн өөрөө хүнд итгэдэггүй, хөндий хүйтэн болжээ. Хорин жилийн хугацаанд чуулган нь олон удаа хагарч бутран, түүний удирдах арга барил нь нийгэмд үлэмж эргэлзээ тархаасан байна. Эцэстээ тэрбээр хотоо орхиж явсан юм. Олон жилийн өмнө тэрбээр том чуулганы нэр нөлөө бүхий, эрэлттэй номлогч байсан бөгөөд олон хүн түүнийг үндэсний хэмжээний хүн болно гэж үздэг байжээ. Гэтэл зөрүүд зан нь түүнийг өөр замаар авч одсон нь эмгэнэлтэй.

Шүүхийн дараа Аарон тэр даруй өөрийнхөө бөгөөд Мириамын төлөө уйлан гэмшжээ. Бурхан тэднийг уучилсан ч, Бурханы тушаалаар Мириам долоо хоног чуулганаас тусгаарлагдах ёстой байв. Яагаад Аароныг тусгаарлаагүй байж, Мириамыг тусгаарлав гэсэн асуулт их гардаг. Магадгүй Мириам Ааронаас илүү хэл амаар дайрсан болоод тэр байж болох. Ямар ч шалтгаантай байлаа гэсэн, хамгийн гол нь үүгээр Бурхан иймэрхүү зүйлд хичнээн ноцтой ханддагаа харуулжээ.

Сүнсний эрх мэдэлтэй тэрсэлдсэн явдлын шүүхээс бид том сургамж авч, өсөх боломжтой. Ийм аюултай шүүхийн дараа гэмшсэн хүмүүс чуулганы хамгийн итгэмжтэй хүмүүс болох нь бий. Заавал ёрын муу зүрхтэйдээ бус, зүгээр хэнэггүй хандлагаасаа болж тэрсэлдэх тохиолдол ч гардаг. Үүнийгээ ухаарсан хүмүүс тэр даруй гэмшдэг. Заримдаа гэмших хүртэл их бага хэмжээний цаг хугацаа шаардагдана. Яагаад гэвэл зарим хүмүүс дэндүү гүргэр учраас, гүрийгээд л хадаасны үзүүр өөд өшигчөөд байдаг юм.

Мириам гутамшигт явдлаа үхэн үхэтлээ санаж явсан нь тодорхой. Тэрбээр дахиж ийм явдал гаргаж, алдаагаа давтаагүй. Харамсалтай

нь хүн болгон Мириам, Аарон хоёр шиг сургамж аваад байдаггүй. Учир нь хожим тэр чуулганы өөр хүмүүс Бурханы төлөөний эрх мэдлийн өөдөөс боссон байдаг.

## Та нар яагаад өөрсдийгөө өргөмжилнө вэ?

Чуулганы гурван хүн - Левигийн удам Кора, Реубений удам Датан, Абирам гурав олны танил 250 удирдагчийг цуглуулан Мосе, Аарон нарын эсрэг босоод: “Та нар арай дэндэж байна. Даяар хотол түмэн, хүн бүр нь ариун бөгөөд ЭЗЭН тэдний дунд байна. Юунд та нар өөрсдийгөө ЭЗЭНий чуулганаас дээгүүр өргөмжилнө вэ? (Тооллого 16:3) гэжээ.

Товчхондоо Мосе, Аарон хоёрын удирдлага дор байсан хүмүүс: “Ингэхэд хэн та хоёрыг бидний дарга болгосон юм? Бид бүгдээрээ Бурханы хүмүүс. Та нарын тушаалтай, тушаалгүй бид Бурханыг дагачихна” гэж хэлжээ. Энэ үгийг сонсож л явсан биз дээ? Яг үгчлэн хэлээгүй байж болох ч, яг ийм сүнсээр яг ийм үйлдэл, үг харуулдаг биз дээ? Тухайлбал “Бид бүгдээрээ тэгш”, “Бид бүгдээрээ ахан дүүс”, “Бид бүгдээрээ Ариун Сүнстэй атлаа яахаараа энэ удирдагчийн үгэнд орох ёстой юм?” гэсэн утга агуулгатай үгийг сонсдог л биз дээ? Ингэж хэлдэг хүмүүс өөрийгөө бусдаас дутахгүй Эзэнийг сонсож чадна гэдэгт итгэдэг ажээ.

1970-аад онд хүчээ авсан “дагалдуулал” гэдэг нэгэн хөдөлгөөн удирдагч - чуулганы гишүүдийн захирах - захирагдах үүргийг хэт туйлшруулан, тэнцвэрийг нь алдагдуулж байсныг мэдэх юм байна. Тэр үед хүмүүс амралтанд явж болох эсэх, тодорхой загварын машин зэрэг томоохон бараа худалдаж авч болох эсэх, хэнтэй гэрлэх эсэхээ пастораасаа л асууна. Би энэ хөдөлгөөнд оролцоогүй учраас, энэ явдал хэр даамжирсныг мэдэхгүй байна. Тийм боловч энэ бүхэн Бичээсээс хальж, замаа алдсаныг оролцож явсан хүмүүс нь ярьдаг л юм.

Энэ хөдөлгөөний суртал ухуулаг нь эсрэг туйл руугаа хадуурчээ. Учир нь үүнээс болж сүнсний эрх мэдэл завхарч, хүмүүсийн жигшлийг төрүүлж эхэлсэн юм. Ийнхүү захирагдаад явчих, гайгүй төгс чуулган олдохгүйн улмаас хүмүүс чуулганаас чуулган, газраас газар дамжин өөр өөрсдийнхөө залбирлын цуглааныг хийж, өөр өөрсдийнхөө чуулганыг хийж, эрх чөлөөт “сайн эрсийг” бас сүнсний “бадарчлалыг” төрүүлжээ. Бидний үед ийм сэтгэхүй газар авахыг урьдаас анхааруулсан байх бөгөөд энэ явдал нь хуульгүй байдлын нууц хүчийг бэхжүүлдэг юм.

Израильчууд Фараоны дарангуй эрх мэдэл дор байжээ. Тэгтэл

гэнэт тэдний амьдралд Мосе орж ирсэн бөгөөд тэрбээр бас л туйлын эрх мэдэлтэй байсан боловч, тэр нь арай л өөр утгатай эрх мэдэл байв. Заримдаа Мосе Израильчуудад Фараоноос ч долоон дор зовлон авчирна. Израильчууд Египетээс гарсны дараа Мосегийн зорилго дуусаад, тэд цаашаа эрх мэдэлтэй болоод, дур дураараа амьдарна гэж бодсон болтой. Хүн бүр өөртөө эзэн. Тэд чинь Бурханы хүмүүс. Тэгтэл Мосе гэж эрх ямбатан бөөн төвөг учруулаад байсан тул тэд Мосе руу бүлэглэн дайрчээ.

Би яг ийм байдлыг аялж явахдаа олонтаа харсан. Бизнесмэнүүд, зуучлан залбирлын бүлгүүд, зөвлөлийн гишүүд бүлэглэж байгаад ядарсан пастораа барьж иддэг. Тэд Бурханаас сонссон л гэнэ, пастор нь харах нүдгүй л гэнэ. Гэтэл тэд хэний сүнсээр үйлдэж байгаага мэддэг ч болоосой.

## **Сүнсний эрх мэдэл дээрээс томилгоотой**

Барууныхан Хаанчлалын зарчмыг ойлгох гэж зүдэрдгийг би өмнө хэлсэн. Бид чинь Хаанчлалаас тэс өөр буюу чөлөөт тогтолцоотой, ардчилсан улсад аж төрдөг хүмүүс. Хаанчлал нь ургийн хэлхээгээр угсаа залгамжилдаг хаантай, томилгоот удирдлагатай байдаг бол, ардчилал нь удирдагчаа сонгон гаргаж ирдэг. Энэ чөлөөт тогтолцооны системээр мөнгөтэй, чадвартай, нөлөөтэй, авьяастай хэнбугай нь ч удирдлагад гарах боломжтой. Тэгвэл Бурханы хаанчлалд ийм зүйл байхгүй. Бурханы хаанчлалд удирдагч нарыг тохоон томилно.

Есүс үйлчлэгч нарыг Өөрөө тохоон томилсон. Есүсээс өөр хүн хэнийг ч энэ байр сууринд гаргаж ирж чадахгүй. Есүс энэ томилгоог Бурханы Сүнсээр хийдэг. Бурханы томилгоогүйгээр эрх мэдлийн байр сууринд гарах нь өөрийгөө өргөмжилсөн хэрэг юм. Энэ нь дуудагдсан боловч, хараахан томилогдоогүй байгаа хүмүүст ч хамаатай. Паул “Надад соёрхогдсон нигүүлслээр би та нарын хүн нэгбүрд чинь хэлье. Өөрийнхөө талаар бодох ёстойгоосоо илүүгээр бүү бод. Харин Бурханы хүн бүрд ногдуулсан итгэлийн хэмжээний дагуу эрүүл ухаанаар бод” (Ром 12:3) хэмээн анхааруулжээ.

Еврей номын бичээч сүнсний удирдлагын байр сууринд санаархахгүй байх нь хичнээн чухал болохыг батлан хэлсэн: “Хэн ч өөртөө энэ хүндлэлийг авахгүй...” Заавал томилогдох ёстой байдгийг тэрбээр үүний өмнөх эшлэл дээр нь хэлсэн бол, цааш нь “Христ

Тэргүүн Тахилч болон Өөрийгөө үүнчлэн алдаршуулаагүй” (Еврей 5:4-5). Есүс ч Өөрөө Өөрийнхөө удирдлагын байр суурийг баталгаажуулаагүй. Түүнийг Аав нь тохоон томилсон билээ.

Паул өөрийгөө юу гэж дүрсэлсэн байгааг сонсоно уу: “Христ Есүсийн боол, дуудагдсан элч Паул, Бурханы сайнмэдээний төлөө тусгаарлагджээ” (Ром 1:1). Тэрбээр эхлээд *дуудагдсан* гээд, дараа нь *тусгаарлагдсан* гэжээ. Тусгаарлагдах гэдэг нь томилогдохын өөр нэг нэр юм. Паул аврагдах үедээ албан тушаалаа эзлээгүй байсан ч, дэлхийн сууриас ч өмнө элч байхаар дуудагдсан байжээ. Паул Антиохын чуулганы удирдагч нарт захирагдсан нь түүний шалгалтын үе байв. Энэ шалгалт хэдэн жил үргэлжилсэн бөгөөд Паул өөрийн биеэр сурсан энэхүү туршлагаасаа үүдэн удирдагч нарт: “Эхлээд тэд шалгагдаг. Тэгээд гэм зэмгүй аваас үйлчлэг” (1Тимот 3:10) хэмээн бичжээ.

Паулын амьдрал нь өнөөдөр бидний үлгэрлэн дагах ёстой сүнсний үлгэр загвар болон тогтсон юм. Паул туслах үйлчлэлдээ итгэмжтэй гэдгээ баглан харуулах шалгалтаа давмагцаа, багш нарын албан тушаал руу дэвшжээ (2Тимот 1:11, Үйлс 13:1). Бичээс албан тушаалын талаарх Эзэний тэнгэрийн зарлигийг илчилдэг: “Бурхан чуулганд нэгдүгээрт элч нар, хоёрдугаарт эш үзүүлэгчид, гуравдугаарт багш нар, дараа нь... туслахуй... тавьжээ (1Коринт 12:28).

Паул туслах талбар дээр шалгуулаад зогсохгүй, багшлах талбар дээр ч шалгуулна. Паулын багшаас элч болсон дэвшлээс Бурханы зарц нартаа зориулсан тусгаарлалын үлгэр загварыг харж болно: “Антиох дахь чуулганд эш үзүүлэгч мөн багш нар байв. Тэд Барнаб, Нигер гэгддэг Симеон, Курений Луки, захирагч Херодтай хамт өсөж торнисон Манаен, Саул нар болой” (Үйлс 13:1). Хожим Паул болсон Саул Антиохын чуулганы багш, эш үзүүлэгч нарын дунд явж байна. 1Тимот 2:11-ээс бид түүнийг эш үзүүлэгч төдийгүй, багш байсныг нь мэдэж болно. Мөн цааш нь уншбал “Тэднийг Эзэнд үйлчилж, мацаг барьж байх үед Ариун Сүнс —Миний дуудсан үйлчлэлд Барнаб, Саул нарыг надад тусгаарлагтун... гэсэн” (Үйлс 13:2) гэдэг.

Ариун Сүнс “Надад тусгаарлагтун” гэжээ. Өөрөөр хэлбэл цаг нь иржээ. Долоо хоногийн наанатай, цаанатай биш, харин яг одоо! Тэгээд Эзэн хэдийд тусгаарлах, хэнийг тусгаарлахаа шийджээ. Паул өөрийгөө элчийн дуудлагатай гэдгээ олон жил мэдэж явсан. Үүнийг нь Бурхан түүнд Дамаскийн зам дээр тохиолдсон явдлаас (Үйлс 9:15) гурав хоногийн дараа илчилсэн. Гэтэл ийнхүү олон жилийн

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

тэртээ дуудсан хүнээ Есүс одоо л тусгаарлаж байна. Паул олон жил өргөмжлөлгүйгээр итгэмжтэй үйлчилжээ.

Эзэн Паулыг томилохдоо, түүний итгэмжтэй хүчин зүтгэсэн чуулганых нь албан ёсны удирдлагаар дамжуулан томилжээ. Тэр чуулганы ахлахууд ч яг ийм маягаар томилогдсон улс байв. “Тэгээд тэд мацаг барин залбирч, тэдэн дээр гар тавиад, явуулжээ. Ийнхүү Ариун Сүнсээр илгээгдсэн тэд Селюкт ирж, тэндээсээ Кипр уруу усан онгоцоор явав” (Үйлс 13:3-4).

“Тэднийг илгээсэн” гэсэн байгааг харна уу. Паул, Барнаб хоёрыг чуулганы албан ёсны удирдлага нь илгээжээ. Үүний дараагийн ишлэл дээр “Ийнхүү Ариун Сүнсээр илгээгдсэн тэд” гэж байна. Есүс Паул, Барнаб хоёрыг албан ёсны удирдлагаараа дамжуулан, Ариун Сүнсээрээ тусгаарлажээ. Есүс үүнийг албан ёсны эрх мэдлээр дамжуулан үйлджээ.

Есүс энэ томилгоог Антиохын нэгэн зуучлан залбирагч бүлгээр юмуу эсвэл хаа хамаагүй хотын, хаа хамаагүй эш үзүүллийн бүлгээр юмуу эсвэл чуулган дахь сүнсний бэлэгтэй хувь хүнээр дамжуулж хийгээгүй.

Эзэн энэ томилгоог Антиохын чуулганы албан ёсны эрх мэдлээр дамжуулан хийжээ. Тиймээс л Бурхан “Хэн дээр ч яаран гар бүү тавь. Бусдын нүгэлд ч бүү оролц. Өөрийгөө цэвэр ариун байлга” (1Тимот 5:22) хэмээн анхааруулжээ. Удирдагч нар нь чуулганд үйлчилдэг хүмүүсийн итгэмжтэй чанарыг хянадаг. Тиймээс Бурхан тэдний зүрхэнд томилох заавар өгөх үед энэ нь Эзэний томилгоо гэдэгт тэд итгэлтэй байдаг. Шинэ гэрээний албан ёсны томилгоо ийм л байна.

## Дутуу төрсөн дуудлага

Тэгээд тэр нас дөч хүрэхэд Израилийн хөвгүүд, нутгийн ах дүү нартайгаа уулзах бодол зүрхийг нь эзэмдэв.

Тэдний нэг шударга бусаар доромжлогдож буйг тэр хараад түүнийг хамгаалан, өнөө египетийг цохин унагаж дарлагдсан хүний өшөөг авчээ. Бурханаас түүний гараар тэдэнд аврал ирэхийг ах дүү нар нь ойлгоно гэж тэрээр бодсон авч тэд нь ойлгосонгүй. Маргааш нь тэр хоорондоо зодолдогч хоёртой таарав. Мосе тэднийг эвлэрүүлэхийг хичээн “Эрчүүд ээ, та нар чинь ах дүү байж юунд бие биенээ гэмтээнэ вэ?” гэжээ. Гэтэл хөршөө бэртээж байсан нэг нь түүнийг түлхэж, “Хэн чамайг бидний дээрх захирагч, шүүгч болгосон юм бэ?” (Үйлс 7:23-27).



Мосегийн удирдлага дорх хүмүүс түүний эрх мэдлийг хүлээн зөвшөөрөөгүй. Нэг хүн Кора, Датан, Абирамын “Хэн чамайг бидний дээр шүүгч болгосон юм?” гэдэг үгийг бараг л давтаж хэлсэн. Гэхдээ Мосе томилогдоогүй байсан учраас, тэр хүн шийтгэлгүй өнгөрчээ. Мосегийн зүрхэнд Бурханы дуудлага амьсгалж байсан ч, Бурханы эрх мэдэл хараахан бууж ирээгүй байсан юм.

Хүмүүс сүүлээрээ Мосегийн дээр Бурханы эрх мэдэл байгааг үзээд, атаархандаа цөлд Мосег жадлан эсэргүүцсэн байх гэж би боддог юм. Үүнийг нь ч “хүмүүс үнэндээ Мосетэй бус, Түүнтэй тэрсэлдэж байна” гэсэн Бурханы Үг баталдаг. Тэгвэл өнөөдөр ч адилхан байдаг. Бурханы жинхэнэ эрх мэдэлтэй хүмүүс л хамгаас эсэргүүцэгддэг. Учир нь хүмүүс үнэндээ тэнгэрлэг эрх мэдэлтэй тэмцэлддэг юм.

## **Өөрийгөө томилох нь мэхлэгдсэн хүний аюулт үйлдэл**

Кора, Датан, Абирам нар Мосе рүү бүлэглэн дайрах үед Мосе хэдийнээ албан ёсны томилгоотой удирдагч болчихсон байв. Харин энэ гурав өөрсдийгөө өргөмжилсөн, бардам хүмүүс байжээ. Тэдний гаргалгаа нь дүрээ хувиргасан, аюултай тэрслэлийн хэлбэр байв. Гэтэл тэд ийнхүү тэрсэлснээрээ Бурханд үйлчилж байна гэж бодсон нь бүр ч аймаар. 250 удирдагч ч өөрсдийгөө Мосе, Аарон нарыг эсэргүүцэн, Бурханд үйлчилж байна гэж бодсон ч, хэрэг дээрээ Бурханыг эсэргүүцэж байгаагаа мэдээгүй юм. Тэд замдаа төөрөлдөөд, Мосегийн дээрх Бурханы эрх мэдлийг хараанаасаа гээхдээ, Мосегийн өөдөөс улам л дүрэлзжээ. Ийм хэрэг маш том шүүх дагуулдаг учраас, тун аюултай. Шууд Люсиферын араас л орно.

Мосе тэдгээр эрчүүдийн үгийн цаад сүнсийг таниад, нүүрээрээ хөсөр унажээ. Мосе тэдэнтэй маргаагүй. Бурханаар томилогдсон хүмүүс Бурханы зүрхийг тээдэг бөгөөд байр сууриа батлах гэж тэмцдэггүй. Мосе Бурханыг дотно мэддэг байсан болохоороо Бурхан Өөрөө түүний удирдлагыг баталгаажуулахыг мэдэж байв. Тэгээд:

Израилийн Бурхан та нарыг Өөртөө ойртуулахаар, ЭЗЭНий асрын үйлчлэлийг хийлгэхээр, хотол түмний өмнө зогсоон тэдэнд үйлчлүүлэхээр Израилийн хотол түмэн дотроос та нарыг тусгаарласан нь та нарт хангалтгүй байна уу? Тэр чамайг Левийн хөвгүүд болох ах дүүсийн чинь хамт ойртуулсан байхад та нар бас тахилч болохоор

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

эрэлхийлнэ үү? Тиймээс л чи болон чиний бүх нөхөд ЭЗЭНий эсрэг хамтдаа цугласан байна. Харин Аарон хэн болоод та нар түүний эсрэг гомдоллон гонгинолдоно вэ? гэлээ (Тооллого 16:9-11).

Тэд өөрсдийнхөө хувиас илүүг атгаад, Эзэний эсрэг бүлэглэжээ. Тэд Бурханы олгоогүй эрх мэдэлд улайрсан. Мосе: “Левийн хөвгүүд та нар арай дэндэж байна!” хэмээн ахин дахин сануулсан байдаг (Тооллого 16:7).

Тэр эрчүүд ухаажихгүй нь тодорхой болоход, Эзэн Мосед: “Хүмүүст Кора, Датан, Абирамын майхнаас холдохыг хэл” гэсэн заавар өгчээ. Тиймээс Мосе босоод, Датан, Абирамын майхан руу яаран очиход, араас нь Израилийн удирдагч нар мөр алдалгүй дагав. Тэгээд Мосе хүмүүст: “Хурдал! Энэ ёрын хүмүүсийн майхнаас холдоод, тэдэнд хамаатай юмст бүү хүр. Хүрэх юм бол, тэдний нүглээс болж та нар сүйрнэ шүү” гэжээ. Тийнхүү хүмүүс гэдрэг ухран, Кора, Датан, Абирамын майхнаас зайдуу зогсов. Датан, Абирам хоёр ч гарч ирээд эхнэрүүд, хүүхдүүд, нялхастайгаа майхныхаа үүдэн дээр зогсжээ.

Тэгтэл Мосе: “Эдгээр бүх үйлсийг хийлгэхээр ЭЗЭН намайг илгээснийг, энэ нь миний өөрийн хийж буй зүйл биш гэдгийг та нар үүгээр мэдэх болно. Хэрэв тэд бүх хүнд тохиолддог үхлээр үхэж эсвэл бүх хүний адилаар шийтгүүлэх аваас ЭЗЭН намайг илгээгээгүй болно. Харин ЭЗЭН цоо шинэ зүйлийг авчирч, улмаар газар амаа нээж, тэднийг бүх зүйлийнх нь хамт залгин, тэд амьдаараа Үхэгсдийн оронд очих аваас энэ хүмүүс ЭЗЭНийг үл тоомсорлосныг та нар ойлгох болно” гэв.

Тэрээр энэ бүх үгийг хэлж дуусмагц, тэдний доорх газар хагаран цуурч, газар амаа нээж, тэднийг болон гэрийнхнийг нь мөн Корад хамаатай бүх хүнийг эд хөрөнгөтэй нь хамт залгилаа.

Тэд болон тэдэнд харьяалагдах бүхэн Үхэгсдийн орон уруу амьдаараа доош оржээ. Газар тэдний дээр хаагдан, тэд чуулганы дундаас устгагджээ. Тэдний эргэн тойронд байсан бүх израиль хүн —Газар биднийг ч залгиж болзошгүй гэцгээн, тэдний хашхирах дуунаас болж зугтжээ. ЭЗЭНээс гал гарч ирэн, утлага өргөж байсан хоёр зуун тавин хүнийг шатаав (Тооллого 16:24-35).

Тэр хүмүүс дээр буусан хатуу шийтгэл бидэнд сэнхэрмээр хоёр үнэнийг зааж байна. Нэгдүгээрт - тэр хүмүүс өөрсдийгөө Бурханд үйлчилж байна гэж бодсон ч, хэрэг дээрээ эсэргүүцжээ. Хоёрдугаарт - Шинэ гэрээнд эцсийн өдрүүдэд дээрх хүмүүстэй адил “зүүдлэгчид махбодыг бузарлаж, эрх мэдлийг үл хэрэгсэн,

сүр жавхланг доромжилно” (и8) гэдгийг Иуда анхааруулсан. Тэгээд Иуда “Тэд золгүй еэ! Учир нь тэд Каины замаар явж, шан харамжийн төлөө Балаамын төөрөгдөлд өөрсдийгөө тушаасан бөгөөд Корегийн тэрслэлд мөхжээ” (11) гэжээ.

## **Тэрслэл даамжирдаг**

Энэ бүлэг дээр хоёр удаагийн тэрслүү үйл явдал гарч байна. Нэгдүгээрт - Кора, Датан, Абирам тэргүүтэй 250 удирдагчийн хэрэг. Хоёр дахь нь маргааш нь чуулган бүхлээрээ Мосе, Аарон хоёрын өөдөөс боссон явдал юм: Гэтэл дараагийн өдөр нь Израилийн хөвгүүдийн даяар хотол түмэн Мосе Аарон нарын эсрэг гонгинолдож —Та нар ЭЗЭНий ард түмнийг үхэлд хүргэсэн гэгцгээв (Тооллого 16:41). Тэд өчигдрийн явдалд гүнээ почирдсондоо, гонсойсон сэтгэлээ Мосед гаргажээ. Эсэргүү эрчүүдийн хүчирхэг нөлөөнд автсан чуулган тэрслүү хүмүүсийг газар залгихыг нүдээр үзсэн ч, ухаажиж эмээсэнгүй. Даанч эмгэнэлтэй. Өнөөдөр ч ийм явдал болдог.

Чуулган Мосе, Аарон хоёр руу бүлэглэн дайрсанд Бурхан хилэгнэж, тэр хүмүүсийг хүйс тэмтрэхийг хүссэн ч, Мосе, Аарон нар хүмүүсийн төлөө зуучлан гуйсны ачаар ард түмэн аврагдсан боловч, Эзэнээс буусан гамшгаар 14,700 хүн үхжээ! Өмнөх өдрийнхөөс ч олон амь!

Бурханы хүмүүс ээ, би та бүхэнд нэгэн зүйлийг анхааруулъя: тэрслэл нь халдвартай бөгөөд үхлийн эд шүү. Библи Бурхан үүнд дургүйлхсэн гэж хэлээгүй. Бурхан үүнийг үзэн яддаг гэж Бичээс тодоос тод хэлсэн. Зүгээр нэг дургүйцэхээс хамаагүй хатуу шүү. Люцифер тэрслэлнийхээ дараа тэнгэрийг орхиж явна уу гэсэн санамж бичиг хүлээж аваагүй, харин тэнгэрээс газар руу цахилгаан цахилах мэт хурдтай шидүүлсэн билээ (Лук 10:18). Тэрслүү хүн үхлээ л дууддаг. Тиймээс л Паул Ромын чуулганд хандсан эцсийн үгдээ:

Ах дүү нар аа, та нарын сурсан сургаалын эсрэг хэрүүл маргаан, саад тотгор гаргагч хүмүүсээс сэрэмжлэхийг би ятгаж байна. Тэднээс холдогтун. Тийм хүмүүс бидний Эзэн Христэд биш, харин өөрсдийн ходоодондоо боолчлогддог. Тэд ялдам зусар үг яриагаараа гэнэн хүмүүсийн зүрхийг мэхэлдэг (Ром 16:17-18) хэмээн ятгасан билээ.

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Би ч мөн Паулын энэ ятгалгаар бүлгээ төгсгөө. Энэ үг танд баяр баясал төрүүлэхгүй ч, амийг чинь аварна. Үнэний вакцин гээд л ойлгочих. Зүүгээр хатгуулах таагүй ч, амийг чинь хамгаална. Та энэ үгэн дэхь Бурханы хайрыг олж харахын төлөө залбиръя. Бурхан таныг аврах гэсэндээ л анхааруулдаг.

## БҮЛЭГ 15

# НЭГ

*Эрх мэдэл нь Бурханы алдрыг  
угтан хүлээн авах эв нэгдлийг бүтээдэг.*

**Т**энгэрийн эрх мэдэл дор амьдрахад энэ хүртэл сурсан зүйлээс маань өөр зорилго, ач тус бий юу? Хариулт нь: мэдээж бий! Энэ нь Бурханы хаанчлалыг үр нөлөөтэй ахиулах том зураглал юм.

Есүс чуулгандаа *нэг байх!* зорилго тогтоож өгсөн. Энэ зорилго нь цаанаа бүр том ашигтай. Есүс:

Би зөвхөн тэдний төлөө бус, тэдний үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн төлөө мөн гуйж байна. Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгд нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Та Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ. Бид нэг байдгийн адил тэднийг нэг байлгахын тулд Надад өгсөн сүр жавхланг тань Би тэдэнд өгсөн билээ (Иохан 17:20-22) хэмээн залбирсан.

Бидэнд хадгалагдсан алдар гэж бий. Гэхдээ алдар нь бидний эв нэгдэлтэй нягт холбоотой. Алдар нь гэдэг үгийг бид тэр бүр хэрэглээд байдаггүй. Энэ үгийг *Мирриам - Вебстерийн цахим толь бичиг* “үлэмжийн гоо үзэсгэлэн, эрхэмсэг байдал: сүр жавхлан” гэж тодорхойлдог. *Докса* гэдэг Грек үг нь ч ойролцоо утгатай. Гэхдээ *Үз судлалын бүрэн толь бичиг* дээр “Бурханы алдар нь үндсэндээ Тэр

Өөрөө болой” гэсэн утгыг илэрхийлсэн байдаг.

Хуучин гэрээн дээр *доксаг* бас *кабод* гэдэг Еврей үгээр илэрхийлдэг бөгөөд энэ нь эрхэмсэг байдал, баян тансаг байдал, хүч чадал, элбэг дэлбэг байдал, хүндэтгэл, эрхмийн дээд, хүнджин зэрэг утгыг агуулдаг. Энэ үгийн хүчийг түр бодож үзнэ үү. Библи *Бурханы алдрын* талаар ярихдаа, Түүний сүр жавхлант эрхэмсэг байдал, Түүний яндашгүй баялаг, Түүний аугаа хүчирхэг байдал, Түүний мөн чанарын баялаг, Түүний аугаа хүндэтгэл, Түүний оршихуйн сүр жавхлангийн талаар өгүүлдэг. *Хүнд жин* хэмээх эцсийн тодорхойлолт нь энэ бүх чанар нь дөнгөжхөн хэмжээгээр бус, харин тулсан хэмжээгээр оршдог бөгөөд товчхондоо энэ нь *Түүний аугаа чанарын жин* болохыг хэлж байна.

Есүс - хүн биеэр илэрхийлэгдсэн Бурхан болой. Бид Түүний: Намайг харсан нь Эцэгийг харсан (Иохан 14:9) гэдэг үгийг үргэлж санах ёстой. Эхнээсээ л Үг нь Бурхан байсныг элч Иохан мэдэгдсэн. Тэгээд цааш нь “Үг нь махбод болж, бидний дунд оршин, бид Түүний алдар сууг үзсэн” (Иохан 1:14) гэжээ. Түүний алдар олон арга замаар илэрхийлэгдсэн ч, онцгойлон Түүний хүчээр илэрхийлэгдсэн байдаг. Үүнийг маш олон хэсэг дээр өгүүлсэн байдгийн нэг нь Иохан 2:11 юм: “Есүс тэмдгүүдийнхээ эхлэлийг Галилын Канаад үйлдэж *алдраа* илчилсэнд шавь нар нь Түүнд итгэсэн юм.” Тэрбээр газар дээр алхаж явахдаа, Бурханы аугаа чанарын жинг харуулжээ.

Есүс явахаасаа өмнө “Эцэг Намайг илгээсний адил Би бас та нарыг илгээнэ” (Иохан 20:21) хэмээн бидэнд үүрэгдсэн. Есүс энэ том захирамжийг биелүүлэхэд маань *Бурханы аугаа байдлын жин* бидэн дээр байхын төлөө залбирчээ. Тийм боловч энэ амлалт нь бидний нэгэн хүн мэт байх эв нэгдэлтэй нягт холбоотой гэдгийг өмнө хэлсэн билээ. “Харагтун, ах дүүс хамтдаа нэгдмэлээр амьдрах нь Хичнээн сайхан, хичнээн тааламжтай вэ! Сахал дээгүүр нь, Аароны сахлаар доош урсан, Хувцасных нь захаар доош урсаж буй Толгой дээрх үнэ цэнэтэй тос адил юм. Сионы уулс дээр буудаг Хермоны шүүдэр адил юм. Учир нь тэнд ЭЗЭН ерөөлийг, Мөнх амийг *тушаасан* билээ” (Дуулал 133:1-3). Түүний алдар дотор байхаас - Түүний оршихуйн бүрэн дүүрнийг эдлэхээс илүү ерөөл үгүй. Энэ нь бутархай чуулганд бус, нэгдмэл чуулганд л боломжтой.

## Төгс үлгэр жишээ

Анхны чуулган үүнийг яруу сайхнаар харуулдаг. Есүсийг тэнгэр өөд өргөгдсөн хойно үнэнч дагалдагч нар нь Түүний дээд өрөөнд байгаарай гэсэн тушаалыг (Үйлс 1:4) ёсчлон биелүүлжээ. Есүс амилсныхаа дараа дөч хоногийн хугацаанд дор хаяж 500-гаад эрчүүд, эмэгтэйчүүдэд үзэгдсэн боловч (1Коринт 15:6), арваадхан хоногийн дараа Иерусалимд 120-хон хүн л үлдээд байв. Бусад зуу зуун хүмүүс нь хаачив? Бид үүнийг мэдэхгүй ч, ямар ч байсан тэр хүмүүс Аавын амлалтыг хүлээгээрэй гэсэн Есүсийн тушаалыг сонсоогүй нь тодорхой байна.

Дээд өрөөнд байсан эрчүүд, эмэгтэйчүүд Түүний Үгийн эрх мэдэл дор - Түүний шууд эрх мэдэл дор нэгджээ. Тэд Есүсийн төлөөний эрх мэдэлд хэрхэн хандсан бол?

Есүс явахаасаа өмнө дагалдагч нараа Петрт даалгасан юм. Петр нөгөөдүүлээсээ арай илүү байжээ. Петр Бурханы арга замыг мэдэхийн төлөө өлсөж цангаж явдгаа харуулж, бусдад нь ирээгүй ойлголтыг хүлээн авч, бусад дагалдагч нартаа нөлөө бүхий байв. Тэрбээр яалт ч үгүй удирдах бэлэгтэй байжээ. Тийм боловч нөгөөтэйгүүр Петр маань эрс тэс авирлаж, Бурханаас алхаа гишгээ зөрөх тохиолдол бишгүй л байв. Петр Есүсийг амьд Бурханы Хүү Есүс Христ хэмээн зоригтой тунхаглахад, Есүс түүний ухаарлыг сайшаагаад, өөрт нь тэнгэрээс илчлэгдсэн энэ үнэний төлөө Петрийг ерөөгдөнө гэсэн байдаг. Гэтэл үүнээс хэдхэн эгшний дараа ийм явдал болжээ: “Тэр эргэж, Петрт — Миний араас зайл, Сатан аа! Чи Надад бүдрүүлэл болж байна. Учир нь чи Бурханы юмсыг бус, харин хүмүүний юмсыг л бодож байна гэлээ” (Матай 16:23).

Өөр нэгэн удаа бусад нь зүгээр л завиндаа үлдээд, болж буй үйл явдлыг ажиглаж байхад, Петр усан дээгүүр явсан. Петр дахиад л тэргүүлжээ. Тийм боловч хэдхэн эгшний дараа бусад нь дууриагаад, усан дээгүүр алхлахын завдалгүй, Петр живж эхэлсэн. Есүс энэ явдалд харуусаад: “Өчүүхэн итгэлтэн минь ээ, чи юунд эргэлзэв?” хэмээн айлджээ.

Бас нэгэн удаа Есүс Петр, Иохан, Иаков гурвыг дагуулаад ууланд гарчээ. Зорьсон газартаа хүрсний дараа Есүс хувирсан - Түүний царай нь нар шиг цацарч, хувцас нь цалин цагаан болсон бөгөөд Мосе, Елиа хоёр гарч ирээд, Есүстэй ярилцжээ. Ийм ер бусын үйл явдлыг гэрчлэх

нь гурван дагалдагчийн хувьд зүйрлэшгүй завшаан, хүндэтгэл байв. Гэтэл энэ үйл явдал дуусаа ч үгүй байхад, Петр майхан сүм барьж өгөх санал дэвшүүлсэн - хоёрыг нь Елиа, Мосе хоёрт зориулж барих гэнэ. Тэрбээр энэ удаа ч тэргүүлсэн боловч, Бурханы үлэмж алдрын дунд ч Түүнтэй эвлэн зохицож чадсангүй.

Есүсийг няцаасан Петрийн аймшигтай алдааг дагалдагч нар санаж л байгаа. Амиллын дараа Бурханы тэнгэрэлч булшин дээр гурван эмэгтэйд заавар өгөхдөө, Петрийг дагалдагч нараас тусад нь авч үзсэн: “Харин явж, Түүний шавь нарт болон Петрт “Тэр та нараас түүрүүнд Галил уруу явсан тул айлдсаных нь дагуу тэнд та нар Түүнийг харах болно” гэж хэл” (Марк 16:7). Тэр гурван эмэгтэй бусдынхаа л адил Петрийг буугаад өгсөн гэж л бодсон байх.

Тэгэхээр, ийм үүх түүх, намтартай хүнд шинэ чуулганы маань гишүүд захирагдаж, үгэнд нь орох болов уу? Петрийн огцом зан авир, ухаарч ойлгох арга барил, эргэцүүлэл, шийдвэр гаргах байдал нь өөгүй цэвэр гэгдэх нь байтугай, өөд нь тагчихмаар тал ч түүнд ховор байв. Петр тийм эгзэгтэй цагт ийм залуухан чуулганыг аваад явах чадвартай нэр дэвшигч байсангүй.

Үүнийг санангаа, чуулган мэндэлсэн өдөр Петрийн гаргасан анхны шийдвэрт дүн шинжилгээ хийж үзье. Хэдэн өдөр өнгөрч, Петр Дуулал номоос Есүсээс урвасан Иудагийн үйл явдалтай шууд холбоотой эш үзүүлийн үгийг олжээ. Петр Дээд өрөөнд байгаа жижиг чуулганд ийнхүү уншиж өгөв: “Харгалзах үүргийг нь өөр нэгэн аваг” (Үйлс 1:20). Петр энэ удаа ч мөн бусдынхаа хараагүйг харж чаджээ. Одоо тэрбээр энэ ойлголтоо зөв арга ухаанаар хэрэгжүүлж дөнгөх болов уу?

Одоо миний хэлэх зүйлийг арай дэнджээ гэж бодох хүмүүс гарах л байх. Гэхдээ би энэ санаагаа Бичээсээр хангалттай баталж чадна гэж боддог. Петр энэ удаа ч бас шийдвэр гаргахдаа, Бурхантай нэгэн зүг хөвж чадаагүй гэдэгт би бүрэн итгэдэг. Учир нь Петр тэдэнтэй анхнаасаа хамт байсан бүх эрчүүдийг цуглуулж байгаад, Бурхан Иудагийн оронд хэнийг сонгохыг нь “сугалаагаар” шийдье гэсэн санал дэвшүүлжээ.

Бурхан элчээ “сугалаагаар” сонгож байхыг Шинэ гэрээний хаанаас ч харахгүй! Есүс гурван жил хагас тэр эрчүүдийг сургаад, “Тэр өдрүүдэд Есүс залбирахаар ууланд гарч, бүхэл шөнийг Бурханд залбирсаар өнгөрөөв. Өглөө болоход Тэр шавь нараа Өөр дээрээ дуудаад, тэднээс арван хоёрыг сонгон, элч нар гэж нэрлэсэн” (Лук 6:12-13) үлгэр загварыг үлдээгээд явжээ. Петр уг нь Есүсийн



үлгэр жишээг дагасан бол дээр байх байж. Түүнээс гадна хэдэн жилийн дараа Антиохын чуулганы эш үзүүлэгч, багш нар Паулыг элчийн албанд тусгаарлахдаа ч Есүсийн үлгэр жишээг даган, мацаг барин залбирч байж үйлдсэн нь (Үйлс 13:1-4) Петрийн шийдвэр түргэдсэнийг батлах шиг.

120 хүн дундаасаа Юүстүс, Матиас гэдэг хоёр нэр дэвшигчийг гаргаж иржээ. Эндээс Петрийн шийдвэрийн үр жимс харагддаг. Матиас сугалаанд хожиж, элч нарын эгнээнд орсон ч (Үйлс 1:23-26) түүний нэр цаашдаа Шинэ гэрээнд нэг ч гардаггүй юм. Яагаад? Учир нь Бурхан Иудасын оронд Матиасыг биш, харин Саулыг (буюу Паулыг) сонгосон байжээ. Тиймээс л Паул:

Тэр дараа нь Иаковт, тэгээд бүх элч нарт үзэгдсэн. Бүгдийн эцэст дутуу төрсөн мэт надад ч Тэр бас үзэгдсэн билээ. Учир нь би элч нараас хамгийн өчүүхэн нь бөгөөд Бурханы чуулганыг хавчиж байсан тул элч гэж нэрлэгдэх зохисгүй хүн (1Коринт 15:7-9) гэж бичсэн юм.

Паул өөрийгөө *буруу цагт* төрсөн мэт хэлжээ. Өөрөөр хэлбэл тэрбээр анхны арван хоёрын нэг байхад хэтэрхий залуудах байж. Би Паулын төрсөн он цагийн талаар 14 жилийн наана цаанатай, хэд хэдэн хувилбар байдгийг хэдэн тооны эх сурвалжаас олж уншсан юм. Тиймээс Паулын насыг багцаалж гаргахын тулд Шинэ гэрээний үйл явдлын дарааллыг харцгаая. Ихэнх тооцооллоор Степаныг Есүсийг амилснаас дөрвөн жилийн дараа алуулсан гэж үздэг. Түүнийг чулуугаар нүүлгүүлэн алуулах үеэр Бичээс Саулын (буюу Паулын) талаар өгүүлэхдээ, “залуу хүн” (Үйлс 7:58) гэсэн байдаг. Шинэ гэрээний Грек - Англи хэлний толь бичгээс үзбэл, “залуу хүн” гэдэг энэ үг нь Грекээр бэлгийн бойжилт явагдаж байгаа хүнийг нэрлэсэн үг ажээ. Тэгэхээр, Паул үнэхээр л анхны дагалдагч нарын нэг байхад арай л багадах байж.

Угтаа Бурхан Паулыг сонгосон гэдэгт би бүрэн итгэдэг. Тэрбээр элч хүний эрх мэдэл, үр жимсийг тулгал эзэмших тал дээрээ Матиасаас хавьгүй илүү байв. Гол санаа нь: “Петр удирдагч хүнийхээ хувьд Бурханы төлөвлөгөөтэй авцалдаагүй, түргэдсэн шийдвэр гаргажээ. Хэрэв Петр өнөөдөр ийм шийдвэр гаргасан бол, түүний шийдвэрээс болж чуулган нь хуваагдах байсан биз. “Элчийг сугалаагаар сонгохыг эсэргүүцэгчдийн бүлэг” нь хаалга савж гараад, “элчийг сугалаагаар

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

сонгодог бүлгийнхэн” нь үлдэх байсан байх. Гэтэл энэ явдлын дараа юу болсныг Бичээс өгүүллрүүн:

Пентэкостын өдөр болоход тэд цөмөөрөө нэг газар цугласан байлаа (Үйлс 2:1).

*Цөмөөрөө* гэдэг нь *хомотумадон* гэдэг Грек үг болно. Энэ үгийн утгыг *Үг судлалын бүрэн толь бичиг* дээр “Нэгэн бодлоор, нэгдмэл сэтгэлээр гаргасан шийдвэрийн дагуу, нэгэн саналаар, бултаараа хамт” гэж тодорхойлдог. Тэд зорилго, бодол, зүрх, сүнсээр нэгдмэл байжээ.

Энэ ган бат нэгдлийнх нь үр дүн юу байв? Бурхан хаана байгаа нь мэдэгдэхгүй 380 хүн дээр бус, харин зүрх, бодол, үйлдлээрээ нэг байсан тэр 120 хүн дээр алдраа илэрхийлжээ. Христийг дагадаг тэр хүмүүсийн дээр буусан Бурханы алдраас болж Иерусалим хот үндсээрээ өөрчлөгдсөн юм.

Дээд өрөөнд байсан эрчүүд, эмэгтэйчүүд хоёр шалтгааны улмаас Петрийн зааварт үг дуугүй захирагджээ: Нэгдүгээрт - хэдийгээр энэ нь Бурханы төлөвлөгөөтэй авцалдахгүй байсан ч, элчийг сугалаагаар сонгох нь нүгэл байгаагүй. Хоёрдугаарт - тэд Бурханы төлөөний удирдагчид бүрэн захирагдсан.

Бурханы шууд бөгөөд төлөөний эрх мэдэл нь хоорондоо харилцан холбоотой гэдэг Библийн үнэн дахин батлагдаж байна. “Би Бурханд захирагддаг” гэх атлаа Бурханы удирдагч нарыг эсэргүүцдэг хүмүүс байна. Тэд бол мэхлэгдсэн хүмүүс. Тэд үнэхээр л Бурханд захирагддаг юм бол, хоёр шалтгаанаар удирдагчдаа ч захирагдах ёстой: Нэгдүгээрт - Бурханы шууд эрх мэдэл биднийг удирдагч нартаа захирагдахыг тушаадаг. Хоёрдугаарт - бид удирдагч нарынхаа дээр буй Бурханы эрх мэдлийг таньдаг учраас, удирдагч нартаа захирагддаг. Тиймээс удирдагч нар биднээс нүгэл үйлдэхийг шаардаагүй тохиолдолд удирдагч нараа дагах нь ач тустай, бурханлаг зүйл юм. Энэ маань Бурханы яруу алдрыг гийгүүлж, хаанчлалыг хурдацтай тэлэх үүдийг нээнэ.

## Хатуу үнэн

Бид дараах хатуу асуултыг асуух хэрэгтэй.

- Бид чуулганыхаа эрх мэдэлд захирагддаггүй байдлаараа

Бурханы алдрын илэрхийллийг бууруулж байна уу?

- Бид зөвшөөрөх эс зөвшөөрөхөөсөө хамааран захирагдаж байна уу?
- Бид чуулган хагалан бутлах ажилд оролцсон уу?

Дээд өрөөнд Петрийг гаргасан шийдвэртэй санал нийлээгүй дагалдагч нар байсан л байх. Есүсийн үлгэр жишээг дагасан бол, дундаасаа нэг хүнийг шалгаруулахаасаа өмнө эхлээд Бурханаас асуух нь мэдээж зөв байх байв. Энэ нь сугалаа явуулж, Бурханы дуудаагүй хүнийг Бурханы томилоогүй албанд тавьж байснаас л дээр арга.

Энэ хэргийг хавьгүй дээр аргаар шийдэж болох байсан ч, дээд өрөөнд байсан хүмүүс *нэг байх* нь юу юунаас эрхэм болохыг ойлгож, удирдагчийнхаа стратегийг даган, хүн бүр яг *өөрийнх нь* санаа мэт давшжээ. Гэтэл бид үйлчлэлийн тал дээрх өчүүхэн, тэнэг зөрөлдөөнөөсөө болоод хэд хагаралддаг билээ? Эсвэл Есүс их зовлонгийн өмнө ирнэ, дундуур нь ирнэ, дараа нь ирнэ гэх мэт биднийг хуваах ёсгүй доктрины итгэл үнэмшлээсээ болоод хэдэн тийшээ сална. Бид пасторыг хослол биш, жийнсэн өмд өмслөө гэж дургүйцдэг. Бид хүндэтгэлийн цуглааны үеэр тайз чимэглэдэг утааны төхөөрөмж, гэрэлтүүлгэд дургүйцдэг. Эсвэл пастор хэтэрхий урт юмуу богино номлолоо гэж дургүйцдэг. Бид ийм, тийм сэдвээр залбирсангүй гэж бас ийм, хурдан, тийм удаан залбирлаа гэж дургүйцдэг. Энэ гомдол урсаад л байна. Дүгнэж хэлэхэд - бид хэтэрхий амархан хуваагдах юм. Хамгийн аюултай нь чуулганы хуваагдал заримдаа тийм ч амархан танигддаггүй. Шинэ гэрээ бидэнд үйлдлээрээ төдийгүй, бүх талаараа нэгдмэл байгаарай гэсэн. Ганц, хоёр жишээ хэлэхэд:

...адил сэтгэж, адил хайртай байж, нэгдэн, нэгэн бодолтой байж, баярыг минь гүйцээ (Филипой 2:2).

Эцэст нь, ах дүү нар аа, баярлагтун. Цэгцэрцгээ. Ятгалгыг ав. Санаа нэгтэй байж, амар тайван амьдрагтун. Хайр ба амар тайвны Бурхан та нартай хамт байх болно (2Коринт 13:11).

Христийн сайнмэдээнд л зохистой амьдар. Тэгвэл би ирээд, та нарыг харлаа ч эсвэл байхгүй байлаа ч та нарыг сайнмэдээний итгэлийн төлөө нэг сэтгэлээр хамтдаа зүтгэж, нэг сүнс дотор бат зогсоцгоо (Филиппой 1:27).

Хуваагдлыг зүгээр нэг үг, үйлдлээр зөрөлдөх явдлаар хязгаарлаж ойлгож болохгүй. Энэ нь тархи, зүрх, сүнс рүү гүн явдаг зүйл. Бид гаднаа нэгдмэл байж болох ч, сэдэл, бодолдоо хуваагдмал байж болох. Ээж, аав хоёр маань Флоридагийн Зүүн эргийн хот болох Веро Эрэг дээр олон жил аж төрсөн билээ. Тэндээс хорь гаруй км зайтай Себастианы үүд гэдэг газар бий. Тэр нутаг хүчтэй сөрөг түрлэгээрээ алдартай. Сөрөг түрлэг гэдэг нь нүдэнд шууд харагддаггүй байгалийн үзэгдэл юм. Далайн толион дээрх ус бүхлээрээ эрэг рүү хуйлран орж ирж байгаа мэт харагдав ч, толион доогуурх ус нь бүх хүчээрээ далайн гүн рүүгээ хуйларч байдаг. Тэгээд замдаа таарсан бүхнийг хаман, задгай далай руу авч одоодоо, ихэвчлэн сүйрэлд хүргэнэ.

Тэгвэл чуулган дотор Бурханы алдрыг илэрхийлэхээс хорьж байгаа сөрөг түрлэгүүд байгаа юм биш биз? Нэгдмэл дагалдагч нарын хүчээр Иерусалим тэр аяараа сүр хүчтэйгээр Есүсийн амилал, Түүний оршихуйн аугаа байдлыг сонссон. Тухайн үед энэ үйл явдлыг суртчилах зурагт, радио подкаст зэрэг олон нийтийн сүлжээ байгаагүй боловч, тэр зарлагдаагүй ер бусын уулзалтаар мянга мянган хүн аврагдсан юм.

Тэгэхээр “Бидний хэд маань Есүсийн шүүх сэнтийн өмнө зогсоод, Түүний илэрхийллээр цочирдож, балмагдах бол?” гэдэг санаж сэрж явмаар нэгэн асуултыг тавьмаар байна. Бид үйлдлээрээ Бурханы Сүнсийг нийгэмдээ илэрхийлэхэд саад хийснийг Есүс уйлан байж илчлэх болов уу? Бидний зөрчил үй олон хүнийг аврал руу ирэхээс хорьсон сөрөг түрлэг болжээ. Бид удирдагчтайгаа зүрх, бодол, үйлдлээрээ үл зөвшилцжээ. Тийм ээ, бидний зөв байсан байж болох. Үнэхээр ч тухайн ажлыг хийх илүү дээр, илүү Бичээсийн арга ухаан, арга зам байсан байж болох. Гэхдээ зөв байх нь чухал уу, Бурханы алдар дор байх нь чухал уу? Зөв байх нь чухал уу, Бурханы хаанчлалд олон хүн орох нь чухал уу?

## Ялгаатай арга барил

Удирдагч нар тэнгэрийн төлөвлөгөө, арга ухааныг олж хардаггүй нь нууц биш. Би ч бас удирдагч хүнийхээ хувьд гаргаж явсан тааруухан шийдвэртээ дагжин гашуудаж байна. Гэхдээ тэр тохиолдолд ч Бурхан зорилгоо биелүүлэхдээ л биелүүлдэг нь гайхмаар - ялангуяа биднийг нэгдмэл байгаа тохиолдолд. Би үүнийг Бурханы хүслийг хайх

шаардлагагүй гэдэг утгаар хэлээгүй, харин над шиг алдаж энддэг удирдагч нарт тайтгарал авчрах гэсэндээ л хэлж байгаа юм.

Одоо биднийг нэгдмэл байхаас хорьдог, өөр нэгэн хатуу үнэнийг хэлмээр байна. Энэ нь чуулганы олон янзын үйл ажиллагааг ойлгохгүй байх явдал юм. Өөрөөр хэлбэл, нэгэн зорилгыг биелүүлэх олон янзын арга зам байна. Чуулган дотор олон янзын бэлэг, албан тушаал байдгийг Паул Коринтын чуулганд хэлсэн атлаа “*Үйлдлүүд нь ялгаатай ч бүгдийн дотор бүхнийг үйлдэгч нь мөнөөх л Бурхан юм*” (1Коринт 12:6) гэж бичжээ. Өөрөөр хэлбэл, Хаанчлалын үйлчлэл нь олон төрлийн арга барилаар амжилттай ажилладаг ажээ.

Элч Паул чуулганд заавар өгөхдөө цэргийн нэр томъёо их хэрэглэсэн байдаг. Энэ нь зүйрлэл биш юм. Учир нь бид үнэхээр газар дээрх Бурханы цэргүүд билээ. Манай Америкийн зэвсэгт хүчинд арми, усан цэрэг, агаарын цэрэг, тэнгисийн цэрэг, эргийн хамгаалалт зэрэг олон төрлийн нэгтгэл анги бий. Эдгээр нэгтгэл анги нь өөр, өөрийн гэсэн, давтагдашгүй онцгой үйл явцаар үүргээ биелүүлдэг боловч, улсаа хамгаалж, эх орныхоо төлөө зүтгэх гэсэн ганц л зорилготой.

Агаарын хүчний цэрэг хүн Америкийн Агаарын цэргийн хүчний цэрэг шиг ажиллахын тулд тусгай бэлтгэл хийнэ. Тэрбээр нэн ялангуяа агаарт ажиллах тал дээр тусгайлан сургагддаг. Учир нь энэ нэгтгэл анги нь гол төлөв агаарыг батлан хамгаална. Гэтэл тэрбээр армид элсэх болвол, дахиад л эхнээсээ сургагдана. Мэдээж аль аль нэгтгэл ангид нь давхацдаг техникууд бий л дээ. Тийм боловч арми нь агаарын хүчнээс нилээд өөр бөгөөд гол төлөв газар дээр үйл ажиллагаагаа явуулдаг болохоор, агаарын хүчинд зүтгэдэг байсан цэрэг маань олон шинэ тактикийн маневр, байлдааны стратегид суралцах ёстой болно.

Энэ дүрслэлийг бодонгоо, Коринтын чуулган бичсэн Паулын үгийг харъя:

Тиймээс та нараас гуйя. Намайг дуурайгсад бай (1Коринт 4:16).

Паул тэр чуулганд өөрийг нь дуурай гэжээ. Тэрбээр өнгөрсөн удаагийнх шиг “Би Христийг дуурайдаг шиг, намайг дуурай” (1Коринт 11:1) гэж хэлээгүй байна. Энэ нь ч учиртай. Үүнийг түүний дараагийн үг тодруулж байна:

Тиймээс та нараас гуйя. Намайг дуурайгсад бай. Үүний улмаас би Эзэн доторх миний хайрт, итгэлт хүү болох Тимотыг та нарт илгээв.

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Хаа сайгүй чуулган бүрд би хэрхэн сургадгийн адил Христ [Есүс] доторх замуудыг минь тэр та нарт сануулах болно (1Коринт 4:16-17).

Тэрбээр чуулганд (өөрийнхөө байгуулсан чуулганд) өөрийгөө дуурай гэж хэлээд, дараа нь “Үүний улмаас... Тимотыг та нарт илгээв” гэжээ. Тимотыг илгээдэг нь ямар учиртай юм? *Христ доторх Паулын арга замуудыг* тэдэнд сануулж байхын төлөө. Тэрбээр: “Тимот на нарт Христийн доторх Иаковын арга замуудыг сануулах болно” гэж бичээгүй. Иаков чуулганы элч байсан уу? Байсан! Тэр бурханлаг удирдагч байсан уу? Мэдээж! Иаков Паулаас ч өмнө элч болсон уу? Тэгсэн. Түүний зам, арга барил үйл ажиллагаа нь Паулынхаас өөр байсан уу? Байсан. Паулын заавар нь Христ доторх Иаковын замыг хүчингүй болгосон уу? Яалаа гэж! Тийм боловч Иаковын замууд нь Паулын төрүүлсэн Коринтын чуулганд тохирохгүй байв. Яг л *агаарын хүчний* арга замууд нь усан цэрэгт тохирдоггүйтэй л адил. Мэдээж нийтлэг арга замууд байх ч, ялгаатай арга зам ч олон.

Үүнийг цааш нь жаахан лавшруулж үзье л дээ. Паул Тимот тус чуулганд Христ доторх “элч Петрийн арга замыг заана” эсвэл “элч Иудагийн арга замыг заана” гэж ч хэлээгүй. Паул энэ чуулганыг төрүүлсэн бөгөөд цаашдаа ч тэнд өөрийнхөө удирдлагын соёлыг тогтоосоор байна. Түүний арга барил нь бусдынхаас өөр байсан ч, Христийн суурь сургаальтай таарч байсан. Анхны чуулганы бүх удирдагч нар нэг л ижил суурь итгэл, сургаальтай байсан. Тийм боловч тэд бүх үндэстнийг дагалдагч болгох захирамжийг биелүүлэхдээ өөр, өөр арга барилыг хэрэглэж байжээ.

Энэ үнэнийг өөрийнхөө чуулган дээр аваад үз. Танай чуулганыг Жим Смит гэдэг пастор гэргий Лизагийнхаа хамт удирддаг гэж бодъё. Тэр хоёр удирдлагын багтайгаа хамт Бурханы нигүүлслээр чуулганаа мянга таван зуун хүнтэй болтол өсгөх явцдаа удирдлагынхаа хэв маягт тохирсон, өөрийн гэсэн соёл, арга барилыг тогтоожээ. Тийнхүү танай чуулганы үр жимстэй байдал ч нийгэмд чинь маш эерэгээр нөлөөлжээ. Танай чуулган нутагтаа алдаршсан боловч, нутгийн дээс даваагүй ажээ.

Тэгтэл өөр нэг газар дэлхий даяар алдаршсан, өөр нэгэн чуулган байжээ. Тэр чуулганыг Доуг Жонс пастор гэргий Хитэрийн хамт удирдана. Тэр хоёр шинэ чиг хандлагыг үүсгэн бий болгож, цоо шинэ арга замаар удирдан, танай пасторуудаас хавьгүй олон хүнд нөлөөлжээ. Тэгвэл та хэнийх нь арга замыг дагах вэ? Жонсынхоны юу,

Смитийнхэний юу? Мэдээж дэлхийд алдартай пасторуудын арга замыг дагаж, тэдний арга барилыг хэрэгжүүлэхэд удирдагч нараа ятгах өдөөлт төрнө. Гийм боловч та эв нэгдэл, алдрын төлөө Коринтын чуулгантай л адил өөрийнхөө удирдагчийн замыг мэдэж, дагахын төлөө явах ёстой. Таны удирдагч нар чинь Жонсынхон биш, Смитийнхэн билээ.

## Шонхорын нүд

Миний бие гуч илүү жил долоо хоног бүр даян дэлхийгээр нисч байна. Дөчин есөн муж, жар гаруй улсын мянга мянган конференцэд оролцох нь миний хувьд том завшаан байлаа. Олон чуулганы олон үйл ажиллагааг гэрчлэн харах ч завшаан тохиосон. Би хаа нэг газар уригдахдаа, урьдаар тухайн чуулганы соёлыг судладаг.

Мэдээж та манай гэрт зочлохдоо, надад гэрээ яаж авч явахыг заахгүй шүү дээ. Та манай гэрийн ёсыг л дагана. Бид хэдэн цагт оройн хоолоо идэх бас юу идэхийг зочин маань шийдэхгүй. Харин ч: “Оройн зоог хэдэн цагт билээ?” л гэж асууна. Тэгээд оройн хоол бэлэн болмогц ирээд, дайлж байгаа хоолыг маань таалан зооглоно.

Би аль нэг чуулганд зочлохдоо удирдагчаас нь: “Би тайзан дээр юу өмсөх ёстой вэ?” гэж асуудаг. Тэгээд дараа нь пасторыг нь бүх талаар дэмжиж оролцоно. Нэг удаагийн конферецэд жийнсэн өмд, чөлөөт цамц цүнхэлж аваад очтол, намайг онгоцны буудал дээрээс бүрэн хослолтой дөрвөн хүн угтаад, гадаа хүлээж байсан хоёр цагаан лимузиндээ суулгаж аваад, зочид буудал, цуглаан руу зөөснийг санаж байна. Би л тэдний тэргүүн пастор байсан бол, зочдоо тэс өөрөөр угтах байсан. Би цэмцгэр сайхан машинд хүүгээ юмуу найдвартаа ажилчнаа суулгаад, онгоцны буудал руу илгээх байсан. Гэхдээ тэр конференц манай конференц биш. Тэр чуулганд гадаад хүндэтгэлийг дээд зэргээр үздэг байв. Би ч авчирсан хувцас маань тэдний соёл, арга барилыг доромжилсон явдал болохыг ухаараад, тэр даруй зохих ёсны хослол авчруулав.

Зочин хүнийхээ хувьд би: “Та намайг яаж яриасай гэж бодож байна?” гэж асуудаг. Тэгээд хүсэлтийг нь хүндэтгээд, усыг нь уухдаа ёсыг нь дагана. Гэхдээ би дандаа ийм байгаагүй ээ. Би миний итгэлийн баатар болсон Томми Барнеттай арван таван жил өдөр тутам сайхан нөхөрлөсөн билээ. (Хуучин Финикс Фёст Ассамбли нэртэй байсан түүний чуулган эдүгээ Финикс Дриим Сентер нэртэй болсон бөгөөд

Томмигийн хүү нь тэргүүн пастораар нь үйлчилж байгаа) Эхний Бүтэн сайны өглөө нь Томми надад номлож, үйлчлэх дөчин минут олгов. Тэд надад тайзан дээрээс цаг харагдана бас цаг дуусч байгааг сануулж хэлнэ гэдгээ мэдэгдэж, хэлснийхээ дагуу хийсэн боловч, би арваад минут хэтрүүлчихэв.

Цуглааны дараа Томми надтай нэг ч дуугаралгүй, шууд гарч явсан юм. Би ч түүнийг гонсгор байгааг мэдлээ. Тэгээд хийсэн хэргийнхээ төлөө үдээс хойшжингоо шаналав. Оройн цуглааны өмнө түүний албан өрөөнд хоёулханаа сууж байхдаа, би Томмигоос өглөөний явдалд уурласан эсэхийг асуулаа.

Томми надад: “Тийм ээ, уурласан” гэв.

Би: “Хэтэрхий удаан номлосон учраас уу?” гэж асуулаа.

Томми: “Тийм!” гэв.

Тэгээд хэсэг дуугүй байснаа: “Жон, би чамайг хайрладаг. Тиймээс яагаад гонсойсноо хэлье. Манайд цагийн хуваарь хариуцаж ажилладаг хэд хэдэн хүн бий. Хүүхдийн цуглаан маань том цуглааныхаа цагийн хуваарийг дагаж хуваариа гаргадаг. Тиймээс чи арван минут хэтрэхэд л хүмүүсийн цаг хайран болно. Манайд хүмүүсийг буцаад дүүрэг хороолол руу нь зөөдөг гучаад автобус бий. Тэд бүгдээрээ гадаа ажлаа алдаад л хүлээж байна. Ийм л байна.”

Гэх мэтээр өгүүлэв.

Тэгээд тэрбээр эцэст нь: “Чи манай соёлыг хүндэтгэлгүй, арван минут хэтрүүлж ярьсан” гэж хэлж билээ.

Би энэ явдлаас хэзээ ч мартахааргүй том сургамж авсан даа.

Цуглаанд зочилж заахдаа, би удирдагчаас нь: “Хүмүүсийг авралд дуудахдаа урагш нь гаргаж ирүүлэх үү эвсэл суудал дээр нь зогсоох уу эсвэл зүгээр л гарыг нь өргүүлэх үү?” гэж асууна. Би тэргүүн пасторынх нь хүсэлтийг анхааралтай сонсоод, тэдний соёлыг илэрхийлдэг. Хүн дээрх гурван нөхцлийн аль алиар нь аврагдаж болно гэдэгт би үнэн голоосоо итгэдэг.

Эдгээр нь миний асуудаг асуултын хэдхэн нь. Заримдаа миний төлөвлөгөө тэр чуулганы соёлоос ялгаатай боловч, илүү дээр байвал, тэргүүн пастораас нь яльгүй өөрөөр хийж болох эсэхийг асуудаг. Тэд ч асуусанд маань баярладаг бөгөөд бараг л ямагт таатайгаар зөвшөөрдөг юм.

Энэ мэтчилэн олон янзаар дүрсэлж болох. Гэхдээ ерөнхий зорилго нь тухайн удирдагчийн байгуулсан “Христ доторх замууд” дотор



ажиллах гэдгийг ямар ч байсан та ойлгосон байх аа. Тийм боловч удирдагч хүн: “Бид авралд дуудах явдалд итгэдэггүй. Учир нь Есүс бол Бурханд хүргэх цорын ганц зам гэдэгт бид итгэдэггүй. Бид мөнхийн аминд хүргэх олон замд итгэдэг” гэх юм бол, би тэдний арга замыг дагахаас татгалзана. Учир нь энэ нь үйлчлэлийн арга замын асуудлаас халиад, Христэд итгэх итгэлийн суурь үнэнийг эсэргүүцсэн явдал болчихож байгаа юм.

Би гуч гаруй жил Христийн биеийг шонхорын нүдээр ажиглахдаа, энэ суурь үнэнийг үл хайхарсан хүмүүсийн үй олон эмгэнэлт төгсгөлийг гэрчлэн харсан билээ. Хүмүүс удирдлагад гарч, Библийн сургуульд явахдаа, тэндээс өөрийнхөө чуулганыхаас тэс өөр соёлыг гэрчлэн хардаг. Библийн сургуулиудын цаана тухайн сургуулийн соёлыг тогтоож өгдөг, том, том чуулганууд оршино. Тиймээс Библийн сургуулийн оюутнууд нь тэр том чуулганы үйл ажиллагааг сургууль дээрээ ч, Бүтэн сайны хүндэтгэлийн цуглаан дээр ч мэдэрнэ.

Төгссөнийхөө дараа оюутнууд маань гал тээсээр хариад, өөрийнхөө чуулганы соёлыг өөрчлөх гэж оролдоно. Тэдний сурсан арга зам нь илүү ач холбогдолтой, үр нөлөөтэй, зөв байж болох. Гэхдээ тэр л янзаараа зүтгээд байвал, нөгөө сөрөг түрлэг болж хувирах аюултай. Санал болгосон арга зам чинь няцаагдах үед залбираад, Бурханаас энэ янзаараа цаашаа үргэлжлүүлээд байх уу эсвэл удирдагчийнхаа арга барилд бүрэн зүрхээр захирагдах уу гэж асуух хэрэгтэй.

Би залуу пастор байхдаа, үйлчлэл нь янз бүрийн үйл ажиллагаа, техник, арга барилаар ажилладгийг мэддэггүй байснаасаа болоод пастортайгаа ана мана үзэлцдэг байжээ. Би Луизианагийн чуулганд очоод, тэдний хэрэгжүүлж байгаа шилдэг арга барилд автан, амжилтанд нь ухаанаа алдахдаа, цааш нь лавшруулан харж, манай чуулганд таарах эсэхийг нь эргэцүүлж чадаагүй юм. Эргээд бодоход, Луизианагаас авчирсан арга барил маань манай пасторын “Христ доторх замтай” огт таарахгүй байсныг тодорхой ойлгодог. Луизианагийн чуулганы тэргүүн пастор нь манай пастораас тэс өөр хүн байсан юм. Хэн, хэн нь Бурханы хаанчлалд үй олон хүнийг нэвтрүүлж байгаа, дэлхий даяар дагалдагч нартай, нэр нөлөөтэй хүмүүс боловч, ажилладаг арга барил нь аргагүй ялгаатай байжээ.

Нийгэм өнөөдрийнх шиг хурдтай хувьсан өөрчлөгдөж байсан үе түүхэнд үгүй байх аа. Дийлэнх хүмүүс амьдралдаа нэг бус удаа орон байраа сольдог. Шинэ нөхөрлөл шинэ соёлыг дагуулдаг. Бид шинэ

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

соёлд зориуд суралцах ёстой. Бусдын “Христ доторх замуудад” аль болох хурдан дасах тусам, хувь хүнийхээ хувьд ч, Христийн биеийн хэсгийнхээ хувьд ч хурдан бэхжинэ.

## МАГАДЛАЛ БА ТӨГСГӨЛ

*Жинхэнээсээ аврагдсан бөгөөд  
Бурханы хүслийг хайж байгаа хүн  
чуулган доторх хууль ёсны эрх мэдлийг  
хүлээн зөвшөөрөх л болно.*

**Ө**мнөх бүлгүүдээр чуулганы болоод нийгмийн эрх мэдэл дээр төвлөрсөн боловч, үндсэн зарчим нь бүх төрлийн эрх мэдэлд хамаатай болохыг хэлсэн. Тэгвэл энэ бүлгээр эрх мэдлийн бүх талбарын талаар буюу онцгойлон гэр бүл доторх эрх мэдлийн талаар Бурханы Үг юу заадгийг үзье. Ихэнх нь өөр, өөрийн гэсэн ангилалдаа л зохицдог учраас, заавал тусгайлан авч үзэх хэрэгтэй. Энэ бүлгийн сэдвээр бүхэл бүтэн ном ч бичиж болно. Гэхдээ бид өмнө сурсан зүйлээ энэ бүлгийнхээ сургамж дээр хэрэгжүүлсэн цагт ном маань бидний зүрхэнд төрөх болно. Үүнээс гадна ном бичихэд арай л дутмаг учраас, дурьдаад өнгөрөхөд л болох, зарим нэг ерөнхий зааврыг цухас үзнэ. Эдгээр шалтгааны улмаас энэхүү бүлгээ “Магадлал ба төгсгөл” гэж нэрлэлээ.

### Гэр бүл

Чуулган, иргэний засаглал, нийгмийн эрх мэдэл үүсэхээс өмнө гэр бүл үүссэн. Гэр бүл нь бүх бүтцийн язгуур учраас, гэр бүлээс л чуулган,

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

иргэний засаглал, нийгмийн эрх мэдлийн эрүүл мэнд шалтгаална. Та төлөөний эрх мэдлийн бусад талбар дээр алдаж эндсэн байлаа ч, гэр бүл чинь тусдаа бат бэх оршин тогтнож чадна. Харин сүйрсэн гэр бүлтэй хүн бусад тал дээрээ эв эрүүл, сав саруул байх ямар ч боломжгүй. Гэр бүл доторх эрх мэдэл нь бусад бүх эрх мэдлийн амин суурь юм.

Бичээс гэр бүл доторх тэнгэрлэг эрэмбэ дарааг зааж өгдөг:

Хүүхдүүд ээ, бүх талаар эцэг эхдээ дуулгавартай байгтун. Энэ нь Эзэнд таалагдана (Колоссай 3:20).

Учир нь Христ чуулганы тэргүүн байдгийн адил нөхөр нь эхнэрийнхээ тэргүүн юм. Христ Өөрөө тэр биеийн Аврагч мөн.

Чуулган Христэд захирагддагийн адил түүнчлэн эхнэрүүд нөхрүүддээ бүх талаар захирагд (Ефес 5:23-24).

Гэр бүл доторх Бурханы эрх мэдлийн бүтцийг зааж өгсөн тушаал Шинэ гэрээнд олон бий. Хүүхдүүд нь бүх зүйл дээр буюу амьдралынхаа *талбар* бүр дээр аав, ээжийгээ дагах ёстой. Энэ тушаал нь гагцхүү аав, ээж нь үр хүүхдээ бэлгийн харилцаа, худлаа ярих, хулгай хийхэд уруу татах, аав, ээжийнхээ хэн нэгийг сонго хэмээн албадан тулгах зэрэг Бурханы Үгийг зөрчсөн хэрэг хийлгэх гэсэн нөхцөлд л хэрэгжихгүй.

Миний өөрийн амьдралд тохиолдсон нэгэн явдал үүнийг маш сайн дүрслэх байх. Би Пердюгийн их сургуульд механикийн инженерээр суралцаж байхдаа, Есүс Христэд амьдралаа өргөсөн бөгөөд төдөлгүй Сайн мэдээний үйлчлэлд дуудагдсан билээ. Тэгээд сургуулийнхаа амралтаар гэртээ ирэхдээ улаан Католик аав, ээждээ сургуулиа дүүргээд, Библийн коллежид явах гэж байгаагаа хэлэв. Тэд миний мэдээнд гонсойж, хэтэрхий огцом шийдвэр байна гэж дүгнэсэн юм. Үнэндээ ээж маань: “За хүү минь, намайг л амьд байхад тэгэхгүй шүү!” гэж хэлж билээ.

Тэгэхээр нь би ээжийгээ хүндэтгэн, даруухнаар: “Ээж ээ, би тандаа хайртай. Миний төлөө хийсэн бүхэнд чинь талархаж явдаг. Гэхдээ би Бурханыг дагах ёстой!” гэж хэлсэн юм. Гэтэл энэ үг ээжийг маань тайтгаруулах нь бүү хэл, улам хилэгнүүлэв.

Есүс “Эцгээ юмуу эхээ Надаас илүү хайрлагч нь Миний хувьд зохистой нэгэн биш. Хүүгээ эсвэл охиноо Надаас илүү хайрлагч ч Миний хувьд зохистой нэгэн биш ээ” (Матай 10:37) гэсэн. Би энэ

тэргүүтэй Бичээсийн Үгээр зоригжин, хайртай аав, ээж хоёрыгоо юмуу Есүсийн дуудлагын аль нэгийг нь сонгох ёстой болсноо ойлгохдоо, сонголтоо шууд хийсэн юм.

Хурцадмал байдал олон жил үргэлжлэв. Би ч аав, ээжийгээ хайрлан хүндэтгэсээр байлаа. Үнэндээ Бурханы нигүүлслээр хуучнаасаа ч илүү хайрлан хүндэтгэх болов. Цаг хугацаа өнгөрсөөр, аав, ээж хоёр маань миний амьдралд Есүсийн тордон ургуулсан үр жимсийг үзэж эхэлсэн бөгөөд арван найман жилийн дараа буюу аавыгаа 79-тэй байхад надад аав, ээж хоёртойгоо авралынх нь төлөө залбирах завшаан тохиож билээ. Үүний дараагаас аав, ээж хоёр маань бидний номыг уншиж, хичээлийг үзэж, найзууддаа бэлэглэдэг болсон юм. Бидний харилцаа үнэхээр ерөөгдөв.

Есүс ч ийм л байсан. Есүс аав, ээждээ аль хэр захирагддаг байсныг “Тэгээд Тэр тэдний хамт явсаар Назарт ирж, үгэнд нь дуулгавартай байлаа. Энэ бүхнийг эх нь зүрхэндээ нандигнан хадгалж байв (Лук 2:51) гэдэг үгээс харж болно. Тийм боловч үйлчилж эхэлснээс нь хойш Есүсийг нялх байхад нь Симеоны эш үзүүлсэн ёсоор илд исгэж, зүрх, бодлуудыг илчилж эхлэжээ (Лук 2:35). Есүсийн хүчирхэг үг олон хүнийг тавгүйтүүлж, уурлуулсан - тэр дундаа гэр бүлийг нь. Тэдний мэдрэмж нь буцалсаар, дараах байдалд тулжээ:

Тэр ухаан мэдрэлээ алджээ гэж тэд ярьсан тул хамаатнууд нь үүнийг сонсоод Есүсийг авчрахаар явав... Есүсийн эх болон дүү нар ирээд гадаа зогсож, Түүнийг дуудуулахаар хүн оруулав. Есүсийг ард олон тойрон сууж байлаа. Тэд Түүнд —Хараач. Эх, дүү нар тань Таныг асуугаад гадаа байж байна гэхэд Тэр тэдэнд хариулан —Хэн Миний эх, хэн Миний дүү нар юм бэ? гээд Өөрийг нь хүрээлэн суугчдыг харж, —Харагтун, Миний эх ба ахан дүүс энд байна. Бурханы хүслийг биелүүлэгч хэн боловч Миний эх, эгч, ах дүүс минь юм гэв (Марк 3:21, 31-35).

Аав, ээж нь Бурханы тушаалыг эсэргүүцэх хүртэл Есүс аав, ээждээ бүх талаараа дуулгавартай л байжээ. Гэхдээ хэдэн жилийн дараа Есүсийн гэр бүл Дээд өрөөнд Ариун Сүнсний цутгаланг хүлээн авч, яваандаа Эзэний дагалдагч болсон нь юутай сайхан.

## Би зөндөө алдсан

Хүүхдүүд аав, ээжийгээ дагах ёсгүй онцгой тохиолдлууд байдгийг өмнө хэлсэн. Эдгээрээс бусад тохиолдолд хүүхдүүд аав, ээжийгээ хүндэтгэх нь давхар амлалт бүхий тушаалын нэг ажээ: *“Энэ нь чамд сайн бөгөөд чи дэлхий дээр урт наслах болно ... Хүүхдүүд ээ, бүх талаар эцэг эхдээ дуулгавартай байгтун. Энэ нь Эзэнд таалагдана”* (Колоссай 6:2-3, Колоссай 3:20).

Би энэ тушаалыг зөрчихийн үр дагаврыг яс махаараа эдэлж байж, ухаарсан билээ. Пердю их сургуулийг дүүргэснийхээ дараа би Роквел Интернэйшнэлд ажил ороод, өмнө ярьсан чуулгандаа явж эхлэв. Хоёрдугаар цуглаанаа тараад, үеийнхээ хэдэн залуустай хоол идэхээр явахдаа, гэрлэж амжаагүй яваа насанд хүрэгчдийн бүлгийн удирдагчтай танилцав. Би ч хотод дөнгөж суурьшаад байсныг хэлэх үү, тэр ч хөлслөх байр хайж байсныг хэлэх үү. Түүнтэй хэсэг ярилцсаны эцэст хамтарч байр түрээсэлбэл дажгүй санагдаад явчихав. Би ч их сургуулиа дөнгөж дүүргэсэн, явын ядуу залуу байсан болохоор мөнгөө хэмнэнэ гэхээс бөөн баяр.

Маргааш нь аав руугаа залгаад, баярт мэдээгээ дуулгахдаа, намайг сар бүр хэдэн зуун доллар хэмнэх гэж байгаад баярлана байх гэж бодтол, аав баярласангүй. Аав: “Миний хөө, наадах чинь дэмий санаа байх аа. Хэрэггүй байх. Чи тэр хүнийг сайн мэдэхгүй шүү дээ” гэлээ. Би ч аавыгаа ятгаад, түүнийг насанд хүрсэн ганц бие залуусын бүлгийг удирддаг хүн гэх зэргээр магтахын дээдээр магтсан ч, аав миний үгд автсангүй.

Би утсаа тавихдаа, аавыгаа итгэгч биш болохоор юу ч мэдэхгүй байна гэж бодож байлаа. Тэгээд ч нөгөө залуу маань том удирдагч хүн шүү дээ. Тиймээс аавынхаа үгийг тоолгүй, маргааш нь нөгөө хүнтэйгээ нэг байр олоод, түрээсийн гэрээ байгуулчихав. Нүүлгэлтийн машин ирэх үед хөрш маань найз нь хэтэвчээ мартаж орхиж, чи төлчих гэлээ. Дараа нь байрныхаа урьдчилгааг төлөх үед ч тэгэв. Энэ явдал үргэлжилсээр, эцэстээ би хоёр хүний хоёр сарын түрээс, хэрэглээний зардал, түүний үй олон холын дуудлагын төлбөрийг бүгдийг нь барагдуулж билээ (Тэр үед холын дуудлага асар өндөр үнэтэй байсан).

Би түүнийг машингүй болохоор нь хэд хэдэн удаа машинаа унуулахад, машиныг маань битүү утаа униарт автуулсан байдалтай өглөө эрт авчирч өгдөг байв. Тэрбээр үүнийгээ “найз нь янз бүрийн

асуудалтай хүмүүст үйлчилсэн юм” гэж тайлбарладаг байлаа. Нэг өглөө машины маань бөөр юу ч үгүй хонхойчихсон байлаа. Уур хүрсэн гэж жигтэйхэн. Гэхдээ зүгээр ээ гээд л өнгөрлөө. Нэгэн удаа үүрийн 4 цагт өрөөнөөсөө гарч иртэл, гартаа шар айраг, тамхи барьчихсан шал танихгүй этгээд том өрөөнд маань сууж байснаа, над руу яг л гадны этгээд үзсэн аятай хачин жигтэй харж билээ.

Би өөрийнхөө гэрт үйлээ үзэж байсан ч, шинэхэн итгэгч байсандаа “*Би хайраар хандах ёстой. Уурлаж, шүүж болохгүй*” гэж бодоод, асуудлаа цэгцлэхгүй явсаар байлаа. Эдгээр нь тэр хүний надад учруулсан зовлонгийн зах зух нь л юм шүү.

Ийнхүү хэдэн долоо хоногийн тамлалын дараа өрөөний маань хөрш гомо этгээд болох нь илрэв. Би түүнийг шууд л хөөсөн боловч, тэр явахгүй гэлээ. Түүнийг нүгэлдээ умбаж явахад, би хамаг төлбөрийг нь төлж байжээ. Гэтэл энэ үеэр ганц бие насанд хүрэгчдийн цуглааны пастор нь тэр этгээдийн үнэн байдлыг олж мэдээд, удирдлагын байр сууриас нь зайлуулсан юм. Түүний завхарсан амьдралын талаар олж мэдсэн сүүлчийн хүн нь бараг би болж таарав. Миний дуулгаваргүй байдал миний ялгах харааг сохолсон байжээ.

Би аавынхаа зөвлөгөөг хэрэгсээгүй учраас, хэдэн зуун доллараа дээрээс нь амар тайвнаа алдсан юм. Энэ явдал надад нилээд том цохилт өгсөн, амьдралын маань хамгийн зовлонтой хоёр сар байж билээ. Энэ явдал эцэслэгдсэний дараа би Бурхан руу: “Бурхан минь, яагаад? Би Таны чиглүүлэгт найдсан шүү дээ” хэмээн хашхирав.

Гэтэл Эзэн надад чиглүүлгээ өгсөөр байтал, би үл хэрэгссэн болохыг маань ухааруулав. Би зог тусаад: “Хэзээ тэр вэ?” гэж асуув.

Тэгтэл Бурхан: “Ааваар чинь. Гэтэл чи сонсоогүй” гэлээ.

Би ч өөдөөс нь: “Гэхдээ аав маань итгэдэггүй хүн шүү дээ” гэж ирээд л маргалаа.

Тэгтэл Эзэн надад Түүний Үг дээр “Хүүхдүүд ээ, *гагцхүү* итгэдэг аав, ээжийгээ л сонс” гэж хэлээгүйг сануулаад: “*Чи бол Миний хүүхэд. Тиймээс Би чамайг чиглүүлж, хамгаалах цэц ухаан, зааврыг аав, ээжийн чинь зүрхэнд тавьдаг юм*” хэмээн тайлбарлав.

Би ч өөдөөс нь: “Би чинь одоо бие даасан, том хүн. Аав маань хэдэн мянган бээрийн цаана амьдарч байгаа. Тэгээд ч аав миний зардлыг төлдөггүй” гэлээ.

Бурхан: “*Чиний зардлыг төлөхгүй байлаа гээд, хэдэн мянган бээрийн тэртээ байлаа гээд, тэднийг дуулгавартай дага гэсэн тушаал*

*маань хүчингүй болохгүй*” гэлээ. Түүний тушаалыг дагасан хүн сайн сайхан амьдардаг бөгөөд би энэ тал дээр *алдсанаа* хүлээн зөвшөөрнө!

Бурхан надад ямар үед хүн аав, ээжийнхээ мэдлээс гардгийг харуулав. Бурхан бүр эхэндээ “Ийм учраас эр хүн эцэг эхээ орхиод, эхнэртэйгээ нийлж, хоёул нэг махбод болдог” (Эхлэл 2:24) хэмээн тушаажээ.

Аав, ээж хүний үр хүүхэддээ өгдөг эцсийн заавар нь гэрлэлтийг нь ерөөх ерөөл юм. Дашрамд хэлэхэд, Лизагийн аав намайг охинтойгоо гэрлэхийг зөвшөөрч, ерөөсөн нь Лизагийн хувьд жинхэнэ гэнэтийн зүйл болсон гэдэг. Учрыг нь асуутал, Лиза: “Яагаад гэвэл чамайг Есүст итгэдэгт аав дургүй байсан” гэж хэлж билээ. Энэ бол хааны зүрх (бидний дээрх эрх мэдэлтний зүрх) Бурханы мутарт байдгийн баталгаа юм.

Бурханы Үг дээр эр, эм хоёр гэрлэлтээр нэгдэхэд, эрх мэдлийн шинэ эрэмбэ үүсэн бий болдгийг цохон тэмдэглэдэг. Бурхан эмэгтэй хүн аав, ээжийгээ орхидог гэж хэлээгүй. Учир нь гэр бүлийн шинэ эрэмбийг эмэгтэй хүн бий болгодоггүй, гэр бүлийн эрх мэдлийг эрэгтэй хүн тэргүүлдэг.

Үр хүүхэд нь гэрлээ л бол, аав, ээжийгээ дагах тушаал цаашид тэдэнд хэрэгжихгүй ч, үр хүүхэд нь аав, ээжийгээ хэзээд хүндэтгэж явах ёстой. Би нэг удаа аав, ээжээсээ Лиза бид хоёрыг буруудаж байгааг мэдсээр байж, яагаад анхааруулж зөвлөөгүйг асуутал, тэр хоёр: “Чи зөвлөгөө асуудаггүй биз дээ?!” гэж хариулж билээ. Энэ бол бурханлаг үйлдэл! Зарим аав, ээжүүд гэр бүлтэй үр хүүхдийнхээ хэрэгт урьдынх шигээ л хошуу дүрээд, оролцоод байдаг. Үүнээс шархтай мэдрэмж, үл ойлголцол л бий болно. Учир нь тэд Бурханы зааврын дагуу үр хүүхдээ тавьж явуулдаггүй.

## **Хүүхдүүдэд өгөх онцгой анхааруулга**

Хэдэн жил залуусын пастораар үйлчилснийхээ дараа би олон залуус халгаатай замаар явж байгааг ойлгосон юм. Аав, ээжийгээ хүндэтгэх тал дээр би Бурханы зарим нэг зөвлөгөөг цохон тэмдэглэмээр байна. Үүнийг үзээд олон залуус аав, ээжийгээ хүндэтгэхгүй байх нүглээс тархдаг хөрөнгөөс бултах болтугай. Энэ нь халдвартай бөгөөд аминд халтай зүйл. Бичээс: “Эцэг эхээ хүндэлдэггүй хүн нь харагдсан!” гэхэд бүх ард түмэн “Амен!” гэнэ” (Дэд хууль 27:16).

Ширээний маань эсрэг талд өсвөр насны хүүгээ дагуулсан нэгэн ээж өөдөөс харан сууна. Яриан дундуур тэр залуу ээжтэйгээ яг



л өөрөөсөө дүү юмуу эсвэл тэнэг хүнтэй ярьж байгаа аятай хэдэр, муухай харилцаж байлаа. Би ч түүнийг хэд хэдэн удаа засварлаж амжив. Ярианыхаа төгсгөлд би өөрийн мэдэлгүй: “Залуу минь, чи ээждээ хандах авир, үйлдлээ гэмшихгүй бол, шоронгийн хаалга татна шүү” гээдхэв. Хэлсэн үгдээ би өөрөө ч цочирдлоо. Тэр залуу өөрийгөө итгэгч гэдэг бөгөөд залуусын цуглаанд явдаг байв. Хайран амьдрал!

Зургаа орчим жилийн дараа (Тэр үед би хэдийнээ залуусын пастораар үйлчлэхээ болиод байв) нөгөө хүүгийн ээж Бүтэн сайны өглөөний цуглааны дараа надтай уулзаад: “Пастор аа, та хүүд минь өөрчлөгдөхгүй бол, шоронгийн хаалга татна шүү” гэж анхааруулснаа санаж байна уу? Тэгвэл хүү минь шоронд ороод хэдэн жил болж байна” гэлээ.

Би энэ явдлыг таг мартчихсан байгаад, эмэгтэйг ярих үед л санаанд орж ирэв. Тэгээд “Энэ ээж надтай ийм юм ярьж байж, яахаараа баярладаг байна аа?” гэж бодлоо. Гэтэл учрыг нь мэдэв. Эмэгтэй: “Хүү минь одоо Бурханы төлөө шатаж яваа. Тэр шоронгийн бусад хоригдлуудад гэрчилж, шоронгийн үйлчлэл хийдэг. Тэр таны номыг уншиж, тэндээс маш их зүйл сурч байгаа” хэмээн дуржигнуулав.

Бурхан шүүхээрээ тэр залуугийн амьдралыг орвонгоор нь эргүүлсэн нь биширмээр. Тэрбээр яс махаараа зовж байж биш, зүгээр үг сонсоод ойлгосон бол, сайн байх байлаа. Гэхдээ эдүгээ түүнд Бурханыг гэх халуун зүрх байгаа нь л юу юунаас илүү чухал билээ.

Хүүхдүүд аав, ээж рүүгээ үг, үйлдлээрээ давшлах нь хичнээн ноцтой явдал болохыг Хуучин гэрээнд авиргүй хүүхдүүдийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж байснаас харж болно: “Хэн эцэг эхээ цохино тэр заавал алуулах ёстой” (Гэтлэл 21:15), Хэн эцэг эхээ хараана тэр заавал алуулах ёстой” (Гэтлэл 21:17). Есүс ч “Бурхан “Эцэг, эхээ хүндэл”, “Эцэг, эхээ хараагч нь үхэх ёстой” гэж айлдсан” (Матай 15:4) хэмээхдээ, Хуучин гэрээний уг тушаалыг эш татжээ.

Мосе ч тэрслүү хүүхдийг хэрхэх талаар дараах зааврыг өгчээ:

Хэрвээ эцэг эхийнхээ дуу хоолойг дагадаггүй, зөрүүд, тэрслүү хүүтэй хүн хүүгээ зодож занчсан ч тэр нь дуулгаваргүй хэвээр байвал эцэг эх нь түүнийг барьж аваад, хотынхоо хаалга уруу хотын ахмадуудад хүргэж өгөөд, хотынхоо ахмадуудад “Манай энэ хүү зөрүүд, тэрслүү хүүхэд, бидний үгэнд ордоггүй танхай балмад, архичин” гэвээс Харатгун, Өмнө чинь байгаа нутгийг ЭЗЭН Бурхан чинь өгсөн. Эцэг

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

өвгөдийн чинь Бурхан ЭЗЭН чамд айлдсан ёсоор яв, түүнийг эзэмш!  
Бүү ай! Бүү зүрхшээ!” гэсэн билээ (Дэд хууль 21:18-21).

Энэ үг өнөөдөр хэрэгждэг байсан бол, өдөр бүр цуглаан дотор овоо хэдэн залуусыг цааш нь харуулах байсан биз. Энэ шийтгэл өнөөдөр хэрэгжихгүй. Гэхдээ эндээс бид тэрслүү занд Бурхан хичнээн хурц, хатуу ханддагийг харж болно. Шийтгэл хэрэгжихээ больсон нь Бурхан хандлагаа өөрчилсөн гэсэн үг биш. Бид тэрслүү байдлыг зүрхэндээ зөвшөөрч болохгүй. Учир нь тэрслүү зан нь алуурчин юм.

Би хөвгүүдээ өсгөхдөө, бүх хэлбэрийн тэрслэлээс биеэ чандлан хамгаалж явахыг захидаг байлаа. Тэрслэлийн хамгийн аюултай бөгөөд зальжин хэлбэр нь гомдоллох юм. Гомдол нь наагуураа хэлэхгүй ч, цаагуураа: “Чиний удирдах арга барил таалагдахгүй байна. Би л байсан бол, өөрөөр хийх байсан” хэмээн дээрх эрх мэдлээ жигших үйлдэл юм. Өөрөөр хэлбэл удирдлагаа доош нь хийх явдал. Израилийн хүүхдүүд гомдол гаргаснаасаа болоод Канаанд нэвтэрч чадаагүйн учрыг одоо ойлгов уу? Тэд хэдийгээр Мосегийн эсрэг гомдол гаргаж байсан ч, цаагуураа Бурханыг жигшиж байжээ. Үндсэндээ “Бурхан буруутай. Бид өөрөөр удирдах байсан юм” гэжээ.

Аав, ээжийгээ хүндэтгэх нь сайн зүйл бөгөөд урт удаан амьдралын гайхамшигт амлалтыг дагуулдаг. Би ч шүүхээс амийг л сонгоно. Энэ асуудлыг бид зүрхэндээ шийдэх ёстой.

## Гэрлэлт

Бүгдээрээ гэрлэлтийн талаарх тэнгэрийн тушаалд анхаарлаа хандуулъя. Бичээс эхнэрүүдийг бүх талаараа нөхрүүддээ захирагдаж яв гэдэг (Ефес 5:24). Энэ тушаал нь сүнсний талбар дээр төдийгүй, амьдралын жирийн талбар дээр ч хэрэгжинэ. Паул “нөхрүүддээ” хэмээн нэр заасан. Эмэгтэй хүн эхнэр хүнийхээ хувьд бүх эрчүүдэд бус, гагцхүү эр нөхөртөө л захирагдана. Мэдээж эмэгтэй хүн гишүүнийхээ хувьд чуулганыхаа сүнсний удирдагч - пастортаа захирагдана. Бас ажилтныхаа хувьд даргадаа захирагдана. Мөн иргэнийхээ хувьд иргэний эрх баригчдад захирагдана. Харин эхнэр хүнийхээ хувьд гагцхүү нөхөртөө л захирагдана.

1980-аад оны дундуур гэргий, бид хоёр алдаатай сургаалд бүдэрсэн юм. Бидэнд “Шинэ гэрээг шовинист хүмүүс бичсэн бөгөөд нөхөр - эхнэрийн эрх мэдлийн талаарх үгийг нь сахих хэрэггүй” гэж

заав. Түүнчлэн Есүсийн бидэнд өгсөн аврал нь эрх тэгш гэж заалаа. Энэ мэдээж үнэн. Гэхдээ аврал эрх мэдлийг үгүйсгэдэггүй. Үүнээс болоод манай гэр бүл олон жил амар амгаланг олоогүй юм. Бид хоёр удирдлагын байр сууриа булаалдан, улайран тэмцэлдэв.

Ийнхүү олон жил тэмцэлдсэний эцэст би гэргийдээ: “Бурхан намайг энэ гэрийн тэргүүнээр тавьсан. Чи намайг дагана уу, байна уу хамаагүй - би гэрээ тэргүүлэх л болно!” гэж хэлсэн юм. Ийнхүү миний амьдрал өөрчлөгдөж эхэлсэн ч, Лизагийн хувьд зөрчил үргэлжилсээр байлаа. Удирдагч хүн удирдлага дорх хүмүүсээ албадан хүчилж болдоггүйг Эзэн надад зааж өгсөн юм. Есүс ч бидэн дээр хүч хэрэглээгүй. Эрх мэдэл дор байгаа хүмүүс эрх мэдлийг дагахгүй бол, өөрсдөө л зовдог.

Би ч тэнгэрийн амралт, амгаланд ороодхов. Гэтэл Лиза гэр бүлийнхээ бүхий л дарамтыг үргэлжлүүлэн үүрсээр байлаа. Тэр намайг хариуцлагагүй удирдагч гэж үзжээ. Би нас залуу, дээрээс нь үй олон алдаа гаргасан болохоор Лиза миний өнгөрсөн амьдралын алдаагаар өөрийнхөө зовнилыг өмгөөлж байлаа. Заримдаа түүний зовнил хэрээс хэтэрч, “намайг эхнэртээ хамаг ачаагаа үүрүүлсэн хариуцлагагүй этгээд” болохыг минь сануулах гэж хар шөнөөр нудран сэрээнэ. Хариуд нь би зүгээр л бүх зовнилоо Бурханд даатгахыг зөвлөөд эргээд хэвтэхэд, Лиза хажууд маань зүсэн зүйлийн мууг ургуулан бодсоор, унтаж чадахгүй хэвтдэг байв.

Эцэстээ Лизагийн зовнил хэрээс хэтэрч, байнгын шаналанд нэрвэгдэв. Лиза манай гэр бүлийг дайрч болох зүсэн зүйлийн хямралыг толгой дотроо хэдэн янзаар ургуулан төсөөлж, зовнил өөд зогсоо зайгүй мацаж байлаа.

Тэгээд эцэстээ тээж явсан зовнилдоо дарагдаж унав. Лиза дарамтаа хөнгөлөх гэж удаан хугацаагаар шүршүүрт цохиулах юмуу онгоцтой усанд хэвтэнэ. Нэгэн шөнийн “угаал үйлдэх ёслолынхоо” үеэр Лиза Бурхан руу ээлжит гомдлоо урсгаж байтал, Бурхан түүнд: “Лиза, чи Жоныг сайн удирдагч гэж боддог уу?” гэж асуужээ.

Лиза ч шууд л: “Үгүй чшш! Би түүнд итгэдэггүй!” гэж хариулж.

*“Лиза чи Жонд итгэх шаардлагагүй. Чи Надад итгэхэд л болно. Чи Жоныг өрхийн тэргүүнийхээ үүргийг олигтой биелүүлдэггүй, өөрийгөө илүү сайн гүйцэтгэдэг гэж үзэж байна. Чиний үүрч яваа зовнил, дарамт чинь өрхийн тэргүүн хүний ачаа юм шүү дээ. Энэ чиний хувьд буулга бол, нөхрийн чинь хувьд нөмрөг юм. Наадахаа тавь!”*

Лизагийн нүд нээгдэв. “Эр нөхөртөө захирагд” гэдэг тушаалыг эрх мэдэлд улайрсан этгээд бус, Бурхан Өөрөө өгсөн шүү дээ. Лиза үүрэх ёсгүй зүйлээ өөрөө авч үүрээд байсан учраас, тэгтлээ ядарчээ. Бурхан эр нөхрийн үүрэг хариуцлагын ачааг тээх тосолгоо, нигүүлсэлтэй нь хамт өгдөг. Гэтэл Лиза тээх тосолгоо, нигүүлслийг нь аваагүй байж, ачааг нь үүрээд байжээ. Лиза шүршүүрээс бөөн нус нулимс болсоор гарч ирээд, баахан уучлал гуйж билээ. Тэгээд миний хэдэн сарын өмнөөс эдлэх болсон амар амгалан, амралтанд орж, ийнхүү манай гэр бүлд олон жилийн дараа энх тайван тогтов.

Ариун Сүнс тэр орой Лизад нөхрийнхөө сонголт, шийдвэрээс дуртай юмуу таалагдсан хэсэг дээрээ л захирагдаж болдоггүйг зааж өгчээ. Лиза Бурханы тушаалд бүрэн захирагдах юм бол, Бурхан Өөрөө түүнийг хамгаалахыг ухаарсан байна. Тэр явдлаас хойш би алдаа гаргасан уу? Гаргасан. Маш их! Гэхдээ энэ бүхэн дунд Бурхан Өөрөө Лизаг хамгаалж, амар амгалангаар бүсэлсэн юм. Лиза Бурханд захирагдсан учраас, эр нөхөр нь хичнээн мунхаг шийдвэр гаргаж байсан ч, Бурхан түүнийг Өөрөө хамгаалжээ.

## **Ухаан муутай юмуу аврагдаагүй нөхрүүд**

Бурхан эхнэрүүдэд “гагцхүү итгэдэг нөхөртөө л захирагдаарай” гэж тушаагаагүй юм. Петр “Түүнчлэн эхнэрүүд ээ, та нар нөхөртөө захирагд. Ингэх нь нөхрүүдийн чинь зарим нь үгийг дагахгүй байгаа ч гэсэн, тэд үггүйгээр эхнэрүүдийнхээ биеэ авч явах байдлаар аврагдана (1Петр 3:1) гэсэн.

Эхлээд “Түүнчлэн эхнэрүүд ээ” гэдэг үгийг үзье. Петр дөнгөж сая эрх баригчдын зүгээс ирэх шударга бус хандлагыг хэрхэн шийдвэрлэх талаар ярьж дуусчээ (Бид энэ талаар 13-аар бүлэгт ярьсан). Тэгээд араас нь шууд “яг ийм маягаар нөхөртөө хандаарай” хэмээн зааварлажээ. Энэ бүхнийг нэгтгэх юм бол, дараах маягийн үг бий болох байх:

Боолууд аа, бүхий л хүндлэлээр зөвхөн сайн, дөлгөөн төдийгүй, бас гажууд эздэдээ ч захирагд. Учир нь хүн шударга бусаар зовохдоо Бурханд ханддаг мөс чанараасаа болж тэвчвэл энэ нь нигүүлсэл юм. ...Яг ийм маягаар эхнэрүүд ээ, та нар нөхөртөө захирагд. Ингэх нь нөхрүүдийн чинь зарим нь үгийг дагахгүй байгаа ч гэсэн, тэд

## МАГАДЛАЛ БА ТӨГСГӨЛ

үггүйгээр эхнэрүүдийнхээ биеэ авч явах байдлаар аврагдана (1Петр 2:18-19, 3:1).

Зарим итгэдэг нөхрүүд итгэдэггүй нөхрүүдээс ч илүү хэцүү хатуу байдаг. Харамсалтай боловч, энэ үнэн. Тийм боловч ерөнхий дүрэм талаас нь авч үзбэл, аврагдаагүй нөхөртөө захирагдах нь илүү хэцүү байна. Итгэдэггүй нөхөр нь итгэдэг эхнэрээсээ Бурханы Үгийг зөрчихийг шаардбал, эхнэр нь нөхрийнхөө зааврыг дагах ёсгүй ч, нөхөртөө захирагдсаар байх ёстой гэдгийг би дахин хэлье.

Энэ хандлага нь эр нөхөрт нь ямар ч номлолоос хүчтэй нөлөөлөхийг Петр цааш нь өгүүлжээ. Би итгэдэггүй нөхөртэй нэгэн эмэгтэйг танина. Тэрбээр нөхөртөө олон жил номложээ. Нөхрийнхөө ажлын газар Сайн мэдээний номууд орхиж, орных нь дэргэд, суух дуртай газар нь, цайных нь ширээн дээр Библи, Христэч ном сэтгүүл тавьж, нөхөрт нь нөлөөлнө гэж харсан, стратегийн ач холбогдолтой танилуудаа гэртээ байнга урина.

Гэтэл нэг өдөр Бурхан түүнээс: *“Чи нөхрийнхөө авралд хэр удаан саад хийх вэ?”* гэж асуужээ.

Цочирдож мэгдсэн эмэгтэй: *“Би нөхрийнхөө авралд саад хийсэн гэж үү? Яаж тэр вэ?”* гэжээ.

Гэтэл Эзэн түүнд нөхөртөө номлож, нөхцөл байдлаар түрэмгийлэн дарангуйлах нь Бурханы хүсэл биш гэдгийг ойлгуулжээ. Бурхан түүнд 1Петрийн зааврыг харуулаад *“Тэр олон танилцуулга, сэтгүүл, Библиэсээ салж, стратегийн ач холбогдолтой хосуудыг оройн зоогт урихаа боль”* гэсэн байна.

“Жон, би нөхрөө зүгээр л хайрлаж, түүнд захирагдсан. Тэгээд хэдэн сарын дараа нөхөр маань амьдралаа Есүст өгсөн” хэмээн ярьж билээ. Би тэднийд зочлохдоо, нөхөр нь Эзэнд үнэхээр хайртай болохыг харсан юм.

Хэрэв бид зүгээр л итгэж, найдаж, Бурханы Үгийг дуулгавартай дагах юм бол, гэрт маань гайхамшиг болж, ойлголтоос давсан амар тайван бууна. Энэ үгийг эрх мэдэлд улайрсан, дарангуйлдаг, атгаг удирдагч нар биш, харин Бурхан Өөрөө хэлсэн гэдгийг би дахин хэлье. Бурхан үүнийг бидний л хангамж, хамгаалалтын төлөө хэлсэн бөгөөд энэ талаар бид дараагийн бүлгээрээ үзнэ. Зовлонд дунд бид Бурханы дараах амлалтанд найдаж болно: “Учир нь та нарт зориулж байгаа төлөвлөгөөнүүдийг Би мэдэх бөгөөд тэдгээр нь та нарт

ирээдүй ба найдварыг өгөх гай гамшгийн бус, сайн сайхны төлөөх төлөвлөгөөнүүд юм” хэмээн ЭЗЭН тунхаглаж байна” (Иеремиа 29:11).

## **Нийгмийн эрх мэдэл**

Ажил, сургуулийн талбар дээр хэрхэхийг Шинэ гэрээ тодорхой зааварладаг. Паул:

“Боолууд аливаа зүйлд эзэндээ захирагдан, таалалд нь нийцүүлж, зөрж эсэргүүцэлгүй, шамшигдуулалгүй, харин алив сайн итгэлийг харуул. Тэгвэл тэд бидний Аврагч Бурханы сургаалыг бүх талаар чимнэ” (Тит 2:9-10) гэжээ.

Ажилтан, албан хаагч нь хоосон номлолоороо бус, харин хүнд хэцүү цагт үзүүлсэн зан чанар, ёс зүйгээрээ Есүсийг эерэгээр гэрчилсэн талаар компанийх нь дарга нар, эзэд гэрчлэхийг сонсох шиг сайхан зүйл байдаггүй юм. Тэд итгэгч ажилтан, албан хаагчаа “маргадаггүй, гомдоллодоггүй, хэдэрлэдэггүй, бусдаасаа илүү ажилладаг, манай хамгийн үнэнч ажилтан” хэмээн магтдаг. Тэр ажилтан, албан хаагчийн ачаар дарга, эзэд нь Есүсийн талаар хэлэх үгд маань зүрх сэтгэлээ нээж өгдөг билээ.

Гэтэл бас таагүй ч гэрчлэл бий. Нэг удаа би онгоцоор зорчихдоо, нэгэн томоохон хотын хоёр дахь том такси компанийн эзэнтэй зэрэгцэж суусан юм. Тэр намайг Есүсийн үйлчлэгч гэдгийг мэдэхээсээ өмнө илэн далангуй, сайхан яриа дэлгэж байснаа, энэ тухай мэдмэгцээ дуугаа хураагаад, нугдайчихав. Бидний харилцаа нилээд сайхан өрнөж байсан учраас, би түүнээс шууд л учрыг нь асуулаа.

Тэгтэл тэрбээр: “Заяахав, хэлье л дээ. Манайд нэг эмэгтэй ажилладаг байлаа. Тэр нөгөө “дахин төрсөн Христэд итгэдэг хүмүүсийн” нэг байсан юм. Тэр ажлын газрын бүх хүмүүст номлож, өөрийнхөө ч, бусдын ч ажлын бүтээмжийг хумсалдаг байсан. Тэгээд манайхаас гарахдаа, баахан юм хулгайлаад, дээрээс нь манай компанийг Германд амьдардаг хүүтэйгээ ярьсан дуудлагын төлбөр гэж найман мянган долларын өрөнд оруулаад явсан даа” гэж ярьсан билээ.

Миний элэг эмтрэв. Мэдээж тийм авир, хулгайн хэргийн дараа тэр компанийн хүмүүс Бурханы Үгийг сонсох уу? Тиймээс л Паул

“зөрж эсэргүүцэлгүй, шамшигдуулалгүй, харин алив сайн итгэлийг харуул” гэсэн байна. Бид ажил олгогч нар, сургуульдаа захирагдаж, хөдөлмөрлөж, хууль дүрмийг нь биелүүлэхдээ Эзэн Есүс Христийнхээ нигүүлслийг гэрчилдэг.

Паул өөр нэгэн газарт:

“Боолууд аа, махан бодынхоо эзэнд бүх талаар дуулгавартай бай. Хүнд таалагдах гэж нүд хууралгүй, харин Эзэнээс эмээн, чин зүрхнээсээ үйлчил. Та нар юу ч хийсэн, хүмүүсийн төлөө бус, Эзэний төлөө чин зүрхнээсээ хийгтүн” (Колоссай 3:22-23) гэж хэлжээ.

Бүх талаараа дага гэсэн байгааг харна уу. Дарга юмуу багш чинь хичнээн боломжгүй зүйлийг шахан шаардаж байсан ч, түүнд дуулгавартай байх нь үнэндээ Эзэнд дуулгавартай хандаж буй явдал юм.

Паул цааш нь: “Учир нь та нар Эзэнээс өв залгамжлалын шагналыг хүлээн авахаа мэддэг. Та нар Эзэн Христэд үйлчилж байгаа юм” (Колоссай 3:24) гэжээ. Тэр эмэгтэй үнэндээ Эзэнээс хулгайлж байгаагаа мэдсэн бол, хэзээ ч тэгэхгүй л байсан байх. Түүнд ойлголт, Эзэнээс эмээх сэтгэл дутжээ.

Паул дараагийнхаа эшлэлд “Бурууг үйлдэгч нь хэн ч бай ялгаагүй, үйлдсэн буруугийнхаа уршгийг хүртэнэ” гэжээ. Үүнийг Мессеж Библи дээр бүр гоё хэлдэг: “Хуурмаг ажилтай, санаа муут зарц хариуцлагаа хүлээнэ. Христэд итгэдэг байх нь муу үйлсийг хаацайлахгүй.”

Эмэгтэй такси компанийн эзнээс юмуу иргэний шүүхээс мултарч болох ч, Христийн шүүх сэнтийгээс мултрахгүй: “Тиймд ойр ч, хол ч Түүнд таалагдах нь бидний эрмэлзэл билээ. Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой” (2Коринт 5:9-10).

## Ерөнхий асуудал

Олон хүн номлодог шигээ амьдардаггүй удирдагчийг сонсохгүй гэдэг. Гэхдээ энэ сэтгэлгээ дуулгавартай байдлаас төрдөг үү, хүний эргэцүүллээс төрдөг үү? “Тэгээд Есүс ард олон болон шавь нартаа айлдсан нь

—Мосегийн сууринд хуулийн багш нар ба фарисайчууд сууж байна. Тиймээс тэдний хэлсэн болгоныг та нар үйлд, сахь. Харин тэдний үйл

хэргийн дагуу бүү үйлд. Тэд ярьдаг ч түүнийгээ эс үйлддэг” (Матай 23:1-3).

Есүс номлодог шигээ амьдардаггүй, завхарсан удирдагч нартаа ч захирагд гэжээ. Учир нь бид захирагч нартаа бус, харин тэдний дээр орших эрх мэдэлд захирагдаж буй юм. Уочман Нии ингэж бичжээ:

Бурхан эрх мэдлийн тогтолцоог бий болгохдоо том эрсдэл гаргаж! Бурханы төлөөний эрх мэдэл Бурханыг буруугаар таниулбал, Бурханы нэр хүндэд үлэмж гарз учрах! Тийм боловч, Бурхан эргэлт буцалтгүйгээр эдгээр эрх мэдлийг тогтоожээ. Бид эрх мэдлийг зоригтой дагах нь Бурхан эрх мэдлийг бий болгосны дэргэд юу ч биш. Бурхан эрх мэдлээ хүнд даатгахаас айгаагүй байхад, бид эрх мэдлийг дагахаас айх юун? Бурхан эрх мэдлийг зоригтой тогтоосон байхад, бид урамтай дагах ёстой. Алдаа гарбал, бид хариуцахгүй, эрх мэдэлтнүүд л хариуцах. Учир нь Эзэн “Бурханаас гадуурх эрх мэдлүүд гэж үгүй бөгөөд Бурханы тогтоосноор л байгаа тул дээд эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд” (Ром 13:1) хэмээн тушаав.

Зүгээр л дуулгавартай дагах хэрэгтэй. Дуулгавартай дагах явц дунд гарсан аливаа алдааг Эзэн бидэнд тохоохгүй, харин алдсан эрх мэдэлтнүүдтэйгээ л ярина. Гэтэл захирагдахгүй байх нь тэрслүү явдал бөгөөд эсэргүү хүн энэ хэргээ Бурханы өмнө толгойгоороо хариуцах. (*Spiritual Authority*, 69-71-ээр хуудас)

Энэ үгийг шударга бус эрх баригчдад мөлжүүлсэн хүн бичжээ. Тэрбээр 1930-1940 онд Хятадын нутгийн чуулгануудыг гадаадын илгээлтийн байгууллагуудаас бүрэн бие даахад нь тусалж, Хаанчлалд олон хүнийг оруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Энэ хүний үйл ажиллагаа Хятадын эрх баригчдыг хилэгнүүлсэн тул түүнийг 1952 онд баривчлан, олон төрлийн хилс хэрэгт унагаад, 1972 онд нас барах хүртэл нь хорьжээ. Тийм боловч тэрбээр Эзэнийг эмээн хүндэтгэх хандлагынхаа хүчээр шоронд олон хүнд Есүсийг гэрчилж, тэр гэрчлэлээр нь олон хүн аврагдсан байна. Түүний зохиол бүтээл энэ олон жилийн дараа ч үй олон хүнд хүрсээр.

## **Эрх мэдлийг хүлээн зөвшөөрөх**

Төлөөний эрх мэдлийг хэрхэн танихыг би номдоо олонтаа заасан. Гэхдээ энэ бүлгийнхээ төгсгөлд дахин нэг батжуулах нь зүйтэй



болов уу. Библи “Эзэний төлөө өөрсдийгөө хүний бий болгосон аливаа бүтцэд захируул” (1Петр 2:13) гэдэг. Бид засгийн газрын гишүүд, тангараг өргөсөн төрийн албан хаагчдын эрх мэдлийг хүлээн зөвшөөрдөг. Үүнээс гадна мөн компанийн удирдлага юмуу боловсролын захирал, багш ажилтнууд гэсэн эрх мэдэлтнүүд ч байна.

Гэр бүл доторх эрх мэдлийг ч хүлээн зөвшөөрөх амархан. Эмэгтэй хүн эрэгтэй хүнтэй гэрлэхдээ, нөхрийнхөө жинхэнэ эрх мэдэл, хамгаалалт, хангамж дор ордог. Шинээр мэндэлсэн хүн аав, ээжийнхээ эрх мэдэл дор орно. Өргөмөл хүүхэд ч аав, ээжийгээ өөрийнхөө төрсөн аав, ээж шиг л хүндэтгэх ёстой. Асрамжийн газар байгаа хүүхэд удирдагч нараа хүндэтгэн, эрх мэдэлд нь захирагдах ёстой.

Тэгвэл чуулган дотор хууль ёсны эрх мэдлийг таних жаахан ярвигтай. Бичээс чуулган доторх хуурамч элч, эш үзүүлэгч, удирдагчдаас сэрэмжлүүлэх бөгөөд бид тэдэнд захирагдаж болохгүй. Паул “Гэвч бид тэдний эрхэнд хормын зуур ч ороогүй. Ингэснээр сайнмэдээний үнэн нь та нарт үлдэх юм” (Галат 2:5) гэсэн. Хуурамч удирдагч нар хоёр замаар илэрдэг. Нэгдүгээрт - тэд Бичээстэй эгнэхгүй доктрин заадаг. Паул дөнгөж сая хэлсэн үгийнхээ агуулгын хүрээнд “Харин бид ч, эсвэл тэнгэрийн зарлага элч ч гэсэн бидний [та нарт] тунхагласнаас өөр сайнмэдээг тунхаглавал тэрээр хараагдаг” (Галат 1:8) гэжээ. Энэ шалтгаанаар Паул тийм удирдагч нарыг хүндэтгэхгүй ажээ.

Хоёрдугаарт - хуурамч удирдагч нар чуулган дотор өөрийгөө өргөмжлөн тодруулдаг бол, Бурханы томилгоо нь Ариун Сүнсээр эхлэн, нэр дэвшигчийн амьдралыг ажиглан батлах албан ёсны амьд сэрүүн удирдагч нараар баталгааждаг. Энэ үйл явцыг Хуучин гэрээ Иошуагийн томилгоогоор дүрслэн харуулдаг юм. Бурхан Мосед:

Нуны хүү Иошуаг ав, түүний дотор сүнс бий. Түүний дээр гараа тавигтун. Түүнийг тахилч Елеазар болон даяар хотол түмний өмнө зогсоогоод, тэдний нүдний өмнө түүнд үүргийг даалгагтун. Израилийн хөвгүүдийн даяар хотол түмэн түүнд дуулгавартай байхын тулд чи өөрийн алдраас түүнд өгөгтүн (Тооллого 27:18-20).

Бурхан Иошуаг сонгосон ч, сонголтоо хэдийнээ байгаа томилогдсон удирдагч нараар буюу Мосе, Елиазар нараар баталгаажуулсан. Энэ үлгэр загвар Шинэ гэрээнд ч гардаг (Үйлс 13:1-4).

Паул үүнийг “Учир нь өөрийгөө сайшаадаг нь бус, харин Эзэнээр

сайшаагддаг нь шалгарна” (2Коринт 10:18) хэмээн бататгажээ. Өөрийгөө өргөмжлөн тодруулсан удирдлагад захирагдах нь аюултай нүүдэл. Бурхан Өөрийнхөө томилсон удирдагчийг заавал хүчин зүтгэсэн чуулганых нь өмнө баталгаажуулдаг. Есүс Туайтерын итгэгч нарыг өөрийгөө эш үзүүлэгчээр тодруулсан Иезебел гэгч эмэгтэйн худал сургаал, эрх мэдэлд захирагдсаных нь төлөө зэмлэсэн (Илчлэл 2:20-25). Би өөрийгөө тодруулсан удирдагч нарыг таних тухайд “*Эзэн ийн айлдруун*” нэртэй бүхэл бүтэн ном бичсэн бөгөөд тэнд тэр хүмүүсийн хуурамч, завхарсан сүнсний эрх мэдлийн талаар дэлгэрэнгүй өгүүлдэг.

Хэдийнээ аврагдаж, Бурханы хүслийг хайж байгаа хүн чуулган доторх хууль ёсны эрх мэдлийг таньдаг. Есүс “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсвэл тэрээр энэ сургаал Бурханаас уу эсвэл Би Өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ” (Иохан 7:17) гэсэн. Гол түлхүүр нь “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсвэл” гэдэг үгд оршино. Бурханы араас явж байгаа хүнд Бурхан Ариун Сүнсээрээ ялгах нүдийг өгнө. Иохан ч үүнийг батлан хэлсэн: “Харин та нар Ариун Нэгэнээр тослогдсон бөгөөд бүхнийг мэднэ” (1Иохан 2:20).

Уочман Нии “Бид Бурханыг үнэхээр дагаж сурбал, хэн дээр Бурханы эрх мэдэл байгааг шууд танина” гэж бичсэн (*Spiritual Authority*, 62-аар хуудас). Бурханыг мэдэх нь эрх мэдлийг мэднэ. Учир нь Бурхан, эрх мэдэл хоёр салшгүй.

Бурхан Өөрийг нь хичээнгүйлэн эрэн хайж, дагадаг хүмүүсийг шагнадаг. Дараагийн бүлгээрээ эрх мэдэлд захирагдахын олон сайхан ашиг тусыг сурцгаая.

## АУГАА ИТГЭЛ

*Хэдий чинь захирагдана - төдий чинээ аугаа итгэлтэй байна.*

**С**үүлийн энэ бүлгээрээ бид “вакцины” ач тусын талаар үзнэ. Өөрөөр хэлбэл, батлан хамгаалалт дор оршин буй бүгдэд ирэх аугаа шагнал, ерөөлийн талаар ярина. Ганцхан энэ ач тусын талаар бичихэд л хэдэн боть ном болох байх. Бид цөөхөн хэдэн ашиг тусын талаар ярих боловч, та Христийн доторх туршлагаараа болоод хувийн судлалаараа бие даан илүү олныг олж мэдэх тавилантай.

### **Эзэн минь, итгэлийг минь өсгөөч**

Хэдэн жилийн турш сурч дадсанаараа, үүрийн 05:30-д залбирахаар ажил дээрээ очтол, залбирч эхлэхээс минь өмнө Ариун Сүнс: “*Лук 17-аар бүлгийг гаргаад, 5-аар эшлэлээс унш*” гэлээ.

Би ч баяртайгаар тэр хэсгийг гаргаад, миний сайн мэдэх бичээсийн хэсэг болохыг танив. Би өмнө энэ хэсгээс номлож байсан ч, энэ туршлага миний оргилуун баяр хөөрийг бууруулсангүй. Ажаад байхнаа, Бурхан надад тодорхой нэгэн эшлэлийг уншихыг зааварлалбал, шинэ зүйл зааж өгдөг байлаа. Бүгдээрээ тэр эшлэлийг харцгаая.

Элч нар Эзэнээс “Итгэлийг маань өсгөж өгөөч” гэжээ (Лук 17:5).

Бурхан надад тэр өглөө юу зааж өгснийг ярихаасаа өмнө эхлээд

тэдгээр эрчүүд итгэлээ өсгөхийн төлөө гуйсан шалтгааныг олж мэдье. Есүс дөнгөж сая үхсэн хүнийг амилуулсан уу? Таван мянган хүнийг хэдэн талх, загасаар хооллосон уу? Эсвэл шуургалах далайг зэмлэж намжаасан уу? Хариулт нь: Үгүй! Есүс дөнгөж сая тэр эрчүүдэд “Болгоомжтой бай! Хэрэв ах дүү чинь нүгэл үйлдвэл, түүнийг зэмлэ. Хэрэв тэр гэмшвэл, түүнийг уучил. Хэрэв тэр чиний эсрэг өдөрт долоон удаа нүгэл үйлдчихээд, чам дээр долоон удаа эргэн ирж, “Би гэмшиж байна” гэвэл түүнийг уучил” (Лук 17:3-4) гэж л хэлжээ.

Ямар ч гайхамшиг дагалдагч нарыг итгэлийн төлөө ингэтэл хашхирахад хүргэж байгаагүйг анхаарах хэрэгтэй. Есүс тэдэнд ердөө л тэднийг хорлож, хохироосон хүмүүсийг уучил гэсэн энгийн тушаал өгсөн. Тэдгээр эрчүүд хууль дор амьдарч, аливаа гомдолд нүдийг нүдээр, шүдийг шүдээр гэдэг сэтгэхүйгээр л амьдарч сурсан байв. Гэтэл Есүс тэдэнд ойлгохын аргагүй арга замаар амьдрах чиглүүлэг өгчээ. Бурханы зан чанараар амьдрах энэ тушаал тэднийг цочроосон. Тэд яаж ийм өндөр тушаалыг дагах юм бэ? Хариулт нь: “Итгэлийг минь өсгөөч!” Дагалдагч нар дуулгавартай байдал, итгэл хоёр шууд холбоотойг мэдэж байсан бөгөөд Бурхан надад үүнийг цоо шинээр ухааруулах гэж байжээ.

Есүс тэдний илүү том итгэлийн төлөөх хашхирааг сонсоод, дараах сургаалт үлгэрийг ярьж өгчээ: “Та нарт гичний үр төдийхөн итгэл байхад л, энэ ялам модонд “Үндсээрээ сугарч, тэнгист урга” гэсэн ч тэр дагах л болно” (иб). Би энэ санааг мэддэг л гэж бодож байлаа. Учир нь би энэ үгийг олон ч удаа номлож явсан бөгөөд Бурханы итгэлтэй байгаад, зүрхэндээ эргэлзэлгүйгээр уулыг усан далайд хаягд хэмээн тушаах юм бол, хэлснээр маань болно гэдгийг үгийг ч мэддэг байлаа (Марк 11:22-24). Энэ түүх ч ялгаагүй утгатай. Есүс энэ удаа зүгээр л уулын оронд ялам модыг л ашиглан ярьжээ.

Эдгээр үгд итгэл нь итгэгч хүн бүрт яг л гичний үр шиг өгөгдсөн болохыг хэлжээ. Энэ нь хаанчлалын тарих ба хураах зарчим билээ: “Бурханы хаанчлал нь газарт үр цацаж байгаа хүнтэй адил юм” (Марк 4:26). Бид аврагдахдаа тодорхой хэмжээний итгэл хүлээн авдаг (Ром 12:3). Энэ итгэл нь үрийн хэлбэртэй байдаг бөгөөд үүнийг боловсруулж, ургуулах нь бидний үүрэг билээ. Үр яаж ургадаг вэ? Хариулт нь айсуй.

## **Зарцын идэх зохистой цаг?**

Дараагийн дөрөв нь намайг ямагт зог тусахад хүргэдэг эшлэл учраас, би анхааралтай уншлаа. Есүс дагалдагч нартаа зүгээр нэг итгэлээ өсгөх томъёо өгөөгүйг би удахгүй ухаарах гэж байв. Тэрбээр тэдний амьдралыг эрх мэдэлд дуулгавартай байх зам руу шууд чиглүүлэх гэж байв. Түүний сургаалт үлгэрийг сонсоно уу:

Гэвч та нараас хэн нэг нь тариаланг чинь эрхэлдэг юмуу малыг чинь хариулдаг боолтой байгаад боолоо талбайгаас ирэхэд нь “Даруй орж, хооллохоор суу” гэж хэлэх үү? Харин ч түүнд “Надад идэх юм бэлтгэ. Бүсээ бүсэлж, намайг идэж ууж дуустал үйлчил. Дараа нь чи идэж ууна биз” гэж хэлэхгүй гэж үү? Тушаасныг нь гүйцэтгэсэнд боолоо тэр илүүгээр таалдаггүй биз дээ? (Лук 17:7-9)

Эзэн яагаад сэдвээ өөрчилснийг би дандаа асуудаг байсан сан. Тэрбээр яриагаа моддыг суга татдаг итгэлээр эхлүүлснээ зарцын протоколын талаарх яриа руу хазайжээ. Энэ бүхэн надад ямар ч утгагүй санагддаг байсан ч, тэр өглөө хамаг учир тайлагдах гэж байжээ.

Би зүрхээрээ Эзэнийг чагнангаа, эдгээр эшлэлийг ахин дахин удаанаар уншиж байлаа. Тэгтэл гэнэт “*Танай талбайд ажиллаж байгаа зарцын туйлын зорилго юу вэ? Сүргийг хариулж байгаа зарцын туйлын зорилго юу вэ? Эцсийн зорилго нь юу вэ?*” гэх асуулт орж ирэв.

Хэсэг эргэцүүллээ. Тэгтэл орж ирж байна аа: Ширээн дээр хоолтой байлгах явдал шүү дээ. Есүс надад ямар нэг зүйл хэлэх гээд байгааг би ойлголоо. Зарц хүний хөдөлмөрийн эцсийн зорилго нь эзэнтнийхээ ширээн дээр хоол тавих явдал юм бол, зарц хүн яагаад эзнээсээ урьтаж идэх гэж? Тэрбээр эхлээд ажлаа дуусгах ёстой бус уу? Мэдээж тэгэх ёстой! Дуусгаагүй ажил нь эхлүүлээгүй ажил шиг л муу юм. Яагаад тариан талбайгаа боловсруулсан атлаа идэхгүй байх гэж?

Яагаад сүргээ хариулах атлаа ноос, мах, сүүг нь ашиглахгүй байх гэж?

Би үүнийг хараад дараа нь Есүсийн дараагийн мэдэгдлийг уншив: “Түүнчлэн та нар ч мөн адил, та нарт тушаасан бүхнийг гүйцэтгээд “Бид тусгүй боолууд. Бид зөвхөн юу хийх ёстойгоо л хийсэн” (Лук 17:10).

Есүс жишээгээ бидэн рүү эргүүлжээ. Намайг уншиж байтал, та нарт *тушаасан бүхнийг гүйцэтгээд* гэдэг үг хуудаснаасаа ховхроод гараад ирэв. Есүс зарц хүний эзэндээ дуулгавартай байх байдлыг

бидний Бурхандаа дуулгавартай байх байдалтай холбожээ. Үүгээрээ Есүс итгэлийн өсөлтөд хамаатай гурван чухал зарчмыг гаргаж иржээ:

1. Итгэл хийгээд эрх мэдэлд захирагдах явдлын хооронд шууд холбоо оршино.
2. Итгэл нь бидэнд тушаагдсан зүйлийг хийх үед л өсдөг.
3. Жинхэнэ даруу хандлага л хамгаас чухал.

Хэсэг бүрийг одоо Бичээсээс харцгаая.

## **Итгэл хийгээд эрх мэдэлдээ дуулгавартай байхын холбоо**

Сайн мэдээнд нэгэн Ром зуутын дарга Есүстэй уулзсан түүх гардаг. Энэ түүх нь итгэл хийгээд дуулгавартай байдлын шууд холбоог харуулдаг. Есүсийг Капернаумд ирэхэд, мөнөөх зуутын дарга Түүнийг хайсаар ирж уулзжээ. Тэгээд өвчиндөө мэдээ алдан, тарчилж байгаа зарцынхаа төлөө Есүсээс гуйтал, Есүс “Би очиж, түүнийг эдгээе” гэж хэлжээ (Матай 8:7).

Гэтэл зуутын дарга: “Эзэнтээн, би Таныг дээвэр дороо оруулах зохистой нь биш ээ. Харин үг л хэлээч, тэгвэл зарц минь эдгэрнэ” (Матай 8:8) гэсэн байна.

Есүс тэр хүний гэрт очихоор хөдөлтөл, зуутын дарга өөрийгөө Есүсийг гэртээ оруулаад байх зохистой хүн биш тулявах шаардлагагүй, зүгээр л зогсож буй газраасаа тушаал өгөхөд л зарц маань эдгэрнэ гэсэн утгатай үг хэлжээ. Зуутын дарга үүнийгээ “Би ч мөн эрх мэдэл дор байдаг хүн. Миний дор цэргүүд бий. Би нэгэнд нь “Яв” гэхэд тэр явдаг. Нөгөөд нь “Ир” гэхэд тэр ирдэг. Зарцдаа “Үүнийг хий” гэхэд тэр хийдэг” (Матай 8:9) хэмээн тайлбарлажээ.

Зуутын даргын байр суурийг авч үзье. Ромын легион зургаан мянган цэрэгтэй. Зургаан мянган цэргийг нь жаран зуутын дарга удирдах бөгөөд бүгдээрээ легионы захирагчийнхаа тушаал дор байна. Зуутын дарга бүрийн захиргаан дор зуун цэрэг байна.

Ромын зуутын дарга өөрөө даргадаа захирагддаг учраас, цэргүүд нь ч түүнийг хүндэтгэж, түүнд захирагддаг хэмээн тайлбарлажээ. Тиймээс тэрбээр удирдагчийнхаа ар тал болж байхад, удирдагч нь

улсынхаа ар тал болж байдаг ажээ. Товчхондоо: “Би эрх мэдэл дор байдаг. Тиймээс надад эрх мэдэл байна. Би тушаал буулгахад л дор байгаа хүмүүс маань шууд гүйцэтгэнэ” гэсэн байна.

Тэрбээр “Учир нь би *бас...*” гэжээ. Тэрбээр Есүсийг Бурханы зарц тул хаанчлалын эрх мэдэлтэй. Тиймээс цэрэг тэрбээр цэргийнхээ талбарт эрх мэдэлтэй байдаг шиг, Есүс ч тэнгэрийн ертөнцөд эрх мэдэлтэй гэдгийг ойлгож байв. Тэрбээр өөрийг нь тушаалаа буулгахад, цэргүүд нь биелүүлэхээр шууд хөдөлдөг шиг, Есүсийн хувьд тушаалаа буулгахад л эдгэрэл ирнэ гэдгийг ойлгожээ.

Есүс үүнд нь хэрхэн хариулсан бэ? Есүс үүнийг сонсоод гайхаж, дагаж явсан олонд — Үнэнээр Би та нарт хэлье. Би ийм агуу итгэлийг Израильд хэнээс ч олоогүй юм байна (Матай 8:10) гэжээ.

Есүс дэлхий дээр гучин гурав наслахдаа Иохан Баптистын юмуу ээжийнхээ итгэлийг ингэтлээ бишрээгүй. Түүгээр эдгэрч, гайхамшиг хүлээн авсан Израильчуудаас ийм итгэл гараагүй. Түүний арван хоёроос ч ийм итгэл гараагүй. Гэтэл Израилийг булаан эзэлсэн Ром улсын цэрэг хүнээс ийм аугаа итгэл гарчээ. Түүний итгэлийг юу тийм аугаа болгов? *Учир нь тэрбээр эрх мэдэлд захирагдахыг ойлгож, итгэсэнчлэн амьдарчээ.*

Үүнийг л Есүс аугаа итгэлийн талаарх сургаалт үлгэрээрээ ойлгуулахыг хүсчээ. Бид хэдий чинээ эрх мэдэлд захирагдана - өөрсдөө төдий чинээ эрх мэдэлтэй байна. *Бид хэдий чинээ захирагдана - итгэл маань төдий чинээ аугаа байна.* Одоо үүнийг аугаа итгэлтэй байхыг хүссэн дагалдагч наргаа хэлсэн Есүсийн үгтэй холбож үзье: “Та нарт гичний үр төдийхөн итгэл байхад л, энэ ялам модонд “Үндсээрээ сугарч, тэнгист урга” гэсэн ч, тэр дагах л болно” (Лук 17:6). Есүс “Тушаахад л мод та нарыг дагана!” гэжээ. Тэр ялам мод хэнийг дагах вэ?

“Тушаалыг гүйцэтгэдэг” нэгнийг (Лук 17:9).

## Эцсээ хүртэл дуулгавартай дагах

Есүсийн зааж өгсөн хоёр дахь гол зарчим нь - тушаалыг гүйцэтгэх үед бидний итгэл өсдөг. Есүс хэрэг дээрээ “Түүнчлэн та нар ч мөн адил, та нарт тушаасан бүхнийг гүйцэтгээд...” гэсэн юм. Зарц хүн эзэнтнийхээ хүслийг хагас дутуу биш, харин бүрэн гүйцэтгэх үүрэгтэй. Бид эхлүүлсэн ажлаа сонирхолгүй болчихлоо эсвэл хэт хүнд байна гэдэг шалтгаанаар дуусгалгүй хаядаг. Тэгвэл жинхэнэ, үнэнч зарц хүн ямар

ч хүнд, ямар ч саадтай төслийн ард гарч байж л салдаг.

Абрахам бол бидний итгэлийн эцэг (Ром 4: 11-12). Абрахам хүүхэдгүй байсан. Далан тавтай байхад нь Бурхан түүнд үзэгдээд, түүнийг олон үндэстний эцэг болгох хүүтэй болно хэмээн амлав. Абрахам олон жил дуулгавартай хүлээснийхээ эцэст зуун насандаа амлагдсан хүүгээ хүлээн авсан.

Хүү нь Абрахамын харах нүднийх нь баясал болон торнив. Хүүг овоо хөөрхөн болсны дараа Бурхан Абрахамыг сорьж сонжихоор, хүүгээ Мориа уулан дээр аваачаад, надад өргө хэмээв. Бичээс “Тэгээд Абрахам өглөө эртлэн боссон...” (Эхлэл 22:3) гэдэг. Түүний ямар хурдан хөдөлж байгааг л хараарай. Зарим хүн Бурханыг дагах уу, байх уу гэж хэдэн өдөр, долоо хоног, сар, тэр бүү хэл жил эргэлддэг. Тэдэнд ариун айдас байдаггүй. Тиймдээ ч аугаа итгэл байдаггүй. Бурхан хэлсэн гэдгийг мэдсэн л бол, тэр даруй хөдлөх ёстой. Гэхдээ амьдрал шийдсэн чухал асуудал дээр эрх мэдэлтнүүдээс баталгаа эрэлхийлэх нь ухаалаг явдал болно.

Абрахам Мориа ууланд гурван хоног явж байж хүрсэн. Гурав хоногийн хугацаанд хүн юуг эс бодохов. Буцъя гэсэн бол, буцаж болох л байсан. Гэтэл Абрахам уулын орой дээр гараад, хүүтэйгээ нийлэн босгосон тахилын ширээн дээрээ газар дээрх ганц хүүгээ өргөхөөр гар хөлийг нь хүлж хэвтүүлээд хутгаа далайтал, Эзэний тэнгэрэлч зогсоов: “Хөвгүүний эсрэг гар бүү далай! Түүнд юу ч бүү хий! Учир нь чи хүүгээ, цорын ганц хүүгээ Надаас харамлаагүй тул чамайг Бурханаас эмээдгийг чинь одоо Би мэдлээ” (Эхлэл 22:12).

Абрахам эцсээ хүртэл дуулгавартай дагасан! Тэрбээр амьдралынхаа хамгаас чухал зүйл болох өв залгамжлагч, найдвар, Бурханы амлалт - Исаакийг алдах гэж байсан ч, дундаасаа буцаагүй юм. Абрахам амлалтаас илүү Бурханыг хайрладгаа батлан харуулжээ. Бид ч үүнийг тунгаах ёстой. *Ай Эзэн минь, өнөөдөр ийм эрчүүд, эмэгтэйчүүдийг босгож ирээч!*

Үүний эцэст Бурхан:

“Чи ийнхүү үйлдэж, хүүгээ, цорын ганц хүүгээ Надаас харамлаагүй учир Би Өөрөөрөө тангараглаж байна. Би үнэхээр чамайг ерөөж, үр удмыг чинь тэнгэрийн одод, далайн эргийн элс мэт асар олон болгоно. Үр удам чинь дайснуудынхаа үүд хаалгыг эзэгнэх болно. Чи Миний үгийг дуулгавартай дагасан учир үр удмаар чинь газар дэлхийн бүх



үндэстэн ерөөгдөх болно” (Эхлэл 22:16-18) гэв.

Абрахамын эрс тэс дуулгавартай зангийн ачаар Түүнд болоод үр садад нь ямар амлалт ирснийг харна уу: “Үр удам чинь дайснуудынхаа үүд хаалгыг эзлэх болно.” Есүс яагаад “Чуулганыг тамын хаалга тогтоож дийлэхгүй” хэмээн айлдсан гэж бодож байна? Абрахам эцгийн дуулгавартай байдлын ачаар чуулган Есүсээс ийм эрхийг олж авчээ. Абрахамын итгэл, дуулгавартай байдал өнөөдөр ч тунхаглагдсаар л байна.

Одоо Еврей номын бичээч Абрахамын дуулгавартай байдлын талаар юу мэдэгдсэнийг анхааралтай уншина уу:

Харин бидний хүсэх нь, хүн нэгбүр чинь найдварын бүрэн баталгааны төлөө эцсээ хүртэл адилхан хүчин чармайлт гаргаж, хойргошилгүй, итгэл ба тэвчээрээр амлалт өвлөгсдийн дуурайгсад болцгоох явдал юм. Учир нь Бурхан Абрахамд амлалт өгөхдөө Өөрөөсөө агуу хэнээр ч андгайлах боломжгүйгээс хойш Өөрөөрөө тангараглаж, “Би үнэхээр чамайг ерөөж чамайг улам олон болгоно” гэж айлджээ. Тэгэхэд Абрахам тэвчээртэй хүлээснээрээ амлалтыг хүртжээ (Еврей 6:11-15).

Абрахам эцсээ тултал хичээнгүй, эцсээ тултал дуулгавартай, эцсээ тултал тэвчээртэй байжээ. Абрахамын дуулгавартай үйлсийг өмнөх бүлэгт өгүүлсэн Саул хааны урвалттай жишнэ үү. Саул дайнд явж, тушаалынхаа 99 хувийг гүйцэтгэсэн. Тэр биелүүлээгүй үлдээсэн өчүүхэн хувиа ч бас “Эзэнийг бодсондоо” л тэр хэмээн учирласан. Товчхондоо: Саул Эзэний тушаалыг гүйцээгээгүй. Гаднаа гүйцээсэн мэт харагдаж байсан ч, гаргасан өчүүхэн дуулгаваргүй авир нь түүнд асар гарзтай тусчээ. Саул эзнийхээ ширээн дээр бараг л хоол тавихаа шахсан ч, зүрхнийхээ сэдлээс болоод аягагай хоолоо хойш нь татчихжээ. Тэрбээр Эзэнээ хүндэтгэж, Түүнд үйлчлэхийн оронд тушаалаар дамжуулан өөртөө ашиг гаргажээ.

Хичнээн хүн Саултай адил баяртайгаар эхэлсэн атлаа замын дунд байдал хэцүүдэж, юмс зоргоор нь болохгүй үед дуулгаваргүй авирладаг билээ? Түүнчлэн эрх мэдлийн удирдлагаасаа яльгүй гажгаад л, өөртөө ашиг унагадаг хүмүүс байна. Ийм хүмүүс Эзэний Үгэнд орж, зүгээр л алах ёстой байсан мал сүргээс Бурханд өргөх нэрийдлээр тарган сайхныг нь шилж үлдээсэн Саул шиг, хийсэн хэргээ элдэв шашны зорилго, шалтгаанаар зөвтгөдөг. Эцсээ тултал

дуулгавартай байхгүй л бол итгэл өсөхгүй, харин буурна!

Абрахам эцсээ хүртэл дуулгавартай байж, жинхэнэ итгэл, тэвчээрээр амлалтыг хүлээн авсан. Түүний итгэл, дуулгавартай байдлыг хооронд нь салгаж болохгүй. Үүнийг Иаков ч тодорхой хэлсэн: (Энэ бичээс дээрх *үйлс* гэдэг үгийг *дуулгавартай үйлс* гэдэг үгээр орлуулж уншъя)

Хоосон хүн ээ, харин чи *дуулгавартай үйлсгүй* итгэл нь ашиггүй гэдгийг хүлээн зөвшөөрөхийг хүсэж байна уу? Бидний эцэг Абрахам тахилын ширээн дээр хүү Исаагаа өргөхдөө *дуулгавартай үйлсээрээ* зөвтгөгдсөн биш үү? Итгэл нь түүний *дуулгавартай үйлстэй* хамт ажиллаж байсныг, итгэл нь *дуулгавартай үйлсээр* гүйцэд болсныг чи харж байна. “Бурханд Абрахам итгэсэн. Үүгээр нь түүнийг зөвд тооцсон юм” гэж өгүүлдэг Бичвэр биелэгдсэн бөгөөд Бурханы анд нөхөр гэж Абрахам дуудагдах болсон. Хүн зөвхөн итгэлээр бус, *дуулгавартай үйлсээр* зөвтгөгддөгийг та нар харж байна. Учир нь сүнсгүй бие үхмэл байдгийн адил түүнчлэн *дуулгавартай үйлсгүй* итгэл ч бас үхмэл болой (Иаков 2:20-24, 26).

Төгсгөлийн эшлэл дээр нь итгэл, дуулгавартай үйлс хоёрыг хүний бие, сүнс хоёртой зүйрлэжээ. Иаков итгэлийг махан биетэй, харин дуулгавартай үйлсийг сүнстэй зүйрлэжээ. Сүнс, бие хоёр нийлж байж л дэлхий дээр өөрсдийгөө илэрхийлдэг. Сүнс биеэс явбал, бие үхнэ. Лазарын тохиолдолтой адил, сүнс биеэс гарбал, бие нь сүнсийг эргэж иртэл босохгүй. Үүнчлэн Иаков энэ жишээгээрээ итгэл нь дуулгавартай үйлсээс хамаардаг болохыг харуулжээ. Тиймээс л Иаков “Чамд итгэл байна, надад үйлс байна. Чи надад итгэлээ үйлсгүйгээр харуул. Би чамд итгэлээ үйлсээрээ харуулья” (Иаков 2:18) гэсэн юм.

Дуулгавартай байдал үгүй бол, итгэл нь жинхэнэ байж чадахгүй. Эндүүрэх хэрэггүй. Бичээс “*дуулгавартай үйлсээр итгэл бүрэн болно!*” хэмээн тодорхой хэлсэн.

Элч нар: “Эзэн минь, итгэлийг маань өсгөж өгөөч!” гэж хашхирсан. Хариуд нь Есүс эцсээ тултал дуулгавартай байх талаар өгүүлсэн! Итгэл нэгт эрхэм нөхөд минь, яагаад л номынхоо турш энэ үгийг чухалчлан анхааруулаад байгааг одоо ойлгож байна уу? Хуульгүй байдал газар авсан энэ үед бид энэ үгийг анхаарах хэрэгтэй.

Та: “Итгэл чинь сонсож, итгэхээс ирдэг биз дээ?” гэж хэлэх байх. Тэр үнэн. Гэхдээ дагалдах үйлдэл л итгэлийг гэрчилнэ. Иймээс л

үгийг сонсоод дагахгүй бол, энэ нь мэхлэгдсэн явдал болно гэсэн юм. Итгэл маань худлаа, хулхи болно.

### Итгэл доторх эр зориг

Энэ үнэнийг чуулганд үйлчилдэг хүмүүсийн талаар: “Эхлээд тэд шалгагдаг. Тэгээд гэм зэмгүй аваас үйлчлэг” гэж хэлсэн Паулын үгээс харж болно. Дикон нь удирдагч биш, тушаалыг гүйцэтгэдэг хүн. Даблью. Ий. Вайн “Дикон гэдэг Грек үг нь “зарц” л гэсэн үг. Эрх мэдлийн дор байдаг хүн” гэжээ. Диконууд итгэмжтэй үйлчилбэл, дуулгавартай байдал нь тэднийг дараах зүйлст бэлэн болгох ажээ: “Учир нь онц үйлчилсэн нь сайн байр суурь ба Христ Есүс дэх итгэлдээ үлэмж зоригийг олж авдаг” (1Тимот 3:13).

Эхний сургаалт үлгэрт Есүсийн тайлбарласан зарцад хоёр зүйл амлагджээ: 1). Сайн байр суурь (үүнд сүнсний дэвшил ч багтана) (Дуулал 75:7). 2). Бүрэн дагадаг хүмүүст аугаа итгэл. Итгэл, дуулгавартай үйлс хоёр нь Бичээс дээр бие биеэсээ тусгаар бус, салшгүй харагдаж байна. Библи ийм жишээгээр дүүрэн. Жишээлбэл:

- Абелын дуулгавартай байдлаар илэрсэн итгэл нь олон мянган жилийн дараа ч яригдсаар байна (Еврей 11:4).
- Енохын дуулгавартай байдлаар илэрсэн итгэл нь түүнийг Бурхантай алхуулсаар үхлийг үзэлгүй, авагдахад хүргэсэн.
- Ялт дэлхий бүхлээрээ нүгэлдээ живээд байхад, Ноагийн дуулгавартай байдлаар илэрсэн итгэл нь гэр бүлийг нь авралд хүргэсэн.
- Абрахамын дуулгавартай байдлаар илэрсэн итгэл нь түүнийг олон үндэстний эцэг болгосон.
- Иосефын дуулгавартай байдлаар илэрсэн итгэл нь гэр бүлийг нь чөлөөлсөн.
- Иошуа, Калев хоёрын дуулгавартай байдлаар илэрсэн итгэл нь тэднийг Амлагдсан газарт оруулсан. Иошуа Мосед итгэмжтэйгээр үйлчилж, түүний залгамжлагч болсон. Иошуа шинэ үеийнхэнийг сүү, балаар халгисан Амлагдсан газар руу удирджээ.
- Янхан Рахаб “зарлага элч нарыг хүлээн авч, тэднийг ондоо замаар явуулахдаа үйлсээрээ бас зөвтгөгдсөн” (Иаков 2:25).

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

Түүний дуулгавартай байдал гэр бүлийг нь аварчээ. Энэ нь түүний жинхэнэ итгэлийг гэрчилсэн юм.

- Ханна өөрийг нь гутаан доромжилсон тахилчид дуулгавартай захирагдсан нь түүний умайг нээгдэхэд хүргэж, улмаар Израиль үндэстэнд сэргэлт авчрах бэлтгэл болжээ.
- Давидын удирдагчдаа гар хүрэхгүй байх дуулгавартай хандлага нь түүнийг Саулын араас оруулалгүй, Бурханы араас гэх сэтгэлтэй аугаа хаан болгосон.
- Даниел, Шадрах, Мешах, Абед-Негогийн дуулгавартай байдал нь тэдэнд Бурханы бөгөөд хааны үлэмж тааллыг авчирсан.

Би өөр юу ярих вэ? Би Гидеон, Барак, Самсон, Иефта, Давид, Самуел болон эш үзүүлэгчдийн тухай яривал надад цаг хүрэлцэхгүй. Тэд итгэлээр, хаанчлалуудыг эзэлж, зөвийг үйлдэн, амлалтуудад хүрч, арслангуудын амыг хааж, галын хүчийг унтраан, илдний ирээс зайлж, буурайгаас хүчирхэг болгогдож, дайн тулалдаанд зоригжин, харийн дайчдыг буулган авч байлаа. Эмэгтэйчүүд өөрсдийн үхэгсдийг амиллаар буцаан авч байв. Зарим нь илүү дээр амилалд хүрэхийн тулд чөлөөлөлтийг хүлээж авалгүй тамлагдсан юм. Зарим нь доромжлогдон, ташуурдуулсан. Тийм ээ, бас гинжлэгдэн, хоригдож байлаа. Тэд чулуугаар шидүүлэн, соригдож, тас хөрөөдөгдөн, илдэнд хөнөөгдөж, хонь ямааны арьс нөмрөн явж, хоосон тарчиг байн, зовж, ад үзэгджээ. Тэд цөл, уул, агуй болоод газрын гаваар тэнүүчлэн байлаа. Тэдний хувьд дэлхий зохисгүй байжээ. Итгэлээрээ тэд бүгд сайн гэрчлэлийг олоод, амлагдсаныг хүлээн аваагүй аж (Еврей 11:32-39).

Еврей номын зохиогч итгэлийг дуулгавартай үйлдэлтэй сүлжжээ. Энэ хоёр салшгүй. Итгэл нь гагцхүү гайхамшгийг хүлээж авахын төлөө л өгөгдсөн юм бол, юу гэж цөл, уулаар бэдэрч, зүдэрч, зовсон хүмүүсийг тоочих билээ? Тэр хүмүүс сайн дуусгажээ. Тэд эцсээ тултал дуулгавартай дагасан. Тэд жинхэнэ итгэлтэй байжээ.

Та аугаа итгэлийг хүсч байвал, шууд болоод бусдаар дамжин Бурханы эрх мэдлийг эцсээ тултал дага. Итгэл, дуулгавартай байдал нь шууд холбоотой!

## Даруу байхын хамгаалалт

Есүсийн дагалдагч наргаа заасан хамгийн сүүлчийн санаа нь даруу хандлагаа тээх явдал юм. Тэрбээр “Түүнчлэн та нар ч мөн адил, та нарт тушаасан бүхнийг гүйцэтгээд *“Бид тусгүй боолууд. Бид зөвхөн юу хийх ёстойгоо л хийсэн”* гэж хэл” гэжээ. Ийм хандлагатай хүн Эзэнээрээ шагнуулна. Өөрийгөө өргөгч нь дарагдана. Харин нүдэндээ даруу оршдог хүмүүсийг Эзэн Өөрөө өргөнө.

Иаков “Эзэний өмнө өөрсдийгөө даруу болго. Тэгвэл Тэр та нарыг өргөмжлөх болно” (Иаков 4:10) гэсэн.

Номхон зүрхтэй хүмүүс шагналд хүрнэ. Дуулгавартай дагасан атлаа үүгээрээ бардамнан сайрхах нь уналтад хүргэнэ. Таны хичээнгүй гүйцэтгэсэн бүхэн нурна. Та энэ номон дахь Бурханы бүх зөвлөгөөг дагаж болох ч, бардамнах л юм бол, дуулгавартай байдлаар олж авсан бүхнээ алдаж мэдэх.

Люсифер тослогдсон байсан. Тэрбээр төгс чанарын лац, цэц ухаан, гоо үзэсгэлэнгийн туйл байсан. Бурхан Өөрөө түүнийг гаргаж ирээд, Өөрийнхөө ариун ууланд суулгасан байв. Түүнээс бардам зан олдох хүртэл тэрбээр бүх талаараа төгс байв. Дараа нь тэр тэнгэрээс аянга цахилгаан гялбахын дайтай хүчтэй шидүүлжээ. Паул эрх мэдлийн байр сууринд тослогдсон хүмүүсийг “биеэ тоон диаволын шүүлтэд унах вий” (1Тимот 3:6) хэмээн анхааруулдаг.

Паул Бурханы дуудлагад дуулгавартай байснаараа ихийг гүйцэлдүүлсэн хүн. Тийм боловч нас явах тусам, улам л даруусчээ. Тэрбээр МЭ 56 онд дөрөв дэхь илгээлтийн аянаа хийхдээ, гуравдугаар аяныхаа үеэр Коринтын эх газарт байгуулсан чуулгандаа захидал бичжээ. Паул үүнээс 10-11 жилийн хойно алуулсан бөгөөд тухайн үед хэдийнээ Эзэний ахмад үйлчлэгч болоод байв. Гэтэл тэрбээр: “Учир нь би элч нараас хамгийн өчүүхэн нь бөгөөд Бурханы чуулганыг хавчиж байсан тул элч гэж нэрлэгдэх зохисгүй хүн юм” (1Коринт 15:9) гэж бичсэн байх юм.

Түүний үгээс даруу зан харагдаж байна уу? Тэр өөрийгөө “элч” нэрийг ч зүүх зохисгүй нэгэн гэж үзжээ. Энэ худлаа даруу зан биш шүү. Хулхи даруу байдал нь даруу харагдахын тулд яаж “политиктай” ярихыг мэддэг боловч, зүрх нь ч, тархи нь ч гэдгэр байдаг. Энэ бол хуурамч даруу зан. Харин Бичээсийг Ариун Сүнсний хүчээр бичиж байгаа хүн худлаа ярьж чадахгүй! Тиймээс Паул өөрийгөө элч нарын хамгийн өчүүхэн нь гэж хэлсэн нь улс төр биш, жинхэнэ даруу зан байжээ.

Одоо Паулын дараах мэдэгдлийг харна уу: “Би тэд бүгдээс илүү зүдэж зүтгэсэн юм. Гэхдээ би биш, харин надтай хамт байдаг Бурханы нигүүлсэл билээ” (1Коринт 15:10). Би бусад элч нараас ч илүү зүтгэсэн! Байзаарай, Паул онгироод байгаа бус уу? Жаахан сэхүүн сонсдож болох ч, онгиргон явдал биш юм. Үнэндээ Паул Эзэнээс л хамааралтай болохоо илэрхийлэхийнхээ өмнө энэ үгийг угтвар болгон өгүүлрүүн. Тэрбээр хамгийн бага элчийнхээ хувьд хүлээсэн даалгавраа зүтгэн биелүүлэхдээ, Бурханы нигүүлслийн хүчээр л энэ бүхний ард гарснаа хэлжээ. Түүний сүнсний ололт болгон нь түүнд хайрласан Бурханы чадвараас л урсан гарсныг Паул үг дуугүй хүлээн зөвшөөрч байна.

Паулыг “хамгийн бага элч” гэдэгт итгэх хэцүү. Паул амьд ахуйдаа ч, хожмын чуулганы түүхэнд ч хамгийн аугаа элчийн нэг байсаар ирсэн. Тэгвэл Паул үхэхээсээ 4-5 жилийн өмнө МЭ 62 онд Ефесчүүдэд юу гэж хэлснийг болгооно уу. 1Коринтыг бичсэн цагаасаа хойш Паул урьд хожид гүйцэлдүүлснээсээ ч ихийг хийсэн. Гэтэл энэ удаа Паул өөрийгөө “Бүх ариун хүний хамгийн өчүүхэн нь болох надад энэхүү нигүүлсэл өгөгдсөний учир нь Христийн яндашгүй баялгийг харийнханд тунхагласан” (Ефес 3:8) гэжээ.

Олон жилийн өмнө Паул өөрийгөө хамгийн бага элч гэж байсан бол, энэ удаа “бүх ариун хүмүүсийн хамгийн бага нь” гэжээ. Юу? Христэд итгэх итгэлээрээ болоод удирдах чадвараараа сайрхах зохистой хүн байгаа бол, тэр нь Паул л байх ёстой. Тийм боловч тэрбээр Эзэнд үйлчлэх тусмаа, өөрийгөө улам л багаар харах болжээ. Түүний даруу зан улам л өссөөр байж. Магадгүй иймээс л өтлөх тусам нь Бурханы нигүүлсэл даган өссөөр байсан юм болов уу? Магадгүй иймээс л Бурхан арга замуудаа Паулд тийм дотно илчилж, элч Петрийг хүртэл гайхшруулсан юм болов уу? (2Петр 3:15-16). Магтаалч “Тэрээр даруу хүнийг шударгаар удирдаж, Тэдэнд замаа сургадаг” (Дуулал 25:9) гэж мэдэгдсэн. Ингэж харбал, магадгүй иймээс л Бурханы “газрын хөрсөн дээрх хэнээс ч илүүгээр маш даруу нэгэн байлаа” (Тооллого 12:3) хэмээн дүрсэлсэн Мосе Бурханы замыг тийм дотно мэддэг байсан юм болов уу? Магадгүй иймээс л Паул, Мосе хоёр тоотой хүмүүсийн л өөрийн болгодог, Бурханы аугаа итгэлийг олж авах нууцыг мэддэг байсан байх.

Паул амьдралынхаа адаг дээр буюу МЭ 64-66 онд Тимотод илгээсэн хоёр захидалдаа өөрийгөө “Христ Есүс нүгэлтнүүдийг аврахаар ертөнцөд ирсэн гэдэг нь итгэмжит бөгөөд бүрэн зөвшөөрөхөд зохистой үг мөн. Тэдний эхнийх нь би байна” (1Тимот 1:15) гэсэн.

Тэр өөрийгөө “нүгэлтнүүдийн тэргүүн!” хэмээв. “Тэргүүн биш, нүгэлтнүүдийн тэргүүн” шүү.

Ийм аугаа ололт амжилттай хүн энэ олон жилийн дараа “Би энэ бүхнийг хийсэн. Тиймээс миний аугаа үйлчлэл үнэлэгдэх ёстой” эсвэл “Би ийм мундаг ажил хийсэн болохоор жинхэнэ элчийн хүндэтгэлийг хүлээх ёстой” гэж хэлээгүй. Тэрбээр хэдэн жилийн өмнө бичиж байсан шигээ “Би хамгийн бага элч” ч гэж бичээгүй, “Би ариун хүмүүсийн хамгийн бага” нь ч гэж бичээгүй. Харин “Би нүгэлтнүүдийн тэргүүн” гэжээ. Хэдийгээр Паул Христийн дотор зөвтгөгдсөн гэдгээ (2Коринт 5:21) ойлгож байсан ч, Бурханы нигүүлсэл, өршөөлөөс хэзээ ч хараагаа таслаагүй юм. Үнэндээ тэрбээр наслах тусам, Бурханы нигүүлсэлд улам л найдах болсон байна. Тэрбээр хэзээд “Би гийгүүлэх юмгүй зарц. Би тушаалыг л гүйцэтгэсэнээс өөр юмгүй” гэсэн хандлагаар амьдарчээ.

Энэ нь Паулын амьдралынхаа адаг дээр шахуу хэлсэн мэдэгдлийг нь тайлбарлаж байна: “Ах дүү нар аа, би өөрөө барьж авсан гэж боддоггүй, харин хийдэг ганц юм маань ардхаа маргаж, урдах өөдөө тэмүүлж, Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналын төлөө бариа өөд урагшилдаг” (Филиппой 3:13-14). Түүний үгээс даруу байдлыг мэдэрч байна уу? “Би барьж авсан гэж боддоггүй, харин ардахаа маргаж, урагшаа л тэмүүлнэ.” Тэрбээр Есүс Христийг танин мэдэх даалгаврынхаа дэргэд бүх ололт амжилтаа “юмын чинээ” үзээгүй байна. Бурхан Өөрийгөө даруу хүмүүст илэрхийлдэг болохыг санаарай! Паул “Би зорилгынхоо төлөө давшдаг” гэсэн. Давшина гэдэг нь эсэргүүцэх хүчинтэй тулгарна гэсэн үг. Дээд дуудлагын хамгийн том эсэргүүний нэг нь *бардамнал* юм шүү.

Есүсийн амьдралыг судлах юм бол, Тэрбээр магтаалыг хүлээж авалгүй, харин Аав руугаа чиглүүлсэн байдаг. Тэр бүү хэл эдгээсэн хүмүүстээ болсон явдлыг нийгэд дэлгэлгүй, Бурханд алдрыг өргөхийг заасан.

Баян залуу захирагч Есүсийг “Сайн багш” гэсэн ч, Есүс тэр даруй Бурханаас өөр хэн ч сайн биш гэж хэлсэн юм. Тэр Өөрөө Бурханы Хүү биш гэж үү? Тэр сайн биш гэж үү? Мэдээж мөн! Есүс хүмүүний магтаалыг Өөртөө авалгүй, гагцхүү Аавдаа л барьсан. Гэхдээ Түүний бардамнаагүй шалтгаан нь даруу чанарт нь оршиж байсан юм. Тэрбээр “Буулгыг минь өөрсөд дээрээ ав. Надаас сур. Би дөлгөөн, *зүрхэндээ даруу*. Та нар сэтгэлдээ амралтыг олох болно” (Матай 11:29) гэсэн.

Бурханы хайр жинхэнэ даруу байдлыг боловсруулдаг. “Хайр тэвчээртэй энэрэнгүй билээ. Хайр атаархдаггүй. Хайр агсганадаггүй, ихэрхдэггүй” (1Коринт 13:4). Бардамнал өөртөө юм хайдаг бол, хайр

өөртөө юм хайдаггүй. Бардамнал өөрт нь ашиггүй дуулгавартай байдалд дургүй бол, хайр Эзэнийхээ алдрыг л хайдаг. Бид хайрладаг учраас, дуулгавартай дагадаг. Бид Бурханыг алдаршуулахын төлөө л зүтгэдэг. Бид Бурханыг алдаршаасай л гэж хүсдэг. Магадгүй тиймээс л Паул “Хэрэв би эш үзүүлдэг мөн бүх нууц болон бүх мэдлэгийг мэддэг байгаад, уулыг нүүлгэх бүрэн итгэлтэй байлаа ч, надад хайр үгүй бол би юу ч биш” (1Коринт 13:2) гэсэн байх.

## Хувь тавилангаа биелүүл

Бид үр жимс ургуулахаар бас Бурханыхаа төлөө аваргалахаар дуудагдсан. Бид Түүний замаар явсан цагтаа л Түүний гайхамшигт нэрэнд жинхэнэ хүндэтгэлийг авчирна. Энэ үг нь бидний ч төлөө, Бурханы алдрын ч төлөө гэдгийг ухаараарай. Бурханы анхааруулгыг сонсох нь хүний ухаанд утгагүй санагдаж болох ч, Бурхан “Бурханы мунхаглал хүмүүсээс илүү мэргэн, Бурханы мөхөс нь хүмүүсээс илүү хүчирхэг” (1Коринт 1:25) гэж хэлээгүй гэж үү? “Бурханы мэдлэгийн эсрэг босогч алив *бардамналыг* устгаж, бодол бүрийг Христийн *дуулгаварт* олзолдог (2Коринт 10:5) гэдгийг өөртөө сануулж яваарай.

Дуулгавартай байдалтай сөргөлддөг учир шалтгааны эргэцүүлэл нь бардамнал юм. Энэ нь Бурханы зөвлөгөөг эсэргүүцдэг. Энэ нь Бурханы мэдлэгийг туйлын эрх мэдэл гэж хүлээн зөвшөөрдөггүй. Энэ нь тун аюултай болохыг би номынхоо турш ярьлаа. Энэ өдрүүдэд Бурхан Өөртөө аугаа итгэл, эрх мэдэл, эр зориг дотор алхлах хүмүүсийг байлгах л болно. Тэд Паулын хэлсэн “Та нарын дуулгавар биелэгдэх үед бид бүх дуулгаваргүйг шийтгэхэд бэлэн ” (2Коринт 10:6) хүмүүс байна.

Цаг бага үлдэж байгаа учраас, бид үр нөлөөтэй байх ёстой. Дуулгавартай байдал нь биднийг үр нөлөөтэй байлгадаг. Би дахин төрөхөөсөө өмнө тун идэвхитэй атлаа дуулгаваргүй хүн байлаа. Би үр нөлөөгүй, заримдаа бүр хэрэгцээгүй амьтан байв. Тийм боловч өсөх тусам, миний хичээнгүй дуулгавартай зан тухайн үедээ намайг юунд ч хүргэхгүй байгаа мэт харагдаж байсан ч, эцсийн дүнд заавал үр нөлөөтэй болгодог байв.

Таны өмнө Бурханы доторх хувь тавилан чинь байна. Та дуулгавартай байдлыг сонгохдоо, хувь тавилангийнхаа биеллийг сонгож байгаа юм. Таныг хэн ч, юу ч зогсоохгүй. Давид, Иосеф,



## АУГАА ИТГЭЛ

Ноа, Естер тэргүүтэй итгэлийн ахмадууд маань маш их зовлон үзсэн. Гэхдээ хувь тавилангаа биелүүлсэн хүмүүст зориулсан алдрын танхим дотор тэдний нэрс байдгийг санаарай. Бурхан эцсийн энэ өдрүүдэд итгэлийн өвөг дээдсийн нэрсийн жагсаалтад нэрийг нь нэмж, Христийн шүүх сэнтийн өмнө хүндэтгэх эрчүүд, эмэгтэйчүүдийг хайж байна. Гайхамшигт Эзэндээ алдрыг авчрахын төлөө амьдарсан хүмүүсийн дунд та бид хоёрын нэр байхын төлөө би залбирч байна.

## БҮЛЭГ 18

# ДҮГНЭЛТ

*Бурханы нөмөрт хорогдонгоо зооглох үр жимс маань  
биднийг Бурханы найранд оруулна.  
Тэнд л бид Бурханы баялгийг хуваалцах болно.*

**Б**ид номоо анхны хосын гаргасан эмгэнэлт шийдвэрээр эхэлж байсан. Тэр эхнэр, нөхөр хоёр Аугаа хүчирхэг нэгэний нөмөр дороос гарч, Бурханы шүхрээс гадуур байдаг зөв, буруугийн эх үүсвэрийг олжээ. Тэд Бурханы эрх мэдлийг түлхсэн ч, бид тэр хоёрын алдаанаас ч, тэр хоёрын замаар явсан хүмүүсийн алдаанаас ч сургамж авч чадна.

Тэгвэл Аугаа хүчирхэг Нэгэний сүүдэр дор үлдсэн хүмүүст ямар шагнал ирэх вэ?

Ой модон дунд алимын мод хэр билээ.  
Олон хөвгүүн дунд амраг чи минь тэр билээ  
Сүүдэр дор нь би суумаар таатай  
*Жимс нь тагнайд минь жигтэйхэн амттай.*  
Дарст цэнгэлийн өргөөнөө дагуулав тэр, намайгаа  
Дарцаг болсон хайраараа даруулав бас, намайгаа  
(Соломоны дуун 2:3-4).

Бурханы сүүдэр дор амийн мод орших. Түүний үр жимс нь ямагт амттай байх. Адам, Ева хоёр өөрийнхөө ухаанаар сайныг хайсан боловч, үхэлд хүрсэн. Учир шалтгааны ухааны модноос хүртсэн хүн болгон тэгэх л тавилантай.

Бурханы нөмөрт хорогдонгоо зооглох үр жимс маань биднийг Бурханы найранд оруулна. Тэнд л бид Бурханы баялгийг хуваалцах болно.

Номоо уншиж байхдаа та дотроо уйман тавгүйтгэсэн байх. Зовиур заавал муу байх албагүй. Энэ тохиолдолд зовиур нь хоёр зүйлийг тодорхойлно. Нэгдүгээрт - гарц хэзээд бий. Энэ гарцыг гэмшил гэдэг. Ятгалга, ял хоёр нь тэнгэр, газар шиг ялгаатай. Аль, алийг нь зовиур дагалдана. Гэхдээ ятгалга нь гарцтай бол, ял нь мухар. Гэмшил нь ердөө л сэтгэлгээ, үйлдлийн өөрчлөлтийг дагуулдаг зүрхний өөрчлөлт юм. Үндсэндээ “Эзэн минь, би өөрийнхөөрөө үзлээ. Чадваргүйгээ мэдлээ. Тиймээс зүгээр л Танд захирагдъя” гэж хэлэх юм. Өөрөөр хэлбэл сайн, мууг мэдүүлэгч мэдлэгийн модноос бий болсон учир шалтгааны арга замаа хаяад, дуулгавартай байдлын зам руу эргэх сонголт юм.

Залбирал, эргэцүүлээр зүрхээ нээж, амьдралд чинь ямар, ямар дуулгаваргүй тал байгааг Ариун Сүнснээс асуу. Шаардлагатай бол, таны нөхцөлд таарсан бүлгүүдийг дахиж умш. Бурханы Үгээр амьдралаа оношлуул. Түүний Үг дуулгаваргүй талбар дээр чинь гэрэл тусгана. Та нэг бол Бурханы Өөрийнх нь эсвэл Түүний төлөөний эрх мэдэлтэй тэрсэлдсэн байж болох. Тийм талууд байвал, цаасан дээр жагсааж бич. Жагсааж бичсэн бол, Бурханы уучлал, сэргэлтийг хүлээж авахын төлөө хамтдаа залбиръя.

*Тэнгэрийн Бурхан Аав минь ээ, миний захирагддаггүй, дуулгаваргүй байдлыг Есүсийн нэрээр уучлаач. Би өөрийнхөө учир шалтгааны ухаанаар амьдарсаар, дараах талбарууд дээр тэрсэлжээ.*

*(Жагсааж бичсэн, Бурханы эрх мэдэлд захирагдаагүй талбар бүрээ нэг бүрчлэн мэдэгд. Бурханы болоод Түүний төлөөний эрх мэдэлтэй тэрсэлдсэн явдал болгоноо хүлээ).*

*Би буруу сэтгэлгээ, үйлдэл болгоноо гэмшиж байна. Та намайг уучилж, Эзэн Есүсийн цусаар цэвэрлээч. Би цаашид Таны эрх мэдэлд захирагдахаас гадна гэр бүл, улс, чуулган, нийгмийн эрх мэдэл зэрэг миний дээр Таны тавьсан бүх эрх*

## БАТЛАН ХАМГААЛАЛТ ДОР

*мэдэлд захирагдана.*

*Үүнийг хүсээд зогсохгүй, Таны тааллаар үйлдэх нигүүлслийг өгөөч. Дуртайяа захирагдаж, дуулгавартайяа дагах зүрхийг өгөөч. Би амьдралаа Эзэн Есүст даатгаж, бүх төрлийн тэрслэлийг хаяж байна. Та намайг бүх талаараа Таны нэрийг алдаршуулаарай гэж дуудсан болохоор, би хичээнгүйлэн захирагдаж байна. Амень.*

Боломжтой бол, жагсаалт дээрх эрх мэдэлтнүүдээсээ аман юмуу бичгэн хэлбэрээр уучлал гуйгаарай. Энэ бол хэрэг зарга үүсгэж, хэргийн эзнийг тодорхойлох цаг биш, харин ямар ч хүнд асуудал дээр хүлээсэн үүрэг хариуцлагаа үүрэх боломж юм. Ингэж чадсан хүн л Бурханы төлөө цаашаа ахина.

Энэ дэлхийн зөвлөгөөнөөс дээд замыг сонгосонд чинь баяр хүргэе. Бид дуулгавартай байвал, гайхамшигт Хааныхаа зорилгыг ахиулна. Дуулгавартай байдал аугаа шагналтай шүү.

Та нарыг бүдрэхээс хамгаалж, Өөрийнхөө алдрын оршихуйд үлэмжийн баяр хөөртэйгөөр, өө сэвгүйгээр зогсоож чадах Түүнд, бидний Аврагч болох цорын ганц Бурханд, бидний Эзэн Есүс Христээр алдар суу, сүр жавхлан, сүр хүч, эрх мэдэл нь бүх цагаас өмнө, эдүгээ болоод мөнхөд байх болтугай. Амен (Иуда 24-25).

**Батлан хамгаалалт дор байгаарай!**

# ЯРИЛЦАХ АСУУЛТ

Хэрэв та энэ номыг видео хичээлтэй нь цуг судлаж байгаа бол, долоо хоног тутмын видеогоо үзээд, тохирох асуултын дагуу бүлгээрээ ярилцаад явахыг зөвлөж байна. Видео хичээл нь энэ номын чухал, чухал сэдэвтэй зэрэгцээ явж, дэлгэрүүлэх тул оролцогч нар видео хичээлээ үзээд, номоо уншаад явбал хамгийн зүйтэй болно.

За амжилт!

## 1-ээр хичээл

### *1-2-аар бүлгийн гол сэдэв*

1. Эрх мэдэл гэдэг үгийг сонсохоор, хамгийн түрүүнд юу бууж байна? Шуурганаар хорогдох дээвэр шиг сайнаар төсөөлөгдөж байна уу? Эсвэл амьдралыг чинь там болгодог дарга шиг муугаар төсөөлөгдөж байна уу?
2. “Батлан хамгаалалт дор” байгаагүйгээсээ болоод хохирч байсан тохиолдол танд бий юү?
3. Ардчилсан сэтгэлгээгээр Хаанчлалын зарчмыг ойлгох хэцүү. Та Бурханы эрх мэдлийн загварыг ардчилсан үзлээр яг яаж шүүдэг байв? Энэ хандлага чинь удирдагч нартайгаа тогтоох харилцаанд чинь хэрхэн нөлөөлдөг байв?
4. Жижиг бүлгийн үдэшлэгийн тал дээр пасторынхаа үгэнд орохоос дургүйцсэн явдал маань тэрслэл байсныг Бурхан надад харуулсан. Та тэр дүгнэлтэнд гайхсан уу? Энэ хичээлийг сурахаасаа өмнө та миний байр суурийг өмөөрч байсан уу?

## 2-аар хичээл

### 3-7-аар бүлгийн гол сэдэв

1. Хичээлийн эхэнд би уншигчдаасаа нүгэл гэдэг үгийг сонсонгуут, санаанд нь юу бууж байгааг асуусан. Энэ асуултыг сонсоод хамгийн түрүүнд танд юу бодогдсон? Бодол чинь хэрхэн өөрчлөгдөв?
2. Та өмч, ажил, харилцаа зэрэг талбараа Бурханы Үгээс дээгүүр тавьж байсан уу? Эдгээрийг Бурханд дуулгавартай байхаас дээгүүр тавих үед юу болж байв?
3. Дутуу дагах нь дуулгавартай байдал биш, харин тэрслэл. Та эцсээ тултал бүрэн дуулгавартай байсан тохиолдол байгаа бол, хуваалцаач. Бас дутуу дагасан тохиолдол байгаа бол, хуваалцаач. Гол ялгаа нь юундаа байв? Тэдгээр нь танд хэрхэн нөлөөлсөн бэ?
4. Библи тэрслэлийг илбэ шид гэсэн (1Самуел 15:23). Илбэ шидийн эцсийн зорилго нь юу вэ? Энэ номын үнэн таны тэрслэлд хандах арга замыг хэрхэн өөрчлөв?
5. Сатаны Библи дээр хамгийн түрүүнд Өөрийнхөө хүслээр хий гэж тушаадаг. Энэ нь Есүсийн тогтоож өгсөн “Би Өөрийнхөө хүслийг бус, харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг” (Иохан 5:30) гэдэг загварын яг эсрэг байна. Та яаж өөрийнхөө хүслийг Бурханаас дээгүүр тавьдаг байв? Үр дүн нь ямар байв? Өөрийнхөө хүслээс дээгүүр Аавынхаа хүслийг идэвхитэй эрэн хайж, дагахын төлөө юу хийж болох вэ?

## 3-аар бүлэг

### 8-10-аар бүлгийн гол сэдэв

1. Ром 13:1-2 дээр “төлөөний эрх мэдлийг эсэргүүцэх нь Бурханыг Өөрийг нь эсэргүүцэхтэй адил” гэдгийг хэлжээ. Хэрэв Есүс таныг гэртээ, ажил дээрээ, нийгэм дээр ямар нэг зүйл хий гэвэл, та яах вэ? Тэгвэл дарга, дасгалжуулагч, цагдан сэргийлэгч зэрэг эрх мэдэлтэн танаас яг адилхан зүйл хүсвэл, та яах вэ? Та тэдэнд Есүст хариулсантайгаа адилхан хариулах уу?
2. Библи “Бурханаас гадуурх эрх мэдлүүд гэж үгүй бөгөөд Бурханы тогтоосноор л байгаа тул дээд эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд.

Тиймд эрх мэдлийг эсэргүүцэгч нь Бурханы тогтоолыг эсэргүүцсэн хэрэг. Эсэргүүцсэн хүмүүс нь өөрсдөдөө шийтгэл хүртэх болно” (Ром 13:1-2) гэдэг. Захирагд гэсэн үгийг цэргийн ч, иргэний ч агуулгаар хэрэглэдэг. Иргэний хэрэглээнд энэ нь иргэн хүн хүсэлтэй хандлагаар, сайн дураараа эрх мэдлийн дор орох явдлыг илэрхийлнэ. Бичээсийн энэ тушаал төлөөний эрх мэдэлд хандах хандлагыг чинь хэрхэн өөрчилж байна?

3. 1992 оны сонгуулийн дараа надад хэцүү байсан. Намайг сэтгэл санааны дарамтанд ороод байтал Эзэн хэнийг өсгөж, бууруулах нь Түүний мэдлийн асуудал гэдгийг сануулав. Улс төрийн үр дүн таныг гонсойлгож байв уу? Миний түүх сонгуулийн үр дүнд хандах хандлагад чинь нөлөөлөв үү?
4. Исаиа 1:19 дээр биднийг хүсэлтэй бөгөөд дуулгавартай байвал, газрын шимийг хүртэнэ гэсэн. Та дуулгавартай боловч хүсэлгүй, хүсэлтэй боловч дуулгавартай байж болно. Дуртай, дургүй дагаж байсан тохиолдлоосоо хуваалцана уу. Үүнийгээ дуртай бөгөөд дуулгавартай дагаж байсан тохиолдолтойгоо харьцуулна уу.
5. Библи нөхцөл болзолгүй захирагдахыг заадаг биш, нөхцөл болзолгүйгээр дуулгавартай дагахыг заадаггүй. Хэрэв удирдагч нар маань биднээр Бурханы Үгийг зөрчүүлэх гэвэл, бид дагах ёсгүй. Удирдагч чинь танаар Бурханы Үгийг зөрчүүлэх гэсэн удаа бий юү? Энэ асуудлыг та хэрхэн шийдсэн бэ? Ямар үр дүн гарсан бэ?

## 4-ээр хичээл

### *11-12-аар бүлгийн гол сэдэв*

1. Библи Бурханы зарц нарын нийгмийн эрхийн талаар ярьдаг. Бурханы зарц нарт хандах зүй зохистой арга зам нь юу вэ? Та нийгмийн эрх баригчдад хэрхэн ханддаг вэ?
2. Дьявол алдааг олохдоо гарамгай ч, Есүс бидний төлөө итгэмжтэйгээр зуучлан залбирдаг. Нийгмийн удирдагч нарын тухайд, та яллагч шиг ажиллаж байна уу эвсэл зуучлагч шиг ажиллаж байна уу? Та нийгмийн удирдагч нарыг элэглэсэн зүйлд инээдэг үү? Хүн олон нийтийн сүлжээгээр удирдагчийг гутаан доромжилж байвал, та гашууддаг уу?

3. Бид удирдагч, дарга, багш, дасгалжуулагч тэргүүтэй нийгмийн эрх мэдэлтнүүдэд захирагдах ёстой. Учир нь тэд Бурханыг төлөөлдөг. Есүсийн төлөө ажиллана гэдэг нь юу болохыг дүрслэн хэлнэ үү. Та ажилдаа цагтаа ирдэг үү? Төслийн ажлаа аргалдаг уу? Энэ хичээл нийгмийн удирдагч нарт хандах хандлагыг чинь хэрхэн өөрчлөв?
4. Бичээс гэр бүлийн бүтцийг маш тодорхой хэлсэн. Таны бодлоор бид юунаас болж гэр бүл доторх Бурханы эрх мэдлийн загварыг сахиж чадахгүй байна? Бурханд найдах нь гэр бүлийн эрүүл динамикийг байгуулахад яаж нөлөөлдөг вэ?

## **5-аар хичээл**

### ***13-14-ээр хичээлийн гол сэдэв***

1. Есүс чуулганыхаа удирдлагыг Өөрөө томилдог болохыг Библи хэлдэг (Ефес 4:11-12). Та өөрийн үүрэг хариуцлагаас хөндлөнгийн зүйлд гар бие оролцож явсан уу? Есүс чуулгандаа тогтоож өгсөн удирдлагынхаа тал дээр юу мэдэрдэг гэж та бодож байна?
2. Ханна хүүхэд хүсэн, олон жил залбирсан. Яагаад Бурхан Ханнаг өөрийг нь гутаан доромжилсон удирдагчид хүндэтгэлтэй хандах үед залбиралд нь хариулав? Та юу гэж бодож байна?
3. Бид удирдагчаа муулах үедээ Бурханы цэц ухаанаас гарч, эцэстээ Түүний хамгаалалтаас тасардаг. Үүнийг Мосег Куш эмэгтэйтэй гэрлэлээ хэмээн буруутган, шүүмжилсэн Мириамын түүхээс харж болно. Танд Бурханы хүсэл, хамгаалалтаас гараад зовсон удаа бий юү? Үр дүн нь ямар байв?
4. Танай удирдагч магадгүй чухал мэдээллээр дутсандаа, мэргэн бус санагдмаар шийдвэр гаргаж байсан уу? Тэгээд ямар үр дүн гарсан? Та түүний оронд байсан бол, асуудлыг яаж шийдвэрлэх байсан бэ? Тэр явдлаас та юу сурсан?
5. Хэдийгээр Саул галзуурч, Давидыг алах гэж улайрч байсан ч, Давид Саул хаанд үнэхээрийн хүндэтгэлтэй хандаж, захирагдаж байсан. Давид энэ хэцүү улиралдаа Бурханы хангамж, амар тайван, хамгаалалтыг хүлээн авсан. Та явал ийнхүү удирдагчаа хүндэтгэж, түүнд захирагдаж сурах бол?



## 6-аар бүлэг

### *15-18-аар бүлгийн гол сэдэв*

1. Чуулган нэгдмэл байхдаа алдрыг хүлээн авдаг. Есүс газар дээр амьдарч байхдаа Бурханы алдрыг илчилсэн. Алдар гэхээр танд юу бууж байна? Бурханы алдрыг хязгааргүй хүлээн авч болно гэдэгт та итгэдэг үү?
2. Пентекост өдөр Дээд өрөөнд байсан 120 хүн нэгэн хүн мэт нэгдмэл байжээ. Тэд нэг ухаан, зүрх, сүнстэй байсан. Өнөөдөр манай чуулганууд ийм нэгдмэл байвал, ямар харагдах бол?
3. Америкийн зэвсэгт хүчин таван нэгтгэл ангитай. Тэдгээр нь бүгд зэвсэгт хүчин мөн боловч, өөр өөрийн гэсэн онцгой үйл ажиллагаатай. Үүнтэй адил чуулган дотор ч өөр, өөр үйл ажиллагаа бий. Бид Бурханы зөвшөөрсөн үйл ажиллагааныхаа хүрээн дотор л ажиллах ёстой. Энэ үг таны чуулгандаа хандах үзлийг хэрхэн өөрчилж байна? Та нийгмийнхээ салшгүй бүтэц болохынхоо хувьд нийгмийнхээ алсын хараан дор нэгдэхийн тулд юуг өөрчилж болох вэ?
4. Бид Бурханы эв нэгдлийн загварыг хүлээн авах үедээ нийгэмдээ, бүс нутагтаа, улс үндэстэндээ яаж нөлөөлөхийг төсөөлж байна уу? Найз нөхдийнхөө хүрээнд, чуулганд, нийгэмдээ эв нэгдлийг улам батжуулахын төлөө юу хийж болох вэ?

# ӨНӨ МӨНХӨӨР ХӨТЛӨГДӨХҮЙ

*Өнөөдөр ч, үүрд мөнхөд ч  
үнэ цэнэтэй байх амьдрал*



Энэ амьдралын нөгөө талд юу ч байхгүй гэж хүмүүс боддог. Гэтэл Бичээс “Хүн энэ ертөнцөд хэрхэн амьдарснаараа нөгөө ертөнцөд хэрхэн амьдрахаа шийднэ” гэх. Энд л хэрхэн амьдарснаараа, тэнд авах шагнал, шийтгэлээ шийдүүлнэ.

Жон Бивэр бидэнд 2Коринт 5:9-11 дээрх зарчмыг сануулаад, хүн бүр Христийн өмнө үйлсийнхээ дагуу шүүгдэж, олон хүн мөнх насгүй зүйлд хамаг амьдралаа зориулсанаа ойлгоод цочирдохыг хэлжээ. Тэгвэл хүн яаж ач холбогдолтой амьдрах вэ? “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” ном таныг амьдралынхаа дуудлагыг олох, хүлээж авсан бүхнээ өсгөн үржүүлэх мөнхийн зарчимд сургаж, өөрийгөө өнө мөнхөд үнэлэгдэх ажилд зориулахад чинь чиглүүлнэ.

Татаж аваарай:  MessengerX.com

# АФФАБЕЛ

*Өнө мөнх рүү өнгийх цонх  
(Сонсдог жүжиг)*



“Аффабел” нь Жон Бивэрийн бичсэн сонсдог жүжиг юм. Үүнд энэ дэлхийн амьдралаас цаашхи бодит амьдралыг өгүүлэх бөгөөд үүгээр Бурханы хаанчлалын олон үнэнийг тусган харуулдаг. Итгэгч хүмүүс өнө мөнхийн хараатай амьдрах ёстой ч, олон хүн өнө мөнх гэж юу болохыг ч мэддэггүй.

Энд та Аугаа хаан Жэйлинтэй, харанхуйн хар санаат эзэн Дагонтай, Өгөөмөр, Бие даагч тэргүүтэй гол дүрүүдтэй, Аффабел хэмээх ер бусын нутагтай бас Ганц хэмээх аймшигт хөсөр газартай танилцаарай. Гол дүрүүдийн амьдралаар дамжин зүрхний чинь үнэн төрх илчлэгдэх үед та өөрийнхөө амьдралын талаар нэгийг бодох буй за. “Аффабел” сонсдог жүжиг нь сонсогчийг нэгэнт ухааруулахын төлөө бүтээгдсэн “Өнө мөнхөөр хөтлөгдөхүй” номын жүжигчилсэн хэлбэр болно.

Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

# САТАНЫ УРХИ

*Өстөн дайсныхаа үхлийн занганаас  
эрх чөлөөтэй амьдар*



“Сатаны урхи” ном нь ерөөсөө л гомдлын талаар өгүүлнэ. Гомдол нь итгэгч хүмүүсийг Бурханы хүслээс гаргахдаа тогтмол ашигладаг, дайсны хайргай урхи ажээ. Олон хүн энэ урхинд мэдээгүй явж орчихоод, орсон хойноо ч мэддэггүй.

Хүн энэ дэлхий дээр байгаа цагтаа гомдлоос дархлаатай оршиж чадахгүй ч, гомдох эс гомдохоо сонгож чадна. Гомдлыг шийдвэрлэсэн хүн л хорслыг даваад, улам хүчирхэгжиж, Бурхантай саадгүй харилцана.

Хорсол, бухимдал, хар сэр, үл итгэлцлээс чөлөөлөгдөж, Бурханы хүсэл дор алхлан, амьдралаа Бурханд бүрэн даатгаж, уучлал, эвлэрэл, баяр хөөрөөр дүүрэн амьдрахын нууцыг эндээс сураарай.

Татаж аваарай:  MessengerX.com

# САТАНЫ УРХИ

*Өстөн дайсныхаа үхлийн занганаас  
эрх чөлөөтэй амьдар  
(Монгол бичгээр)*



“Мараната” үйлчлэл Өвөр Монгол дахь Христийн чуулганы итгэгч хүмүүсийг итгэлд бэхжүүлэхийн төлөө мөн Монгол бичгээр унших хүсэлтэй бүх хүнд зориулж зохиолч Жон Бивэрийн Монгол хэл дээрх (кирилл бичиг дээрх) номуудыг Монгол бичиг дээр хөрвүүлэн буулгаж байгаа бөгөөд анхны бүтээл болох “Сатаны урхи” номоо та бүхэнд өргөн барьж байна.

Энэ номыг [CloudLibrary.org](http://CloudLibrary.org) хаяг дорх “Монгол бичиг” гэсэн хэсгийг сонгоод, үнэ төлбөргүй татаж авна уу. Монгол чуулганы энэ бэлэгийг Өвөр Монгол дахь Христийн итгэл нэгт ах, эгч дүүдээ болоод Монгол бичигт нэвтэрсэн бүх хүнд түгээн дэлгэрүүлээрэй!

Татаж аваарай:  [MessengerX.com](http://MessengerX.com)

# САЙНЫГ УУ, БУРХАНЫГ УУ?

*Бурхангүй “сайн” сайн биш байдгийн учир*



Сайн л бол, Бурханаас байх учиртай. Тийм үү? Өнөөдөр “сайн” хийгээд “Бурхан” гэдэг хоёр үгийг ижил утгатай үгс шиг хэрэглэх болжээ. Бид “сайн” гэж үздэг зүйлсээ Бурханы хүсэлтэй төгс эгнэх учиртай гэж итгэдэг. Өгөөмөр, даруу, шударга зан чанар нь сайн юмс. Амиа хоохойлох, тоомжиргүй зан, харгислал нь муу юмс. Ядах юмгүй ялгачихмаар харагдаж байна. Гэхдээ ингээд л боллоо юу? Сайныг ялгахад тийм амархан юм бол, Библи яагаад сайн, мууг ялгах хараатай бай гэж хэлсэн юм бол?

Энэ ном нь бас л нэгэн төрлийн хувь хүний хөгжлийн гарын авлага биш юм. Энэ ном танаас зүгээр нэг сайн сайхан, зөв хүн болохыг шаардахгүй. Энэ ном таны Бурхантай тогтоосон харилцааг хэзээ ч байгаагүй өндөрлөгт гаргаж, амьдралыг чинь эд эсээр нь ширхэглэн сэгсэрч, үндсээр нь эргүүлнэ.

Татаж аваарай:  MessengerX.com

# ГЭРЛЭЛТИЙН ТҮҮХ

*Гэрлэлтээ авар*



Эртээ урьдын цагт... Гэрлэлт бол үүрд өнө зүйл. Энэ нь нэг эрэгтэй, нэг эмэгтэйг холбож зангиддаг гэрээ бүхий харилцаа юм. Энэ холбоо тэднийг бүтээгдсэн анхны зорилгоор нь хөглөж, хүчирхэгжүүлнэ. Тэд тусдаа биш, хамтдаа байхдаа л хүчтэй. Харин энэ бүхний эхлэл нь хурим юм. Хурим нь амар сайхандаа жаргахын төлөө амьдралын босгыг давж буй, ариун нандин үйл явдал болой. Энэ амьдралын төлөөх сонголт бүр, үйлс бүр чухал. Зүрхээрээ нийлж, гараараа хөтлөлцсөн нөхөр, эхнэр хоёр тааж мэдэшгүй ирээдүйг чиглэн Бүтээгчийн хайраар амьдралаа сүндэрлүүлнэ.

Гэтэл бид энэ хайрын түүхээс хагацжээ. Тэгвэл “Гэрлэлтийн түүх” номоороо Жон, Лиза хоёр гэрлэлтэд хандсан Бурханы анхны төлөвлөгөөг дэлгэж байна. Та гэрлэсэн байна уу, гэрлэж амжаагүй байна уу, сүй тавьсан байна уу – Бурханы их хайрын түүхийн нэгээхэн хэсэг мөн болой.

Татаж аваарай:



MessengerX.com

# АРИУН СҮНС

*Түүнтэй танилцахуй*



Анхны дагалдагч нар Есүстэй 3 жил хамт байж, Түүний заасан бүхнийг сонсож байсан. Харин загалмайд цовдлогдохынхоо өмнө Есүс: “Би явж Ариун Сүнс ирэх нь та нарт илүү дээр юм” гэжээ. Хэрэв Есүстэй өдөр бүр байсан дагалдагч нарт Ариун Сүнс амин хэрэгтэй байсан юм бол, бидэнд бүр их хэрэгтэй бус уу?

Жон Бивэр танд Ариун Сүнсийг танилцуулж, Ариун Сүнсний мөн чанар, хүч чадлыг заажээ. Таны итгэлийн төлөвшил ямар ч төвшинд байсан “Ариун Сүнс: Түүнтэй танилцахуй” ном танд Бурханыг улам ихээр дотно танин мэдүүлнэ.



# СЭЛЭМТЭЙ ОХИД

*Загалмайгаа жинхэнэ баатар шиг үүрье*



Бурханы Үг болох илдний тухай судлах нь илдийг сугалж хэрэглэхээс амархан бөгөөд таатай байдаг. Охид бид тэнгэрийг газартай холбох цаг болжээ. Дэлхий даяар эмэгтэйчүүд алив гадуурхал, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлийн бай болсоор байна.

Лиза Бивэр энэ номдоо эмэгтэйчүүдийн өнгөрснийг биш, харин ирээдүйг өгүүлжээ.

Тиймд Бурханы дайчин охид оо, эр зоригтойгоор босоод, ялгах чадвараа ашиглан, уучилж, мэргэн байж, сэлмээ эргүүлэн баатарлаг үйлсийг бүтээгээрэй.

Татаж аваарай:  MessengerX.com

# КРИПТОНИТЫГ УСТГА

*Хүчийг чинь сорогч зүйлийг устга*



Супермэнд дайснаа дарах ер бусын хүч байдаг шиг, Христийн дагалдагч бидэнд ч тийм нэгэн хүч бий. Гэвч криптонит гэгч нэгэн бодис Супермэний хүчийг ч, дагалдагч бидний хүчийг ч ховх сордог. Мэдээж Супермэн, криптонит хоёр зохиомол зүйлс боловч, сүнсний криптонит нь жинхэнэ зүйл юм.

Анхны чуулганы итгэгч нарт байсан тэнгэрийн хүч яагаад өнөөгийн бидэнд байхгүй байгааг энэ ном тайлбарлана. Түүнчлэн криптонит гэж юу болох, яаж үйлчилдэг болох бас үүнийг хэрхэн устгахыг зааж өгнө.

Энэ номыг амьдралаа жинхэнээсээ өөрчлөх хүсэлтэй Христийн дагалдагч нарт зориулав. Уншсан шиг уншаарай!

# БУРХАН МИНЬ, ТА ХААНА БАЙНА?!

*Цөл дунд зорилготой бөгөөд хүчтэй байх*



Өмнө нь Бурхан ярьдаг байснаа одоо таг дуугүй болжээ. Өмнө нь та итгэлээр явдаг байсан бол, одоо Бурханы оршихуй бараа сураггүй болжээ. Тэгвэл Бурханаас амлалт хүлээж аваад, энэ амлалт биелэхийг харах хоёрын дунд оршдог дамжин өнгөрөхөд тавтай морил.

Гэхдээ энэ нь ямар ч зорилгогүй хөсөр газар биш юм. Бурхан цөлөөр дамжуулан биднийг хувь тавиланд маань бэлтгэн, боловсруулдаг - гэхдээ ганцхүү та зөв хариу үйлдсэн тохиолдолд шүү. Олон хүний боддог шиг - энэ улирлаар туулах нь зүгээр л Бурханыг хүлээгээд суух явдал биш юм. Цөл дундуур жолоогоо зөв залахад таны үүрэг оройл их. Морин тойруулгаар эргэлдэж цагаа гарздах гээгүй л юм бол, цөлийг мэддэг байх хэрэгтэй.

Нүд тайлсан энэхүү номоороо бестселлер зохиолч Жон Бивэр таныг хуурай, бэрх улиралдаа жолоогоо зөв залсаар, Бурханы зэхсэн бүхэнд нэвтрэхэд чинь туслах Библийн түлхүүр болсон ухаарал, гүн түүхээр өсгөн боловсруулж байна.

Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

# Х: Бурханаас хүлээж авсан хүчин чадлаа үржүүл




Та Бурханы Хаанчлал дотор үзэгч юм шиг мэдрэмж тээж явна уу? Үйлчилмээр байгаа боловч хэрхэн гэдгээ мэдэхгүй байна уу? Бурханд үйлчлэхийг хүсдэг ч дараах асуултад хэрхэн хариулахаа мэдэхгүй зөрчилдөж явна уу: Надад хандсан Бурханы хүслийг алдаагүй гэдгээ хэрхэн баталгаатай мэдэх вэ? Бурханы Хаанчлалын төлөө надад өгөгдсөн бэлэг авьяас ямар үүрэгтэй вэ? Бурханы өгсөн хүчин чадал дотор амьдарч байгаа гэдгээ хэрхэн баталгаатай мэдэх вэ? Би “Чуулганд” бүтэн цагаар үйлчилдэггүй. Тэгэхээр миний дуудлага чухал биш гэсэн үг үү гэх мэт асуулт танд байна уу?

Тэгвэл энэ бүх асуултад энэхүү ном хариулах болно. Бурханаас хүлээн авсан бэлэг авьяасаа үржүүлэн Түүнийг алдаршуулж амьдрахад тань энэ ном чиглүүлж тусална.

Татаж аваарай:  [MessengerX.com](https://messengerx.com)

# X MessengerX.com

Газар газрын хүн бүрт зориулсан дагалдагчийн аян




- 110 гаруй хэл дээр үнэ төлбөргүй үзэх боломжтой.
- Апп хэлбэрээр ч, онлайн хэлбэрээр ч хэрэглэх боломжтой.
- Таны өсөлт төлөвшилд зориулагдсан материал.
- Өөрийн түүх, дагалдагчийн аяныг хянах боломжтой.



Бүх төрлийн төхөөрөмж дээр үзэх, унших, сонсох боломжтой цахим ном, сонсдог ном, богино хэмжээний кино, видео сургаал, Библи зэрэг дагалдагч бэлтгэхэд нэн шаардлагатай бүх материалыг Messenger сангаас хүлээн авна уу.

## MessengerX.com



Дэлхий даяар App Store болоод Google Play дээр үзэх боломжтой.

# Та дарга, удирдагчтайгаа санал нийлэхгүй үедээ тэдэнд хэрхэн ханддаг вэ? Ямар учраас хамгаас түрүүнд тэднийг сонсох ёстойгоо бодож байв уу?



Шинэчлэн найруулсан энэхүү хувилбартаа бестселлер зохиолч Жон Бивэр эрх мэдэлтнүүдээр дамжуулан Бурханы хангаж өгдөг хамгаалалтын хил хязгаарыг шинэ үеийнхэнд дахин тодруулж өгчээ. Түүнчлэн дайсан Бурханаас тогтоон хуваарилсан эрх мэдлийг таних чадварыг маань алдуулж, чи тэнгэрийн удирдлагатай удирдлагагүй хувь тавилангаа биелүүлчихнэ гэж залилан мэхлэдгийг заажээ. Жон бидэнд удирдагч нартаа хэрхэн зүй зохистой хандахыг зааж өгөхдөө, эрх мэдэл дор багтаж амьдрах амьдрал нь хангамж, хамгаалалт, ирээдүйн төлөөх найдвараар хангадаг газар болдгийг хэлжээ.

Батлан хамгаалалт дор ном:

- туйлын зөв атлас бурду байж болдгийг
- шударга бус явдалд хандах Библийн арга замыг зааж өгнө.

Цоо шинэ бүлэг, хэлэлцүүлэг, онцгой сэдвээр баяжуулагдсан “Батлан хамгаалалт дор” ном нь Бурханы эрх мэдэлд захирагдах нь ямар чухал болохыг илчилж, амьдралд маань байгаа удирдагч нарт хэрхэн хандахыг зааж өгсөн, амьдрал өөрчлөгч, практик ном билээ.



**ЖОН БИВЭР** нь Бурханы үгийг найраагүй, зоригтой заадгаараа олон улсад нэртэй номлогч, бестселлер зохиолч болно. Жон гэргий Лизагийн хамт энэ дэлхийг өөрчлөгч, Христийн үнэнч дагалдагч нарыг боловсруулдаг Мессенжер Интернэйшнэл байгууллагыг үндэслэн байгуулжээ. Харин Колорадо дахь гэртээ байхдаа Жон дөрвөн хүүтэйгээ өрсөлдөөнтэй хөзрөн тоглоом тоглож, Лизаг гольф тоглоё гэж уруу татах дуртай.



Бусад материалыг дараах цахим хуудаснаас: [MessengerX.com](https://messengerx.com)

**MessengerX**



**MESSENGER**  
INTERNATIONAL

Энэ ном нь танд зориулсан зохиолчийн бэлэг бөгөөд ХУДАЛДАХЫГ ХОРИГЛОНО.

Илүүг эндээс

